35.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 28
Бүгд: 96
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

36. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 26
Бүгд: 96
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

37. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 26
Бүгд: 96
72.9 хувийн саналаар дэмжигдлээ.

38. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 29
Бүгд: 96
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

39. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 34
Бүгд: 96
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

40. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 29
Бүгд: 96
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

41. Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 27
Бүгд: 96
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	68
Татгалзсан:	28
Бүгд:	96

70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Бусад.Ховд аймгийн онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах ангийн албан хаагчид, Баянхонгор аймгийн Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 1983 оны төгсөгчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн 12^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын сургуулийн багш, оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Н.Батсүмбэрэл нарын урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын Социал Демократ Монголын залуучуудын холбооны гишүүд, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчид, нийслэлийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 9^а ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Төгс дэлгэрэх” сургуулийн 8^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын Ардчилсан намын хорооны “Салхит” үүрийн гишүүд, нийслэлийн ерөнхий боловсролын “Эрхэт эрдэм” сургуулийн 9^а, 9^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы урилгаар Улаанбаатар төмөр замын Сайншанд өртөөний замын 4 дүгээр ангийн ажилчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Электрон жаал” сургуулийн 12¹ ангийн сурагчид, Дархан-Уул аймгийн Хонгор сумын одонтой ээжүүдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы урилгаар Ховд аймгийн Жудо бөхийн өсврийн шигшээ багийн дасгалжуулагч болон тамирчид, Улсын Их Хурлын гишүүн

Л.Мөнхбаясгалан, Г.Ганбаатар нарын урилгаар Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Арвис” сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн 12^в ангийн багш, сурагчид, “Шихихутаг” Хууль зүйн их сургуулийн Эрх зүйн эчнээ ангийн төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 17 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 33 минут үргэлжилж, 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр 18 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдааны ирц 126 гишүүн ирвэл зохихоос 69 гишүүн буюу 54,8 хувийн ирцтэй байна. Чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Зочин танилцуулъя.

Ховд аймгийн онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах ангийн албан хаагчид, Баянхонгор аймгийн Галуут сумын ерөнхий боловсролын сургуулийн 1983 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай мэдээллийг гишүүддээ өгье.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн байнгын хорооны 19-ний өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатарын гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүн 2026 оны 3 сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн байнгын хорооны 5 сарын 19-ний өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааныг хэлэлцэх асуудлаас хасагдсан.

3.“Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Пүрэвдорж нарын 42 гишүүн 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн байнгын хорооны 5 сарын 20-ны өдрийн хуралдааны явцад тогтоолын төсөл хэлэлцэхийг хойшлуулсан тул хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан байна.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүд 5 сарын 22-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат, Цэвэгдоржийн Туваан нар төржээ. Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат, Цэвэгдоржийн Туваан нартаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд эртэч гишүүдээ бас танилцуулъя. Сүхбаатарын Эрдэнэболд, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Аюушийн Ариунзаяа, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Бөхчулууны Пүрэвдорж нарын гишүүд өглөө 9 цагт ирцдээ орсон байна.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр маш их өндөр ачаалалтай хуралдана. Нийтдээ 17 асуудлыг хэлэлцэнэ. Гишүүд маш олон санал хураалттай, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө дээр 200-аад саналтай билүү. Тийм болохоор өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд гишүүдийг бас идэвхтэй оролцож, санал хураалтдаа идэвхтэй оролцохыг бас хүсэж байна.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн өргөн барьсан, хэлэлцэх эсэх

2.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

4.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг

5.Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг

6.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа нарын 6 гишүүн өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 1 саналтай.

7.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 1 саналтай.

8.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 5

сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 4 санал хураалттай.

9.Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийтдээ 3 төсөл байгаа.

10.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 203 саналтай. Энэ маш чухал санал хураалтууд болно. Гишүүдийг бас идэвхтэй оролцохыг дахин сануулъя.

11.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газар 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх

12.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Засгийн газар 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, асуулт асуух хугацаа 60 минут.

13.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна.

14.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

15.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцүүлэг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 20 гишүүн өргөн мэдүүлсэн.

16.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

17.Бусад асуудлын хүрээнд Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ийм 17 асуудлыг өнөөдөр хэлэлцэх нь байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжих эсэх саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ирцэд 85 гишүүн бүртгүүлсэн байна. Санал хураалтад бэлтгэсэн 63 гишүүн, бэлэн бус 22 гишүүн байна. Тэгээд гишүүд хуруугаа уншуулж ирцдээ бэлтгэнэ үү. Гишүүдийг суудлаа эзлэхийг хүсэж байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт. Энэ татгалзсан гарч байгаа 26 гишүүн санал хураалтдаа бэлтгэе. Танхимд байхгүй бол танхимдаа хүрэлцэн ирье. Санал хураалтыг явуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 62,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 61,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмж хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

10.11 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал

хураалт явуулъя. 88 гишүүн санал хураалтад оролцож, 58 гишүүн буюу 65,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 69,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 73,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 68,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

10.14 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачилсан илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлтгэнэ үү. Санал хураалтыг явуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 71,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Прокурорын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцож, 64 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 88 гишүүн санал хураалтад оролцсоноос 66 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 67 гишүүн 76,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 88 гишүүн санал хураалтад оролцсоноос 62 гишүүн буюу 70,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 72,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ.

10.17 цаг.

Зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн Хүрэлбаатар багштай 12^Б ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт сурагчдадаа удахгүй өгөх элсэлтийн шалгалтаа амжилттай өгч, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ элсэн орж, эх орондоо хэрэгтэй, бүтээлч, хариуцлагатай иргэн болж төлөвшихийг нийт Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Дараагийн асуудалдаа оръё.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооноос Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 69,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.20 цаг.

Дараагийн асуудалдаа орёе.

Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооноос Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Эрүүгийн хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Энэ Эрүүгийн хуулийн гүтгэхтэй холбоотой заалт байгаа. Өчигдөр гишүүд нэлээн нухацтай ярьсан. Нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг шүүмжлэх, олон нийтэд алдаа дутагдлыг нь ил тод хэвлэх, мэдээлэх, нийтлэх энд бас хариуцлага тооцох, Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх бол буруу. Энэ бол нээлттэй байх ёстой. Энэ дээр гишүүд ярилцаж, ерөнхий зарчмын хувьд ойлголцсон.

Нөгөө талдаа худлаа мэдээлэл тараах, яах аргагүй гэмт хэрэгт гүтгэх, нэр хүндэд нь гутаах, доромжлох иймэрхүү асуудлууд гарах юм бол Эрүүгийн хуулийн хариуцлага хүлээлгэх ёстой гэдэг дээр ажлын хэсэг Тэмүүжин гишүүн, Их Хурлын гишүүд ярилцаж, ойлголцолд хүрсэн.

Гэхдээ Эрүүгийн хуулийн өөрчлөлтийг Байнгын хороо, гишүүд санаачлах нь зохимжгүй гэж үзсэн учраас Засгийн газраас энэ хаврын чуулганд багтааж, хуулийн төслийг оруулж, хэлэлцүүлж, батлуулах чиглэлийг өгөхөөр болсон. Хууль зүйн байнгын хороо энэ дагуу Засгийн газарт бас чиглэл өгөх арга хэмжээг авч ажиллаарай гэдгийг бас хэлье.

10.21 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хураах санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэснийг төслөөс хасах. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 78,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

10.24 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хороодоос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам,

эвслийн бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 1 санал байна. Гишүүд санал хураалтад илтгэе. Дэгээрээ л явна даа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн талаар Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас дэмжээгүй санал

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд дэх

- нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ 2027 онд 36,493.4 тэрбум төгрөг гэснийг 34,318.8 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 31.9 гэснийг 30.0 гэж, 2028 онд 38,644.0 тэрбум төгрөг гэснийг 36,355.9 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 30.4 гэснийг 28.6 гэж, 2029 онд 40,444.7 тэрбум төгрөг гэснийг 39,596.2 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 28.6 гэснийг 28.0 гэж;

- нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2027 онд 32,495.4 тэрбум төгрөг гэснийг 26,316.7 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 28.4 гэснийг 23.0 гэж, 2028 онд 34,827.4 тэрбум төгрөг гэснийг 27,963.6 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 27.4 гэснийг 22.0 гэж, 2029 онд 36,908.5 тэрбум төгрөг гэснийг 31,110.6 тэрбум төгрөг гэж, ДНБ-д эзлэх хувь 26.1 гэснийг 22.0 гэж;

- ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2027 онд 5.8 гэснийг 6.3 гэж, 2028 онд 6.0 гэснийг 6.5 гэж, 2029 онд 6.3 гэснийг 6.0 гэж;

- Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 2027 онд 7.0 гэснийг 6.5 гэж;

- Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2027 онд 57,114.9 гэснийг 51,403.4 гэж, 2028 онд 63,610.1 гэснийг 57,249.1 гэж тус тус өөрчлөх, эдгээр өөрчлөлтүүдтэй уялдуулан эдийн засгийн бусад үзүүлэлтэд нөлөөлөх нөлөөллийн тооцооллыг хийх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Үг хэлэх гишүүн бол ганцхан гишүүн л байгаа. Үүрийнтуяа гишүүн. Урьд нь нөгөө нэр авчихсан. Дэгээрээ. Энэ дэмжээгүйг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явагдана.

Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье. Санал хураалтад 92 гишүүн оролцоноос 63 гишүүн буюу 68,5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Энэ бас ингэж эдийн засгаа боомилсон ийм саналууд бас гаргаж болохгүй байх. Гишүүд дэмжлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.29 цаг.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл, урлалын сургуулийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт багш, оюутнууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хороодоос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагддаггүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Дэгийн хуулиараа бас нэг ийм болчихсон юм байна лээ. Тийм болохоор энийг бид нар тухайн хэлэлцүүлгийн үед гишүүд бас асуулт асууж, санал хэлэх боломжийг нээхээр сая бид бас хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн хуульд орж байгаа. Энэ үедээ бас манай ажлын хэсэг байгуулагдах байх. Анхаараад, ер нь бас чуулганы хуралдаанаар энэ зарчмын зөрүүтэй саналуудыг тайлбарлаж гишүүд бас ямар учраас яагаад зарчмын зөрүүтэй санал гарсныг нь бас ойлгох, мэдэх боломжийг бүрдүүлэх үүднээс эндээ бас хэлэлцдэг байх нь зөв байх. Тийм болохоор энэ заалтыг ажлын хэсэг бас байгуулах үедээ анхаарна уу. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар:

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас дэмжээгүй санал.

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах, үүнтэй уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны

төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан гишүүн тайлбарлаж үгээ хэлье. Наранбаатар гишүүн. Бас гишүүдийн ойлгох, мэдэх боломжийг бүрдүүлэх ёстой. Ямар учраас яагаад ийм санал гаргасан бэ тайлбарлая.

Н.Наранбаатар: Энийг бол гишүүд маань гар хүрэхгүй байж байгаад босгочихмоор байгаа юм. Яагаад гэхээр энэ дээр бол үзэл баримтлалын хувьд янз бүрийн өөрчлөлт бол байхгүй. Миний гаргасан зарчмын зөрүүтэй саналд зүгээр л техникийн алдааг зассан ийм л санал байгаа юм. Хуулийг зөв хэлбэрт нь оруулах, хуулийн тэр заалтыг зөв хэлбэрт нь оруулах ийм л заалт байгаа юм. Тэгэхээр зэрэг та бүхэн гараа хүрэхгүй байж байгаад ингээд босгож өгөөрэй гэж.

С.Бямбацогт: Төсвийн байнгын хорооны дарга, мэргэжлийн Байнгын хорооны дарга бас тодорхой саналаа тайлбарлаж үг хэллээ. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад. 93 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 9,7 хувийн саналаар энэ дэмжигдсэнгүй.

Энэ санал дэмжигдээгүй тул Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлан буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно. Энэ дагуу.

Хоёр.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас дэмжээгүй санал

Хуулийн төсөл дор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

“1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “мэдэгдэл, түүний нэмэлт өөрчлөлтийг” гэснийг “мэдэгдлийг” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Төсвийн байнгын хорооны дарга саналаа тайлбарлаж үг хэлье.

Н.Наранбаатар: Энэ бас гараа хүрэхгүй байж байгаад босгох юм байгаа юм. Цэг, таслалын л засвар байгаа. Өөр утга агуулгын засвар байхгүй.

С.Бямбацогт: Байнгын хорооноос дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсон 15 гишүүн буюу 16 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

2.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “7.5 дахь хэсгийн “түүний нэмэлт, өөрчлөлтийг”, “төсвийн тодотголын” гэснийг тус тус хассугай” гэснийг “7.5 дахь хэсгийн “төсөл, төсвийн тодотголын” гэснийг хассугай” гэж өөрчилж, мөн зүйлийн

дугаарыг “2” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар. Төсвийн байнгын хорооны дарга саналаа тайлбарлаж үг хэлнэ үү.

Н.Наранбаатар: Энэ бас найруулгын шинжтэй зарчмын зөрүүтэй санал байгаа юм. Тийм учраас та бүхэн бас гараа хүрэхгүй байж байгаад босгож өгөөрэй.

С.Бямбацогт: Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдааныг дэмжээгүй саналын томъёолол сайн уншсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 15 гишүүн буюу 16 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.37 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Цусны донорын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Бэлэн бус 21 гишүүн байна. Санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүдийг санал хураалтдаа бэлтгэхийг хүсэж байна. Хурууны хээгээ уншуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44.2-т “нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно.” гэж заасан. Санал хураалтыг явуулъя. Гишүүдийн олонх 64-өөр батлагдах ёстой.

1.Цусны донорын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 77 гишүүн буюу 81,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Маш чухал хуулийг санаачилсан Чинбүрэн нарын гишүүд, ажлын хэсгийг ахалж ажилласан манай Баярбаатар гишүүн ахалж ажилласан билүү. Гишүүддээ бас ажлын хэсэгтээ баяр хүргэе. Баясгалан гишүүн, манай Баясгалан гишүүн ажлын хэсгийн ахалж ажилласан. Ганбаатар гишүүн дэмжсэн шүү. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

Дараагийн санал хураалт.

2.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал. Хураалт. Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 79 гишүүн буюу 83,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай Засгийн газар өргөн барьсан. Улсын Их Хурлын гишүүн Уянга гишүүн ажлын хэсэг ахалж ажилласан. ажлын хэсэгт ажилласан гишүүддээ бас нэлээн чухал хууль батлагдсан. Тэгээд энэ гишүүддээ бас талархал илэрхийлье.

Байгаль орчинд нөлөөлөх, тийм ээ, Уянга гишүүн ахалсан.

3.Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 69,5 хувийн саналаар, Бейсен гишүүнийг дэмжсэнд тооцъё. 67 гишүүн боллоо. 67 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг эцэслэн баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгтээ талархал илэрхийлье. Чухал хуулиудыг бид бас шуурхай хугацаанд эцэслэн баталлаа.

10.41 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Очирбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 194 дүгээр захирамжаар “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, дэд ахлагч Н.Наранбаатар нараар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг,

Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, Н.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрэм, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан дээрх тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга барихад эрчим хүчний хэмнэлттэй байх, дулаан алдагдал багатай байх шаардлага тавьдаг асуудал дээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны байр суурь, бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэт олон зорилт, зорилгуудаас хэрэгжилт нь хангалтгүй байдаг талаар дурдаж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Монгол Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээнд уялдуулан жил бүрийн төсвийг батлах, үүнд хагас жил тутам хяналт тавьдаг болгож өөрчлөх саналын талаар Эдийн засгийн яамны байр суурийг сонсож, асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасныг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг ирүүлснийг та бүхэнд танилцуулж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримтлан 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан байна.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ямар байх ёстой, улсын төсвөөс юугаар ялгаатай байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотгол болон дахин инженерчлэлийн үр дүн, сонгуулийн санал тоолох машин ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгууль хэвийн ажиллаж чадах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл төрийн албан хаагчдын цомхотгол, чиг үүргийн давхардалд анхаарах тухай асуудал орон нутагт хүндрээд байгаа тухай болон хэмнэлтийн талаар ямар бодлого барьж ажиллаж төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа улсын төсвийг батлах хариуцлагатай байх, халамжийн бодлогод шинэчлэл хийх, асрамжийн газрууд санхүүжилтээс болж хаагдах асуудал үүссэн талаар болон шаардлагатай бол тухайн харилцааг зохицуулж байгаа дүрэм, журмыг өөрчлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар мал эмнэлгийн дэвшилтэт технологийн үйлдвэр, Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгаа, туршилтын төв байгуулах зорилт, малын вакцин

үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангаж, импортыг орлох зорилтууд Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Тус байнгын хорооны хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулахад Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримтлан тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгасан усны төслүүдийн талаар тодруулж, усны тархалтыг тогтоох зураглалын ажлыг өргөжүүлэх, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх ажлыг хаана хийхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ирэх оны улсын хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын 2026-2030 оны хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлтэй уялдуулах, энэ төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ард иргэдийн, малчин өрхийн амьдралын чанар сайжирч байгаа эсэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд арьс шир зэрэг малын гаралтай бусад түүхий эдийг үнэ цэнтэй болгох талаар хэрхэн анхаарч байгаа талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа томоохон төслүүдийн үр дүн, хэрэгжилтийг тооцож үзсэн эсэх талаар, ялангуяа шинэ хоршоо хөдөлгөөнийг оновчтой хэлбэрээр эрчимжүүлж, ирэх оны хөгжлийн төлөвлөгөө, дунд болон урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцүүлж, өмнөх жилүүдийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарал хандуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүд, зээлийн хүү, хугацаа эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен малын арьс шир, ноос үнэгүйдэх байдлыг анхаарч малын гаралтай түүхий эдийг боловсруулж байсан өмнөх сайн туршлагыг хэрэгжүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Тус Байнгын хорооны хуралдаанаар “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн зүгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Алсын хараа 2050, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай”, Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын

болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн зарчмын зөрүүтэй 62 санал бэлтгэсэн.

Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй 145 санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 дэх хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Нямтайширын Номтойбаяр Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд. Сайд нар танхимдаа суух ёстой шүү. Жилийн хөгжлийн төлөвлөгөө хэлэлцэж байна. Баттөмөрийн Энхбаяр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Цэндийн Сандаг-Очир Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Жуковын Алдаржавхлан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Энхтайвангийн Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Цагаанхүүгийн Идэрбат Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Бадрахын Найдалаа Эрчим хүчний сайд, Энхбаярын Батшугар Эрүүл мэндийн сайд, Содномдаржаагийн Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Шүрэнчулууны Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Энэ албан тушаалтнууд бүгд байгаа биз. Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэнгийн Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бавуужавын Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батмөнхийн. Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга, Батдэмбэрэлийн Эрдэнэтулга Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Буяндэлгэрийн Баттуяа Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Мангалжавын Оюунжаргал

Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын дарга, Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сүхбаатарын Цогтгэрэл Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Төмрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батсуурийн Мөнхбаяр Гадаад харилцааны яамны Бодлогын газрын дэд захирал, Мэлсчойгийн Мэндбаяр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Аж үйлдвэрийн бодлогын газрын дарга, Эрхэмбаярын Гансүх Батлан хамгаалах яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Юрагийн Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Баяраагийн Урьболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Доржийн Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Лувсандонойн Баянзул Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбасүрэнгийн Туяа Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга. Ажлын хэсгийн гишүүд, Засгийн газрын гишүүд чуулганы хуралдаанд оролцох ёстой шүү. Танхимд хүрэлцэн ирье.

Зочин танилцуулна. Түүнээс өмнө ажлын хэсгийн мэдээлэл өгөөдөхье.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн гишүүн үнэн зөв, бодит мэдээллийг бүрэн гүйцэд өгөх үүрэгтэй. Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, гишүүдийн асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно. Чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаан хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж заасан байдаг хуулийг сануулж байна. Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг, Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг та бүхэндээ сануулж байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягийн урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэддээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Жадамбын Энхбаяр гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Нэг дэх хүсэлт хурлын дарга аа, Засгийн газрынхныг уг нь энэ талд бөөнөөр нь суулгачихдаг байсан. Тэмүүжин гишүүний хэлээд байгаа бас Ерөнхий сайд энэ дотроо өөрөө ороод суух ёстой гэдэг энэ саналыг дэмжиж өгөөд сайд нарыг бүгдийг нь нэг дор суулгачихвал өөрсдөө хоорондоо юмаа яриад, нааш цаашаа гүйлдээд байхгүй, харахад амар, асуултад хариулахад ч амар ийм болох гээд байна. Энийг нэг шийдвэрлэж өгөөч. Энэ дүрэм, журмаар зохицуулагдаагүй. Хурлын дэд дарга өөрсдөө суудлынхаа хуваарилалтаа батлаад л болчих юм байгаа юм.

2 дахь нь болохоор би Энхбаяр сайдаас төсвийн бодлого болон хөгжлийн бодлого өөрөө хоорондоо юугаараа ялгаатай юм бэ гэдэг ийм асуултыг асуусан. Тэгээд надад бол их л хэгжүүрхэж, дургүйцэж хариулж, бид 2 социал дээр нэлээд бид 2-ын мэтгэлцээн явсан. Одоо бол яг миний энэ асуулт зөв байсан юм байна гэдгийг ойлгосон болов уу гэж би бодож байгаа юм. Яагаад гэхээр Эдийн засгийн байнгын хороо, бусад Байнгын хороод дээрээ энэ гишүүдийн оруулж байгаа санал нь өөрөө яагаад буруу юм бэ, яагаад энэ саналыг оруулж болохгүй юм бэ гэж маш их эсэргүүцэж, уурсаж тайлбар хийж байна лээ л дээ. Зөв шүү дээ. Би хэлсэн шүү дээ. Жилийн бодлого чинь өөрөө төсвөөсөө юугаараа ялгаатай юм бэ. Одоо гишүүд зарчмын зөрүүтэй саналуудыг гаргаад, тэгээд түүнийгээ санал хураахыг нь хураагаад, унагаахыг нь унагаагаад, унасан нь эргэж эндээ босоод, тэгээд замбараагүй юм бол болдог байхгүй юу.

2025 оны жилийн төлөвлөгөөний биелэлт нь 20 хувьтай, 2026 оных ч гэсэн тэр хэмжээгээрээ л байна. Яагаад вэ гэхээр төсөвтэйгөө андуураад маш олон өөрийнхөө тойргийн хөрөнгө оруулалтуудыг оруулдаг байхгүй юу даа. Угаасаа ингэж яваад яваад байна. Тэгээд тэр нь намар батлагдаж байгаа төсөвтэйгөө огт уялдахгүй. Ажлын хэсэг дээр 200 гаруй саналыг хураасан. 50 гаруй санал нь яах вэ найруулгынх юм байна. Тэгээд ажлын хэсэгт байсан гишүүд нь минийх, чинийх, тэр минь, энэ минь гэж байгаад гаргасан. 150 санал унасан. Яагаад гэвэл Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Төсвийн ТЭЗҮ гээд шалтгаанаараа хуульд нийцэхгүй байна гээд унасан байхгүй юу. Эргээд Эдийн засгийн байнгын хороон дээр яасан бэ гэхээр бас мөн адилхан дэмжээгүй. Энэ чинь 100, 200-аад саналыг тэвчээртэй тэгээд саналаа өгөөд суух гишүүд ч гэсэн цөөхөн байлаа.

Эдийн засгийн байнгын хороо дээр юу болсон бэ гэхээр Байнгын хорооны дарга нь саналуудаа уншлаа дэмжээгүй, дэмжээгүй гээд л саналууд нь унасан. Одоо юу болох вэ гэхээр бас дахиад энд тэвчээртэй байх хүмүүс байх уу, байхгүй юу. Кнопоо битгий дараарай, босгоод өгөөрэй гэсэн орилолдоо бас дахиад болно шүү дээ. Болно. Тойргийнхоо асуудлыг хэн ч оруулахыг хүснэ шүү дээ. Тэгээд тэгээд

ях вэ гэхээр маш олон саналууд босно. Эргээд асуудлууд нь орно. Тэгээд энэ чинь өөрөө эргээд хууль зөрчиж байгаа асуудлууд нь ч гэсэн орчих байхгүй юу даа. Бид нар тэгээд айлын хүүхдийг хэнийг нь гомдоох вэ дээ гээд нэгнийхээ оруулж байгаа саналыг дэмжээд явж байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь зарчмынхаа хувьд маш буруу. 200-аад санал хурааж байхаар Эдийн засгийн байнгын хорооны дарга нь гүйцээн боловсруулах чиглэлээ аваад, тэгээд энэ саналуудаа хуульд нийцүүлээд орж болохгүй асуудлуудаа зүгээр хэний ч санал байсан оруулмааргүй байгаа байхгүй юу.

Тэгээд энэ жилийн төлөвлөгөө гэдэг энэ асуудлаа больцгооё. Бид нарт 2050 гэж байна. 2030 гэж байна. 5 жилийнх байна. 4 жилийнх байна. Бүх төлөвлөгөөнүүд чинь байна шүү дээ. Тэгээд жил болгон 1 жилийн хөгжлийн төлөвлөгөө гэж тусдаа дахиж ийм асуудал гаргаад, тэгээд тэр нь биелдэггүй ийм төрийн албан хаагчдын цагийг үрсэн, өөрсдийгөө хуурсан ийм юм оруулж болохгүй байхгүй юу. Засгийн газар өөрөө оруулж ирж байгаа асуудлууд нь Дарханы эмнэлэг, Баянхонгор, Архангай, Баянхонгор, Шинэжинст зам гээд өөрсдөө ингээд оруулахаар чинь би ч гэсэн Алтайг оруулмаар байна шүү дээ. Адилхан шүү дээ. Тэгэхээр энэ төсвөөсөө юугаараа ялгаатай юм.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүний бас ярьж байгаа асуудал анхаарах ёстой. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль баталсан. Үндсэн хуульдаа бид нар Монгол төрийн бодлого тогтвортой байна. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь урт, дунд, богино хугацаандаа харилцан уялдаатай байна гэж 2019 онд Үндсэн хуульдаа тусгасан. Үүний дагуу 2020 онд миний бие Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг санаачилж, Их Хурлаар батлуулсан. Алсын хараа 2050 гээд бас урт хугацааны бодлогын бичиг баримтаа баталсан. Дунд хугацааны зорилтот 8 хөтөлбөр батлах ёстой батлаагүй байгаа. 5 жилийн үндсэн чиглэлтэй болсон. Засгийн газрын үйл ажиллагаа нь 4 жилийн хөтөлбөртэй болсон. Төлөвлөгөөндөө төлөвлөлтөд суурилж төсөвлөдөг байх энэ зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн.

1990 оноос хойш 2020 он хүртэл үндсэндээ төлөвлөгөө дээр, төлөвлөлт дээр суурилж төсөв зардлаа хуваарилдаг ийм тогтолцоогүй явж ирсэн. Энэ тогтолцоонд шилжсэнээс хойш жилийн төлөвлөгөө бол чухал ач холбогдолтой болсон. Тийм учраас 200-аад санал гарсан байх. Төлөвлөгөө дээрээ суурилж, төсвөө баталдаг байя гэж. Тэгэхгүй бол ямар ч бодлогогүй, төлөвлөгөөгүй төсөв орж ирдэг. Тэр нь үзэмжээрээ Засгийн газар болон гишүүд ханддаг. Үүнийг л Улсын Их Хурал бас урт, дунд, богино хугацаанд бодлого, төлөвлөлт нь нэгдсэн байя, ойлгомжтой байя, тодорхой байя, төлөвлөгөөгөө баталж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд төсвөө баталдаг байя гэсэн ийм л хууль хэрэгжиж байгаа. Харин энэ 203 санал маань үнэхээр Төсвийн хүрээний мэдэгдэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, энэ бүх юмтайгаа уялдсан уу, уялдаагүй юу. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиа зөрчсөн үү, зөрчөөгүй юу. Хэрвээ зөрчсөн энэ зөрчсөн санал хураалтууд яагаад Байнгын хороон дээр явагдсан юм. Энийг Байнгын хороо маань бас нэгтгээд заавал 203 санал хураалгах шаардлагатай байна уу, үгүй юу. Сэддорж дарга, Энхбаяр сайд бас шийдэл гаргаж өгөөч. Одоо ингээд гишүүд танхимд ихэнх нь гараад явчихсан. Ирцэд 96 гишүүн орчихсон. Тэгээд Байнгын хорооны дэмжээгүй саналууд ихэнх нь байна. Энэ дэмжээгүй саналууд чинь тэгээд гарч явсан гишүүдийнхээр дэмжигдээд явчихна. Баахан хууль зөрчсөн 200 санал хураагдаад,

тэгээд ингээд ийм асуудал болох гээд байна шүү дээ. Ийм л зарчимгүй ажилламааргүй л байна л даа.

Тэгэхээр Байнгын хороон дээр мэргэжлийн Байнгын хороод яагаад хэлэлцээд байгаа юм. Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо энэ дээрээ жоохон ажил хэрэгч ханддаг баймаар байна шүү дээ. Дэмжээгүй, үнэхээр зарчмын зөрүүтэй саналууд нь хууль зөрчсөн бол Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцэхгүй бол хураалгахгүй байх ёстой. Хураах юм бол энийг анхаарах ёстой. Энэ дээр 2 Байнгын хороо ямар боломж байна. Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Эдийн засаг, хөгжлийн сайд тодорхой хариулт өгөөч. Энхбаяр сайд. Энэ болох юм уу, болохгүй юм уу энэ олон саналууд чинь. Яах вэ. Одоо үндсэндээ ийм асуудал үүсэж байна. Дэмжээгүй саналыг дэмжье гээд босчих гээд байна шүү дээ бүх саналууд чинь. Тэгээд ямар үр дагавартай вэ гэдгийг та бас тайлбарлаж өгөөч.

Ж.Энхбаяр: Ажлын хэсэг, Байнгын хороо дээр 206 санал 2,9 их наяд төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийг зарцуулах ийм санал гаргаж, хураагдсан. Шулуухан хэлэхэд энэ Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг Үндсэн хуулийн заалтыг шууд бүдүүлгээр зөрчсөн. Дараа нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг байна гэсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг зөрчсөн. Дээрээс нь санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон. Хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх гэдэг суурь шаардлагыг зөрчсөн ийм саналууд хураагдсан. Хууль сануулсан гишүүдэд. Харамсалтай нь манай Их Хурлын зарим гишүүд Улсын Их Хурлын бүрэн эрх хуулиас дээгүүр үйлчилдэг гэж тайлбар өгч байна лээ.

Улсын Их Хурлын бүрэн эрх байгаа. Их Хурлын даргын үүрэг байгаа. Та улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлах Их Хурлын бөгөөд даргын үүрэг байгаа. Энэ хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шаардлагыг хангаагүй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахгүй байх ийм хуультай. Одоо хуулиа биелүүлж, жоохон төсөв, санхүүгийн сахилга баттай болцгооё. Үнэхээр бүдүүлэг, байж боломгүй юм болж байна шүү дээ. Орж ирээд л нэг нь 300 тэрбум, 1 нь 500 тэрбум, 1 нь 40 тэрбум, 50 тэрбум гэж нэмээд, яагаад Улсын хөгжлийн бодлогын өмнө төсвийн хүрээ баталдаг юм. Төсвийн хүрээнд бид нарт 2,2 их наядын хөрөнгө оруулалтын орон зай байгаа. Одоо бидэнд хүлээгдэж байгаа 3,6 их наядын шилжих хөрөнгө оруулалтууд явагдаж байна. Энийгээ л бид нар хангахын төлөө явна. 2027 онд 1 ч шинэ хөрөнгө оруулалт хийх боломж, орон зай байхгүй төсөвт. Яагаад гэвэл бид нар урсгал зардлаа хэт их нэмсэн. Цалин тэтгэврийн хэт нэмэлт өөрөө төсвийн хөрөнгө оруулалтын боломжийг хязгаарлалчихсан. Тэгэхээр ийм байдлыг үүсгэж, ийм хууль зөрчиж, ялангуяа Үндсэн хууль зөрчиж, энэ чинь өнгөрсөн 30 жилийн парламентын түүх болоод хэлэлцүүлэг болоод улс төрийн намууд, 5 нам энийг хүлээн зөвшөөрөөд, Үндсэн хуулиа өөрчилсөн байхгүй юу. Бүр Үндсэн хуульдаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой байлгая. Улс төрийн намуудаас ангид байлгая. Аль нам

сонгуульд ялахаас үл хамаараад батлагдсан бодлогоо урт хугацаанд тууштай аль аль нь хэрэгжүүлээд явъя гэдэг л ийм үндэсний томоохон зөвшил Үндсэн хуулийн өөрчлөлт шүү дээ.

Мэргэжлийн байгууллага, судалгааны институцүүд бүтэн бэлдээд жилийн хугацаанд боловсруулалт хийгээд, ажиллаад ороод ирсэн зүйлийг 1 гишүүн орж ирээд өөрчилж байгаа байдал, эх үүсвэргүй, тодорхойгүй ямар нэгэн хуулийн шаардлага хангаагүй, техник-эдийн засгийн үндэслэлгүй, дур зоргын, орон нутгийн хэмжээнд шийдэх асуудлуудыг сүүлдээ бүр сумын төвийн доторх инженерийн байгууламж, сумын төвийн эмнэлгийн тоног төхөөрөмж энэ чинь арай хэтэрч байна шүү дээ. Их Хурлын гишүүд ээ, би хууль сануулах үүрэгтэй. Ийм хуулийн зөрчлийг Их Хурал, та бүгд өөрсдөө хийчхээд, яаж төрийн байгууллагуудаас, Засгийн газраас хууль нэхэх юм. Яаж энэ бодлогын хэрэгжилтийг шахах юм. Яаж энэ хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг шахах юм бэ. Ноднин бас ахиад 151 .../минут дуусав/

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүү, Нацагдоржийн Батсүмбэрэл нарын урилгаар Чингэлтэй дүүргийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа Чингэлтэй дүүргийн иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Батсүмбэрэл гишүүн, Баатархүү гишүүд хуралдаа идэвхтэй оролцдог бас хариуцлагатай гишүүд шүү гэдгийг бас сонгогчид нь бас дамжуулж уламжилъя.

Их Хурлын гишүүд бас сая Энхбаяр гишүүний хэлж байгаа зөв. Энхбаяр сайдын. Бас хаа хамаагүй санал гаргаж болохгүй, хуультай шүү дээ. Тэгээд Байнгын хороон дээр яагаад хураалгасан юм бэ. Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, дарга нар маань юу хийж байсан бэ. Тэр Байнгын хороодын зөвлөхүүд юугаа хийдэг вэ. Хууль зөрчсөн санал хураалтыг хураалгаж болохгүй шүү дээ. Тэгээд 203 санал хураагдчихсан. Одоо ингээд гишүүд нь дэмжээгүй саналыг дэмжихгүй гээд нөгөө хуулийн цоорхойгоор чинь бүгд дэмжигдэнэ. Улс орны төсөв, санхүүгийн ачаалал даахгүй ийм л юм болох гээд байна шүү дээ. Наранбаатар дарга байнгын хорооны дарга, Сэддорж дарга та 2 тайлбараа хий. Хариуцлагатай байх ёстой шүү дээ. Ямар гаргалгаа байгаа юм. Ажлын хэсэг Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Хөгжлийн төлөвлөгөө дээр ирсэн 206 санал ирсэн байх. Төсвийн байнгын хороон дээр орж хэлэлцэгдэхгүй. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэгдсэн. Ажлын хэсэг бол ажиллаад яг хуулийн шаардлага хангасан, тэр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан 64 байх, 53 болж байсан уу ялгаад, тэгээд шаардлага хангаагүй 160 гаруй байсан. Ингээд 2 ялгаад Эдийн засгийн байнгын хороо дээр оруулж танилцуулсан. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо дээр зарим нь дэмжигдээд, зарим нь дэмжигдээгүй асуудлууд гарсан.

Зүгээр ажлын хэсгийнхний хувьд юу гэж бодож байна вэ гэхээр Эдийн засгийн байнгын хороо руу гүйцээн боловсруулах чиглэл аваад, тэгээд тэн дээрээ заавал 206 байх шаардлага байхгүй эргэж үзээд, тэртээ тэргүй хууль зөрчсөн байвал тэд нарыг үлдээгээд тэгээд тэр шаардлага хангасан 50 хэд байдаг юм уур, 40 хэд байдаг юм уу тэд нарыгаа аваад орж ирээд хураалгасан нь зөв болов уу гэсэн ийм л саналтай байна.

С.Бямбацогт: Дуламын Бум-Очир гишүүн асуултаа асууя. Тамгын газар, Эдийн засгийн байнгын хороо гаргалгаа бэлд. Энэ дээр ямар шийдэл байх юм. Мягмарцэрэн зөвлөх ажлаа сайн хий та. Хуралдаан даргалагчдаа та мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ёстой. Дуламын Бум-Очир гишүүн асуултаа асууя. Үгээ хэлье.

Д.Бум-Очир: Би энэ жилээс жилд цөөрөөд, үгүй болоод, алга болоо, эрсдэлд ороод устаад байдаг нэгэн чухал зүйлийн тухай асуулт асуух гэж байгаа юм. Тэр юу вэ гэхээр энэ соёлын өвийн тухай асуудал юм. 1921 онд биет болоод биет бус соёлын өвийн өвлөн уламжлагч 11189 байжээ. 2025 оны байдлаар 10448 буюу 741 хүнээр хорогджээ. Жилд дунджаар 148 хүнээр энэ салбар маань хорогдож байдаг. Өвлөн уламжлагчид маань. Жишээ нь, энэ жилийн байдлаар хамгийн өндөр настай өвлөн уламжлагчид гэвэл 95 настай, 96 настай 2 ахмад буурай байх жишээтэй. Ингээд нийт статистикийг нь харах юм бол нийт өвлөн уламжлагчдын 51-ээс дээш насных нь 54 хувийг нь эзэлж байгаа юм. 65-аас дээш насныхан нь бол 27 хувийг нь, 51-64 насных нь 27 хувийг нь. Ингээд нийлээд 54 хувийг нь бол үндсэндээ энэ 10448 хүний 54 хувийг нь 51-ээс дээш насныхан эзэлж байх ийм тоо байгаа. 19-35 насны залуучууд бол дөнгөж 14 хувийг нь эзэлж байгаа. Өөрөөр хэлбэл цаг хугацаа өнгөрөх тусам энэ 10448 хүн чинь бол цөөрөөд үгүй болох нь.

Миний асуух гэж байгаа гол зүйл бол юу вэ гэхээр яг энэ өвлөн уламжлагчид цөөрч байгаа, ялангуяа тухайн өвлөн уламжлагчидтай монголчуудын үнэт оюуны биет болоод биет бус соёлын өвийн зүйлс хамт үгүй болчихдог. Жишээ нь, одоо байгаа 95-тай, 96-тай энэ 2 хөгшний уртын дуучид байлаа л даа. Энэ мэдлэг чадварыг нь хэчнээн хүн өвлөж авч байдаг юм бэ. Ингээд цааш нь насыг нь дурдаад яриад байвал яриад байж болохоор байгаад байгаа юм. Энэ тал дээр соёлын салбарынхан маань анхааран ажиллаач. Энэ ерөөсөө цаг хугацаа хүлээдэггүй, бид нарыг хүлээдэггүй, мөнгө хүлээдэггүй ийм зүйл. 1 настай хүн, 1 өвлөн уламжлагч өндөр настан нас барахад түүнтэй хамт бидний хэн нь ч өвлөж авч чадаагүй мэдлэг, мэдээлэл, ёс заншил, элдэв зүйл устаж байдаг. Бид нар магадгүй түүнийгээ хэзээ ч эргүүлэн сэргээж чадахгүй байж магадгүй.

Яг энэ хөгжлийн төлөвлөгөө дээр бол нүүдлийн соёл иргэншлийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ гээд тэр дотроо соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн тоог нэмэгдүүлнэ гээд тэр дотроо нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль зохион байгуулах гэххээд энэ дотроо 3 ангилчихсан байгаа юм л даа зардлаа. Үзэгч оролцогчид гэж нэг хэсэг байгаа юм. Оролцогч, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид гэж байгаа юм. 3 дахь нь шавь сургалтад хамрагдсан өвлөн уламжлагч гэдэг энэ миний яриад байгаа зүйл байгаад байгаа юм. Тэгээд миний тодруулахыг хүсэж байгаа зүйл бол жишээ нь энэ дээр бол шавь сургалтад хамрагдсан өвлөн уламжлагч гээд суурь түвшин 100, зорилтот түвшин 150 гэхихсэн байгаа юм л даа. Тэгээд би энийг тодруулмаар байна л даа. Яг суурь түвшин нь 100 гэдэг нь 100 өвлөн уламжлагчийг хэлээд байгаа юм уу, 150 гэхээр 150 хүнд хүргэнэ гэсэн үг юм уу. Ард нь ингээд үндсэндээ яг энэ жилийн тухайлсан жилд шаардагдах санхүүжилт гээд 2 тэрбум 400 сая гэхихсэн байгаа юм. Тэгэхээр яг миний анхаараад яриад байгаа энэ 10448 хүн, түүний өвлөн уламжлагчдад энэ 2 тэрбум 400 сая төгрөгийн хэд нь очиж байгаа юм бэ гэдгийг тодруулмаар байна.

Тэгэхдээ миний ажиглаж байгаагаар бол чиглэлийнх нь салбарын хүмүүс байхгүй харагдаад байх юм. Хэрвээ байгаа бол хариулж өгнө үү. Хэрвээ байхгүй

бол энэ асуудлыг Соёлын яам анхаарч, мөнгө төсөв тавьж, энэ соёлын өвөө хадгалж хамгаалж, өвлүүлэх асуудал дээр ажиллаж өгөөч гэж хүсмээр байна.

С.Бямбацогт: Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас л асуугаад байна. Сайд нарыг би уг нь танхимд дуудсан юм сан. Хариултаа өгмөөр байх юм. Шадар сайд Доржханд хариулъя.

Т.Доржханд: Зөв зөв. Би Бум-Очир гишүүний саналыг нь бол дэмжиж байна. Тэгээд яг тодорхой хариултыг Соёлын яамны Төрийн нарийн байх шиг байна. Өгчхөөрэй. Би зүгээр 1 зүйлийг хэлэх гэсэн юм. Түрүүн нөгөө Энхбаяр Шадар сайдын хэлсэн зүйл бол яг бодитой юм. 2020-2024 оны хооронд тухайн үеийн парламент 52 их наяд төгрөгийн ийм төсөл, арга хэмжээг тухайн үед баталж байсан. Гэтэл төсвийнх нь эх үүсвэр 12 их наяд төгрөг байсан. Ингээд боломжит эх үүсвэрээсээ 4 дахин эх үүсвэрийг баталсан. Дараа нь үр дагавар нь юу болсон бэ гэхээр Засгийн газрын үйл ажиллагааны биелэлт гэдгийг үнэлэхэд дандаа 25 хувьтай л гарсан. Мөнгө, санхүүжилт нь байж байж ажил явдаг. Тэгээд байхгүй зүйл дээр ингээд маш их хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ тусгасны үр дүнд маш их улс төржилт болдог. Тэгээд орон нутагт маш их хүлээлт үүсдэг. Гэтэл бодит байдал нь бол парламент нь ч гишүүд нь ч худлаа амлалаа, Засгийн газар нь ч ажил хийж чадсангүй гэдэг ийм байдлаар иргэдэд ойлгогдож ирсэн. Энийг засахын тулд тухайн үеийн парламентад суудалтай намууд яриад өнөөдөр байгаа энэ 5 намын бас удирдлагууд энийгээ өөрчилье гээд, тэгээд төлөвлөлт дээрээ анхааръя, хязгаарлалтаа хийдэг байя, бодитой төсөвлөдөг байя, чадахгүй зүйлээ иргэддээ хэлдэг байя гээд ингээд тохирч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.

Тэгээд тийм болохоор би Их Хурлын даргад мөн Төсвийн байнгын хорооны дарга, Эдийн засгийн бодлогын байнгын хорооны дарга эд нарт хэлэхэд энэ 203 санал одоо хураагдах юм бол яг энэ үлгэрээ давтана. Тэгээд сонгууль ойртож байгаа. Маш их улс төрийн бужигнаан болно. Тийм болохоор бодитой эдийн засгийн үнэлгээ дээрээ үндэслээд, энэ Байнгын хороод маань эргэж энийгээ дахиж санал хураалтаа явуулаад, гүйцээн боловсруулах чиглэлийг нь өгөөд явах нь зүйтэй гэсэн ийм байр суурийг бас дахиж илэрхийлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Сэддорж гишүүн, Эдийн засгийн байнгын хороо нэмж хариулъя.

Р.Сэддорж: Гишүүдэд бол Байнгын хорооны хурал дээр хууль сануулсан. Протокол дээр байгаа. Болохгүй байна гэдгийг бол яг холбогдох яамны сайд Энхбаяр сайд гишүүдэд удаа дараа хэлсэн. гишүүд бол 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэлд орсон ажлууд байгаа. Гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргах эрхтэй гэдгээрээ саналаа хураалгая. Тэгээд дэмжих, дэмжихгүйг бол Байнгын хорооны гишүүд мэдэг. Саналаа бол гаргах эрхтэй учраас саналаа хураалгая гэсэн. Тэгээд үүний дагуу л хураалгасан.

С.Бямбацогт: Тэр хууль зөрчсөн, бодлогын бичиг баримтуудтай зөрчилдсөн саналуудыг хураалгаж болохгүй л дээ. Энэ дээр Тамгын газар гаргалгаа бэлдэж байгаарай. Ямар шийдэл байж болох вэ. Соёл, спорт, аялал жуулчлалын яам. Алдаржавхлан сайд орж ирээгүй байна уу. Төрийн нарийн бичгийн дарга нь байна уу. Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас хүн алга. Байгаа юм уу. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофонд хариулъя.

Б.Урьболд: Соёл, спорт, аялал жуулчлалын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Урьболд байна. Бум-Очир гишүүний асуултад хариульъя.

2025 оны байдлаар 362 соёлын биет бус өвийн төрөл зүйлийг өвлөн эзэмшигч нийтдээ 1530 өвлөн уламжлагч соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байгаа. Үүнээс бол 54,2 хувь нь буюу 5717 өвлөн уламжлагч нь 50-аас дээш насныхан байгаа. Үүнээс бол 3145 хүн буюу 29 хувь нь бол тэтгэврийн насныхан. 2025 оны байдлаар бол 160 өвлөн уламжлагч нас барсан ийм тооцоо мэдээлэлтэй байна. Үндэсний өвийн жагсаалтад бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагчийн 99,5 хувь буюу 98 нь 55-аас дээш насны хүмүүс байгаа. Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас бол .../минут дуусав/

С.Бямбацогт: Хариултаа гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

Б.Урьболд: Засгийн газрын тогтоолоор батлагдсан соёлын биет бус өвийн үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулсан түгээн дэлгэрүүлэх онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журмын дагуу бол сонгон шалгаруулалт зохион байгуулж өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгож явдаг. Мөн өвлөн уламжлагчдын шавь сургалтыг зохион байгуулдаг. 2025 оны улсын хэмжээнд бол биет бус өвийг өвлүүлэн уламжлагч 158 шавь сургалтыг 132 удаагийн уралдаан наадмыг өвлөн уламжлуулагчдыг түшиглэн зохион байгуулсан. Энэ хүрээнд бол мөн таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах гэсэн ийм арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг.

2027 оны жилийн төлөвлөгөөнд бол Монгол өв ба дэлхий дахин төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа. Үүнд бол олон улсад соёлын өвийн үзэсгэлэн гаргах мөн дэлхийд тархсан Монгол өв ном бүтээх ийм 2 арга хэмжээг соёлын өвтэй холбогдсон ийм арга хэмжээ.../минут дуусав/

С.Бямбацогт: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя.

Л.Мөнхбаясгалан: Говийн усны төслийн талаар л дахиад ярина даа. Анх удаа бид нар чинь 126-тай парламент улсынхаа хөгжлийн төлөвлөгөөг хэлэлцэхдээ Засгийн газар нь бүрэн бүлээн огцрох асуудалгүйгээр хэлэлцэж байна шүү дээ анх удаа. Тэгээд тайван сайхан байгаа байх. Би Ерөнхий сайдыг миний энэ үгийг анхаараасай гэж бодож байгаа юм. Доржханд сайд аа, та анхаарлыг нь сарниулаад байна. Та түр байж байгаач тэгэх үү. Энэ говийн бүсийн хамгийн тэргүүлэх асуудал Орхон-Онги, Хэрлэн-Тооно усны мега төсөл гэж уг нь өмнөх Засгийн газар, тэрний өмнөх Засгийн газар баталсан байдаг л даа. Тэгээд би энэ дээр 2027 оны Монгол Улсын хөгжүүлэх төлөвлөгөө дээр дахиад л нөгөө Онги, Цагаан бургастай дээр мөнгө байхгүй. Өнгөрсөн жилийн Засгийн газрын таны дэмжиж өгсөн 9 тэрбум төгрөгөөр бол сая тендерээ амжилттай зарлаад, одоо компаниуд нь шалгараад, ажил нь бол хийгдэнэ.

Тэгэхээр 2027 онд дахиад мөнгөгүй байгаа байхгүй юу. Тэгээд ингээд мөнгө тавихгүй болохоор чинь л мөнгө оруулах гээд л зарчмын зөрүүтэй санал гаргаад ирж байгаа шүү дээ. Яагаад гэхээр Монгол Улс жилдээ 682 сая м3 ус хэрэглэдгийн 113 сая м3-ийг нь говийн бүсэд хэрэглэдэг юм. Энэнээсээ Өмнөговь аймаг 63,2 сая м3-ийг нь хэрэглэдэг юм. Яагаад гэхээр тэнд нөгөө боловсруулах үйлдвэрүүд чинь байгаа юм. Уул уурхай чинь байгаа юм. Одоо газрын тосны Алтанширээгийн

үйлдвэрийг сая бид нар Гадаад зээллэгийн хуулиар батлаад өгөөд, хурданд нь хийчихлээ. Энэ үйлдвэр ашиглалтад орвол дахиад л ус хэрэгтэй. Тэгээд улсын төсвийн 80 хувийг оруулж байгаа энэ бүсдээ усаа хүргэх гол төсөл дээрээ мөнгө хасаад байгаа юм Ерөнхий сайд аа, Энхбаяр сайд аа. Тэгэхээр энийг та бүхэн бодож өгөөч ээ. Бид нар усгүйгээр яаж үйлдвэрлэл явуулах юм, яаж орлогоо олох юм, яаж баяжуулах үйлдвэрүүд ажиллах юм.

Сая 1 харамсалтай мэдээ тойргоосоо яваад сонсоод ирлээ. Цогтцэций сум дээр Ерөнхийлөгчийн тэрбум мод хөтөлбөр цаашаа явах боломжгүй болсон. Мод тарих усгүй болсон. Тэгээд нөгөө үйлдвэрүүд нь яаж явах юм бол. Тэгэхээр та бүхэн энэ хөгжлийн төлөвлөгөө дээрээ анхаараад, бид хэдийг мөнгө хаанаас олох юм бол гээд харааных нь бядыг шалгаад, хэр ажиллагаатай гишүүн юм гээд тэрийг нь шалгаад л ингээд байдгаа болиод, усныхаа төслийг 1 номерт тавиад өгөөд явуулдаг байгаач. Энийг яагаад мөнгө тавьдаггүй юм бэ. Энэ хөтөлбөрөө цааш нь үргэлжлүүлэх хэвээрээ юу. Энэ асуудлыг Ерөнхий сайд, Энхбаяр сайд 2-оос асууя даа. Байгаль орчны сайд бол дэмжээд өгнө тийм ээ.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Мөнхбаясгалан гишүүний энэ санал, санаачилгыг бол би анхнаас нь дэмждэг. Тийм ч учраас өнгөрсөн жил бол ТЭЗҮ боловсруулах зардлын санхүүжилтийн асуудлыг бид хамтдаа шийдвэрлэсэн. Орхон-Онги төслийн ТЭЗҮ хийх сонгон шалгаруулалт явж байна. Тэгээд би сүүлийн мэдээлэл аваагүй байна. Гэхдээ явж байгаа. Тэгэхээр бид ТЭЗҮ-ээ боловсруулж дууссаны дараа мэдээж тодорхой төсөв мөнгө бол тавих ёстой. Гэхдээ энийг улсын төсвөөр дан санхүүжүүлэх нь зохимжгүй. Гэхдээ Орхон-Онгийн энэ ТЭЗҮ хэрвээ дуусаад, боловсруулагдчих юм хөрөнгө оруулагч нарт бид нар танилцуулах бололцоо бүрдэнэ. Ялангуяа Коп-17-гийн үеэр бол Орхон-Онги ч тэр, Хэрлэн-Тооно ч тэр аль аль нь ТЭЗҮ-г нь хөрөнгө оруулагч нарт танилцуулаад, энэ бол Коп-17-ийн гол бодлогын мессеж болно гэж тэргүүн ээлжийн ажил хэмээн би бол үзэж байгаа юм.

Тийм учраас энэ Орхон-Онгийн төслийг боловсруулах ажлыг нь хурдлуулъя. Одоо ингээд компани шалгарчихсан байгаа бол тэр ажлыг нь шахаж шаардаж дуусгая. Хэрлэн-Тоононы хувьд бол 2026 оны 3 дугаар сард ТЭЗҮ нь дууссан гэж би бол мэдээлэлтэй байна. Ингээд мөн энэ Хэрлэн-Тоононы ТЭЗҮ дууссан учраас хөрөнгө оруулагч нарт бас танилцуулах арга хэмжээнүүдийг авна гэж зорьж байгаа.

Тэгээд бүтэн санхүүжилтийг улсын төсөв дээр шууд тавина гэж мэдээж тийм бололцоо байхгүй. Гэхдээ энэ 2 ТЭЗҮ хоёулаа ингээд дуусаж байгаа тохиолдолд бид нар ирэх оны төсөв хэлэлцэх үеэр тодорхой санхүүжилтийг нь шийдээд, гол нь хөрөнгө оруулагч нарт ямар хэмжээний хувь хэмжээг оруулах бололцоог бүрдүүлэх вэ гэдэг дээр нь ажиллах ёстой. Тэгээд одоогоор мэдээж энэ байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болоод бусад асуудлууд дээр ялангуяа энэ нөгөө ТЭЗҮ-г нь олон улсын хөрөнгө оруулагч нарт танилцуулах учраас Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хууль бас хүлээгдэж байна. Энэ Бизнесийн эрх чөлөө, Эдийн засгийн эрх чөлөөний анхдагч хуулийн төслийг дагасан 115 хууль дээр бол бид нар энэ байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, олон хуулиуд дээр тэр олон улсын аудит, олон улсын үнэлгээ оруулах, олон улсад хөрөнгө оруулалт татахад танилцуулахад зориулаад бид нар стандартад нийцсэн, олон улсын шаардлагад нийцсэн нөлөөллийн үнэлгээ болоод бусад арга хэмжээнүүдийг авахаар төлөвлөж байгаа.

Тэгээд Орхон-Онги, Хэрлэн-Тооно аль алин дээр нь бол Ерөнхий сайдын хувьд гол анхаарлаа хандуулна. Тэгээд үүнийг бол тантай хамтдаа шийдвэрлэхэд бэлэн байна.

С.Бямбацогт: Энхбаяр сайд нэмж хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд.

Ж.Энхбаяр: Усны төсөл, үүн дотор ус дахин ашиглах, ус боловсруулах төсөл, арга хэмжээ онцгой чухал. Засгийн газар тэргүүлэх бодлогын 1 байгаа. Мэдээлэл өгөхөд Хэрлэн-Тооно энэ ТЭЗҮ хийгдээд дууссан. 4 ийм трасс гарчихсан байгаа. Одоо энэ 4 трассаас хамгийн үр ашигтайг нь сонголт хийнэ. Ингээд үндсэндээ ажил нь цаанаа гарч байгаа гэсэн үг. Нөгөө талаас Мянганы сорилтын сангаар та бүхэн мэдэж байгаа Улаанбаатар хотыг 60, 70 жил усны эх үүсвэрээр хангах, ус цэвэршүүлэх, саарал ус ашиглах гээд томоохон төсөл амжилттай хэрэгжээд дууссан. Тэгэхээр Засгийн газрын тэргүүнд энэ усны бодлого, төсөл арга хэмжээ байгаа. 2027 оны хөгжлийн хөтөлбөрт орсон байгаа. Эрэмбэлэгдээд жилийн төлөвлөгөөний төсөлд тусаад явж байгаа ийм хөтөлбөр байгаа шүү.

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүн хариулъя.

Л.Мөнхбаясгалан: Энхбаяр сайд аа тэр Хэрлэн-Тооно 4 трасстай байгаа. Энэ чинь бол Хэрлэн-Тооно төсөл чинь бол уул уурхайн төсөл биш шүү дээ. Тэгэхээр иргэний төсөл гэдэг зарчмаа баримтлаад, иргэнд ашигтайгаар трасса батлах ёстой шүү гэдгийг хэлье. Тэгээд яг тэр трасса батлах дээр бол говийн бүсийн гишүүдтэй тэгээд ер нь нэлээн юу болох байх. Бид нар бас явцыг нь сонссон юм. Орхон-Онги чинь бол амжилттай явж байгаа шүү. Одоо тэгээд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг ажиллаж байгаа. Дандаа төсөв дээр үүрүүлэхгүй. Тэгэхдээ энэ чинь 2027 он дээр 30 тэрбум байхгүй юу. 1,7 их наядыг өгч байгаа аймгийн усны төсөв 30 тэрбумыг л гуйж байгаа шүү дээ. Тэгэхдээ бол дандаа төсөв дээр үүрүүлэхгүйгээр бид нар ТЭЗҮ-ээ энэ жилдээ багтаагаад дуусгаж чадах юм бол мөнгө босгох боломж нь бол байгаа. Тийм учраас та бүхэн энэ дээр мөнгө тавихдаа битгий харамлаарай. Мөнгө тавиагүй байсан шүү. Би тэгээд мөнгө тавиулаад зарчмын зөрүүтэй .../минут дуусав/

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүн намайг багшаа гээд би Мөнхбаясгалан гишүүнийг хариулъя гээд бид 2 жоохон будилж байна шүү. Тэгээд асуучихлаа. Хэн хариулах вэ. Сандаг-Очир сайд хариулъя.

Ц.Сандаг-Очир: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Мэдээж таны хэлж байгаатай адилхан Хэрлэн-Тооно төслийг мэдээж нутгийн говийн ард иргэдэд үр өгөөжтэй байх, ач тустай байх, аль трассаар нь явбал үр ашигтай байх гэдгийг мэдээж та бүхэнтэй болоод орон нутгийн удирдлага, ард иргэдтэй ярилцаж байж хийх нь бол гарцаагүй ажил. ТЭЗҮ-ийн ажил дуусаж байгаа. Дууссан гэдгийг хэлье. Онги гол дээр улсын хөгжлийн 2027 оны төсөл дээр бас 30 тэрбум төгрөг суугаад дэмжигдээд явж байгаа. Тэгээд гишүүд маань дэмжиж өгвөл бас төсөв хэлэлцэх үеэр энэ мөнгөө бас батлуулаад авчихвал бид нар томоохон хэмжээний эхний шатын хөрөнгө оруулалтын ажлыг, тэгээд та бүхэн гишүүд маань бас сайн дэмжиж өгөөрэй. Таны оролцоо бас их туйлын чухал байгаа. Санаачилгатай ажиллаж байгаад чинь бас баярлаж байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууя. Үг хэлж болно.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр 2, 3 асуулт байна.

1 дүгээр асуудал Ерөнхий сайд аа, махны үнэ өсөхөд та огцруулдаг. Одоо харин хүний амь нас алдсан сайддаа ямар арга хэмжээ авах вэ. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2 дугаар зүйлд гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг дэмжих, хүүхдийн хөгжил хамгааллыг шинэ шатанд гаргана гэж тусгасан байна. Тэгээд хүн төвтэй хөгжлийн бодлого хэрэгжүүлж байгаа энэ үед Баянхонгор аймгийн Зэвсэгт хүчний 339 дүгээр ангид байлдагч амь насаа алдсан ийм маш харамсалтай явдал, хэрэг гарлаа шүү дээ.

Тэгээд 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд цэргийн албан хаагчдын аюулгүй байдал, хүний эрх, сэтгэл зүйн дэмжлэг, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх ямар арга хэмжээ авахаар тусгасан байна. Ямар зорилт байна. Тэгээд төрөөс хүн амын өсөлт, гэр бүлийг дэмжих бодлого хэрэгжүүлэе. Хүүхдийн хамгааллыг шинэ түвшинд, шинэ шатанд гаргах ийм зорилт тавьчихсан байж байна. Гэтэл үр хүүхдээ цэргийн албанд эрүүл энх, эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ шинжилгээнд хамрагдаад, эрүүл гэж батлагдаад явсан хүүхдүүд нь амь нас, эрүүл мэндийн доройтолд ороод байгаа ийм эцэг эхчүүдийн хувьд бол энэ бол маш том итгэл, аюулгүй байдал суларсан ийм асуудал байж байна шүү дээ. Тэгээд энэ Батлан хамгаалахын яаманд, энэ салбарт чинь хяналт гэдэг зүйл байгаа юм уу. Хяналт байхгүй учраас энд тэндгүй эрүүл саруул айлын хөвгүүд эрүүл мэнд, амь насаараа хохироод байна шүү дээ. Тэгээд энэ асуудлыг яаж шийдэх гэж байна.

Дээрээс нь энэ хөгжлийн төлөвлөгөөнд ерөөсөө Улсын Их Хурлын гишүүд өөрсдийнхөө мөрөөдлийн жагсаалтыг, өөрөөр хэлбэл дараагийн сонгуульд өөрсдийнхөө тойргийг тойглох ийм завхарсан юмаа хийгээд, Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааг хянах ёстой байтал хэн нь хянах юм, хэн нь хянагдах юм ойлгомжгүй юм болчихсон. Тэгээд ерөөсөө энэ хөгжлийн төлөвлөгөөний гол цөм нь хүн байх ёстой. Хүн амаа хөгжүүлэе гээд байгаа мөртөө зөвхөн барилга байшин, зам харгуй барих төдийхнөөр ингээд тойргоо тойглох асуудлыг чухалчлаад байхад энэ Засгийн газрын үйл ажиллагааг Улсын Их Хурлын гишүүд яаж хянах юм бэ. Өөрсдөө сайд нарыгаа тойглоод, өөрсдөө сайд нарыгаа харуулдаад, өөр өөрсдийнхөө жижиг сажиг юмыг явуулах гээд байж байгаа хүмүүс эргээд яаж энэ ард түмний хяналтыг Засгийн газарт тавих гээд байгаа юм. Тэгээд яг энэ хөгжлийн бодлоготойгоо уясан юм маш ховор. Энэ 203 жагсаалтад. Бүгдээрээ тойргоо тойглоё. Үүнийхээ улмаас энэ сайд нарыг тойглоё гэдэг ийм юм болчихсон. Тэгэхээр ийм утгагүй юмнууд явуулаад байгаа цагт энэ өөрөө Засаг төрийн чинь голдирол нь, хяналт нь тэр чигээрээ байхгүй болчихоод байна. Тэгэхээр ийм ийм асуудлыг асуух гэсэн юм.

Тэгээд дээрээс нь энийг дараа нь асууя. Эхлээд энэ хэдэн асуултдаа хариулт авчихъя.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон Ерөнхий сайдын бүрэн эрх аймаг, орон нутгийн удирдлагууд хариуцлагагүй ажиллавал хэнтэй ч гэсэн хариуцлага ярина. Тийм учраас ард түмний ахуй амьдрал, аягатай хоолоор улс төр хийж болохгүй гэж би хатуу байр суурьтай байгаа. Мах агуулахуудад нөөцөлсөн атлаа зах зээл дээр гаргахгүй

барьсан асуудлыг бид шалгах хэрэгтэй л гэж би байр сууриа илэрхийлсэн. Ингээд Засгийн газар шийдвэр гаргаад, 1400 орчим тонн агуулахад байсан махыг гаргуулсан. Тэгээд 6 цэг дээр худалдаалагдаж байна. Анх тухайн компаниудтай тохирсны дагуу өнөөдөр тэр цэгүүдээр махны үнэ яг анх тохирсныхоо дагуу үхрийн мах 15, хонины мах 13 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна. Ингэснээрээ зах зээл дээр инфляцад гол нөлөөлөөд байгаа махны үнийн асуудлыг тогтворжуулах арга хэмжээнүүдийг авч байна.

Хүнсний тухай хуулиараа нийслэл, аймаг өөрөө махаа нөөцөлдөг. Ингээд 9, 10, 11 сард нөөцөлчхөөд, энэ хаврын саруудыг давдаг байхгүй юу. Тэгээд ийм л арга хэмжээ. Тэгэхээр бид нар Ерөнхий сайдын хувьд шат шатад нь хариуцлага тооцоод л ажилладаг энэ зарчмынхаа дагуу л ажиллаж байна. Тэрнээс үндэслэлгүй асуудал бол биш. Их Хурлын гишүүд болоод Их Хурлын бүрэн эрхэд бол би халдаж ямар нэгэн үг, үйлдэл гаргасангүй. Тэгэхээр би өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд ажлаа явуулж байгаа гэдгийг хэлье.

Батлан хамгаалах салбарт буюу өнгөрсөн хугацаанд үнэхээр харамсалтай үйл явдал боллоо. Би үнэхээр их харамсаж байна. Батлан хамгаалахын салбарын бодлого, үйл ажиллагаа алдаатай удирдлагын дарамт шахалт, анги, салбарын болон төрийн тусгай албан хаагчийн буруутай үйлдэлтэй холбоотойгоор тэр цэрэг хүү амиа алдсан нь хэрвээ тогтоогдох юм бол хэн ч байсан хариуцлага заавал хүлээх ёстой. Үүнийг улс төржүүлж болохгүй. Батлан хамгаалахын салбарт бол өнгөрсөн жил орчимд маш олон ажлуудыг эхлүүлсэн үү гэвэл эхлүүлсэн. Өнгөрсөн хугацаанд бол батлан хамгаалахын салбар илүү сэтгэлтэй ажилласан гэж би бодож байгаа. Яагаад гэхээр сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлгүүд цэргийн ангиудад ажиллаж эхэлсэн. 10 мянга орчим албан хаагч хугацаат цэрэг болон тэдний гэр бүлд сургалтууд, сэтгэл зүйн зөвлөгөө хийж эхэлсэн. Одоо бол хууль хяналтын байгууллагууд тэнд шалгалт хийж байна. Цаашдаа хяналтын тогтолцоогоо илүү сайжруулах зайлшгүй шаардлагатай байгаа учраас цэрэг армия айдсаас чөлөөлье гэдэг реформыг батлан хамгаалахын салбарт эхлүүлэх тодорхой үүрэг, чиглэлүүдийг өгсөн.../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайдын хариултыг гүйцээе. 1 минут.

Н.Учрал: 1 дүгээрт бол хариуцлагыг улам өндөржүүлье гэж ажлыг эхлүүлсэн.

Хоёрт, бид нар хяналттай дабль стандартыг нэвтрүүлэх буюу ангиудын камерыг тухайн ангийн дарга биш Жанжин штабын нэгдсэн төвөөс 24 цагаар онлайнаар хянадаг системийг эхлүүлэх гээд Цахим хөгжлийн яам болон бусад яамдыг оролцуулан ажиллаж байна.

3 дугаарт бол хиймэл оюун, технологид суурилсан шинэ аргыг би нэвтрүүлнэ гэдгийг танд бас хэлье. Чанга яригч, яаралтай тусламж дуудах тэр улаан товч гэдэг арга хэмжээг бол авч хэрэгжүүлнэ. Тэгээд ер нь бол зөвхөн IQ түлш EQ гэж нэрлэдэг л дээ. EQ рүү буюу сэтгэл хөдлөлөө удирдах чадвар гэсэн арга хэмжээнүүдийг бол авч хэрэгжүүлнэ. Тэгээд ер нь асуудлуудыг засаж залруулаад урагшаа хараад явж байгаа гэдгийг бас танд хэлье.

С.Бямбацогт: Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Ерөнхий сайдад бол үнэхээр гайхамшигтай зан чанар байна. Тэр нь болохоороо зэрэг өмгөөлөх, хамгаалах бол ямар ч буруутныг, ямар ч авлигачныг өөрийнхөө бүрэн эрхийн дор өмгөөлж чаддаг ийм гайхамшигтай зан чанар байна танд. Тэгэхээр зэрэг хүний амь нас алдчихаад байхад та сэтгэлтэй ажилласан гэж хэлж байгаа чинь яг энэ хүүхдээ алдчихсан байгаа эхийн хувьд яаж тусах вэ гэдгийг та бодоорой. Таныг өвчтэй хэцүү байхад ээж тань ямар их шаналж байсан бол. Ард түмнээрээ шаналж байсан. Гэтэл тэнд 1 айлын хүү нас барчхаад байна. Тэгэхэд та энэ салбарын сайдыг сэтгэлээрээ, сэтгэлтэй ажилласан гэж байгаа юм уу. Энэ салбарт үеийн үед цэргүүд амь насаа алдаж байсан. Гэтэл одоо энэ сайд чинь сэтгэлтэй ажилласан байхаараа 2-ын 2 Засгийн газарт улирч сонгогдоод, шөнө үүрээр аливаа ажлаа сүр дуулиантай аваад байсан байж байж энэ нь сэтгэлтэй ажилласан болоод хүний амь нас эрсдээд байж байгаа юм уу. Одоо тэгээд энэ хүүхдийн амь насанд хэн хариуцлага .../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Хууль хяналтын байгууллагаас ажлын хэсэг гарч шалгаж байна. Би түрүүн байр сууриа хэлсэн шүү дээ. Үнэхээр энэ батлан хамгаалахын салбарын бодлого, үйл ажиллагаа, алдаатай удирдлагын дарамт шахалт, энэ анги салбарын болон төрийн тусгай албан хаагчийн буруутай үйлдэлтэй холбоотойгоор амь насаа алдсан дээр нь би шалгалт явуулж байна. Тийм учраас би хэнтэй ч хариуцлага тооцно. Тэр дээр бол эргэлзэх зүйл байхгүй. Би хэнтэй ч хариуцлага тооцно. Тэнд танил тал хэн байгаа нь үл хамаарна. Би цэрэг хүн амиа алдсанд үнэхээр их харамсаж байгаа.

Тийм учраас би холбогдох чиглэлүүдийг өгсөн. Шаардлагуудыг би тавьж байгаа. Тэгэхдээ цаашид та нар ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр нь 5 чиглэлийг хэлж шахаж, шаардаж ажиллаж байна. Та энэ асуудлыг бусад асуудалтай битгий холио Нара гишүүн ээ. Та тэр хот дээр миний, манай намын дотоод асуудалд битгий ор. Юунд та их санаа зовдог юм.

С.Бямбацогт: Нарантуяа.-Нара гишүүн тодруулж асууя. Нэмэлт асуулт.

М.Нарантуяа-Нара: Танд ер нь ичих нүүр гэж алга Ерөнхий сайд аа. Ямар ичгүүргүй юм бэ та. Би хүний амь насны тухай асууж байхад та яахаараа хотын дарга, улс төржилт, танай намын асуудлыг яриад байгаа юм. Танай намын асуудал надад ямар хамаатай юм. Хүний амь нас эрсэдчихээд байна шүү дээ. Төдийгөөс өдийг хүртэл байнгын хүний амь нас эрсэдсээр ирсэн энэ салбар сэтгэлтэй ажилласан байдлаасаа ингээд явж байгаа юм уу. Ингээд дахин дахин хүн үхээд байж байгаа юм уу. Энэ бол үнэхээрийн гутамшигтай байна. Та бол ерөөсөө харамсаагүй байна. Одоо энд яах вэ гэхээр та нар зүгээр 1 төрийн албан хаагчийг тэнд байсан хүнийг халаад, тэгээд л хаана энэ хэргийг. Шат шатанд энэ босоо тогтолцоотой удирдлага чинь өөрөө шат шатаараа удирдаж чадахгүй байгаа болоод өнөөдөр хүн үхэж байгаа юм биш үү. Энд тэр хотын дарга чинь байна уу, танай МАН надад ямар хамаатай юм. Би энд үрээ алдсан эх хүний өмнөөс үзэл бодлоо, үг хэлээ, ард түмний үгийг хэлж байна.

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Би тэгээд наад батлан хамгаалахын салбарынханд та нар яагаад энэ сэтгэлтэй нь ажиллахгүй байгаа юм бэ. Тийм учраас дараах 5 арга хэмжээг авч хэрэгжүүл гэдгээ хэлээд байна шүү дээ. Тэр цэргийн анги дээр байгаа камерыг яагаад зөвхөн дарга нь хянаад байгаа юм. Нэгдсэн удирдлагын системтэй болго. Тэгээд би холбогдох үүргүүдийг өгөөд арга хэмжээнүүд авч байна шүү дээ. Би үнэхээр хэрвээ энэ нөхдүүдээс болоод ийм үйлдэл байгаа бол та нар энэ арга хэмжээг авч хэрэгжүүлж, дээрээс нь би та нарт хариуцлага тооцно гэдгээ хэлсэн. Тэрнээс биш та энэ асуудлыг битгий тэр улс төртэй холбоод байна. Дээрээс нь тэр манай дотоод асуудал. Үгүй ээ, та л хэд хоног санаа зовоод, уйлах гээд л бөөн л юм боллоо шүү дээ. Битгий хүний амь настай холбоотой энэ өөр асуудлыг хольж хутгаад бай. Үгүй ээ, та л харамсаад хэд хоног уйлан дуугарлаа шүү дээ. Одоо болоо шүү дээ.

С.Бямбацогт: Амь насны асуудал дээр бас Их Хурлын гишүүд бид бүхэн бас эмгэнэж байгаагаа илэрхийлсэн. Мэдээж хариуцлага алдсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох ёстой. Хууль хяналтын байгууллага хяналт шалгалтаа явуулж байгаа юм байна лээ. Тэгээд түүний дараа бас хэн буруутай нь тогтоогдох байх. Манай гишүүд бас тэрийг нь анхаарч, хүлээцтэй байя. Ойлгож байгаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдиннямын урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын Социал Демократ Монголын Залуучуудын холбооны гишүүд, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Сайн байна уу. Өчигдөр би бас энэ асуудлыг нэлээн дэлгэрэнгүй ярьсан. Тэгээд чуулган тарахад бараг 11 дөхөж байсан байх. Ж.Энхбаяр сайд яамдад энэ мэдээллийг бас хүргүүлэе гэсэн.

1 дүгээрт энэ эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар дундаж наслалт, тэрний зөрүү, эрсдэлт хүчин зүйл Монголд үнэхээр аюултай орчин болчихоод байгаа. Зөвхөн эрүүл мэндийн биш салбар дамнасан асуудал гэсэн утгаараа хэд хэдэн яамны асуулт байгаа юм. Юу гэсэн үг вэ гэхээр бид нар ид үедээ явж байгаа ч гэсэн залуучуудаа алдаж байгаа энэ бол зөвхөн өндөр наслалтын асуудал биш гэдгийг тодотгож хэлье. Энд нь манай хөвгүүд 25-64 насны хүмүүс хамгийн өндөр эрсдэлт хүчин зүйлээр тодорхойлогдчихсон байгаа. Бусад улс орнуудад энэ нь бүр эрчүүдийн эрүүл мэндийн стратегийн бодлого гэж боловсруулаад суурь түвшинтэй, тэгээд жил өнгөрөх тусам энийгээ сайжруулах ийм бодлогуудыг олон улсад хэрэгжүүлдэг. Манайх ч гэсэн ингэх боломжтой. Ингээд 2027 оныг эрүүл мэндийн жил болгож зарласантай холбоотой эрэгтэйчүүдийн эрүүл мэнд дээр тусгайлсан хэд хэдэн арга хэмжээ бас тавигдсан байна. Энэ дээр зөвхөн Эрүүл мэндийн яамнаас гадна Гэр бүл, хөдөлмөр, хамгааллын яам энэ тэртэй нэгдээд эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх гэж оруулж ирсэн байна. Одоо суурь түвшин 0, тэгээд 50 хувь болгоно гэж яасан байна. Энэ арга хэмжээ нь яг ямар арга хэмжээ юм. Суурь түвшин нь ямар байгаа юм. Ямар болгох гээд байгаа гэдгийг жоохон тодорхой дэлгэрэнгүй хэлж өгнө үү.

Яг үүнтэй ижил бас эрэгтэйчүүдийн эрүүл мэндтэй холбоотой Эрүүл мэндийн яам дээр эрүүл мэндийн хэвшил дадлага, амьдралын хэв маяг сайтай иргэдийг төлөвшүүлнэ гээд эрэгтэйчүүдийн эрүүл мэнд гээд мөн арга хэмжээний хэрэгжилт гэдэг төсөл, арга хэмжээ орж ирээд байгаа. Энэ яг ямар арга хэмжээ, дахиад суурь түвшин ямар болгох юм. Тэрийгээ хэд болгоод жишээлбэл дундаж наслалтыг бууруулчих юм гэсэн яг тоотой, баримттай яривал хариулаад өгөөрэй.

Үүнээс гадна өнгөрсөн 7 хоногийн чуулган дээр байх бид хэд бас ярьж байсан. Энэ механик байдлын сонин алдаатай юмнууд гарч ирээд байгаа юм. Энийг та нар зассан уу. Би 2 жил зарчмын зөрүүтэй санал гаргаж, уг нь засваруудыг явдаг. Жишээлбэл, энэ уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг өргөжүүлнэ гэж оруулж ирснээ яг төсөл арга хэмжээ, шалгуур үзүүлэлт нь дандаа эрт илрүүлэг болчихоод байгаа байхгүй юу. Сургуульд суурилсан эрт илрүүлэг, нярайн эрт илрүүлэг, хорт хавдрын эрт илрүүлэг. Тэгэхлээр энэ уламжлалт анагаах ухааны үр дүн, тогтолцоог сайжруулахын тулд бид нар эрт илрүүлгийн арга хэмжээгээр яаж засах гээд, юун дээр суурилж ийм юм гаргаж ирээд байгаа юм бэ.

3 дугаарт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна гэнгүүтээ дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барина. Чингэлтэй, Хан-Уул гээд. Энэ нь тэгээд гадаадын зээлээр. Гадаадын зээлээр өрийг нь төлөн барин барилга байшин барьснаараа эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар нь яаж нэмэгдээд, үр ашиг нь яаж сайжирчхаад байдаг юм бэ. Юун дээр тулгуурлаж яг ийм асуудлуудыг хэдэн жил дараалан байнга оруулж ирээд байгаа юм бэ. Энэ дээр бас яг тодорхой хариулт хэлээд өгөхгүй юу.

Ер нь бид нар нийгмийн эрүүл мэндийн асуудлыг хаячхаад байгаа учраас эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, дундаж наслалт, архаг өвчлөл, тэгээд эрсдэлт хүчин зүйлүүд бүгд нэмэгдээд байгаа. Тэгэхлээр жишээлбэл орчны хувьд нийгмийн эрүүл мэндийг сайжруулахын тулд ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ, явган хүн алхах, тэгээд дугуйтай хүн явах ч гэдэг юм уу. Тийм эдгээр асуудлуудыг шийдэхээр дараа жилийн төлөвлөгөөндөө оруулсан юм. Энэ Засгийн газраас яг юу юу байгаа вэ. Яаж хүмүүс өөрсдөө 1 алхаад, ядаж энэ хотын “А” бүсдээ заавал машинаараа шахцалдахгүй, бие биеэ сигналдахгүй, стрессдүүлэхгүй энэ боломжийг гаргаж өгөх вэ гэдэг дээр хэдэн цогц байдлаар нь хариулт өгөөч.

С.Бямбацогт: Батшугар сайд хариулъя. Эрүүл мэндийн сайд.

Э.Батшугар: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь эрэгтэйчүүдийн дундаж нас эмэгтэй хүнээс 9,7 жилээр бага, 30-60 настай эрэгтэй хүн нас барах статистик нь 4 дахин эмэгтэйчүүдээс их. Тэгэхээр шалтгааныг нь эхлээд харъя л даа. Ямар шалтгаан байна гэвэл эхлээд зүрх судасны өвчнөөр нас барж байна. Аваар осол, архины хордлого, тэгээд хавдар гээд. Тэгэхээр бид нар эхлээд суурь тогтолцоог нь эмчлэх нь хамгийн зөв гэж харж байгаа юм. Энэ юу вэ гэвэл манай эрчүүдэд эхлээд нь амьдралын зөв хэвшил хэрэгтэй гэхээсээ илүү бас давхар манай өрхийн эмнэлгүүд болон анхан шатны эмнэлгүүдийнхээ тогтолцоог нь сайжруулаад илүү тухайн өрх аймаг орон нутагтаа эрчүүдээ хянадаг болъё. Зүрх судасны өвчин нь бүр хүндрэхээсээ өмнө даралт нь ихсээд харвахаасаа өмнө урьдчилан сэргийлье. Энэ хүрээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас яг энэ эрэгтэй хүний нас бараад байгаа эмзэг бүлэг гэх үү, эрсдэлтэй бүлгийн эрсдэлтэй эрэгтэй хүмүүстээ санхүүжилтийн 111 хувиар нэмэгдүүлчихсэн.

Тэгэхээр 1 ёсондоо санхүүгийн хөшүүргийг нь тавьж өгч байгаа юм. Өрхийн эмч нь эрэгтэй хүнийг үзлэгт оруулбал илүү санхүүжилт тухайн эмнэлэг нь авна. Ингэснээр нөгөө эрэгтэй хүн нь сахар, дебет, аль эсвэл даралт, зүрх судасны өвчинтэй гэдгийг эхлээд өөрөө танина, мэднэ. Дараад нь тэгэхээр тогтмол эмээ уух уу, аль эсвэл нөгөө талдаа бол илүү жингээ хасах уу, амьдралын зөв хэв маягт орох уу гэдэг нь тодорхой болж эхэлж байгаа юм. Яг үнэндээ мэдэхгүй явж байгаад л нас барчхаж байгаа тохиолдол маш өндөр байна л даа. Уламжлалын анагаах ухаан талдаа бол яалт ч үгүй манай Монголын бас энэ өв соёл бараг 4 мянган жилийн түүхтэй гэж ярьдаг. Өнөөдөр 345 жилийн ойн яг албан ёсоор болж байгаа. Тэгээд Уламжлалт анагаах ухааны нэгдсэн төв гэж байгуулагдаж байгаа. Энэ нь бол уламжлалтын шинжлэх ухааны төв, судалгааны төвөө нэгтгээд, эмнэлгээ нэгтгээд, тэгээд уламжлалт анагаах ухаантай интеграцид оруулж, Монгол Улсын иргэнийг дан Европын анагаах ухаан гэхээсээ илүү бас давхар уламжлалт анагаах ухааныхаа урьдчилан сэргийлэх, эдгээх, эмчлэх тийм арга руу оръё гэж байгаа юм. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ дээр ирэх жилээс АХБ-ны төслөөр 17 бүс, орон нутагт нэгдсэн төв эмнэлгүүд баригдана. Ингэж байж бид анхан шатныхаа болон лавлагаа шатынхаа хүртээмжээ нэмэгдүүлж, тусламж .../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр индэр дээр нэмж хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр. Сая сайд маань нэлээн мэдээллүүд өгчихсөн байгаа. Энэ суурь түвшинтэй холбоотой судалгаанууд манай 2021-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан боловч яг хийгдээгүй байгаа. Гэхдээ сая 2025 оноос эхлээд бас нэг ийм судалгаа хийгдсэн. Энэ бол эрчүүдийн хоол тэжээлийн байдал, өсвөр насны эрсдэлт хүчин зүйл, сэтгэцийн эрүүл мэнд гэсэн ийм 3 чиглэлээр судалгааны ажлууд хийгдээд, ер нь бол бид нар суурь түвшнээ тодорхойлох бас боломжууд бүрдэж эхэлж байгаа. Ер нь цаашдаа бол бид нар энэ дээр бас нэлээн анхаарал тавьж, Эрүүл мэндийн яамнаас бас ажиллана гэдэг байдлаар ингэж төлөвлөгдөж байгаа.

Түрүүн таны асуусан нөгөө эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой юмнууд дээр өмнөх 1 дүгээр хэлэлцүүлгийн үед бол гарсан байгаа. Энэ дээр техникийн шинж чанартай алдаанууд бас байсан. Ингээд бид нар бас зарчмын зөрүүтэй саналаар .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээчихье. Хариултаа дуусгачихъя. 4 дүгээр индэр.

Н.Эрдэнэбаяр: Ажлын хэсгийн хуралдаанууд болон Байнгын хорооны хуралдаанууд дээр бас засварлаад яг нөгөө зөв байдлаар явсан. Техникийн алдаанууд бол засагдсан байгаа.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн тодруулж асууя. Даваасамбуугийн Ганмаа гишүүн.

Д.Ганмаа: Яг тэр хавсралт 2 дээр байгаа хэдэн асуултуудыг хариулчих. Тэгэх үү. Зарчмын зөрүүтэй саналыг оруулаад зассан юмнууд байгаа юм байна. Тэгэхдээ энэ урд талд нь яг аятайхан шиг төсөл хөтөлбөрийн арга хэмжээгээ тавингуутаа арга хэмжээний хэрэгжилт, арга хэмжээний хэрэгжилт гээд яваад байна шүү дээ.

Тэр дээр яг юуг төлөвлөөд, суурь түвшин нь ямар байгаад, 2027 онд энэ чинь хэд болчих юм гэдэг арга хэмжээгээ тайлбарлаад өг дөө. Яг тодорхойлж асуусан.

30 секунд байгаа учраас түрүүн хэлсэн бас нийгмийн эрүүл мэндтэй холбоотой орчны бүр Засгийн газрын бодлого энд байх ёстой байх л даа. Хот төлөвлөлт, орчны эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, боловсрол бүх талаасаа. Энэ дээр ногоон байгууламжийг нэмэх, явган алхах боломжтой болгох, тэгээд нийгмийн эрүүл мэндийн асуудал one health-ийн асуудал, тэр байтугай ер нь энэ нийт хэрэгжилт гэдэг асуултыг тодорхой болгоод, сайхан хариулаад өгвөл сайн байна.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофонд ажлын хэсэг хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганбаа гишүүний асуултад нэмж хариулъя. Ер нь бол бид нар энд яг манай салбар дээр бол маш олон ийм арга хэмжээний хөтөлбөрүүд байгаад байгаа юм. Тэгэхээр энд бид нар яг дотоод бас нэмэлт мэдээллүүдийг гэхээс илүүтэй нөгөө яг энэ төлөвлөгөө дээр тусгаж байгаа байдал дээрээ арга хэмжээ гэдгээрээ оруулчхаад байгаа. Энэ болгон дээр бол таны саяын асуугаад байгаа суурь үзүүлэлт, хүрэх түвшин гэдэг бол орсон байгаа. Зарим 1 үзүүлэлтээр Монгол Улсад яг баримтлах суурь үзүүлэлт байхгүй байгаад байгаа. Тэгэхээр бид нар энэ дээр олон улсын аргачлал буюу ДЭМБ-аас гаргасан зарим ийм үзүүлэлтүүдийг бас энэ дээрээ ашиглаж ингэж явсан байдлаар тусгасан байгаа.

Байгаль орчинтой холбоотой асуудал юм уу, бас энэ дээр салбар дундын хамтын ажиллагаа, салбар хоорондын хамтын ажиллагааны бас ийм зүйлүүд байгаа. Энэ дээр бол холбогдох яамд болон нийслэлээс бас нэмэлт хариулах байх гэж ингэж бодож байна.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн дахиж асууя.

Д.Ганмаа: Яг тодорхой бүр асуугаад, үгтэй нь асуугаад байна л даа. Энэ сайддаа найдаад сонсохоо байчихсан юм уу асуултыг. Асууж байна шүү дээ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ гэж хэлчхээд хөтөлбөрийн үр дүн дээрээ, төслийнхөө арга хэмжээ дээр дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийг Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрхийн барилгыг барина гэж оруулж ирээд байгаа чинь ямар шинжлэх ухаан дээр суурилоод энэ 3 барилга баригдсанаараа манай тусламж үйлчилгээ хаанаа яг яаж сайжирчих гээд байгаа юм бэ. Дээрээс нь энэ гадаадын зээл юм байна.

Уламжлалт анагаах ухаан гэххээд баахан эрт илрүүлгийн хамрагдалтын хувь яваад байгаа чинь ямар шинжлэх ухаан дээр суурилж, энийгээ гаргаж ирээд байгаа юм бэ. Механик алдаа юм уу. Тэрийгээ зассан гэж хэлж байвал бас болж байна. Яг үүнтэй адилхан эрэгтэйчүүдийн эрүүл мэнд гэххээд баахан төсөв хөтөлбөрийн хэрэгжилт гэж яваад байгаа нь яг юуг хэлээд байгаа юм бэ гэдэг энэ 3 асуултад тодорхой хариулаад өгчих л дөө.

С.Бямбацогт: Тодорхой хариулт өгье. Товчхон, тодорхой. 1 минут 4 дүгээр индэр.

Н.Эрдэнэбаяр: Ганмаа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ гишүүн ээ, ер нь бол яг техникийн алдаа байсан. Тэгээд энийг бид нар засаад оруулчихсан байж байгаа.

Уламжлалт анагаах ухаан дээр бол Ерөнхийлөгчийн зарлиг гарсан 03 дугаар зарлиг. 2026 оны 1 сарын 16-ны өдөр гарсан байгаа. Үүнтэй холбоотой бид нар уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх 6 чиглэлтэй, 37 арга хэмжээ төлөвлөсөн ийм үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаад ингээд бүх улсын хэмжээнд эрүүл мэндийн салбараараа энэ бүх үйл ажиллагаанууд явж байгаа. Энэ хүрээнд маш олон ажлууд зохион байгуулагдаж байгаа. Энд бол Уламжлалт анагаах ухааны тухай хуулийг бид нар бас ажлын хэсэг байгуулаад, энэ хуулийн төслүүдийг хийж хэлэлцүүлгүүд авч байгаа.

Энэ эрт илрүүлэгтэй холбоотой бас техникийн асуудал гарсан юм байна лээ.

С.Бямбацогт: Хариултуудаа бичгээр гүйцээж өгье. Гишүүд тодорхой асуулт асуугаад байхад тодорхой хариулахгүй, хариулт нь хангалттай биш. Сүүлдээ бүр буруу хариулт өгч байх шиг байна. Тийм болохоор Эрүүл мэндийн яам Ганмаа гишүүний асуултад бичгээр хариулт өгье.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн Долгорсүрэн багштай 9^а ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлага хөдөлмөрийн өндөр амжилтыг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй болох гэж байгаа анги дэвших шалгалтдаа амжилт гаргаарай. Бүгдээрээ бас хонхны баяр болж байгаа юм шиг байна. Хонх зүссэн баяр хүргэе бүгдэд нь.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Р.Эрдэнэбүрэн: Баярлалаа. Өнөөдөр Ариунзаяа гишүүнтэй санал 1 байна. Бид нар ингэж өөрсдийгөө хуурч, цаг үрж суумааргүй байна. Гишүүдээс энэ төлөвлөгөөтэй холбоотой саналаа өг гэдэг ийм юу ирсэн. Тэгээд би бол санал өгөөгүй. Яагаад гэвэл энэ бүтэхгүй. Бүх гишүүд хөрөнгө оруулалтын санал гаргах юм бол энэ хэзээ ч явахгүй. Угаасаа бүтэхгүй шүү дээ. Мөнгө нь байхгүй юм чинь. Тэгэхээр Ерөнхий сайд, Энхбаяр сайд 2-оос би зүгээр ийм л юм асуух гээд байна л даа. Төлөвлөгөө гэдэг чинь ийм мөрөөдлийн жагсаалт байхаасаа илүү хаанаасаа илүү бид нар хөрөнгө оруулалтаа хийвэл мөнгө олгох вэ гэдгээ эхэлж бодож ингэж явж болохгүй юм уу. Одоо бид нар чинь бүсчилсэн гээд ярьсан. Би зүгээр нөгөө говийн бүсийнх учраас жишээ авмаар байгаа юм. Говийн бүс бол ингээд боловсруулах үйлдвэрүүд нөгөө түүхий эдээ түүхийгээр нь гаргахаа аль болохоор болиод, боловсруулах үйлдвэрүүд явж эхэлж байна. Тэгэхээр жоохон хөрөнгө оруулалт байвал гаднын тусламж бүх юмаа зөвхөн 1 бүсээ хангалттай хөгжүүлээд авмаар байна. Дэд бүтэц, ус, юу байдаг юм эрчим хүч, бүгдийг нь ингээд янзалж өгөөд, тэнд үйлдвэрлэл хөгжих, мөнгө олох боломжийг нь бүрдүүлчихмээр байна. Бусад бүсээ түр хойшлуулж байгаад. Тэгээд тэр мөнгө олж байгаа хэсгээсээ олсон орлогоо аажим аажмаар бусад бүсүүд рүүгээ явуулах, хөгжүүлэх ийм бодлого хийх гэж л бид нар энэ төлөвлөгөө гэж ярьж байгаа байх гэж бодож байгаа юм. Бид нар чинь олон жил ингээд аманд ч үгүй, хамарт ч үгүй энд тэндгүй нийт даяар нь цацсаар байгаад ерөөсөө ингэж явж болохгүй юм байна. Төлөвлөгөөтэй явъя гээд ингээд

ийм 4 жилийн, 2050 он хүртэлх энэ тэр гээд баахан төлөвлөгөөнүүд гаргасан шүү дээ.

Тийм учраас би Засгийн газарт ийм санал хэлэх гээд байна л даа. Одоо бид нар 200 санал хураалгаад явах юм бол энэ чинь төлөвлөгөө ч биш болно. Зүгээр ямар ч хэрэггүй мөрөөдлийн жагсаалт. Тийм учраас энийгээ засаг татаж аваад, рам гаргаад гишүүдэд ойлгуулах хэрэгтэй байна. Бид нар эхний ээлжид хөрөнгө оруулалт юм хумаа ийшээ хийгээдэхье. Энэ хэсгийгээ хөгжүүлээдэхье. Эндээсээ бид нар эргээд хөрөнгө оруулалт, мөнгө олоод буцаагаад бүсүүдээ хөгжүүлэе гэдэг ийм рам гаргаж өгөөд, тэгээд энийгээ гишүүдэд ойлгуулаад, ард иргэдэд ойлгуулаад ингээд цаашаа явмаар байх юм. Тэгэхгүй бол одоо ингээд л яг өмнөх жилүүдийн төлөвлөгөөнүүд шиг ийм л юм болно. Тэгээд бид нар мөнгө байхгүй юм хэчнээн эрүүл мэнд, боловсрол, соёл яриад ямар ч нэмэр байхгүй шүү дээ. Мөнгө байхгүй юм чинь. Тэгээд эхлээд хаанаас мөнгө олох гээд байгаа юм бэ. Тэр хэсгийгээ хөгжүүлээдэхье л дээ. Тэр мөнгө олох, олж байгаа хүмүүсээ дэмжье л дээ. Тэгээд төсвийн чинь 80, 90 хувь нь урсгал зардал болчихоод байна шүү дээ. Мөнгө олох хэрэгтэй байна шүү дээ. Энэ урсгал зардлыг хасаж чадахгүй шүү дээ бид нар. Тэгээд Засгийн газар ч гэсэн өөрөө алдаатай байна шүү дээ. Ингээд сая оруулж ирэхдээ гишүүдтэй адилхан энд тэндгүй хөрөнгө оруулалт ярьчихсан. Ийм юм тодорхойгүй болгож оруулж ирээд, энэ төлөвлөгөө чинь ийм болчихлоо шүү дээ. Тийм учраас одоо засаг энийгээ цэгцэлж аваад, гишүүдэд эхлээд ойлголт өгмөөр байна. Бид нар ингэж бодоод байгаа учраас ийшээ хөрөнгө оруулалт хийх гээд байгаа юм. Тийм учраас бусад тойргуудын ч байдаг юм уу, бусад бүсүүдийн тэр мөнгө олох боломж .../минут дуусав/

С.Бямбацогт: Ерөнхий сайд хариулъя. Энэ 203 санал байгаа 203 саналаас Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн 50 гаруй санал, дэмжээгүй 150 санал. Одоо ингээд чуулганы хуралдаанд нөгөө дэмжээгүй саналыг дэмжье гэхээр гишүүд маань танхимд байхгүй байж байгаад бүгд босчих гээд байгаа. Тэр дэмжсэн 53 санал нь үнэхээр бас бололцоотой юм уу, бололцоогүй юм уу, дэмжээгүй 150 саналыг сая бас бид нар Тамгын газартаа лавлагаа гаргуулж авлаа. Ер нь дэмжээгүй тэр 150 саналыг бол гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, Эдийн засгийн байнгын хороо руу санал хураалгахгүй буцаах ийм чиглэл гарч байна. Гэхдээ 53 саналаа харин яах ёстой гэдэг дээр бас манай Засгийн газрынхан тодорхой байр сууриа хэлэх нь зөв байх. Ерөнхий сайд хариулсны дараа тодруулчих уу. Ерөнхий сайд хариулъя.

Н.Учрал: Эрдэнэбүрэн гишүүн бас Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсны хувьд бас үнэн бодит саналыг хэлж байна. 206 юм уу, 203 юм уу. 203 санал чинь нийтдээ бараг 2,9 бараг 3 их наяд төгрөг байхгүй юу. Тэгэхээр ийм хэмжээний санал гишүүдээс гарсан юм байна. 35 санал нь дангаараа 1,3 их наяд юм байна. Тэгэхээр төсвийн орон зай ийм бага байхад бид ийм хэмжээний төлөвлөгөөнд зорилтуудыг тусгалаа гээд хэрэгжих бололцоо байхгүй. Тэгээд дараа жил дахиад улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 20 хувьтай гээд л сууж байна. Тэгээд өнгөрсөн жил яг л энэ давтагдаж байгаа юм л даа. Өнгөрсөн жил би бас тухайн үед Эдийн засаг, хөгжлийн сайд байсан учраас тэгээд жилийн төлөвлөгөөгөө өөрөө танихаа больчихсон дараа нь. Дараа нь өөрсдөө таниагүй шүү дээ. Тэгээд энэ манай төрийн албан хаагчдыг ажлаа хийгээч, гүйцэтгэлээ танилцуулаач гэхээр 20 хувь хүрэхгүй нь үнэн. Тэгэхдээ хэн нэгний буруугаас биш тэр бол юу вэ гэхээр төсөв байхгүй. Тэгээд жилийн төлөвлөгөөнд ТЭЗҮ байхгүй, зураг төсөв байхгүй ажлууд суучихдаг. Ингээд намрын төсвийг барих гэхээр намрын төсөв дээр энэ жилийн

төлөвлөгөөнд суусан ажлуудыг тусгах гэхээр ТЭЗҮ нь ч байхгүй, зураг төсөв нь ч байхгүй. Тэгээд суулгах ямар ч бололцоо байхгүй. Тэгэхээр ийм л нөхцөл байдалтай л байна л даа. Тэгээд бид нар бас үнэтэйгээ нүүр тулах ёстой.

Тийм учраас бид нар сая Засгийн газар дээр жилийн төлөвлөгөөгөө мөрөөдлийн лист биш энэ бол бодитой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц цаг хугацаатай байна гэж зориод энэ жилийн төлөвлөгөөг нэлээд хумиад оруулж ирсэн. Тэгсэн чинь одоо жилийн төлөвлөгөө маань танихын аргагүй болчихоор цаашаа хэрэгжихэд хүнд болно гэдгийг гишүүд маань бас ойлгохыг хүсэж байна.

Мөн энэ жилийн төлөвлөгөө бол улсын жилийн төлөвлөгөө. Улсын жилийн төлөвлөгөө дотор сум, орон нутгийн асуудлуудыг, сум дундын замуудыг, баг дээр баригдах байр сумын сургууль гээд жилийн төлөвлөгөөндөө авчраад тавьчихдаг бол энэ чинь жилийн төлөвлөгөө биш шүү дээ. Улсын жилийн төлөвлөгөө бол бодлого, тэгээд түүнийг нь хэрэгжүүлэх төлөвлөгөө. Магадгүй тэр суманд сургууль барих гэж байвал Засгийн газрын бодлоготой уялдаж байх ёстой. Тэгээд эргээд хариуцлага нэхэхэд ч хүндрэлтэй. Бид нөгөө жилийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлээд барьж аваад явахад ч хүндрэлтэй, эргээд тайлагнахад ч хүндрэлтэй. Тэгээд ирэх оны төсвийг өргөн мэдүүлэхэд ч хүндрэлтэй ийм л гацаанд оруулчихаад байгаа юм. Тэгэхээр гишүүд маань бас үүнийг ойлгож хүлээж авахыг хичээнгүйлэн хүсье.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гишүүн нэмж хариулъя. Эрдэнэбүрэн гишүүн тодруулчихаад, тэгээд ажлын хэсэг нэмж хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Би бол ийм л санал хэлэх гээд байна л даа. Тэгээд энэ хүлээж авч болохоор юм байна уу, болохооргүй юм байна уу хэлээд өгөөч. Одоо бол урсгал зардал тэртээ тэргүй тодорхой төсөв дээр. Жоохон хөрөнгө оруулалтын зай байна уу, үгүй юу, мэдэхгүй байна. Тэгэхээр бид нар энэ бусад бүсүүдийнхээ зайлшгүй шаардлагатайгаас бусад тэр хөрөнгө оруулалтуудыг нь 1, 2 жилдээ түр зогсоож байгаад, тэрийг л ойлголцох хэрэгтэй байгаа юм. Тэгээд мөнгө хаанаас олох вэ гэдэг хэсгээ л тэр дэд бүтэц шаардлагатай эрчим хүч, ус, бүх юмаар нь ингээд шахаад хийчихмээр байгаа юм. Тэгээд бид нар давын түрүүнд мөнгө олох юм руугаа анхаарлаа хандуулчихаад, тэгээд тэр хэсгээ нэлээн сайн дэд бүтцийг нь сайжруулж хөгжүүлээд, тэр .../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг Очирбат гишүүн хариулъя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Тэгээд ажлын хэсэгт орж ажилласан. 2027 оны төлөвлөгөөг боловсруулах. Тэгээд ажлын хэсэг бол 194 дүгээр захирамжаар Бямбацогт Их Хурлын дарга ажлын хэсэг гаргасан. Лувсанжамц гишүүн ахалсан, Наранбаатар гишүүн дэд даргаар ажилласан, Ариунзаяа гишүүн, Баасанжаргал гишүүн, Бадамсүрэн гишүүн, Батбаяр гишүүн Ганзориг, гишүүн Мөнхсайхан, гишүүн Мөнхтуяа гишүүн, Нарантуяа -Нара гишүүн, Очирбат гишүүн, Пүрэвдаваа гишүүн, Сэддорж гишүүн, Ундррам гишүүн, Уянгахишиг гишүүн гээд олон гишүүд ажилласан. Хуулийн дагуу. Тэгээд ажиллаад шөнө оройгүй суулаа. Тэгээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө тухай хуулийн үндсэн гол заалтуудаа барилаа. Төрийн хэмнэлтийн тухай хуулиа барилаа. Ингээд олон хуулиуд бариад ажил болгоод ороод ирчихсэн юм.

Байнгын хороо дээр бас бүтэн суусан. Байнгын хороо дээр суугаад, одоогийн хуулиараа бид нар Их Хурлын гишүүдийн зарчмын зөрүүтэй саналыг хүлээж авна шүү дээ. Аваад санал .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Очирбат гишүүний микрофон өгье.

Г.Очирбат: Эдийн засгийн байнгын хороо дээр яг энийг чинь нэг бүрчлэн, Байнгын хорооны гишүүд хуулийн зүйл, заалттай нь энэ мэргэжлийн экспертүүд, яам, тамгын институтийн дарга нар ирээд, Энхбаяр сайд суугаад бас 2 өдөр ажилласан юм. Тэгэхээр одоо Их Хурлын гишүүд өөрсдөө бас зарчмын зөрүүтэй санал гаргах эрхтэй. Байнгын хороон дээр ч тэр, Их Хурлын тогтоолын төсөл дээр ч өгдөг. Бүх юман дээр өгдөг. Тэгэхээр тэрийг нь бид нар хуулийн хүрээнд хүндэтгэж аваад ажилласан. Тэгэхээр одоо бол Бямбацогт дарга аа, та Их Хурлын гишүүдийнхээ ирцийг бүрдүүлээд, зарчмын зөрүүтэй санал нь болно, болохгүй гэдгийг нь энд хэлж өгөх гээд институтийнхэн маань Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан бүгд ирчихсэн байна. Ерөнхий сайд маань сууж байна. Тэгээд ажлаа л хийцгээе тэгэх үү. Тэгэхгүй нэг нь нэгнийгээ үгүйсгэж болохгүй шүү дээ. Түүрүүн бол энэ ажлын хэсгийнхэнд Эдийн засгийн байнгын хороо руу буцаа гэдэг чинь юу гэсэн үг вэ. Тэгээд яаж ойлгох вэ. Бид нар Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ дагуу зарчмын зөрүүтэй санал оруулаад ирж байхад хүндэтгээд л суусан шүү дээ. Тэгээд одоо хэдүүлээ сууж байгаад ажлаа хийгээд л дуусгая. Өмнөх жил ч гэсэн ингээд л явсан.

С.Бямбацогт: Очирбат гишүүн ээ, ажлын хэсэг санал гаргаад, энэ нь болно, энэ нь болохгүй гэж та нар гаргасан байна шүү дээ. Тэгээд та хэдийн дэмжсэн саналууд чинь Байнгын хороон дээр дэмжигдсэн юм байна. Гэтэл та хэдийн дэмжээгүй саналууд чинь байнгын хороонд бас дэмжигдээгүй юм байна. Та хэдийг муу ажилласан гэж огт хэн ч хэлсэнгүй. Тийм болохоор гүйцээн боловсруулах чиглэл өгөх ёстой гэж үзэж байгаа юм. Энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.10.2-т санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, ТЭЗҮ, зураг төсөл нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх ийм шаардлага тавигддаг. Энэ хуулийн шаардлагад нийцээгүй саналууд хураагдаад, энэ хураагдсан саналууд чинь Эдийн засгийн байнгын хороон дээр дэмжигдээгүй, ажлын хэсэг дээр дэмжигдээгүй. Тийм учраас дэмжигдээгүй саналууд чинь Их Хуралд орж ирээд, гишүүд чинь орж ирэхгүй байж байгаад дэмжигдэх ийм эрсдэл гарчхаад, энэ чинь улс орны эдийн засаг, төсвийн байдал, Засгийн газарт маш том ачаа болох гээд байна шүү дээ. Эргээд энэ дээрээс төсөвт суулгах мөнгө байхгүй. Дахиад цаад талд нь хэрэгжихгүй болохоор Засгийн газар ажлаа хийсэнгүй, Улсын Их Хурлын баталсан хууль тогтоомж хэрэгждэггүй гээд ийм юм руу л орчих гээд байгаа учраас энийг гүйцээн боловсруулъя. Ажлын хэсэг, Эдийн засгийн байнгын хороо дахиад 1 ажиллаадах гэж чиглэл өгөх гэж байгаа юм. Энийг бас гишүүд маань зөв ойлгоорой. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууж, үгээ хэлье.

С.Эрдэнэбат: Хөгжлийн төлөвлөгөөний эрэмбэ гэдэг зүйл яг ингээд харж байхад орж ирсэн саналуудыг харахад бол ер нь алдагдсан юм харагдсан. 1 дүгээрт.

2 дугаарт юу вэ гэхээр ер нь бид нар энэ хөгжлийн төлөвлөгөөнөөс ирэх жил гэхэд иргэдийн бодит орлого яаж нэмэгдэв, тэр зам тавих гээд байгаа бол хамгийн ойрхон аймгийнхаа засаг захиргааны нэгж рүү очиход 1 сум дунджаар хэдэн километр ойртов, зарцуулж байгаа цаг нь яаж буурав гэх мэтчилэн ийм байдлаар бас харж үзэх хэрэгтэй юм байна лээ. Зарим аймаг юуг харж байхад бол замаар бүрэн холбогдчихсон ийм байдаг. Тухайлбал, би сая Хөвсгөлд очиход 170км-ийн суманд очихын тулд 8 цаг туулж байгаа байхгүй юу. Бороо орчих юм бол тийшээ явна гэж бол юу ч байхгүй. Хөвсгөл аймгийн Ханх сум гэхэд яг ний нуугүй хэлэхэд бол өвөл гэхэд л наашаагаа орж ирдэг, зун бол тийшээ явна гэдэг ойлголт байхгүй гэх мэтчилэн. Сургууль барихад яадаг вэ гэхээр тийшээ очиж сургууль барьдаг газар байдаггүй гэх мэтчилэн тодорхой нөхцөл байдлын хүндрэл гээд олон зүйлийг харах юм бол янз янз харагдах юм байна лээ.

Тийм учраас зүгээр энийг юу гэж хэлэх вэ гэхээр гишүүдэд зарим нь 20, 30 санал гаргадаг юм байна лээ. Бүгдийг нь бичээд тавьчихдаг. Хэдэн тэрбум ч юм. Тийм учраас яах вэ гэхээр гишүүдийг бас буруутгах аргагүй юм байна. Очихоор нь яадаг вэ гэхээр чи ер нь юу хийсэн бэ, чи энийг шийдүүлж ирэхгүй бол битгий ирээрэй гэдэг ард иргэдийн, нутаг орны хүмүүсийн шаардлага байдаг. Тэгэхээр 1 ч гэсэн гишүүн 1 юмыг хийе гэхийн төлөө явдаг. Гэхдээ энд хэмжээ хязгаар байх ёстой.

Тийм учраас би бол ер нь алсдаа тухайн орон нутгийн тэр бүс нутгийн гэдэг юм уу, аймаг, орон нутаг, сумын тэр удирдлагуудынхаа саналыг 1 дүгээрт эрэмбэлээд, Их Хурлынх нь гишүүд нь тэндээ саналаа нэгтгээд, 10 гишүүн 1 бүсэд байдаг бол 10-уулаа нийлж байгаад, 3 санал оруулаад ирдэг байх юм бол нэг нь барьчхаад, нөгөөдөх нь барихгүй болохоор яадаг вэ гэхээр би ганцаараа шийдүүлсэн, чи тэрэнд шийдүүлээгүй гэдэг байдлаар бие биедээ барьцах байдлаар л явчихдаг юм байна гэж би бол яг ний нуугүй хэлэхэд энэ хөрөнгө оруулалттай холбоотой саналууд дээр ингэж дүгнэсэн. Яг Эдийн засгийн байнгын хороо дээр яах вэ, ингээд яг бодитоор хэлэхэд 200 саналаас эхний 50, 60 санал явж байгаад, тэгээд сүүлийн саналууд нь гишүүд саналаа дэмжүүлээд л эсвэл дэмжихгүй болонгуут нь гараад л явцгаасан. Тэгэхээр саяын Их Хурлын даргын хэлж байгаа шиг зарим ажлын хэсгийн санал дэмжигдээд, зарим нь уначихсан. 203 санал дотор мөнгө шаардахгүйгээр зүгээр техникийн ганц нэгэн өөрчлөлттэй саналууд их олон байсан шүү гэдгийг бас би хэлмээр байна.

Тийм учраас тухайлбал нэг санал хэлж байгаа нь мэдээж жагсаалтын гишүүн учраас 3 аймаг дамнасан үр ашигтай 1 замын асуудлыг л эхлүүлбэ. Ядаж давааг нь эхлүүлээд тавья гэдэг ийм саналыг тавьж байгаа. Зарим нь бол ерөөсөө ирэх жил миний бүх саналыг тавьж өг гэдэг энэ тэнгэр, газар шиг ийм ялгаа байгаа учраас гишүүдийг зөвшилцөөд, зарим саналаа нэгтгээд, заримаа татаад, тэгээд энэ хөгжлийн төлөвлөгөөгөө .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Зочин танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Төгс дэлгэрэх” сургуулийн Соёлмаа багштай 8^а ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Тэгээд эрдэм номдоо

шамдан суралцаад удахгүй болох гэж байгаа анги дэвших шалгалтаа амжилттай өгөөрэй.

Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөг бид хэлэлцэж байна. Энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө харилцааг тусгайлан зохицуулсан бид хууль, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Энэ хүрээндээ бид энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө асуудлыг авч үзэж явж байгаа. Тэгэхээр улсын хөгжлийн төлөвлөгөө гэдэг бол дан ганц Монгол Улсын төсвөөр хийдэг зүйл биш. Энэ бол улс, хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, санхүүгийн дэмжлэгийн оролцоо, шууд хөрөнгө оруулалт гээд олон зүйлээр босож, бий болдог ийм зүйл байгаа юм. Тэгэхээр бид энд зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтынх нь юмыг яриад байна.

2025 онд бид Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэлийг батлаад, үндсэн чиглэлийн хавсралт болгож хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөө баталчихсан. Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдчихсан. Тэгэхээр энэ ирэх 5 жилд энэ улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудыг хангах тэр бодлогын чиглэлээс 2027 онд юуг нь хийх юм бэ гэдэг асуудал л энэ төлөвлөгөөний үндсэн суурь нь байх ёстой юм. Тэгээд энэ тал руугаа нэлээн илүү анхаарч ажиллах ёстой. Би бол анх энэ төлөвлөгөө орж ирэхдээ энэ тал руугаа нэлээн харсан юм байна гэж ингэж ойлгосон. Гэхдээ манай гишүүдийн буруу биш, өнөөдрийн бидний энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө асуудлыг зохицуулж байгаа хууль дотор ч байгаад байгаа юм. Энэ төлөвлөгөө батлах гээд байгаа тогтоолын төслийн заалт дотор ч байгаад байгаа юм. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг 2027 оны төсвийн боловсруулалтдаа анхаарч тусга гэдэг үг орчхоод байгаа учраас энэ улсууд чинь бүгд энэ рүүгээ хошуурчхаад байна. Тэгэхээр үүнийг мэдээж бид бүгдийг нь гүйцэлдүүлж чадахгүй учраас ойлгомжтой. Мөрөөдлийн жагсаалт гэж яриад байгаа чинь тэр л байхгүй юу. Тэгэхээр үүнийгээ яг гүйцээн боловсруулах чиглэлээр нь дахиж Байнгын хороон дээрээ яриад. Харин нэгэнт энэ 4 жилийн гэдэг юм уу, дунд хугацааны хөгжлийн бодлогын чинь суурь нь бүсчилсэн хөгжил гээд хэлээд өгчихсөн юм бол энэ бүсүүдийн хөгжлийг түргэтгэх бодлогын зорилтуудаа хангах тал дээр ер нь ямар арга хэмжээ авах юм гэдэг заалтаараа тодотгоод л оруулчих хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгээд үүн дээрээ тулгуурлаж, манай салбарын яамд 2027 оныхоо төсвийн боловсруулалтдаа эрэмбэ дараа энэ бүх юмнуудаа анхаарч, тусгаж оруулж ирэх тухай асуудал нь байх юм байна гэдэг ийм л надад бодол санаа байгаад байна.

Тийм учраас энэ талаас нь асуудалдаа харж, энэ хөгжлийн төлөвлөгөөнийхөө хэлэлцүүлгийн үйл явц дээр ер нь чуулган дээрээ яриад, Эдийн засгийн байнгын хороо дээрээ цаг хугацаа их авчигүйгээр дахин нэг яриад ийм зохицуулалт хийвэл яасан юм бэ гэж.

Дээр нь энэ төлөвлөгөө өөрөө бас бидэнд цаг хугацааны цаглавартай. Тийм учраас хоног хойшлох боломжгүй. Тэгээд яг энэ талаасаа асуудлаа харж зохицуулалтаа хиймээр байна. Ийм саналтай байна.

С.Бямбацогт: Санал хэллээ. Чинбатын Ундрэм гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Ундрам: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Миний хувьд ч гэсэн энэ бүлгийн дарга болон бусад гишүүдтэй адил саналтай байгаа. Би өөрөө энэ ажлын хэсгийн гишүүн. Тэгээд ажлын хэсэгт ажиллаж байгаа зарим Их Хурлын гишүүд энэ 203 саналыг чинь бас нэлээдгүйг нь оруулж байгаа байхгүй юу. Зөвхөн өөрийнхөө тойрогт, зарим нь бол бүр сумын дотуур байрны засварыг хүртэл оруулж байгаа байхгүй юу. Энэ арай дэндэж байгаа юм. Тэгээд ядаж ажлын хэсгийн гишүүд нь өөрсдөө ёс зүйтэй байгаад, нийтлэг Монгол Улсын хэмжээний асуудал яриад, зарчмын асуудлууд яриад оруулахгүй, өөрсдөө тойргийнхоо асуудлыг хийгээд, тэгээд хоорондоо бүр үгсэн хуйвалдаад, нэг нэгнээ дэмжээд, ажлын хэсэг дээр дэмжүүлээд тэгээд Байнгын хороо дээр орж байгаа юм. Тэгэхээр миний хувьд ч гэсэн өнөөдрийн энэ асуудлыг бүхэлд нь хуульд нийцүүлэн боловсруулах чиглэл өгөөд, Улсын Их Хурлын дарга тэгээд дахиад ажлын хэсгийг ажиллуулмаар байна.

Тэгээд энд бас гендээ ч байна, гоондоо ч байна гээд би бас бодож байна л даа. Засгийн газар ч гэсэн оруулж ирж байгаа асуудлаа бас яг зарчмаа зөв тайлбарлаад, зарим бас ганц 2 засах юмнууд байна лээ. Тэрийг нь бид нар ажлын хэсэг дээр хасахыг нь хасаад, ингээд цэгцлээд Байнгын хороогоор оруулах саналтай байна. Тэгэхгүй бол энэ жилийн төлөвлөгөө ямар ч ач холбогдолгүй болох юм байна.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүд маань ч гэсэн үнэхээр эх орноо бодоод, жоохон сахилга баттай байгаад эндээ хандчих юм бол ач холбогдол нь өндөрсөх байх. Тэгэхгүй энэ хэвээрээ явах юм бол ямар ч ач холбогдолгүй, мөрөөдлийн ийм жагсаалт болох гэж байна. Тэгээд төлөвлөгөөг чинь ер нь боловсруулахдаа биелэгдэхүйц байх гэдэг бас нэг шалгуур үзүүлэлт байдаг шүү дээ. Гэтэл огт биелэгдэхгүй ийм мөрөөдлийн жагсаалт өөрсдөө баталчхаад, дараа нь нөгөөдхөө биелэхгүй байна гээд Засгийн газар луугаа дайрах юм байна л даа. Тэгээд биелүүлсэнгүй учраас ингэ тэг гээд бөөн юм болох ийм л юм болох гээд байна.

Ерөнхийдөө түрүүн бас зарим гишүүд мөнгө олдог салбар луугаа илүү анхаарах нь зөв гээд ярьж байгаа. Би энэнтэй бас санал нэг байгаа юм. Жишээлэх юм бол аялал жуулчлалын салбарт бид нар аялал жуулчлалын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулахын тулд нийт Монгол Улсын 4 зүгт орон нутгийн нисэх буудлуудаа сайжруулах хэрэгтэй юм байна. Олон улсын стандартад нийцүүлэх ёстой юм байна гээд намайг Засгийн газарт ажиллаж байхад Эдийн засаг, хөгжлийн яамтай бид нар яриад тэр асуудал бол энд ороод ирсэн байгаа. Тэгэхээр өнгөрсөн жил жишээлбэл шууд Хөвсгөл аймгийн Мөрөн рүү Солонгосоос нислэг авсан байхгүй юу. Тэрний хүчээр Солонгосын бас жуулчид нэмэгдсэн. Тэгэхээр бид нар энэ нисэх буудлуудынхаа стандартыг сайжруулчих юм бол шууд Ховд руу, шууд Хөвсгөл рүү шуу, шууд Дорнод руу, Өмнөговь руу жуулчдыг аваад, тэндээ бас орон нутгийн орлогыг нэмэгдүүлээд явах боломж бүрэн бүрдэж байгаа гэх мэтчилэн ийм зарчмын асуудлууд, мөнгө олдог ийм салбаруудаа дэмжээд, тэрний дараа эдийн засаг сайжраад, мөнгө олоод ирэх юм бол бусад асуудал руугаа орж болно шүү дээ. Тэгэхээр 1 иймэрхүү зарчим бариад хэдүүлээ ажилламаар байна. Тэгэхгүй тэгээд дур зоргоороо сумын дотуур байрны засварын асуудлуудаа оруулах юм бол бүгд л оруулмаар болоод л явчихна шүү дээ. Тэгэхээр ядаж ажлын хэсгийн гишүүд ёс зүйтэй байгаад энэ олон тойргийнхоо асуудлуудыг татаж аваад ажиллах л ёстой байх гэж бодож байна.

Тэгэхээр Бямбацогт дарга аа, бүхэлд нь хуульд нийцүүлэн гүйцээн боловсруулах чиглэл авмаар байна. Ажлын хэсгийн гишүүний хувьд. Баярлалаа.

С.Бямбацогт: Ерөнхий сайд. Энэ бас Засгийн газрын өргөн барьсан төсөл. Жилийн хөгжлийн төлөвлөгөө бол маш чухал бичиг баримт. Төлөвлөгөө дээр суурилж төсөв гарна. Төлөвлөгөөнд орсон зүйлүүдийг төсөвт суулгах ёстой гээд бас хуультай. Тийм болохоор энэ төлөвлөгөө маань хөдөлчихвөл төсөвт суулгаж чадах уу, ирэх жил хэрэгжүүлж чадах уу. Ер нь ямар шийдэл байх бол Ерөнхий сайдын байр суурийг сонсьё.

Н.Учрал: Өнгөрсөн жил 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулахад зөв болгох гэж аягүй их хичээсэн юм. Яг KPI-уудаа тавиад үндэсний үзүүлэлт, салбарын үзүүлэлт хэд байх юм бэ. Дандаа тоогоор хэмжээд, энийг олон улсын индексүүдтэй нь холбочихсон юм. Тэгэхээр энэ 5 жилийн чиглэл бол амьдралд илүү нийцсэн. Тэгэхээр тэр 5 жилийн чиглэл нь өөрөө тэр смарт гээд байгаа тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, цаг хугацаатай, бодитой байх шалгуур нь дандаа тоон хэмжүүртэй байгаад байдаг. Үүнд нь суурилсан жилийн төлөвлөгөө орж ирэхийн тулд мөрөөдлийн лист гэхээсээ илүүтэйгээр бид нар сая ийм хүрч болохуйц гэдэг зорилгоор нэлээн хумиад оруулж ирсэн. Тэгээд дээрээс нь жоохон орон зай хэрэгтэй байгаа юм. Төсөв дээр. Одоо 35 санал нь дэмжигдсэн байгаа чинь дангаараа 1,3 их наяд байхгүй юу. 1,3 их наяд гэдэг чинь жишээ нь тэтгэврийг бараг 25, 30 хувь нэмэх мөнгийг зөвхөн энэ дээр нэмчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр төсөв дээр бага орон зай хэрэгтэй байна. Тэгэхээр энэ орон зайг сум дундын зам, сум дундын сургууль гээд аваачаад хуваагаад тавьчихдаг. Гэтэл бусад тэр чинь сум болгоныг шийдэж чадахгүйгээс хойш улсын жилийн төлөвлөгөөнд энийг тусгалаа гээд яах вэ. Нийтдээ байгаа 203 саналын төсөв чинь 2,9 болно гэдэг бол энэ чинь хүүхдийн мөнгө чинь л 1,7 байгаад байна шүү дээ. Тэгэхээр бид ийм орон зай байхгүйгээр ирэх оны төсөв дээр тэтгэврээ нэмэх асуудлыг шийдэж чадахгүй, цалингаа нэмж чадахгүй, халамж зорилтот бүлэгт хүрч чадахгүй л байхгүй юу. Тэгэхээр өнөөдөр энэ үнийн өсөлт ингэж их өндөр байгаа үед бид нар тэтгэврийг жишээ нь реформ хийе гээд орон нутгийн уулзалтууд бид нар яриад явж байна шүү дээ. Тэтгэврийг шударга тогтолцоо руу шилжүүлнэ гэдэг орон зай хэрэгтэй байна. Засгийн газрын тэргүүлэх ажил бол нийгмийн даатгалын реформ.

Тэгэхээр манай энд ингээд ахмадууд ирчихсэн байна шүү дээ. 2014 оноос хойш өмнө нь тэтгэвэрт гарсан ахмадууд 1 сая 400-аас тооцуулаад, 3 жилийн дараа тэтгэвэрт гарсан хүмүүс 2 сая 400-аас тооцуулаад ийм ялгаатай. Тэгээд сүүлийн 5 жилд нь аваачиж шимтгэл хэн илүү төлсөн нь өндөр тэтгэвэр тогтоолгоод. Тэгэхээр ийм шударга тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх реформыг хийгээд, Засгийн газарт ийм орон зай өгөөч ээ гэж л гишүүдээс хүсээд байгаа юм. Тэрнээс биш яг ийм 35 санал гээд л 1,3 энэ тэр шийдчих юм бол ирэх жил ер нь юу ч шийдэж чадахгүй. Ялангуяа тэтгэвэр цалин хөлс шийдэгдэхгүй. Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлээч ээ гэж гишүүдээсээ хүсэж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболдын урилгаар Дархан-Уул аймгийн Дархан сумын Ардчилсан намын хорооны “Салхит” үүрийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Цэвэгдоржийн Туваан гишүүн, Далайн Батбаяр гишүүд бас Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ бас ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн маань бас хүрэлцэн ирлээ. Тэгээд хамтдаа бас иргэд сонгогчидтой бас ойр ажилладаг, манлайлж тойрогтоо ажилладаг гишүүдийн маань 3 гишүүн зогсож

байна. Туваан, Батбаяр, Эрдэнэболд, Энхбаяр, Ундррам гишүүд гээд олон гишүүдийн маань тойрог байна. Мэнд хүргэж байна бүгдэд нь.

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө бол маш чухал бодлогын баримт бичиг. Урьд нь 30 жил төлөвлөлтгүй явж ирсэн. Төлөвлөгөөтэй болдог, төлөвлөж эхэлдэг, төлөвлөгөө дээр суурилж, төсвөө баталдаг ийм тогтолцоонд шилжээд 4, 5 жил болж байна. Тийм учраас жилийн төлөвлөгөө дээр 203 санал гараад, ажлын хэсэгт нь бүгдээрээ би орно, би орно гэж нэлээн асуудал болж ороод, орохдоо яаж төлөвлөгөөгөө сайжруулах вэ, улс орныхоо эдийн засаг, нийгмийнхээ нөхцөл байдал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, ард иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдгээсээ илүү манай ажлын хэсгийн гишүүд маань сая одоо ажлын хэсгийн гишүүдийн ярьж байгаагаар илүү юу гэдэг юм найз дундаа тойрогтоо гэдэг юм уу асуудлууд ярьсан юм байна. Ажлын хэсгийн олон гишүүн хэллээ. Ариунзаяа гишүүн, Ундррам гишүүн, Эрдэнэбүрэн гишүүн, Нарантуяа-Нара гишүүн гээд олон гишүүд илэрхийлж байна. Бүлгийн дарга Батжаргал гишүүн. Засгийн газар ч гэсэн үнэхээр орон зай байхгүй байхад энэ 203 саналыг бүгдийг нь дэмжээд явчих юм бол үүнийг төсөвт тусгах орон зай алга. Цалин тэтгэвэр нэмэх орон зайгүй болно. Нэн шаардлагатай хөрөнгө оруулалт, эрүүл мэнд, боловсролын салбарт хийх хөрөнгө оруулалтыг хийх боломжгүй болно гэсэн байр суурийг Ерөнхий сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн шадар сайд, Шадар сайд бүгд илэрхийлж байна.

Тийм болохоор Эдийн засгийн байнгын хороо, ажлын хэсэг маань дахиж ажиллая. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн бас тодорхой заалтууд зөрчсөн байна. Энэ дээр Тамгын газар бас мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүл. Сайн ажиллах ёстой. Хариуцлагатай байх ёстой. Тийм болохоор энэ асуудлыг 203 саналын дэмжсэн санал нь ч уначих, дэмжээгүй санал нь ч босчих тийм эрсдэлтэй болчихсон байна.

Тийм болохоор гүйцээн боловсруулж, хуулийн хугацаатай 6 сарын 1-ний дотор улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Улсын Их Хурал баталсан байх хуулийн хугацаатай. Хуулийн хугацаанд нь багтааж гүйцээн боловсруулж, нэгдсэн чуулганы хуралдаанд оруулж ирэхийг Эдийн засгийн байнгын хороо, ажлын хэсэгт чиглэл өгье. Энэ олон саналуудаа бас цэгцлэх хэрэгтэй.

12.28 цаг.

Дараагийн асуудалдаа орёе.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

3.Мэндсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу Засгийн газраас боловсруулж,

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна.

Энэ хүрээнд Сангийн яам, Татвар, Гаалийн байгууллага, МҮХАҮТ болон Улаанбаатар хотын худалдааны танхим, Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээж авлаа.

Иргэд, аж ахуйн нэгжүүдээс татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварын энгийн ойлгомжтой илүү уян хатан болгох зэрэг саналууд голчлон ирүүлсэн.

Түүнчлэн Ойрх дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Сангийн яам дээрх уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг судлан үзэхээс гадна олон улсын байгууллагуудаас өгч буй санал, зөвлөмжийг харгалзан үзсэний үндсэнд Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг боловсрууллаа.

Энэ удаагийн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хариуцлагатай татвар төлөгчдийг дэмждэг, урамшуулдаг татварын тогтолцоог бүрдүүлэхээр зорьсон бөгөөд иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 2,2 орчим их наяд төгрөгөөр үе шаттай бууруулахаар тооцож байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Татвар, Гаалийн байгууллага, татвар төлөгчийн татварын эрсдэлд орохоос өмнө анхааруулах, зөрчлөө засах боломжийг олгодог болох, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, татварын өр барагдуулах үйл ажиллагааг уян хатан болгоход чиглэнэ. Тухайлбал,

1.Хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих, урамшуулах, татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Гааль, Татварын алба татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг тодорхойлон мэдэгдэж, татварын тайлан ноогдлоо өөрөө засах, зөрчлөө арилган эрсдэлээс сэргийлэх боломжийг олгоно.

2.Татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчийн санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй хүндрэл эрсдэлийг харгалзан дансыг бүхэлд нь битүүмжлэх бус орлогын тодорхой хувийг суутгах,

дансыг хэсэгчлэн битүүмжлэх замаар татварын өрийг төлүүлэх боломж бүхий зохистой үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.Татвар төлөгчийн алдаа зөрчлөө өөрөө арилгах боломжийг бүрдүүлэх зорилгоор татварын тайланг задруулах хугацааг 2 жил болгон нэмэгдүүлэх.

4.Татвар төлөгчид их хэмжээний алданги тооцуулах эрсдэлээс хамгаалах зорилгоор алдангийн дээд хэмжээг 50 хувиар тогтооно. Түүнчлэн татварын актад гомдол гарсан тохиолдолд алданги, торгууль нэхэмжлэхгүй, маргаан эцэслэн шийдвэрлэсний дараа хураана.

5.Татварын алба хооронд татварын зорилгоор автоматаар харилцан мэдээлэл солилцох стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн үүргийн хэрэгжүүлэх этгээдийг тодорхойлох, шаардлагатай мэдээллийг бүрдүүлж, уг мэдээллийг тогтоосон хугацаанд олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр бусад гишүүн оронд хүргүүлэх нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг холбогдох байгууллага, эрх бүхий этгээдэд олгох зэрэг өөрчлөлтийг тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчийг алдаа гаргасны дараа хяналт, шалгалт хийж, акт, торгууль тавих бус татварын тайланг залруулах хугацааг сунгаж, татварын алба эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөл бий болно.

Мөн Глобал форумын гишүүн орны хувьд автоматаар мэдээлэл солилцох, харилцан солилцох, стандартыг хэрэгжүүлэх нэмэлт зохицуулалтуудыг тусгаснаар Монгол Улсад нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлэх боломж бүрдэж, татвараас зайлсхийх болон хууль бус санхүүгийн гүйлгээг бууруулах, дотоодын орлогыг хамгаалах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын ил тод байдлыг нэмэгдүүлэх эерэг үр дүн гарна.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Мэндсайхан сайдад баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, Монгол Улс санхүүгийн дансны мэдээллийг автоматаар солилцох тухай эрх бүхий этгээд

хоорондын олон талт хэлэлцээрт нэгдэж, 2027 оноос автоматаар харилцан мэдээлэл солилцох стандартыг хэрэгжүүлж эхлэхээр болсонтой холбогдуулан уг стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах, татварын таатай орчныг бүрдүүлж, иргэд, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, татвар төлөгчдийг татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх мөн татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар татвар төлөгчдийг татварын эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж, татварын өр барагдуулах үйл ажиллагааг уян хатан болгохын зэрэгцээ татварын таатай орчин бүрдэнэ гэж үзсэн байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төсөлд татварын өрийг гаргуулсны дараа татвар төлөгчийн банк дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс үл маргах журмаар гаргуулах татварын өрийн хэмжээ нь тухайн орлогын 80 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтын талаар холбогдох тооцоо судалгаа хийгдсэн эсэх, энэ хувийг 50 хувь болгосон тохиолдолд үүсэх эрсдэлийн талаар асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 62,5 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүнд баярлалаа. Түрүүн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуулийн хугацаатай гүйцээн боловсруулж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрхэт эрдэм” сургуулийн Эрдэнэчимэг багштай 9^б ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч багачууддаа сурлагын өндөр амжилтыг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаж, удахгүй болох анги дэвших шалгалтаа амжилттай өгцгөөгөөрэй хүүхдүүдээ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Орлогын хэлтсийн дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга.

Ажлын хэсгийн гишүүддээ Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ийм бас хуультай. Оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх ёстой. Худлаа хариулт, буруу мэдээлэл өгөхийг хориглодог. Хэрэв Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлгүй хандвал, буруу мэдээлэл өгвөл, худлаа мэдээлэл өгвөл, асуултад хариулахаас татгалзвал хуулийн дагуу бас хариуцлага хүлээдэг болохыг сануулъя. Тийм болохоор үнэн зөв, бодитой мэдээлэл өгч, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг та бүхнээс хүсье.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ Татварын ерөнхий хуулийн өөрчлөлттэй хамт орж ирж байгаа НӨАТ-ын хууль дээр би бас тодорхой үг хэлье гэж бодож байна. Манайх бол нэг талаасаа хөдөө аж ахуйн орон. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зах зээл рүү орж ирж байгаа. Мах, сүү, ноос, ноолуур тэгээд төмс, хүнсний ногоо, буудай зэрэг. Энэ бүх зүйл зах зээл рүү орж ирэхдээ бүгдээрээ газар тариалан эрхэлдэг хүмүүс, малчид бүгдээрээ НӨАТ төлсөн гээд жишээ нь махан дээр ярихад НӨАТ төлсөн гэж үзээд Мах импекс дээр очиж байгаа. Мах Импекс нь цаашаа хиамны үйлдвэр ч юм уу, аль эсвэл ресторан руу махаа өгөхөд НӨАТ-ын баримт авах уу, авахгүй юу гэхээр нь НӨАТ-гүй авчихъя гээд хямдхан аваад явчхаж байгаа юм. Тэгээд ерөөсөө 1 талаасаа 30 хувийн бараа бүтээгдэхүүн зах зээл рүү НӨАТ-ын баримтгүй орж ирж байгаа юм.

Нөгөө талаар манайх бас хэрэглэгч орон. Манай нийт хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүний 90 хувь чинь БНХАУ-аас орж ирдэг. Тэр бараа бүтээгдэхүүн бид нарын өмсөж байгаа хувцас хэрэглэл, энэ бүх тоног төхөөрөмж эд нар бүгдээрээ орж ирнэ. Тэрний ихэнх нь гаалиар яаж орж ирдэг вэ гэх дээр том том ачааны машинд маш их олон 1 машин дээр гэхэд хэдэн 100 нэр төрлийн бараа орж ирдэг. Тэрийгээ яадаг вэ гэхээр амраар нь жин, тонн ихтэй, бага үнэтэй цемент ч юм уу, барилгын материалаар мэдүүлээд ороод ирдэг. Тэгээд тэр бүх бараанууд бүгдээрээ Нарантуулын зах дээр орж ирээд, тэр 330 сум, аймаг, дүүрэг рүү ингээд хуваарилагддаг. Анхнаасаа бичиг баримт нь байхгүй тэр бараанууд яадаг вэ гэхээр бүгд НӨАТ-ын баримтгүй, НӨАТ-гүй бүгдээрээ Монгол Улс даяар тараагддаг байхгүй юу даа. Ингээд 2 талаасаа ерөөсөө НӨАТ-ын баримтгүй ийм бараа бүтээгдэхүүн Монгол Улсад орж ирээд, энэ нь ямар ч худалдаа үйлчилгээг бүртгэх боломжгүй болж байгаа юм. НӨАТ-ын хууль чинь ер нь бараа бүтээгдэхүүнийг бүртгэх ёстой хууль шүү дээ. Өнөөдөр та нар төсвийн орлого бүрдүүлдэг татвар болгоод хувиргачихсан байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ бүх зүйл юунаас болж байна вэ гэхээр өндөр 10 хувийн татвараас болж байгаа юм. 2016 он хүртэл энэ

НӨАТ-ын татварыг их ярьдаггүй байсан юм. Одоо яагаад яриад байна гэхээр МАН 2016 оноос хойш 9 төрлийн татварыг нэмсэн. Дээрээс нь маш их олон хураамж төлбөрүүдийг газрын төлбөр гэхэд өчнөөн олон дахин, автомашины төлбөр гэхэд 5 дахин нэмэгдчихсэн байж байгаа шүү дээ. Тэгээд энэ бүх зүйлд компаниудын иргэн, аж ахуйн нэгжүүдийн бүх нөгөө эргэлтийн хөрөнгийг нь бүгдийг нь ховх сороод, одоо тэгээд НӨАТ-ын татвар чинь маш том ачаалал болчихоод байгаа байхгүй юу даа. Тэгээд жишээ нь Мэндсайхан сайд таны Мянгад сум дээр 15 дэлгүүр байгаа. 15 дэлгүүрийн 1 нь л НӨАТ-ын баримт өгч байгаа юм. Алдаг оног. Тэгэхээр тэр хөдөө, орон нутагт амьдарч байгаа хүмүүс чинь НӨАТ-ын баримт өгөхгүй болохоор НӨАТ-ын шивэлт байхгүй, буцаан олголт байхгүй, сугалаанд оролцохгүй. Тэгэхээр тэнд ерөөсөө тэр НӨАТ-ын татвар чинь үйлчлэхгүй байна гэсэн үг.

Гэтэл Улаанбаатар хотод бүх хүмүүс ажил үйлчилгээнээсээ НӨАТ-ын баримтаа авдаг, шивдэг, сугалаандаа оролцдог, татварын буцаан олголтгоо авдаг. Тэгэхдээ нийслэлд үйлчилдэг хөдөө, орон нутагт үйлчилдэггүй ийм 5 хувийн буцаалтыг Занданшатар дарга оруулж ирсэн. Би энийг эсэргүүцэж байсан. Тэгээд энийг сая буцааж байгаа нь зөв.

Нөгөө талдаа та нарын оруулж ирж байгаа жишээ нь НӨАТ-ын босгыг 400 сая болгож байгаа байх. Тэгээд дээрээс нь алслагдмал бүсүүдэд 1 хувь, янз янзын юманд явж байгаа. Энэ чинь нөгөө татварын ижил байх зарчмыг, тэр бүх зүйлийг бүгдийг нь алдагдуулж байгаа байхгүй юу даа. Энэ чинь буруу.

С.Бямбацогт: 1 минут тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тийм учраас энэ татвар чинь ерөөсөө энэ ажил, үйлчилгээг бүртгэх тэр зүйлээсээ халиад, ерөөсөө айхтар дарамт болчихсон байна. 10 хувь чинь, 2 хувийн буцаалт чинь.

Тийм учраас миний өргөн барьсан НӨАТ-ын татварыг 5 хувь болгох, буцаан олголт нь 2 хувь байх. Ингэсний үр дүнд татварын анхнаасаа тэр зах зээл рүү орж ирж байгаа бүх бараа бүтээгдэхүүн дээр энэ татварын 5 хувийг ноогдуулж, 2 хувийн буцаан олголт олгож, 3 хувийг төлснөөр бүх бараа бүтээгдэхүүнүүд чинь бүгдээрээ бүртгэгдэж, энэ НӨАТ төлдөг аж ахуйн нэгжүүдийн чинь тоо нэмэгдэж, өнөөдөр 70 мянган аж ахуйн нэгж НӨАТ төлөгчөөр бүртгүүлчихсэн байгаа. Бид нар 200-аад мянган аж ахуйн нэгжтэй шүү дээ. Дээрээс нь 250 мянган хувиараа хөдөлмөр эрхэлдэг хүмүүстэй. Тэрний дөнгөж 40-өөд мянга нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлчихсэн байж байгаа. Энэ бүх хүмүүс чинь татвар нь бага байх юм бол бүгдээрээ НӨАТ төлөгчөөр бүртгүүлж, энэ НӨАТ төлөгчийн татварын бааз суурь нэмэгдсэний үр дүнд ямар ч орлого багасахгүйгээр илүү .../минут дуусав/

С.Бямбацогт: Асуулт асуулаа. Мэндсайхан сайд хариулъя. Загджавын Мэндсайхан сайд хариулъя. Сангийн сайд.

3.Мэндсайхан: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр НӨАТ-ын татвар бол төсвийн орлогын 20 хүртэл, 20-оос дээш хувийг бүрдүүлж байгаа манай үндсэн гол тогтвортой татвар байгаа. Зүгээр дэлхий дээр аваад үзэх юм бол НӨАТ-ын системтэй 175 орны дунд бид нар судалгаа хийхэд Монгол Улсын 10 хувийн хэмжээ бол харьцангуй доогуур тооцогдож байгаа. Манайхаас доошоо НӨАТ-ын татвартай 9 орон л байгаа. НӨАТ-ын хэмжээг 5 хувь болгоод бууруулснаар улсын

төсөв дээр орж ирэх орлого бол 4,1 их наяд төгрөгөөр тасрахаар байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн тогтвортой орлогогүй болно гэсэн үг. Ер нь ОУВС-ийн зүгээс бол НӨАТ-ын хувь хэмжээг бууруулахыг буруу гэж зөвлөхөөс гадна өмнө бид нарт гашуун олон улсын туршлага байгаа шүү дээ. Шриланк улс 15 хувийн НӨАТ-тай байж байгаад 8 хувиар бууруулсан. Төсвийн орлого нь 30 хувиар тасалдсан. Үр дүнд нь дефолт болсон. Иймэрхүү гашуун туршлагууд байгаа. НӨАТ-ын татвар бол манайд тогтвортой төсвийн орлогыг бүрдүүлэгч татварын нэг.

Сүүлийн 5 жилийн дунджаар нийт төсвийн орлогын 22,3 хувийг бүрдүүлсэн байна. Тэгэхээр НӨАТ-ын татварыг тэгж 5 хувь болгож оруулж ирэхээс илүүтэй бид нар ер нь түрүүн та хэлж байна лээ. Бүгд НӨАТ-ыг төлөхгүй байгаа гэж. Худалдаа хийж байгаа аж ахуйн нэгжүүд, татварын албанд тайлагнаж байгаа аж ахуйн нэгж, иргэд болгон бүгдээрээ л цахим бүртгэлийг бүртгүүлж байгаа шүү дээ. Худалдаан дээр. Нэмэлт мэдээллийг ажлын хэсгээс өгчих.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя. Тодруулъя Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би уул уурхайн компаниуд, дээрээс нь банк, санхүүгийн байгууллагууд энэ шилдэг аж ахуйн нэгжүүдийн дээгүүр бүгдээрээ орчихдог юм. Эд нар чинь жишээ нь банк, санхүүгийн байгууллагууд ерөөсөө НӨАТ төлөгч биш. Тэд нар төлөхгүй байгаа. Хамгийн их баяжиж байгаа. Дээрээс нь уул уурхайн компаниуд тэр хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүн дээрээ л НӨАТ-аа төлдөг болохоос биш гаргаж байгаа экспортоороо НӨАТ төлөхгүй байгаа. Тэгэхээр ер нь бол энэ чинь яг жирийн аж ахуйн нэгжүүд, эцсийн худалдан авагч хийж байгаа тэр ард иргэд л энэ НӨАТ-ын татварыг бүгдийг нь төлж байгаа байхгүй юу даа. Та нар ингээд иргэд дээрээ хамаг ачааллыг нь бүгдийг нь үүрүүлчхээд, тэгээд энэ томоохон Монгол Улсын баялгийг бүгдийг нь авч байгаа тэр компаниуд дээрээ бас энэ НӨАТ төлөлтийн үйл ажиллагаа чинь бүрэн сайн дүүрэн явахгүй.../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсэг хэн хариулах вэ. хамаагүй Чимидсүрэн дарга 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр НӨАТ-ын 10 хувийг буулгахаар бол нөгөө орлогын тэгш бус байдлын чинь асуудал бас хэвээр хадгалагдана. Одоо авч байгаа буцаалтыг өндөр орлоготой, хэрэглээ өндөртэй хэсэгт буцаалт маань бол өндрөөр очоод байгаа юм. Тэгэхээр яг энэ систем бол 5 хувь болгоод, тэгээд нөгөө таны хэлснээр 20 хувийн буцаалттай явахтай зэрэг энэ мөн л ялгаагүй тэр дүнгээрээ явчхаж байгаа юм. Олон улсынхаа практикаар ч гэсэн манай НӨАТ-ын хэмжээ 10 хувиар тооцоод, 20 хувийн буцаалттай буюу ингээд 8 хувьтай гэдэг дэлхийн дундаж 16 хувиас бол манайх 2 дахин бага байгаад байгаа юм л даа.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Татварын ерөнхий хууль дээр бас ахиц дэвшил гарч байна. Аж ахуйн нэгжүүд бас удаан хүсэж байсан саналуудаас бас оруулж ирсэнд талархалтай байна. Тэгээд энд миний онцлогоор онцолмоор заалт болохоор 63.2 дээр татварын өр барагдуулах энэ албадлагын арга хэмжээг илүү хөнгөвчилсөн ийм зүйл, заалт

оруулж ирсэн байна. Тэгээд энийг бас аж ахуйн нэгжүүд бол талархалтай дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл энэ аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулж, дампуурах эрсдэлээс нь тэр орлогыг нь хамгаалах, тасалдалгүй үйл ажиллагаа явуулах, үргэлжлүүлэх энэ бололцоо боломжийг нь олгож, татварын өрийг нь хураахын тулд дансыг нь хааж байгаад бүх орлогыг нь татдаг биш 20 хувийг нь үйл ажиллагаанд нь зарцуулах ийм бололцоо боломж олгож ийм заалт оруулж ирчхээд бас аж ахуйн нэгжүүд бол компаниудаас талархалтай байгаа.

Тэгэхээр энэ дээр үүнтэй холбогдуулж бас санал гэх юм уу даа. Энэ зүйл заалтад болохоор хувь хүн болон хуулийн этгээд хоёулаа хамрагдахаар байгаа. Тэгэхээр хуулийн этгээдтэй холбоотой асуудал дээр болохоор энэ 20 хувь гэдгийг бас тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх бололцоог харж үзээч гэсэн ийм саналтай байгаад байгаа юм. Ер нь жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд бол манай үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд бол цалингийн зардал, цалин, нийгмийн даатгалын зардал нь бараг үйл ажиллагааныхаа зардлын 25-35 хувь байдаг ийм жишиг байгаа. Тэгэхээр энэ хувь хэмжээг 30 хувь болгоод үлдээчихвэл ядаж ажилчдынхаа цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах ийм бололцоо боломжуудыг нээж өгөхөөр ийм заалт болж аж ахуйн нэгжүүдэд нөгөө талаасаа татвар хураалтад ч гэсэн ийм дэмтэй зүйл заалт болох юм уу гэсэн ийм санал байгаа юм.

Нөгөө талаас энэ хуулийн зүйл заалт маань бас хувь хүмүүст хамааралтай байгаа. Тэгэхээр олон улсын жишгээр харахаар бол protected amount энэ хамгаалагдсан орлогын хэмжээ гэж байдаг. Энийг бол тогтмол дүн юм уу, хувиар тооцдог. Тэгэхээр аж ахуйн нэгжүүдийнх нь хувьд жишээлбэл энэ дүнг нь үлдээх дүнг нь 30 хувь хүмүүс дээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ ч гэдэг юм уу ийм тодорхой дүн тавивал яасан юм бэ гэсэн ийм санал байна. Тэгээд энэ нь бас энэ хуулийн зүйл, заалт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 88, 89-тэй бас зөрчилдөхөөр харагдаад байгаа юм. Тэгээд хувь хүний хувьд энэ татвар төлөхдөө 1 удаа гаргуулах төлбөрийн хэмжээ нь цалин хөлсний 50 хувиас хэтэрч болохгүй гэсэн ийм заалт байдаг.

Дээр нь бас тодорхой хэмжээний төлбөр гаргуулж болохгүй ийм орлогууд байдаг. Жишээлбэл энэ хөдөлмөрийн чадвараа алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмжүүд, донорт олгож байгаа нөхөн олговрын төлбөрүүд, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмж гэх мэтчилэн энэ орлогуудаас нь суутгал хийж болохгүй гэсэн Шүүхийн шийдвэрийн тухай хууль байдаг. Тэгэхээр энэ зүйл заалтыг хувь болон аж ахуйн нэгж 2 ингээд ялгаад аж ахуйн нэгж дээр нь үлдээх орлогын 30 хувь, энэ нь болохоор цалин, нийгмийн даатгалтай тэнцэх хэмжээний үйл ажиллагааг нь үлдээх, тэгээд үйл ажиллагаагаа явуулаад татварын өрөө барагдуулах энэ бололцоо боломжийг нь хангах, нөгөө талаас хувь хүний хувьд бол энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулсан ч юм уу энэ тодорхой амьжиргааны баталгааг хангах энэ дүнгээр нь дүн тогтоож өгвөл яасан юм бэ гэсэн ийм санал байгаа юм. Тэгэхээр яах вэ, энэ нь бол аж ахуйн нэгжүүдийн хувьд ер нь үйл ажиллагааг нь дансыг нь хаачихаар дампуурах эрсдэл рүү орчихдог. Тэгэхээр энэ нь буцаад олон хүмүүсийн ажил амьдралтай холбоотой байдаг учраас энэ зүйл заалтыг оруулж ирсэнд талархалтай байна. Тэгээд саяын байдлаар бас өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргая гэсэн ийм бодолтой байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэлсэн үү. Үг хэллээ. Одоо Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Татварын ерөнхий хуулийн өөрчлөлт бол нэг тийм техникийн шийдлийн асуудал биш. Энэ бол төр ч юу байх вэ, Засгийн газар татвар төлөгч нараа түнш гэж үзэж байна уу. Төсөв бүрдүүлэгч гэж үзэж байна уу. Нэг бол сэжигтэн гэж үзэж байна уу гэдгийг тодорхой хэмжээнд зааглаж байгаа асуудал гэж би хувьдаа ойлгож байгаа. Бизнес эрхлэгч нар, компанийн захирлууд их олон зүйл ярьдаг. Бид нар ингээд зүв зүгээр юу байх вэ дээ хөөрхий татвараа төлж амжаагүй хугацаа хэтрүүлээд л явж байсан чинь гэв гэнэтхэн Монголын татварын байгууллага, Сангийн яам, Сангийн яам л гэж ярьж байгаа шүү дээ. Тэр чинь Засгийн газар гэсэн үг дансыг нь хаачихдаг. Татварын асуудлаас болоод, нийгмийн даатгалаас болоод. Тэгэнгүүт нь нөгөө харилцагч түнш байгууллагууд олон хувь нийлүүлэгчид байдаг юм уу, гадна дотнын хөрөнгө оруулагчид нь энэ нөхөр гэмт хэрэгтэн юм байна гэж харж эхэлдэг. Гадаад талдаа бизнесийн орчинд бол аж ахуйн нэгж, хувь хүний дансыг шүүхийн шийдвэрээс бусад тохиолдолд дансыг нь хаадаггүй. Тэгэхээр нь Монголын аж ахуйн нэгж ингээд дансаа хаалгачихаар энэ нөхөр миний хамтраад хөрөнгө оруулаад байгаа нөхөр чинь гэмт хэрэгтэн юм байна шүү дээ. Засгийн газар нь тэгж үздэг юм байна. Шүүхийн шийдвэргүйгээр энэ татварын байгууллагууд, бусад байгууллагууд данс хаадаг асуудлыг бүтэн хааж чадсан уу. Хаасан харагдахгүй байна. Хэрвээ хаадаг дээрээ тулбал шүүхийн шийдвэрээр хаадаг байх ёстой шүү дээ.

Тэр олон улсын бизнесийн тэр мэдээлэл энэ тэр гээд хуулийн төсөлтэй явж байна. Өөрчлөлт дээрээ. Тэгэхдээ Монголын иргэн, аж ахуйн нэгжийнхээ мэдээллийг хэн, ямар зорилгоор ямар хугацаанд хамгаалалттайгаар солилцох асуудлаа гаргасан уу. Хаан банк билүү аль банк билээ. Монголын 2 сая иргэний данс хуулга, регистр, хувийн нууцын мэдээлэл олон улсын хар зах зээл дээр гараад зарагдчихсан гээд, сонгуулийн үеэр тэрийг нь олоод авчихлаа тэдэн 100 доллароор зарна гэсэн хүмүүс зөндөө явж байдаг шүү дээ. Та нар татварынхаа асуудал дээр энэ хамгаалалтаа явж байгаа юм уу. Тэгээд алдангийн хэмжээгээ 50 хувь гэсэн байгаа юм. Хуучин бол 2019 он байх хууль өөрчлөгдөхөөс өмнө 20 хувь гэж бас санагдаад байна. Тэгж байснаа 80 хувь ч болсон билүү. Одоо ингээд 50 хувь болгож байгаа нь болж байна гэж байна. Дээрээс нь тэр орлогынхоо 80 хувийг нь татварынхаа өрөнд өглөгт авчихаар цаана нь 20 хувиар тэр цалингаа тавьж, дулаан цахилгаанаа шийдэж, НДШ, хүн амын орлогын албан татвар, эд нарыг нь төлж чадах юм уу. Төлж чадахгүй болохоор эргээд дахиад л нөгөө хашилтууд нь босоод ирнэ шүү дээ. Энэ хувийг жоохон өөр болгож тавих зүйлээрээ бодмоор байгаа юм.

Дээрээс нь энэ татварын онооны систем гээд дэлхий нийтээр янз бүрийн улс орнуудад иргэний оноо, татварын оноо энэ тэр гээд байж байгаа. Тэгэхдээ энэ татварын онооны систем дээр муу гэдэг дүн тавьж байгаа нь эргээд нөгөө аж ахуйн нэгж, байгууллага, төсөл тендер, хөрөнгө оруулалт, банкны зээл, санхүүжилт энэ бүх зүйл дээрээ дандаа хаалт болгоод ирнэ шүү дээ. Дараа нь төрийн байгууллагууд Засгийн газар бол хамгийн том худалдан авагч байгаа. Зарлаж байгаа бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ дээрээ татварын муу оноотой, дунд оноотой аж ахуйн нэгжийг оруулахгүй гэдэг босго тавиад эхэлнэ. Тэгэхээр энэ хууль дээрээ энийг тавихгүй гэдэг зүйлийг оруулж ирүүлэх шаардлага гарч байгаа юм биш үү. Оноо тогтооно гэдэг чинь уг нь бизнесийн байгууллагуудаа дэмжих чиглэлд явах ёстой байгаад байгаа юм. Тэгсэн чинь энэ чинь дандаа хаалт буюу .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Загджавын Мэндсайхан хариулна.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь Татварын ерөнхий хуулийн гол зорилго бол татвар төлөгчийг эрсдэлд орохоос өмнө анхааруулж, зөрчлөө засах боломжийг нь олгох, тэгээд татварын өр барагдуулах үйл ажиллагааг уян хатан болгох, татвар төлөгчийг дэмжихэд чиглэсэн ийм нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаа юм. Ер нь бид нар таны хэлж байгаагаар янз бүрийн төрлөөр нь авч үзэхээс илүүтэй бид нар татвар төлөгч л гэж ойлгож байгаа. Хууль дээрээ ч ингэж тусгаж өгч байгаа. 1 л ойлголт байгаа. Татварын ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалаас нь бид нар 20 хувийг нь үлдээгээд, 80 хувийг нь авъя гэдэг, өр төлбөрт нь суутгаад явъя гэдэг энэ бол аж ахуйн нэгжүүдэд нэлээн том боломж олгож байгаа гэж үзэж байгаа. Ер нь аж ахуйн нэгжүүд түр хугацааны, богино хугацааны мөнгөн хөрөнгийн дутагдлаас болж өр үүсэж байгаа. Энд хамгийн их нөлөөлөл үзүүлдэг татвар бол нэмэгдсэн өртгийн албан татвар байгаа. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтийн хугацааг бид нар 2 сар болгож аж ахуйн нэгжүүддээ боломжийг нь олгоё. Мөн мөнгөн урсгалыг нь 20 хувийг нь үлдээе гэж. Үүнээс дээшээ хувь үлдээгээд явах юм бол хуримтлагдсан татварын өрийн хэмжээ чинь нэмэгдээд явах ийм эрсдэл байгаа. Ер нь энэ данс хаана гэдэг бол олон улсад байдаг практик. Бид нар илүү бизнесийн орчноо дэмжих, аж ахуйн нэгжүүдээ тогтвортой үйл ажиллагааг нь эрхлэх тодорхой цаг үе мөчлөгөөс хамаарсан янз бүрийн мөнгөн урсгалын дутагдлаас болоод дансаа хаалгах ийм нөхцөл рүү оруулахгүйн тулд ийм зохицуулалтыг хийж өгч байгаа. Ажлын хэсэг нэмээд тэр мэдээлэл солилцохтой холбоотой асуудлыг нь хариулчих.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофон. Нэр, албан тушаалаа хэлээд хариулна.

Ч.Чимидсүрэн: Сангийн яам Татварын бодлогын газрын дарга Чимидсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2024 он, 2025 онд бид Глобал форумын улс бүрээр тайлан гаргах мөн дансны мэдээллийг солилцох энэ олон улсын гэрээ конвенцод нэгдэж орсон. Ингээд бэлтгэл ажлаа хангаад 2027 оноос бид нар бол нэгдэж орох юм байгаа юм. Тэгэхээр цаад зорилго нь юу вэ гэхээр манай улсын тодорхой компаниуд үндэстэн дамнаад бусад оронд өөрийн салбар нэгжтэй байх эсвэл бусад улс орны салбар нэгж, охин компани манай улсад үйл ажиллагаа явуулдаг бол тэр тайланг нь гаргаад, улс хоорондоо солилцох тэр боломжийг олгосон зохицуулалт байгаа юм. Тэгэхээр энэ олон улсын байгууллагад бид нар нэгдэж орсны дагуу энэ Татварын ерөнхий хуульд орж байгаа зохицуулалт байгаа юм. Одоогоор бол энд нэгдэж, мөрдөгдөөгүй байгаа учраас бид нар дансны мэдээллийг нь шууд өгч байгаа зүйл бол байхгүй. Зүгээр хяналт шалгалтын хүрээнд харилцан мэдээлэл .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд нэмж хариулъя.

3.Мэндсайхан: Татвар төлөгчийн их хэмжээний алданги тооцуулахаар эрсдэлээс хамгаалах үүднээс алдангийн дээд хэмжээг Иргэний хуультай нийцүүлэх гэж энэ хяналт шалгалтаар тавигдсан, актаар тавигдсан өр төлбөрийг өмнө нь бол энэ чинь төлж чадахгүй байх юм бол алдангийн хэмжээ нь өсөөд л яваад байдаг байсан. Тэгээд дээшээ хязгаар байхгүй. Энэ чинь явж явж байгаад хэрвээ урт хугацаанд үргэлжлэх юм бол үндсэн төлбөртэйгөө ч гэсэн актынхаа төлбөртэй дүйцэж очих, тэрнээсээ давах ч тийм эрсдэл үүсэж байгаа. Тэгэхээр иргэний хуульд

бол энэ алдангийн хэмжээ 50 хувиас дээшгүй байна л гэж байгаа. Тэгэхээр тэр Иргэний хуультайгаа нийцүүлж, хяналт шалгалтаар тогтоогдсон актын өр төлбөр бол алдангийн хэмжээ, үндсэн өр төлбөрийнхөө 50 хувиас хэтрэхгүй байна гэдэг Иргэний хуулийн заалттай л уялдуулж өгч байгаа юм.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: 2008 оны хуулиар энэ алдангийг 20 хувиас хэтрүүлэхгүй гэдэг ийм зүйл байж байгаад, 2019 онд МАН засаг барьж байхдаа алдангийн хэмжээг хязгааргүй болгоод, тэрнээс болоод наад алданги чинь ингэж өсдөг болсон. Энэ бол Ардын намын бий болгосон алдангийн тогтолцоо. Энийгээ засахдаа дөнгөж 50 хувь л гэж байгаа. 2008 оных нь түвшнийг хуулийн түвшинд нь буцааж аваачиж болохгүй юм уу гэж асууж байгаа. Нэг ёсондоо Ардын нам алдаагаа засаж байгаа юм байна. Тэгэхдээ гүйцэд засахгүй байна гэж би ингэж хараад байгаа юм.

Дээрээс нь хууль даган мөрдөлтийнхөө түвшнийг ингээд хэд хэдэн янзаар үнэлж байгаа асуудлыг ярьж байна. 176 мянга орчим санал татвар төлөгчдөөс авсан гэж байна. Тэгээд хуулийн өргөн барьж байгаа зүйлээс харахад 176 мянган санал .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Тэр алдангийн асуудал бол бид нар бусад хууль тогтоомжтойгоо нийцүүлж байгаа л асуудал. Иргэний хуультай нийцүүлж байгаа. Иргэний хууль дээр нийт алдангийн хэмжээ үндсэн төлбөрийн 50 хувиас давж болохгүй гэж байгаа. Тэгэхээр нийтлэг ойлголт руу нь бид нар авчирч байна гэсэн үг. Хэлэлцүүлэг хийгээд бага санал оруулж ирлээ гэж. Энэ бол татварын нэмэлт, өөрчлөлт. Бид нар богино хугацаанд манай эдийн засагт гадаад эдийн засгийн нөлөө өндөр байгаа үед аж ахуйн нэгжүүд, иргэдээ дэмжих, ялангуяа бид нар ажлын байрыг хадгалж үлдэх, бизнесийн орчноо тогтвортой явуулахад богино хугацаанд авч болох тэр арга хэмжээнүүдийн хүрээнд энэ татварын нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Өмнө нь хийсэн хэлэлцүүлгүүд бол татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд хийсэн хэлэлцүүлгүүдээс бид нар хуулийг буцаан татаж аваад, богино хугацаанд эдийн засагт өгөөжөө өгөх тэр иргэд, аж ахуйн нэгжийн эдийн засгийн хүндрэлтэй үед, эрсдэлтэй үед дэмжлэг болох энэ заалтуудыг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирж .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: Яах вэ, нөгөө замд явж байгаад дугуй хагарахаар дугуйгаа хийлээд цаашаа явдагтай л адилхан зүйл. Тийм болохоор амьдрал практик дээр энэ байлгүй л яах вэ. Гэхдээ би энэ хэлээд байгаа нь тэр байна шүү дээ. Та нар жишээлэхэд 2024 оны сонгуулиар манай намын хэд хэдэн хүмүүс нийслэл болон сонгуульд нэр дэвших гэсэн чинь татварын өртэй гээд гараад ирсэн. Бодит байдлаараа тэр өр байхгүй. Тэрэнтэй адилхан тэгээд яаж ч чадахгүй сонгуульд дэвшихгүй үлдсэн. Тэгэхэд энэ онооны механизм, оноо, үнэлгээ тавьчхаад, аж ахуйн нэгжүүдэд оноо буруу тавигдвал тэд нар тэрийгээ хурдан засах тэр боломжийг нь, 7 хоногт засдаг боломжийг нь бий болгох чиглэл рүү ажиллахгүй юм уу. Энэ хууль дээр бол би огт буруу юм оруулаад ирчихсэн гэж ерөөсөө хэлээгүй шүү дээ. Зарим зүйлийг сайжруулах, өшөө анхаарах зүйл 1 дугуй хагарчихсан

тэрийгээ нөхлөө, нөгөө дугуй нь хий багатай байна. Тэрийгээ нэмээд хийлчихгүй юм уу л гэж асууж байгаа.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулна.

3.Мэндсайхан: Засгийн газар өргөн барьсан хуулийнх нь нэмэлт, өөрчлөлтийг танилцуулж байна. Их Хурал одоо хэлэлцэж байна. Ингээд бид нар өнөөдөр хэлэлцээд, хэлэлцэх эсэхийг нь дэмжчих юм бол цаашдаа бид нар хэлэлцүүлгийн шатад та санаа оноогоо тусгаад явах боломж нь байгаа.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Жамбалын Ганбаатар гишүүн алга байна.

Их Хурлын дарга цайны завсарлагагүй явуулаарай гэсэн. Яагаад гэвэл өнөөдөр хэлэлцэх асуудал ихтэй, үг хэлэх гишүүд олон байгаа. Тэгээд Дэгийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу олонхын саналаар хуралдааны цагийг сунгаж болно гэсэн заалтын дагуу цайны завсарлагагүйгээр явуулна. Хуралдааныг сунгалаа.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууна.

О.Номинчимэг: Татварын багц хууль Засгийн газраас оруулж ирсэн. Тэгээд ер нь бол би дэмжиж байгаа. Ер нь энэ татварын бодлого гэдэг бол зөвхөн орлого орлох механизм биш. Өдий хүртэл бас зөвхөн орлого төвлөрүүлэх механизм гэж харж явцуу хүрээнд харж ирснээс болоод олон зүйл гажуудсан юм бол байгаа. Тэгээд Татварын хууль тогтоомж, энэ арга хэрэгсэл бол төрийн маш хүчтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тэгш байдлыг хангах, ер нь төрийн чадамжаа ч гэсэн улс төрийн чиг баримжаагаа ч гэсэн тодорхойлох маш хүчтэй ийм механизм байдаг. Тэгээд энэ удаа Засгийн газраас аж ахуйн нэгжүүдээ иргэдийнхээ татварын дарамтаас хөнгөлж чөлөөлж, эдийн засгийг идэвхжүүлж гэсэн үзэл санаагаар концепцоор бас оруулж ирсэн байна гэж харж байгаа.

Татварын багц хууль ер нь бас түрүү жилээс хойш нэлээн удаан яригдсан. Олон ч хувилбар гарсан. Тэгээд энэ дээр аж ахуйн нэгжүүдтэй бас уулзалт хийгээд явж байхад гол нь шударга бус байна шүү дээ. Процессын асуудал байна. Хувь хэмжээ гэхээсээ илүү процесс нь маш ийм төвөгтэй, дарамттай, дээр нь би энд шударгаар татвар төлөөд байхад хажуугийн аж ахуйн нэгж бол ямар нэгэн байдлаар тэндээс зугтаад, татвар төлөхгүй байгаа байдал байдаг. Тэгээд иргэд бол ер нь тийм шударга бус байдал их байна гэдэг бүх зүйл дээр ажиглагдаад байна гэдгийг бас хэлдэг. Тэгэхээр энэ хуулийн төслийн хувьд дагаж орж ирсэн төслүүдийн хувьд ялангуяа Хүн амын орлогын албан татварын хууль дээр тодорхой хэмжээний иргэдийн орлогыг татвараас 100 хувь чөлөөлж байгааг би бол дэмжиж байна. Энэ байх ёстой. Ингэж байж иргэдийнхээ инфляц өндөртэй байгаа асуудал дээр төр нь татварынх нь дарамтыг багасгаж, амьжиргааг нь, эдийн засгийн эргэлтийг нь сайжруулах тал дээр ийм бодлого авах нь зөв.

Мөн нийтийн өргөдлөөр орж ирсэн тэр үл хөдлөх хөрөнгийн яг орон сууцаа борлуулсан тохиолдолд 2 хувийнх нь татварыг нь байхгүй болгоно гэдэг асуудлыг бас нарийвчилж, илүү алдаа мадаг гаргахгүйгээр оруулж ирсэн байна.

Би энэ хуулиуд дээр ганц л юм асуумаар байгаа юм. Ер нь мэдээж ингээд аж ахуйн нэгжүүдээ дэмжих, хувь хүмүүсийнхээ татварыг багасгах, дарамтыг багасгах юм орж ирж байгаа боловч бүх нийтээрээ энэ шударга татвараа төлдөг тогтолцоог илүү бэхжүүлэхийн тулд энэ хуулиуд дээр ямар нэгэн өөрчлөлт, заалтууд орж ирсэн үү. Татварын Ерөнхий хууль дээр бол ер нь процессыг илүү хөнгөвчилье, илүү стандартжуулъя, илүү аж ахуйн нэгжүүддээ дөхөм болгоё гэсэн юмнууд орж ирж байна. Гэхдээ бас аж ахуйн нэгжүүдийн чинь маш их хэлээд байгаа юм нь шударга бус байна. Би энд шударгаар төлөөд байхад хажуугийн нэг том компани ерөөсөө шударгаар төлөхгүй байна шүү дээ гэдэг юм байгаад байгаа юм. Тэгэхээр татварын бааз суурь гээд манай татварынхан зөндөө л ярьдаг. Энийгээ өргөтгөхийн тулд энэ бүх нийтээрээ шударга татвараа төлдөг тогтолцоог илүү бэхжүүлэх тал дээр ямар нэгэн өөрчлөлтүүд, заалтууд энэ хуулийн төслүүд дээр орж ирсэн үү гэсэн асуулт байна.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Сангийн яамны Татварын бодлогын газар Чимидсүрэн. Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ удаа бол бид нар өмнө нь хэрэгжсэн хэлэлцүүлэг дээр гарсан 176 мянган саналуудаас яг нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулаад Татварын ерөнхий хууль, ингээд 4 хууль дээрээ цөөн тооны иргэдийнхээ яг хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, орлогыг хамгаалсан, аж ахуйн нэгжийнхээ татварын ачааллыг бууруулсан 5, 6 заалттай л зохицуулалтыг оруулж байгаа. Тэгэхээр энэ татварын ачааллыг бууруулах, мөн хялбарчилсан горимын зохицуулалтууд тэгээд ерөнхий хууль дээр орж байгаа тайлангаа засах, дансыг хэсэгчлэн нээж явж байгаа зохицуулалтууд гэх мэтчилэн эдгээр зүйлүүд маань татвар төлөгчдөө л энгийн хялбар байх, ойлголцох тал дээр явж байгаа юм. Тэгэхээр энэ утгаараа бас татвар төлөгчдийг тэгш шударга байх, энгийн хялбар байх талаасаа нэг талаар явж байна.

Нөгөө талаараа татварын албан дээр бас зөвлөн туслах чиглэлийн стратеги гараад бас хэрэгжүүлээд ингээд явж байгаа. Бид нар хууль дээр бол өмнөх төсөл дээр байсан. Энэ удаа бол байгууллагынхаа түвшинд буюу процессын түвшиндээ шийдвэрлэхээр явж байгаа. Тэгэхээр зөвлөн туслах чиглэлийн хүрээнд ер нь татвар төлөгчдөө мэдээллээр сайн хангах, сургалт, зөвлөгөө мэдээллээр хангах юм бол энэ хууль даган мөрдөлтийн энэ үл ойлголцлууд бол төдий хэмжээгээр багасаж, шударга бүх нийтээрээ татвар төлөхөд бол бас нэмэртэй байх болно гэж бодож байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одонгийн Цогтгэрэл дарга асуулт асууна.

О.Цогтгэрэл: Татварын багц хууль гээд нэлээн хэдэн жил дуншиж, нэлээн олон Засгийн газар дамжиж, тэгэхдээ нэлээн шоудаж, пи-ардаж олон л юм болж байж хэлэлцүүлэг эхэлж байна л даа. Үнэхээр орж ирж байгаа энэ хуулиудыг нь харахад үнэхээр хангалтгүй ийм нүглийн нүдийг гурилаар хуурсан ийм л хуулиуд орж ирж байна. Нүглийн нүдийг гурилаар хуурсан гэж бид нар аргацаасан зүйлийг хэлдэг. Тэр аж ахуй нэгж дээр шатлалууд гаргаж, дунд нь 1 шатлал гаргаж байгаа юм байна. Явсаар явсаар энэ нь тэгээд 1 аж ахуй нэгжүүдийг жижгэрэхэд чиглэсэн л нэг өөрчлөлт. Тэр НӨАТ дээр НӨАТ-ын босго нэмж байна л гэж байна. Яг үнэндээ энэ өөрөө НӨАТ-ыг тэгш хүртээмжтэй хамрагдалтыг нэмэгдүүлээд энд бараг бүтнээрээ энд НӨАТ-аа төлдөг байх нь шударга ёсонд нийцэх болохоос биш яг энэ

бол өөрөө дахиад зах зээлээ эвдсэн, зэрэгцээ 2 дэлгүүр, 2 компани, 1 нь НӨАТ төлдөг, 1 нь төлдөггүй энэ зүйлийг хөхиүлэн дэмжсэн урамшуулсан, яг энэ оруулж ирж байгаа Татварын багц хуульд өөрчлөлт, шинэчлэлт үнэндээ алга. Ямар ч зүйл алга энэ дээр.

Тэгээд эцсийн дүндээ яг амьдрал дээр юу болдог вэ гэхээр иргэдэд үнийн өсөлт, эдийн засгийн бодлого, үнийн өсөлтийг яаж барьж, буулгаж, тогтворжуулах юм гэдэг дээр иргэдэд энэ бодлого өөрөө хамгийн чухал ийм цаг үе. Бизнесүүдэд болохоор зээлийн хүү гэдэг зүйл. Тэгэхээр энэ бодлогууд маань яг хаана очиж, яаж энэ үндсэн чиглэл дээрээ үндсэн саяын тэр 2 зүйл дээр яаж нөлөөлөх юм бэ гэдэг 1 дүгээрт нь их сонирхолтой байна. Энэ дээр тооцоо баримт, дүгнэлт байна уу. Энэ Засгийн газраас явуулж байгаа энэ татвар, сангийн бодлогууд чинь явсаар байгаад яг иргэдэд бодит орлогод нь яаж нөлөөлж, үнийн өсөлтөд яаж нөлөөлөх юм. Тэгэхээр үүний цаана би бас холбож хэлэх гээд байгаа нь өнгөрсөн 10 жилийн Засгийн газрын бодлого энэ бүгдийнхээ эсрэг л яваад ирчихсэн. Эсрэг гэдэг нь том төсөл гээд баахан том төслүүд явуулга хийчихсэн. Үүнээс баахан урьдчилгаа гаргачихсан. Энэнээс үр дүнд хүрсэн нэг ч зүйл байхгүй. Нефтийн үйлдвэр гээд таг дундаа ороод гацчихсан. 1 мухар төмөр зам Гашуун сухайт руу аваачаад тавьчихсан. Нөгөө Туулын хурдны зам гээд хэдэн 100 тэрбум гаруй мөнгө төлчихсэн. 1 харахаар энэ улс мөнгөтэй байгаа юм шиг. Нөгөө харахаар Засгийн энэ их мөнгө чинь өөрөө тэр Монгол банканд нь мөнгөний орон зайг нь өгөхгүй, мөнгөний орон зайг нь өгөхгүй болохоор бодлогын хүү өндөр, бодлогын хүү өндөр болохлоор наад инфляц чинь өндөр, инфляц чинь өндөр болохоор зээлийн хүү чинь өндөр. Энэ бүгдийг дагаад юмны үнэ өндөр. Энэ Засгийн газрын эрх баригчдын сая өнгөрсөн 10 жилд явуулсан ийм бодлогын том алдааны нөгөө талд энэ үнийн өсөлт, яг тэрний чинь нөгөө талд энэ Монгол банкны зээлийн хүүгээ өндөр байлгахаас өөр аргагүй энэ нөхцөл байдал дээр л ингээд оччихлоо л доо.

Тэгээд энэ нүглийн нүдийг гурилаар хуурсан ийм л бодлого өнөөдөр ингээд орж ирээд, тэгээд энэ өмнө нь НӨАТ-ын хууль дээр хүртэл бас 1 дэвшилттэй зарим зүйлүүд яригдаж байсан. Хэрэгжиж эхэлнэ гээд хууль явж байсан. Нөгөөдөх нь хэрэгжиж эхлээгүй байтал хүчингүй болгох гэж байгаа юм шиг байна. Тэгэхээр энэ ийм авахад ч хэцүү, хаяхад ч хэцүү. Яг үнэндээ тэр татвар гэдэг зүйл ард иргэдээ хамгаалсан, дундаж давхаргаа хамгаалсан энэ бодлого руу чиглэх ёстой зүйлээ эргээд тэгш, шударга хамрагдалтыг нэмэгдүүлсэн энэ бүгдийнхээ эсрэг ийм бодлого. Аж ахуйн нэгжүүдийг жижгэрэхэд чиглэсэн. Тэгээд үүнээс өөр та нарт ингээд бодлогын сонголт олон зүйлүүд энэ Засгийн газарт, Сангийн яаманд байсангүй юу даа. Үнэхээр харамсалтай ийм бодлого бол орж ирж байна. Энэ дээр нэг байр сууриа илэрхийлээч. Тэгээд би тодруулъя.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Сангийн яам, Улсын Их Хурал аж ахуйн нэгжүүдийн дунд хэлэлцүүлэг хийгээд, эндээс гарч ирсэн нийт саналуудыг нэгтгэж, бид нар Татварын багц хуулийн өөрчлөлтийг хэлэлцэж байсан. Ингээд Их Хуралд өргөн барьсан байсныг Засгийн газар буцаан татсан. Татсан шалтгаан бол Татварын багц хуулийн хэлэлцүүлэг хийгээд явах юм бол намрын чуулган хүрэх юм байна. Бид нар богино хугацаанд гадаад эдийн засгаас нөлөөтэй таны яриад байгаа дотоод инфляц өсөж байна. Инфляцыг бид нар импортоор авч байна. Энэ булангийн оронд үүсээд байгаа энэ газрын тостой

холбоотой асуудлаас болоод үнийн өсөлт үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор Монгол банкны чинь бодлогын хүү өсөөд явж байна. Ингээд эдийн засаг руу мөнгөн урсгал орж ирэхгүй, эдийн засаг агших, царцах ийм байдал руу орох гээд байна. Ийм учраас богино хугацаанд аж ахуйн нэгжүүдээ үйл ажиллагааг нь тогтвортой явуулах, хөдөлмөр эрхэлж байгааг дэмжих энэ бодлогыг богино хугацаанд авч хэрэгжүүлэхийн хүрээнд Засгийн газар оруулж ирсэн татварын нэмэлт, өөрчлөлт юм байгаа юм. Энэ нэмэлт, өөрчлөлтүүд батлагдсанаараа богино хугацаанд аж ахуйн нэгжүүд иргэддээ энэ зах зээлд дэмжлэг өгнө.

Хуулийн төслийн хүрээнд нийт иргэн, аж ахуй нэгжүүдийн татварын ачааллыг 2,2 их наяд төгрөгөөр бууруулахаар тооцоолсон байгаа. Цалин хөдөлмөрийн хөлсний орлогын хувьд сарын 792 мянга хүртэлх орлогод нь ноогдох албан татварыг бид нар 100 хувь чөлөөлнө гэж байгаа юм. Энэ бол хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийнхээ нийтдээ 1 сая 20 орчим мянган иргэн байгаа. Энэ иргэдийнх дээрээ бодит дэмжлэг болгож үлдээе. Ажил эрхэлж байгаа иргэдээ л дэмжье гэж байгаа юм. Аж ахуйн нэгжүүдийн хувьд 90 хувийн хөнгөлөлтийн босгыг 2,5 тэрбум болгосон байгаа. Ингээд нийт аж ахуйн нэгжүүдийн 94 хувь нь 1 хувийн татварын ачаалалтай болгох боломжийг бүрдүүлж өгч байгаа. Харин 6-10 тэрбумын ашигт ажиллагааг нь 15 хувь болгож, дунд нь шатлалтай босго нэмж оруулж ирж байгаа. Ингэснээр том аж ахуйн нэгжүүдийн ачаалал бол 0,3-0,5 хувиар буурч байна. 13 хувьд хүрэхээр байна. Хуулийн төслүүд хэрэв батлагдаад, мөрдөгдөж эхэлснээр богино хугацаанд буюу 2027-2028 онд эдийн засгийн өсөлт бол 0,7 хувиар, өрхийн орлого 3,2 хувиар өснө гэсэн ийм тооцооллыг бид нар гаргаж ирсэн.

Б.Пүрэвдорж: Цогтгэрэл дарга нэмж тодруулъя.

О.Цогтгэрэл: Тэгэхлээр үнэхээр иргэд, аж ахуйн нэгжид яг бодлогын үзүүрт очиж нөлөөлөх хамгийн чухал зүйлүүд иргэдэд юмны үнийн өсөлт, аж ахуйн нэгжүүдэд өрсөлдөх чадварт нь хамгийн ихээр нөлөөлж байгаа энэ зээлийн хүү л байна л даа. Гэтэл яг энэ бодлогууд чинь төрөөс явуулж байгаа, засгаас явуулж байгаа энэ бодлогууд чинь яг энэ бүгд дээр очиж байж жинхэнээсээ яг тэр бодлогын үзүүрт яг хөрсөн дээрээ гэж ярьдаг энэ зүйл болох ёстой. Гэтэл та нар болохоор шалтаг, шалтгааныг өөр газраас л хайж байна. Яг үнэндээ зээлийн хүү, юмны үнийн өсөлт, инфляцын өсөлт чинь өнгөрсөн 10 жилийн төрийн томролт, төсвийн томролт, төрийн өмчит компаниудын томролт, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн эзэрхийлэл энэ олон зүйлүүдээс төр чинь томорчихоор иргэд, бизнесүүдэд орон зай, мөнгө очихгүй л ийм л нөхцөл байдал байгаа юм. Энэ зүйл дээрээ бодлогын өөрчлөлтийг хийсэн бол бараг аяндаа юм чинь ингээд цэгцрээд аяндаа энэ зохион байгуулалт руугаа ороод .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Санал хэллээ. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: 2016 онд татвар нэмэхгүй гэж амлаж гарч ирсэн МАН өнөөдөр 11 төрлийн татвар нэмсэн. Татвар чөлөөлөх, бизнес эрхлэгчдээ дэмжих, иргэдээ бодох, иргэдийнхээ халаастай орлогыг яаж нэмэгдүүлэх биш, яаж байгаа бүгдээс нь хуу хамах вэ гэдэг бодлого явуулсан. Хуу хамдаг. Жижиг, дунд бизнес эрхэлнэ гэдэг бол Монголд өнөөдөр эрүүгийн ял болсон. Би энэ үгийг дахиад хэлье. Тухайн бизнес эрхлэгч яадаг вэ гэхээр өөртөө хамгийн бага цалинг тавиад, хамгийн бага нийгмийн даатгалын шимтгэл төлөөд, ажлаа бодоод, ажилтнаа бодоод, дөнгөж өндийж бойжиж байгаа, үүсгэн байгуулж байгаа компаниа бодоод, өөрийгөө

нийгмийн бүх халамжаас ингээд хаяж орхидог. Үр дүнд нь яадаг вэ гэхээр хамгийн бага нийгмийн даатгалын шимтгэлтэй хүн цалингийн зээл гардаггүй, ипотекийн зээл гардаггүй, виз гардаггүй. Ингээд тэр хүн жижиг, дунд бизнес хийгээд анхлан бизнес эрхэлснийхээ төлөө эрүүгийн ял үүрэх ийм хэмжээнд оччихдог. Тэгээд энэ бизнесийн бодлого дээр ямар байгаа юм бэ.

Монгол Улсын татвартай холбоотой 30 хууль байгаа. Хамгийн багадаа 1 удаа өөрчлөгдсөн. Хамгийн ихдээ 58 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. 58 удаа. Энэ нь өөрөө юуг хэлээд байна вэ гэхээр татварын орчин, бизнесийн орчин, эдийн засгийн орчин, зах зээлийн орчин чинь эрүүл бус тогтворгүй байна гэсэн үг.

2016 онд та нар засаг авснаас хойш ийм арга хэмжээ л байна. Аж ахуйн нэгжүүд чинь байдгаа барьж байгаа шүү Мэндсайхан сайд аа. Өнөөдөр хардаа 263 мянган хуулийн этгээд жишээ нь Монгол Улсад бүртгэлтэй. Түүний 44 хувь нь л үйл ажиллагаа явуулдаг. 44 хувийн 90 хувь нь 1-9 ажилтантай л компани байгаа. Бид нар чинь худалдааны эдийн засагтай байхгүй юу. Тэгээд худалдааны эдийн засагтай энэ улсаа анхан шатных нь бизнес эрхлэгчтэй дэмжиж байгаа бодлого Монгол Улсад байхгүй. Яаж бүгдийг нь хуу хамах вэ, яаж бүгдийг нь авч чадах вэ гэдэг л ийм татварын орчин, бодлоготой. Нийслэлийн татварыг 2 дахин нэмсэн. Тээврийн хэрэгслийн татварыг 5 дахин нэмсэн. Авто зам ашигласан татварыг 3 дахин нэмсэн. Иргэдийн банканд хадгалдаг багахан хадгаламжаас нь хүртэл хүү тооцдог болсон. Газрын төлбөр нэмсэн. Суудлын автомашины онцгой албан татвар нэмсэн. Өнөөдөр манай Монгол Улсын татварын бодлого яаж хөдөлмөр эрхэлж байгаа, яаж аж ахуйн нэгж ажиллуулж байгаа, яаж хүн цалинжуулж байгаа тэр бүтцээ яруу тодоор хуу хамах вэ гэдэг ийм татварын бодлоготой.

Тэгээд энэ Татварын багц хуулиудыг ер нь дахиад бүр цогцоор нь олон нийтийн хэлэлцүүлэг хиймээр байгаа юм. Бизнесийн компаниудтай, жижиг, дунд бизнес эрхлэгчтэй, ХАҮТ-тай. Давхар Хөрөнгө оруулалтын хуулийг оруулж ирмээр байна. Өнөөдөр ТҮЦ ажиллуулж байгаа хүн хүртэл хөрөнгө оруулагч шүү дээ. Гэртээ байгаа багахан мөнгөнөөсөө хөрөнгө оруулаад, ТҮЦ ажиллуулж байгаа байхгүй юу. Тэр хүн чинь хөрөнгө оруулагч шүү дээ. Ажлын байр бэлтгэгч шүү дээ. Өөрөө өөртөө ажлын байр шүү дээ. Энэ бүгдийг нь хүртэл манайхан бүгдийг нь яадаг юм, устгадаг ч юм уу бүр нэг тийм хүнийрхүү хандлагатай гэх юм уу. Өнөөдөр 10 ажилтантай, тоног төхөөрөмжийн бизнес хийдэг, жилд 2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой компани бараг 200-аад сая төгрөгийн зөвхөн татвар төлж байна шүү дээ. Тэгээд дээр нь НДШ компаниас, хувь хүнээс, Хүн амын орлогын албан татвар гээд нийт орлогын чинь бараг 30 хэдэн хувь нь зөвхөн татварт явчхаж байна. Тэгэхээр хүн хэнийг ажиллуулахыг хүсэх юм бэ. Хамгийн гол нь бид нар ингээд ажлын байрыг бэлдэнэ гээд байна. Энэ ном дээр чинь байна лээ шүү дээ. 1,5 сая ажиллах хүчтэй болно гээд. Үгүй ээ, 1,5 сая ажиллах хүчийг чинь бид нар ажлын байраар хангах ёстой шүү дээ. Зах зээлийн орчныг нь бий болгож өгөх ёстой шүү дээ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханы урилгаар Улаанбаатар төмөр замын Сайншанд өртөөний замын 4 дүгээр ангийн ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Манай Дэлгэрсайхан сайд энэ зам, тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа ийм идэвхтэй сайд шүү гэдгийг хэлье.

Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

3.Мэндсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2025 оны эцсээр нийт татварын байгууллагад тайлагдсан 191 мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Тэгэхээр 260 мянгаас 40 хувь нь л үйл ажиллагаа явуулж байна гэдэгтэй бол зөрүүтэй байна. Энийг бас тоо, баримттай нь хэлье.

Ер нь бол яах вэ, тантай санал нэг байна. Өнөөдөр аж ахуйн нэгжүүд маань бизнесийн орчин, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаараад үйл ажиллагаа явуулахад эдийн засгийн хувьд, мөн олон улсын геополитикийн хувьд тийм таатай орчин биш байна. Тийм учраас л энэ хуулийг Засгийн газар яаралтай, богино хугацаанд өргөн барьж байгаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд хэлбэрээр өргөн барьж байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татварыг аж ахуйн нэгжүүд дээр дарамт болж ирдэг гэж байна. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвар бол худалдааны татвар байгаа. Аж ахуйн нэгжүүддээ энэ хуулийн өөрчлөлтөөр юу оруулж ирж байна гэхээр 2 сарын дараа нэмэгдсэн өртгийн албан татвараа төлөх тэр боломжийг нь бүрдүүлж оруулж ирж байгаа. Та түрүүн хэллээ. Худалдааны эдийн засагтай байна гэж. Тэгэхээр манай улсын хувьд импортын аж ахуйн нэгжүүд маань ихэвчлэн импортын бараа бүтээгдэхүүнийг оруулж ирж байгаа. Ингээд гааль дээр гаалийн татвараа төлөөд, нэмэгдсэн өртгийн албан татвараа тухайн бараа, үйлчилгээг худалдан авсан өртгөөрөө нэмэгдсэн өртгийн албан татварыг урьдчилж төлдөг байсан.

Энэ хуулийн өөрчлөлтөөр бол бид нар бараа үйлчилгээгээ, импортоор оруулж ирсэн бараа таваараа худалдан борлуулсны дараа буюу ашгаа хүртсэний дараа 2 сарын дараа төлөх тэр боломжийг нь оруулж өгч байгаа. Мэдээж ажлын байрыг хадгалах чиглэл дээр санал 1 байна. Тэр хүрээнд хөдөлмөр эрхэлж байгаа 1 сая 20 орчим мянган иргэн байх шиг байна. Энэ иргэдээ бүгдийг нь ажлын байран дээр нь тогтвортой байлгая. Тэдэн дээр бодит дэмжлэг үзүүлье гэж энэ хүн амын орлогын албан татвар дээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 792 мянган төгрөгөөр чөлөөлж өгье. Оны эцэст нийтдээ 950 мянган төгрөг 1 хөдөлмөр эрхэлж байгаа хүнд буцаалт хэлбэрээр орно гэдэг ийм байдлаар татварын хөнгөлөлтүүдийг тооцож оруулж ирлээ.

Таны тэр цаашдаа энийг бид нар хэлэлцүүлэх шаардлагатай байна гэж. Хэлэлцүүлгүүд бол хангалттай хийгдсэн байгаа. Зүгээр одоо бид нар дахиад дахиад Татварын багц хуулийг оруулж ирэхдээ таны хэлж байгаа саналын дагуу бид нар хамтдаа энийг хэлэлцэх хэрэгтэй. Тэр том бизнес эрхлэгчтэй нь ч уулзах ёстой, ХАҮТ-тай, орон нутгийн салбар танхим, зөвлөлүүдтэй, татвар төлөгч аж ахуйн нэгжүүдтэйгээ дахин энэ уулзалтыг зохион байгуулж, эцсийн хэлбэрээр буюу татварын багц хуулиар оруулж ирнэ. Энэ бол богино хугацаанд үр дүнгээ өгөх буюу эдийн засаг, нийгмийн энэ хүндрэлтэй үед аж ахуйн нэгж, иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр оруулж ирж байгаа хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж хэлэх байна.

Б.Пүрэвдорж: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Тийм бид нар чинь нийт манай компани тэдэн 100 мянга байна, тэдэн хүн татвар төлж байна гээд яг бодит тоог нь задлаад харахаар 1-10

ажилтантай компани чинь нийт аж ахуйн нэгж чинь 90 хувь байгаа шүү дээ 90 хувь. Тэгээд ийшээ чиглэсэн бодлого Татварын багц хууль дээр чинь алга гэж байгаа юм.

2 дугаарт яагаад татварын багц хууль орж ирж л байгаа юм бол, ийм олон татварын хуулиуд орж ирж л байгаа юм бол Хөрөнгө оруулалтын хууль чинь хаана байгаа юм. Хөрөнгө оруулалтын хууль чинь яагаад байхгүй байгаа юм. Жишээ нь би дахиад хэлье Мэндсайхан сайд аа. ТҮЦ эрхэлж байгаа хүн хүртэл хөрөнгө оруулагч шүү дээ. Гадаад, дотоодын гэж ялгаж ярих гэж байгаа бол дотоодын хөрөнгө оруулагч байхгүй юу. Өнөөдөр Нарантуул зах дээр шорлог хийж байгаа хүн ч бизнес эрхлэгч шүү дээ. Нэг талаасаа хөдөлмөр эрхэлж байгаа хүн шүү дээ. Тэгээд бид нар ийм хүмүүс рүүгээ, анхан шатныхаа бизнес рүүгээ явахгүй зөвхөн том татвар төлөгч рүүгээ чиглэсээр байгаад энэ бизнесийн орчин чинь өөрөө ийм хумигдмал болчихлоо.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд нэмж хариулъя.

3.Мэндсайхан: Засгийн газар, Ерөнхий сайдын бодлого бол эдийн засаг, бизнесийн орчинд хамгийн их чөдөр тушаа болж байгаа бүх зүйлийг чөлөөлье л гэж байгаа юм. Энэ хүрээндээ Бизнесийн эрх чөлөөний хууль буюу чөлөөлөх хөдөлгөөний хүрээнд бид нар хуулийг ирэх 7 хоногт Засгийн газар хэлэлцээд, ойрын хугацаанд Их Хуралд өргөн барина. Энэ бизнесийн эдийн засгийн салбарт одоо аж ахуйн нэгжүүд дээр таны саяын дурдаад байгаа шиг асуудал болоод байгаа, чөдөр тушаа болоод байгаа нийтдээ 200 орчим хуулиудыг нэгтгэж оруулж ирнэ. Хөрөнгө оруулалтын асуудлаар, Татварын асуудлаар, бизнесийн асуудлаар, газрын асуудлаар, тусгай зөвшөөрлүүдийн асуудлаар энэ бүгдийг нэгтгээд Бизнесийн эрх чөлөөний хуулийг ирэх 7 хоногт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, Их Хуралдаа өргөн барина.

Б.Пүрэвдорж: Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуулт асууна.

Р.Эрдэнэбүрэн: 2008-2012 он, 2012-2016 он гээд Ардчилсан нам засагт оролцож байхдаа, засаг барьж байхдаа энэ татварын өөрчлөлтүүдийг бас нэлээн хүчтэй хийж байсан юм. 4/10-ын бодлого эд нар гээд. Тэгээд гол санаа нь нөгөө татвар төлөгчийнхөө сууриа өргөсгөх, яаж олон татвар төлөгчтэй болох вэ гэдэг ийм чиглэл рүү их томоохон алхмууд хийж байсан. Сүүлдээ сүүлийн жилүүдэд бол татварын ачаалал нэмэгдсэнээс болоод энэ суурь чинь өөрөө ширгээд, хэцүү байдалд орж байгаа учраас буцаад маш олон аж ахуйн нэгжүүд татан буугдаад, татвар төлж чадахаа болиод, жижгэрээд ийм болсон учраас буцаад бас өөрчлөлт хийх гэж оролдож байх шиг байна. Би энэ Татварын хуулийн талаар ямар өөрчлөлт орж байгаа талаар аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс ч гэсэн тэр ер нь маш их сонирхож байгаа учраас дахин дахин асуугаад, яг ямар өөрчлөлт орж байгаа юм бэ гэдгийг хэлүүлээд баймаар санагдаад байгаа юм.

Би өөрөө мэдэж авахаасаа илүү энэ аж ахуйн нэгжүүд энэ өөрчлөлтийн дагуу бас энэ ажлаа төлөвлөдөг. Тийм учраас энэ татвар төлөлтийн чинь яг үндсэн концепц нь юу юм, яг хуучнаасаа ямар ямар өөрчлөлт орж байгаа юм бэ гэдгийг дэс дараалаад хэлээд өгөөч гэж хүсмээр байна.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр татварын өөрчлөлтийн үндсэн концепц бол дахиад хэлье. Иргэн өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээс гадна олон улсын нөхцөл байдалтай уялдуулаад богино хугацаанд эдийн засагт нөлөөлөл үзүүлэх тэр заалтуудыг л бид нар нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирж байгаа. Хуулийн төслийн хүрээнд нийт иргэн, аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг 2,2 их наядаар бууруулна.

Татварын ерөнхий хууль дээрээ бол бид нар ямар өөрчлөлт орж ирж байна гэхээр татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг үнэлэх, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих механизмыг бий болгож, хууль тогтоомжийг сайн дураар дагаж мөрдөхөд нь чиглэсэн тогтолцоог хэрэгжүүлье. Татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчийн санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй хүндрэл эрсдэлийг харгалзан дансыг бүхэлд нь битүүмжлэх бус орлогын тодорхой хувийг суутгах, дансыг хэсэгчлэн битүүмжлэх замаар татварын өрийг төлүүлэх боломж бүхий зохистой үе шаттай арга хэмжээ авдаг болъё. Татвар төлөгчдийн их хэмжээний алданги тооцуулах эрсдэлээс хамгаалах зорилгоор алдангийн дээд хэмжээг Иргэний хуультай нийцүүлье. Нийт үндсэн төлбөрөөс 50 хувиас хэтэрч болохгүй гэдэг. Татварын хяналт шалгалтаар ноогдуулсан нөхөн ногдуулалтын актын алданги, торгуулийг татвар төлөгч, маргаан таслах зөвлөл шүүхэд гомдол гаргасан тохиолдолд гомдол шийдвэрлэгдэхээс өмнө татварыг нэхэмжлэхгүй байх ийм ийм зохицуулалтуудыг оруулж ирж байгаа. Мөн тайлангаа задруулах хугацааг нь 2 жил болгож нэмж өгч байгаа.

Татварын алба хоорондын татварын зорилгоор автоматаар харилцан мэдээлэл солилцох тэр стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүргийг хэн хэрэгжүүлэх юм. Шаардлагатай мэдээллийг бүрдүүлж, уг мэдээллийг тогтсон хугацаанд нь олон улсын жишигт нийцсэн хэлбэрээр нь бусдад гишүүн оронд хүргүүлэх нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг холбогдох байгууллага, эрх бүхий этгээд нь олгоё гээд ийм ийм зохицуулалтыг Татварын ерөнхий хууль дээрээ оруулж ирж байгаа. Ер нь зүгээр хуулийн хүрээнд бол дахиад та дахиад хэлээд бай гэсэн учраас дахиад хэлье. Хуулийн төслүүдийн хүрээнд нийт иргэн, аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг 2,2 их наядаар бууруулна. Цалин, хөдөлмөрийн хөлсний орлоготой иргэдийн хувьд буюу хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийнхээ сарын цалингийн 792 мянга хүртэлх орлогод ноогдох орлогын албан татварыг бол 100 хувь чөлөөлье.

Аж ахуйн нэгжүүдийн хувьд 90 хувийн хөнгөлөлтийн босгыг 1 хувийн татвар төлдөг дээд босго нь 1,5 тэрбум байсан. Энийг 2,5 тэрбум болгож нэмэгдүүлж өгье. Томоохон аж ахуйн нэгжүүд маань 6-10 тэрбумын ашигт 15 хувийн татвар ноогдуулах босгыг дунд нь оруулж өгье. Энэ чинь шууд 6 хүртэл 10, түүнээс дээшээ 25 байсан. Энэ 2-ын дунд 15 гэдэг шатлалыг оруулж өгье. Хуулийн төслөөр батлагдах юм бол богино хугацаанд эдийн засгийн өсөлт 0,7 хувь ирэх жил өсөх боломж харагдаж байна. Иргэдийн маань өрхийн орлого 3,2 .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Өдрийн мэнд хүргэе. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэж байна. Яах вэ, татварын ерөнхий нөгөө зарчимтай холбогдолтой энгийн ойлгомжтой байх, хүмүүс аль ч түвшний бас татвар

төлөгчид ойлгох гэдэг энэ агуулгаасаа бас жоохон зарим зүйлүүд нь арай өөр төвөгтэй байдлууд бий болчих вий дээ гэсэн ийм эмзэглэл байна.

Тийм учраас би бас хэд хэдэн зүйл тодруулж асууя. Мөн дээрээс нь суурь асуудал байгаад байгаа. Бүгд ер нь татварт жигд төлөх тухай асуудлыг бас бид бүхэн янз янзын байдлаар үндсэндээ тойруулаад яваад байна. Тэгэхээр энэ суурь зарчмуудыг хангах чиглэл дээр жишээлэх юм бол энэ 76 дугаар зүйл дээр татвараа сайн төлөөд, энэ хуулиа даган мөрдөөд байх юм бол оноожуулалттай болох ийм зохицуулалт бол орж ирж байх шиг байна. Тэгэхээр татвар төлөгчдөө бас л ингээд жоохон төвөгтэй байдал руу бас оруулахгүй юу. Тэдэн оноо авсан сайн, муу гэдгээр нь дүгнээд юмнууд явна. Үүний бас сайн үр өгөөжтэй тал нь юу вэ. Улам л тийм ойлгомжгүй, төвөгтэй ийм ангилсан, заагласан энэ байдал бол эсрэгээрээ яг энэ татварын суурь зарчмынхаа үндсэн энэ санааг эвдсэн ийм нөхцөл байдлууд бас бий болох юм биш үү гэсэн эхний асуулт байгаа.

2-т нь шинээр орж ирж байгаа бас зохицуулалтууд нэлээн ерөнхий байдалтай орж ирж байгаа. Нарийвчлан зохицуулах яаж, хэн үндсэндээ энэ оноожуулалтын асуудлуудыг шийдэх энэ тэр гэдэг энэ зохицуулалтууд дээр бол нэлээн тодорхойгүй байна. Тийм учраас ялангуяа энэ хөдөө аж ахуйн салбар малчдын хувьд энэ оноожуулалтын асуудал, бусад шинээр орж ирж байгаа саналууд яаж буух вэ гэдгийг бас энгийнээр та бүхэн маань бас тайлбарлаж өгөөч ээ.

Яг одоогийн байгаа нөхцөл байдал дээр бол сая зүүн бүсийн хөдөө аж ахуйн зөвлөгөөн дээр бас нэлээн олон үйлдвэрлэгчид, малчид бас энэ хялбаршуулсан горимтой холбогдолтой асуудлыг бас хөндсөн. Энэ татварын байцаагчдын ажлыг мах худалдаж авч байгаа үндсэндээ аж ахуйн нэгжүүд бол үндсэндээ хийгээд байна. Тэгээд жилийн эцэст нөгөөдхөө бүртгүүлсэн, бүртгүүлээгүй гэдэг байдлаар 1 хувийн боломжоо авч чадахгүй, 10 хувийн татвар төлнө гээд буцаагаад бид нар дээр ирж гомдол мэдүүлж байна. Тэгэхээр энэ энгийн байх, ойлгомжтой байх, хялбаржуулсан горимыг үндсэндээ нэвтрүүлэх энэ чиглэлийн ажлууд дээр яг ямар ажлууд бас хийгдэж байгаа вэ. Бүртгэл, мэдээлэлтэй холбогдолтой, сайжруулалттай холбоотой санал хуулийн төсөл дээр бас тусгагдсан байх шиг байна. Тэгэхээр энэ чиглэлийн ажлууд бас байх уу. Энийг илүү сайжруулахгүй бол бас бодит нөхцөл байдал дээр бол нэлээн төвөгтэй ийм байдлууд бий болж байна. Уг нь бид бүхэн хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бас хэд хэдэн төрлийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх ажлыг зохион байгуулж байгаа. Гэхдээ үүний цаана байгаа энэ бүртгэл мэдээлэл энэхүү зохион байгуулалтаас болоод бас олон асуудлууд яг ингээд тулж байна. Тэгээд энийг илүү сайжруулах чиглэл дээр бас тодорхой ажлуудыг бид нар зайлшгүй хийх хэрэгтэй байна. Тэгэхээр энэ зүйлүүдийг тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ хууль бид нар татвар төлөгчийг илүү л хүндрэлгүй, ойлгомжтой болгох чиглэлд л зориулж энэ өөрчлөлтүүд орж ирж байгаа. Энд ойлгомжгүй гэхээсээ илүүтэй бид нар илүү энгийн хялбаршуулъя гэж. Татвар төлөгчийн босго жижиг аж ахуйн нэгжүүдэд маань жижиг, дунд үйлдвэрлэлүүд маань 1,5 тэрбумын босготой байсан бол 2,5 тэрбум болгож өгье. НӨАТ-ын босго 50 сая байсан бол 400 сая хүртэлх дээр НӨАТ-ын босго тавьж өгье. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг нь хойшлуулж өгье. Иргэдийнхээ орлогыг орлогын албан татвараас тодорхой цалингийнх нь хэсгийг

чөлөөлж өгье. Мөн татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшнийг энэ үнэлэгч нь өөрөө мөрдөлтийн түвшнийг тодорхойлж, татвар төлөгчдөд энэ үнэлгээг явуулснаараа хууль даган мөрдөх энэ идэвх нь бий болдог. Мөн нөгөө талдаа татвар төлөгчийг татварын өөрчлөлтөөс сэргийлнэ. Энэ мэдээллүүд маань нээлттэй явна. Сар, улирал бүр тайлагнаад явна. Ер нь бол татварын байгууллага цаашдаа зөвлөн туслах байна гэдгийг энэ хуулиар оруулж ирж байгаа. Нэмээд Чимидсүрэн дарга хариулчих.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Цэндийн Баатархүү. Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар. Цогтнаран. Хувь хүний орлогын албан татварын тайлангийн 2025 оны жилийн эцсийн тайлангаар бол 2 сая 466 мянган иргэнээс тайлан хүлээж авсан. Үүнээс 99 мянган татвар төлөгч нь хялбаршуулсан горимоор татварын тайлангаа ирүүлсэн байгаа. Өөрөөр хэлбэл хялбаршуулсан горимоор 1 хувийн татвар ХХОАТ дээрээ ноогдуулсан гэсэн ийм мэдээ байна. 1 хувийн тайлангаа ирүүлж байгаа.

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүн нэмж тодруулъя.

М.Ганхүлэг: Яах вэ, яг асуултдаа бүрэн хариулт авч чадахгүй байна л даа. Илүү ийм төвөгтэй байгаа байдлуудыг яаж сайжруулах вэ л гэж асуугаад байгаа юм. Орж ирж байгаа өөрчлөлтүүд нь бас хөдөө аж ахуйн салбар, яг малчдын хувьд яаж буух вэ гэдэг дээр та хэд маань бас ойлгомжтойгоор тайлбарлаад өгөөч. Тайлан гаргах улиралтай холбогдолтой мал аж ахуйн салбарт бас яг тэр 3 дугаар улиралд байдаг юм уу, яг тэр ид ажлын үед нь бас давхцаад байгаа асуудлууд байгаа юм. Хөдөө аж ахуйн орлогыг болон бусад орлогыг тусгаарлах ийм аргачлал нарийн бус ийм байдлууд бас байгаа.

Орон нутгийн татварын байгууллагуудын чадавх, мэдээлэл өгөхтэй холбогдолтой ийм нарийн асуудлууд бол байгаа. Тэр 1 хувийн үндсэндээ хялбаршуулсан энэ горимд бүртгүүлэхтэй холбогдолтой асуудал, сүлжээний асуудал гээд ингээд үндсэндээ техникийн асуудлаас энэ тэр болоод ингээд болохгүй байгаа асуудлуудыг бид нар ер нь яах вэ гэдэг ийм нарийн асуудлуудыг л би асуугаад байна л даа. Энэ чиглэлээр үндсэндээ сайжруулах чиглэлийн ажлуудыг яах вэ.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя. Ажлын хэсгийг 4 дүгээр микрофон хариулъя.

Ч.Чимидсүрэн: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Тэгээд түрүүний хууль даган мөрдөлтийн түвшин дээр бас төвөгтэй байдалд оруулав гэдэг дээрээс нэмэлт хэлчихье. Одоо мөрдөж байгаа хуулиар, мөн практик дээр бид нар яаж байна гэхээр аж ахуйн нэгж, байгууллагынхаа эрсдэлийн үнэлгээг тооцдог тийм системтэй. Мөн бизнес скоринг гээд үнэлгээ өгдөг ийм бас тогтолцоотой. Тэгээд аж ахуйн нэгж, байгууллага маань тэрийгээ хараад, тэрэнд нь үндэслээд ер нь манай оноо ямар байна, бид нар хууль даган мөрдөлтийн түвшин ямар байна вэ гэдгийг нь бид нар тодотгоод, энэ Татварын ерөнхий хууль дээр хууль даган мөрдөлтийн түвшнийг нь тогтоох ийм нэмэлт зохицуулалтыг оруулж ирж байгаа юм байна. Эдгээр маань уялдаад хууль даган мөрдөлтийн түвшин сайтай тийм татвар төлөгчдөө татварын

ийм бодлогоор дэмждэг, түрүүний хэлснээр татвар төлөх НӨАТ төлөх хугацааг нь 2 жилийн хугацаагаар хойшлуулах гэх мэтчилэн ийм зохицуулалтуудыг нь нарийвчилж орж өгч байгаа юм.

Тэгээд журамд оруулахгүйгээр хуульд оруулахаар ингээд бичигдсэн учраас арай их харагдаж байсан байж магадгүй. Өмнө та бас асууж байсан. Энэ асуудлаар .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Ч.Чимидсүрэн: Татварын ерөнхий газраас бичгээр хариу давхар явж байгаа юм байна. Тэгэхээр ер нь бол иргэд дээр ердийн горимоор тайлагнах, хялбаршуулсан горимоор тайлагнах гэсэн ийм 2 асуудал байгаа. Тэгэхээр ердийн горимоор тайлагнаагүй тохиолдолд буюу өөрөөр хэлбэл хялбаршуулсан горимоор явъя гэвэл тэр хүн заавал хүсэлтээ өөрөө гаргах ёстой болчхоод байгаа юм. Тэгэхээр тэр хүсэлтээ гаргаагүй болохоороо л нөгөө ердийн горим руу очиж нөгөө хугацаанд нь хүсэлтээ гаргаагүй учраас ердийн горимоор тайлагнах болоод тэр 10 хувь руу очих болоод байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ дээр нь Татварын алба бол сүүлийн үед зөвлөн туслах буюу энэ мэдээ мэдээллээр хангах чиглэлээр нэлээдгүй ажиллаж байна. Дээр нь салбарын онцлогтой холбоотой нарийвчилсан ийм зөвлөгөө, мэдээлэл, зөвлөмжийг гаргах ийм зохицуулалтууд дээр бас анхаарч ажиллах нь зүйтэй байгаа.

Б.Пүрэвдорж: Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Татварын ерөнхий хуулийн өөрчлөлт бас орж ирж байна. Энэ дээр үндсэндээ Монголын нийгэмд манай аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэд дээр хамгийн хүндрэлтэй байгаа асуудал бол өөрөө татварын асуудлууд байгаа. Үндсэндээ Монгол Улсад бизнес эрхэлье, ажил үйлчилгээ явуулъя, ажил хөдөлмөр эрхэлье гээд яваад үзэхээр үндсэндээ санхүүгийн дарамтыг бууруулахгүй бол энэ хүндрэл бэрхшээл асуудлын шалтгааныг нь шийдвэрлэхгүй бол цаашид нөхцөл байдал хүнд байна гэдэг асуудал байгаа. Тэгэхээр би зүгээр энэ татварын суурь реформыг суурь юу гэдэг юм агуулгаар нь, үндсээр нь өөрчлөхгүйгээр асуудлууд шийдвэрлэгдэх боломж, бололцоо байхгүй байна. Та хэд энэ асуудлуудаа томоор нь харж чадаж байгаа юм болов уу.

Үндсэндээ бид бүхний хувьд өнгөрсөн энэ зах зээлийн нийгэмд шилжсэн 35 жилийн хугацаанд энэ хувийн хэвшил дээрээ суурилсан хүчирхэг эдийн засгийг ерөөсөө л бий болгочихдог болчхоод байгаа юм. Хувийн хэвшил дээрээ суурилсан хүчирхэг эдийн засаг. Тэгээд энэ хүрээндээ бид нар хувийн хэвшлийг дэмжиж чадаагүй учраас эсвэл юу гэдэг юм, хувийн хэвшилдээ үүссэн тэр дарамт ачааллуудыг нь бууруулж чадаагүй учраас үндсэндээ ажлын байрыг ч дорвитой шинээр бий болгож чадсангүй, ядуурлын түвшнийг ч бууруулж чадсангүй. Яг л ерөнхийдөө нөхцөл байдлууд өөрөө бахь байдгаараа байгаад байдаг ийм нөхцөл байдалд байна. Тэгэхээр үндсэндээ татвар бол өөрөө нийгмийн шударга ёсны хэмжүүр болчхоод байгаа юм. Энэ шударга ёсны хэмжүүрийг бид нар зөв шийдэхийн тулд энэ иргэд, аж ахуйн нэгжүүд дээр байгаа эрх ашгийг нь хамгаалахын тулд сууриар нь, томоор нь, бодлогоор нь хийх зайлшгүй шаардлага байна гэж хараад байгаа юм. Тэрнээс одоо бол бид нар зүгээр өнгөц 3, 4 татвараар

гэдэг юм уу, 3, 4 юу гэдэг юм хувь хэмжээгээр ч гэдэг юм уу бууруулаад асуудал шийдэгдэхгүй нь бол ойлгомжтой болчхоод байгаа асуудал байгаа юм. Тэгэхээр энийг та хэд том сууриар нь бас дахиж харж үзээч ээ.

Одоо бол үндсэндээ бид нар өнгөрсөн 35 жилийнхээ татвар санхүүгийн, эдийн засгийн тогтолцоотой холбоотой суурь асуудлаа шийдэхгүй бол хүн болгон дээр хамгийн том асуудал өөрөө энэ байдаг шүү дээ. Үүний хамгийн бодит жишээ зүгээр энгийн асуудлууд, аж ахуйн нэгжүүд дээр яах вэ татвартай холбоотойгоор судалгаа хийж үзлээ л дээ. Тэгээд хамгийн том та бүхэнд санхүүгийн ачаалал дарамт чинь хаана байна гээд аваад үзэхээр үндсэндээ хууль болоод түүнтэй холбоотой эрх зүйн орчны асуудал бол нийт аж ахуйн нэгжүүдийн чинь 56 хувь нь хэлээд байна. Зээлийн хүүгийн дарамт буюу энэ санхүүжилтийн зардал чинь үндсэндээ асар их байна гэдэг асуудал чинь 43 хувь болчхоод байгаа юм. Энэ чинь бас л татварынхаа тогтолцоотой уялдаж холбогдоод байгаа бид бүхний бодлогын алдааны шийдлээс гараад байгаа асуудал болчхоод байгаа юм.

Тэгээд татвар шиг шахуу энэ нийгмийн даатгал чинь бас өнөөдөр үндсэндээ бид нарт нуугдмал татвар шиг энэ асуудлыг бол дагуулж байна. 24 хувь нь энэ асуудлыг гаргаж ирж байна гэдэг асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр хүссэн хүсээгүй бид нар эдийн засгийн оновчтой, зөв бодлого, татварын зөв оновчтой яг хүрсэн бодлогыг хийхгүй бол үндсэндээ энэ зээлийн хүү, НДШ, дээрээс нь дахиад 5, 6 дахь асуудал орж ирэх нь инфляцын асуудал. Энэ чинь бас ингээд давхар, далд утгаараа татвар болчхоод аж ахуйн нэгж, байгууллагууд чинь энэ доороос гарч ирж чадахгүй. Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд өөрөө бага багаар хорогдоод дампуураад байгаа асуудлууд чинь хамгийн том асуудал болчхоод байна. Ажил хөдөлмөр эрхлэхийг хүсэхгүй байгаад байгаа нийгмийн масс маань бол үндсэндээ суурь бас асуудал болчхоод байна. Тэгэхээр сууриар нь энэ эдийн засгийг өөрчлөх, татварын тогтолцоог нь өөрчлөх энэ хувийн хэвшлийг дэмжсэн суурь том бодлогыг гаргаж ирэхгүй бол болохгүй болчхоод байна. Ковидын үед 1200 гаруй аж ахуйн нэгж, байгууллагууд үүд хаалгаа хааж байсан гэсэн. Тэгсэн өнгөрсөн жил 4000 хаасан гэж ярьж байгаа. Гэтэл бид нар эсрэгээрээ эдийн засаг 6, 7 хувийн өсөлттэй байгаад байдаг, GDP өсөөд байна гэж яриад байдаг, тэр хэмжээгээр юу гэдэг юм яг бодитоор хөрсөн дээр хэдэн хувь эдийн засгаар тэлж байгаа юм. Хэчнээн ажлын байрыг бид нар шинээр бий болгож байгаа юм. Хэчнээн шинэ компаниуд гарч ирлээ, шинэ салбар хөгжлөө гэдэг асуудлууд байхгүй болчхоод байна. Тэгэхээр энэ дээр харахгүй бол үндсэндээ тоо статистикууд сайнгүй байна. 242 мянган тайлан ирүүлэх ёстой аж ахуйн нэгжүүдээс 69 хувь нь буюу бараг 70 хувь нь 0 болон алдагдалтай тайланг ирүүлж байна гэж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр тоо статистик сайнгүй байна гэж үүнтэй санал нэг байна. Өнгөрсөн жил татвар тайлагнасан нийтдээ 191 мянган аж ахуйн нэгж тайлан гаргаж өгснөөс 70 орчим мянга нь л ашигтай ажилласан байна. Бусад нь бүгд алдагдалтай ажилласан байна. Тийм учраас тантай санал нэг байна. Бид нар энэ богино хугацаанд сууриар нь татварынхаа реформыг хийх ёстой гэж. Тэгэхээр Засгийн газар нэн тэргүүнд татварын суурь реформ буюу багц хуулиараа биш богино хугацаанд эдийн засагт аж ахуйн нэгжүүдэд маань тодорхой хэмжээний дэмжлэг өгөх заалтуудыг оруулж

ирсэн. Татварын нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж ирсэн. Мөн гол агуулга нь бол ажлын байрыг хадгалъя гэдэг байдлаар.

Ер нь аж ахуйн нэгжүүд дээр байгаа зардлуудын хамгийн их эзэлж байгаа зардлыг та бас дурдлаа. Гол нь энэ санхүүгийн эх үүсвэрийн зардал их өндөр байна гэж ярьж байгаа. Удахгүй Засгийн газар Бизнесийн эрх чөлөөний хуулийг хэлэлцээд, Их Хуралдаа өргөн барина. Жишээ нь, өнөөдөр банкнууд гаднын эх үүсвэр болон санхүүжилтийн эх үүсвэрийг олж ирэхэд тухайн эх үүсвэрийг олж ирснээс авч байгаа татвар бол 5 хувь байгаа. Бусад банк бус байгууллагуудаас бол 20 хувь байгаа. Тэгэхээр энэ чинь өөрөө бас бид нарын банкнуудаас уялдаатай хүүгийн зардал өндөр байх түвшнийг бүрдүүлж өгөөд байгаа. Тийм учраас бизнесийн эрх чөлөөний хууль дээр энийг адил түвшинд аваачихаар Засгийн газар боловсруулж оруулж ирж байгаа. Ер нь цаашдаа бид нар татварын хуулийг дахин зүгээр өнөөдрийн татварын аж ахуйн нэгжүүдийнхээ тоо хэмжээнээс харахад л ойлгомжтой байгаа юм. Томоохон татвар төлөгч аж ахуйн нэгж бол 1000 орчим, дунд аж ахуйн нэгж 3000, тэгээд жижиг, дунд, бичил гэхээрээ бусад нь болчхож байгаа юм. Үлдсэн 180 мянга чинь энэ бичил рүү орчхоод байна. Тэгэхээр энэ аж ахуйн нэгжүүдээ томруулах, бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулахад татварын энэ зөв бодлого хэрэгтэй.

Ийм учраас бид нар дараагийн удаа Засгийн газар Татварын багц хуулийг сууриар нь хөндөж оруулж ирнэ.

Б.Пүрэвдорж: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн нэмж тодруулъя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр үндсэндээ яг энэ нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх цогц бодлого хэрэгтэй байна шүү. Өнгөрсөн 35 жилийн алдааг давтахгүй байх үндсэндээ сууриар нь өөрчлөлт хийх бодлого бол хэрэгтэй байна шүү гэдэг зарчмын асуудал.

2 дахь нь яг цаг үеийн нөхцөл байдал өөрөө бас сайнгүй болчихлоо шүү. Инфляц өөрөө 10 гараад явчихлаа. Цаашид ингээд нэмэгдээд явах эрсдэлүүд өөрөө гарч ирж байна. Залгуулаад гадаад зах зээл дээрээ ч гэсэн энэ санхүүжилтийн хүүгийн зардлууд маш өндөр өсөж байна. Эргээд импортын инфляц нь өөрөө нэмэгдээд орж ирж байна. Тэгэхээр яг ийм хүнд үе дээр бид нар бас яг өнөөдөр энэ жил аж ахуйн нэгж байгууллагууд иргэдээ хямралаас аврах хямралын татварын бодлогыг түр татварын хөнгөлөлт бизнесээ хамгаалах бодлого ингээд юу гэдэг юм тодорхой эрсдэлээс хамгаалсан стресс тест хийсэн ийм татварын зохицуулалтуудыг энэ жилдээ багтаж хийхгүй бол бас нөхцөл байдал бүүр доройтоод, өнгөрсөн хойно нь бид нар амаа барьсан зүйл .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд нэмж хариулъя. Ажлын хэсэг хариулах юм байна.

Ч.Чимидсүрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр дараа дараагийн удаа нэлээн тийм өргөн хүрээнд суурь судалгаатай, суурь шинэчлэл хийхийг зорин ажиллана. Тухайлбал бидний хувьд ч гэсэн судалгаа хийгдэж байгаагаар хөрөнгийн татварын хуулиуд, өв залгамжлал, бэлэглэл, тэгээд АМНАТ-ийн төлбөртэй холбоотой тухайлсан хууль байх эсэх асуудлууд дээр бол ингээд бас судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. Тэгээд богино хугацаандаа бид нар түрүүний хэлсэн иргэний орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, аж

ахуйн нэгжийн татварын ачааллыг бууруулах ийм цөөхөн 5, 6 заалттай төсвийн нөлөөлөлтийн ийм заалттай нэмэлт, өөрчлөлтийг энд оруулсан байгаа.

Тэр бизнесийн байгууллагууд дээр тэр стресс менежмент төрөл бүрийн судалгаануудыг хийж ажиллах болно. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Тэмүүлэн гишүүн нэмж тодруулъя.

Г.Тэмүүлэн: Үгүй ээ, би ингээд байгаа юм. Одоо яг даруйхан шиг энэ гарч ирж байгаа юм чинь бол юу гэдэг юм дараа жилээс хэрэгжээд эхлэх ч гэдэг юм уу, одоо ингээд нөхцөл байдал бол том зургаараа эдийн засагтаа дэм үзүүлэх бодлогыг хийгээд байдаг. Гэтэл яг одоо энэ сараас, дараа сараас ч гэдэг юм уу энэ тоон үзүүлэлтүүд, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд чинь өөрөө доошийгоо унаад байдаг. Тэгэхээр үндсэндээ яг энэ богино хугацаанд зориулсан, хямралын үеийн татварын бодлого өөрөө шаардлагатай байна. Тэр татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг үзүүлэх гэдэг юм уу, бизнесээ хамгаалах, иргэдийн амьжиргаа орлогыг нь хамгаалах бодлогыг зохицуулалтуудыг шуурхай ковидын үеийнх шиг оруулж ирж хийвэл яасан юм бэ. Энэ чинь тэгэхгүй бол одоо ингээд дахиад энэ газрын тосны үнийн инфляц, нөлөөлөл чинь орж ирээгүй байгаад байдаг. Дээрээс нь импортын барааны инфляцууд чинь дахиад нэмэгдээд, сар болгон нэмэгдүүлээд байдаг өргөн хэрэглээний бараа, инфляцууд чинь нэмэгдэх гээд байдаг. Энэ дээр юу гэдэг юм тэсэж гарч ирэх боломж бололцоо ер нь бараг харагдахгүй байгаад байна шүү. Тэгэхээр бид нар яг ийм хүнд үед салхинд туугдсан хамхуул шиг ерөөсөө байж болохгүй болчхоод байгаа.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд тодруулъя.

З.Мэндсайхан: Засгийн газар дээр энэ асуудал бас яригдаж байгаа. Өмнө бол ковидын тодорхойгүй үед бид нар ковидын тухай хууль гаргаад төсөв дээрээ богино хугацаанд маневр хийх боломжтой энэ эрхээ Засгийн газар өөр дээрээ аваад явж байсан. Тэгэхээр одоо бол бид нар зүгээр та ч гэсэн мэдээлэлтэй байгаа байх. Макро орчны тоонуудаа хараад үзэх юм бол бид нарт бас тийм яг эффект нь ороод ирсэн гэж хэлэхэд бол тодорхойгүй байгаа. Гэхдээ худалдааны эдийн засгаа хараад үзэх юм бол импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний хэрэглэгч дээр ирж байгаа дарамт нь өндөр байна. Тэгэхээр энэ тодорхойгүй нөхцөл цаашаа бол яаж богино хугацаанд хэрхэн өөрчлөгдөх нь ийм тодорхойгүй байгаа үед бид энэ хуулийг бол санаачилж оруулж ирэхэд бэлэн байгаа. Энэ дээрээ Засгийн газар ойрын хугацаанд бас шийдэл гаргах байх. Ингээд явбал бид нар төсөвтөө болон Засгийн газар өөр дээрээ төсвийн эрхээ аваад ингээд цаашаа зохицуулалт хийгээд явах тэр боломж нь бол ковидын хууль шиг үүснэ гэж үзэж байгаа.

Б.Пүрэвдорж: Эдийн засгийн байнгын хороогоор саяхан даргаар томилогдсон Батжаргалын Заяабал асуулт асууна.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал одоо яригдаж байна. Энэ бол яг цагаа олсон, хамгийн их татвар төлөгчдийн ярьдаг гол асуудлууд, дээрээс нь олон улсын татварын ерөнхий хуулиуд дээр байдаг гол чиг хандлагууд орж ирсэн ийм цөөхөн боловч маш чанартай ийм өөрчлөлтүүд орж ирсэн гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Татварын ерөнхий хууль бол нэг талаасаа төр, иргэн 2-ыг хоорондын харилцааг зохицуулдаг. Төрийг нь татварын алба төлөөлж харьцдаг, иргэнийг нь татварын албатай харилцахаараа нэр нь татвар төлөгч гээд өөрчлөгддөг. Ингээд татварын алба, татвар төлөгч 2-ын харилцааг зохицуулсан ийм гол хууль. Гол ерөнхий хууль. Энэ хууль дээр нь юу байдаг юм бэ гэхээр татвар төлөгч талаас бол хэрхэн татвар төлөгчөөр бүртгэгдэх юм бэ, хэрхэн тайлангаа өгөх юм бэ, хэрхэн тайлангаар ноогдсон тэр ноогдлоо татвараа төлөх юм бэ. Хэрвээ эрсдэл үүссэн, татвараас зугтаж, зайлсхийсэн нөхцөл байвал ямар хууль журмын дагуу яаж хяналт шалгалтад хамрагддаг юм бэ гэдэг ийм асуудлыг татвар төлөгч талаас зохицуулсан.

Төр буюу татварын алба талаасаа бол хэрхэн тайланг нь хүлээж авч хянаж үзэх юм бэ, хэрхэн ноогдлыг нь үнэн зөв төлүүлэх юм бэ, өр үүссэн нөхцөлд ямар дэг журмаар яаж, өрийг нь төлүүлэх юм бэ гэдэг ийм харилцаануудыг нь зохицуулсан хамгийн чухал гол хууль.

Монгол Улсын хувьд 1990 онд бид нар ардчилал зах зээлийн нийгэмд шилжсэн цагаас эхлээд 1992 оноос эхлээд анх энэ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хууль гэж анх үүсэж эхэлсэн. Үүнээс хойш олон улсын зах зээл, ардчиллын нийгэмд байдаг яг л энэ улс орнуудад байдаг татварын харилцаанууд 2007 он хүртэл шинэ төрлийн харилцаанууд, татварын харилцаанууд үүсэж, шинээр хуулиуд нэмж ингэж гарсан байдаг. Ингээд анх удаагаа 2007 онд энэ татварын хуулиудыг ер нь багцаар нь авч үзэх ёстой юм байна гээд одоо бид нарын байнга ярьдаг 4/10-ын бодлого гэж ярьдаг энэ хуулийн анхны Татварын багц хуулийн өөрчлөлт явагдсан.

1992 оноос хойш 2007 он гээд үзэх юм бол 15 жилийн дараа анхны Татварын багц хуулийн өөрчлөлт явагдсан байдаг. 2 дахь Татварын багц хуулийн өөрчлөлт 2019 онд явагдсан. Бас энэ 4/10-ын бодлого буюу 2007 онд хийгдсэн татварын бодлогоос хойш даруй 13 жилийн дараа Татварын багц хуулийн өөрчлөлт явагдсан байдаг юм. Одоо бол 2019 оны энэ татварын өөрчлөлт хийгдсэн энэ хуулиуд маань хэрэгжээд явж байна. Энэ дээр яригддаг татвар төлөгч талаас голдуу асуудал яригдаж байгаа гол зүйлүүдийг бол энэ дээр оруулж ирсэнд сайшаалтай байна гэдгийг би хэлэхийг хүсэж байгаа юм.

Тэгээд энэ дээр юу гэж хэлэх гэж байгаа юм гэхээр ер нь олон улсад бол татварын алба нь татвар төлөгчийг өөрөө хуулиар оногдуулсан тэр татварыгаа сайн дурын үндсэн дээрээс хуулиа дагаж мөрддөг ийм харилцааг төрийн зүгээс дэмжих ийм бодлогыг явуулж байгаа. Яг энэ харилцааг өнөөдөр энэ Татварын ерөнхий хууль дээр энэ заалтыг оруулж ирсэн нь сайшаалтай байна гэж ингэж үзэж байгаа.

Татвар төлөгчийг хууль даган мөрдөлтийн түвшнээр нь ангилж, үнэлгээ тавьдаг. Тэгээд өөрөөр хэлбэл үнэлгээ тавьж байна гэдэг бол өмнө нь бид нарын мэддэгээр шилдэг татвар төлөгчийг гаргаж байна гэсэн үг. Маш сайн татвар төлөгч гэдэг чинь шилдэг татвар төлөгч гэсэн үг. Өмнө нь бидний мэддэгээр. Сайн татвар төлөгч, дунд татвар төлөгч, муу татвар төлөгч гээд ингээд ангилж байгаа юм байна. Өмнө нь олон улсын жишгийн дагуу энэ харилцааг бид нар бас нэвтрүүлж байсан. Тэгээд үүний дагуу сайн татвар төлөгч буюу шилдэг татвар төлөгчид ямар нэгэн хөнгөлөлт байдаггүй. Эргээд эдийн засаг, бизнесийн асуудалд чинь 1 өдөр орлого дутдаг, ингээд татварын өрөнд ордог. Тэгэнгүүт татварын алба хуулиа биелүүлээд дансыг нь хаадаг. Тэгэнгүүт татвар төлөгчдийн зүгээс бол байнга татвараа төлдөг

шилдэг байчхаад бид нарт юм байхгүй юм уу, төрөөс дэмжлэг байхгүй юм уу гэж байнга гомдол тавьдаг. Энэ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хоёуланг нь өгчихье. 2 минут.

Б.Заяабал: Энэ асуудлыг бол оруулж ирж өгч байгаа юм байна. Ингээд энэ 76¹ дээр Татварын албаны хууль даган мөрдөлтийн түвшин, татварын бүртгэл, тайлагнал төлөлт, дээрээс нь энэ гаалийн хууль тогтоомжийн зөрчил, гаалийн бүрдүүлэлт гэсэн ийм 5 үзүүлэлтээр энэ үнэлгээг гаргаад, сайн байх юм бол одоо нөгөө НӨАТ-ын хууль дээр яриад байсан Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр орж ирсэн байна лээ. Сайн татвар төлөгч байх юм бол татвар төлөх өрийг нь эхлээд 30 хоногоор хойшоо сунгая. Дахиад боломжгүй бол дахиад 2 сараар хойшоо сунгаж өгье. Үндсэндээ ингээд 3 сарын дэмжлэг үзүүлье гэсэн энэ хуулийн заалтууд орж ирж байгаа юм байна лээ. Тэгэхээр миний асуух гэж байгаа зүйл нь нэмэгдсэн өртгийн албан татвар дээр орж ирсэн тэр сайн татвар төлөгчид үзүүлэх татварын төлөх хугацааны хөнгөлөлтийг Татварын ерөнхий хуулийн 53 дээр та нар яагаад оруулж ирээгүй юм бэ гэдэг ийм асуулт байна. 53 дээр энэ асуудлаа оруулж ирээч ээ гэж 1 дүгээрт нь.

2 дугаарт нь энэ гаалийн мэдээллүүд энэ татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшин дээр орж ирж байгаа юм байна. Тэгвэл энэ нөхцөлд ер нь гаалийн байгууллага яг энэ орлого төвлөрүүлэх чиг үүргээрээ татварын байгууллагатай ер нь цаашаа нэгдэнэ, нэгдэх процесс явна гэж ингэж ойлгож болох уу. Яагаад гэвэл олон улсад ийм байдаг л даа. Үндэсний татварын алба, Үндэсний орлогын газар гэж байдаг. Тэр дээрээ нийгмийн даатгалын орлого цуглуулах чиг үүрэг, гаалийн орлого цуглуулах чиг үүрэг бүгдээрээ Үндэсний орлогын газар дээрээ байдаг. Тэгэхээр энэ заалтын цаана цаашдаа Монгол Улс ер нь тийшээ явж байгаа юм болов уу гэсэн ийм ойлголт авах гээд байна. Энэ дээрээ бас нэг хариулт өгөөч ээ гэж.

3 дугаарт нь бид нар энэ хууль тогтоомжийн даган мөрдөлтийг бид нар оруулж ирэхдээ татварын албыг яг удирдаж байх үедээ оруулж ирэхдээ 2017 онд Нобелийн эдийн засгийн шагнал авсан Ричард Тейлер гэдэг эдийн засагч байдаг. Энэ эдийн засагч эдийн засгийн харилцааг сэтгэл зүйтэй холбосон, өөрөөр хэлбэл татвар төлөх харилцаан дээр энэ бас чухал байгаа юм. Татвар төлөгчдөд мэдээллийг нь өгөөд байх юм бол татвар төлөгч өөрөө зугтдаггүй юм. Хууль даган мөрдөлт сайжирдаг юм.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ. 1 асуулт байх шиг байна даа. Тэрийг индрийн 4 дүгээр микрофоноос хариулъя.

Ч.Чимидсүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Татварын бодлогын газар Чимидсүрэн. Тэгэхээр ерөнхий хууль дээр орсон НӨАТ-ын өрийг төлөх хугацааг 2 сараар хойшлуулах энэ боломжийг ерөнхий хуулийнхаа 53 дээр яагаад оруулж ирсэнгүй вэ гэсэн асуудал ярьж байгаа. Тэгэхээр ерөнхий хууль дээр хугацааны хөнгөлөлт эдлэх зохицуулалт нь хэвээрээ байгаа. Энэ удаа бол бид нар гааль дээр бараа бүтээгдэхүүн худалдаад авахад НӨАТ-аа шууд төлөөд орж ир гэдэг ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр зөвхөн НӨАТ-ын харилцаанд нь хугацааны хөнгөлөлт эдлүүлж байгаа учраас ерөнхий хууль дээр биш, НӨАТ-ынхаа хуулиар зохицуулаад явсан байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Электрон жаал” сургуулийн Мөнхнаран багштай 12¹ дүгээр ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн. Индрийн 1 дүгээр микрофоноос үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Чамлахаар чанга атга гэдэг. Тэгээд татварын хуулиуд бас өөрчлөлтүүд нь бас маш удаан орж ирдэг. Тэгээд энэ удаагийн бас татварын өөрчлөлтүүд дээр хувь хэмжээг буулгаж байгаа, сайжруулж байгаа зүйл заалтууд бас нэлээн олон байна. Тэгэхээр Татварын ерөнхий хууль дээр байгаа энэ татварын өр үл маргах журмаар хураадаг энэ үйл ажиллагааг бас аж ахуйн нэгжүүдэд бас нааштай ийм шийдэл гаргаж ирж, өөрөөр хэлбэл дансанд орж ирж байгаа орлогыг нь битүүмжилж, татварын өрийг хураадаг байсныг тодорхой хэсгийг нь өөрөөр хэлбэл 20 хувийг нь үлдээж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа бас тасралтгүй явуулах бололцоо, боломжийг нь хангах ийм зүйл заалт оруулж ирсэнд аж ахуйн нэгж, компаниуд бас талархалтай байгаа. Тэгээд энэ зүйл заалтуудыг улам сайжруулах шаардлагууд бас байгаа. Түрүүн асуулт асуухдаа бас хэлсэн байгаа.

Хувь хүний хувьд бол энэ аж ахуйн нэгжүүд, хуулийн этгээдийн хувьд бол бас харилцан адилгүй ялгаатай байхаар ийм зохицуулалтууд байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль дээр бас хувь хүнтэй холбоотой асуудал дээр энэ орлогын данс хөрөнгөтэй холбоотой маргаан битүүмжлэхтэй холбоотой харилцаан дээр бас 50 хувь гэсэн хязгаарлалтууд байдаг. Тэгэхээр энийг хувь хүн болон аж ахуйн нэгжүүдийн хувьд ялгаатай байхаар, мөн дээр нь аж ахуйн нэгжүүдийн хувьд бол энэ данс битүүмжилж байгаа энэ үйл ажиллагаа дээр 20 хувийг үлдээж байгаа дээр бас ер нь бололцоо боломж байвал аж ахуйн нэгжүүдийн хувьд бол ядаж цалин, НДШ-тэй тэнцэх хэмжээний орлогоо жишээлбэл үйл ажиллагаа тасралтгүй явуулах үүднээс үлдээвэл татвар хураалт талаасаа, тэгээд энэ татвар төлөгчдийн бааз сууриа хадгалах талаасаа бас зөв алхам болов уу гэж бодож байгаа.

Тэгээд Аж ахуйн нэгжүүдийн хувьд бол манайд жижиг, дунд үйлдвэрлэл аж ахуйн нэгжүүдийн хувьд үйл ажиллагааны зардлынх нь 25-35 хувь нь цалин, нийгмийн даатгалтай холбоотой ийм зардлууд байдаг. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор энэ аж ахуйн нэгжүүдэд үлдээх буюу protected amount гэж олон улсад бас ярьдаг юм байна лээ. Тэгээд энэ дүнг нь бол 30 хувь болгоё гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж, ажлын хэсэг дээр энэ саналыг хураалгая гэсэн ийм бодолтой байгаа. Тэгээд түрүүн эхэндээ хэлсэн. Чамлахаар чанга атга гэж тодорхой хэмжээнээс өөрчлөлтүүд орж ирж байгаа учраас Татварын энэ хуулийн өөрчлөлтүүдийг дэмжиж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Цайны цаг болж байгаатай холбоотойгоор санал хураалтыг үдээс хойш 5 цагт хуулиудыг нэгтгэн явуулна.

14.02 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

3.Мэндсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу Засгийн газраас боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна.

Энэ хүрээнд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, МҮХАҮТ, Улаанбаатар хотын худалдааны танхим болон Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээж авлаа.

Иргэд, аж ахуйн нэгжүүдээс татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварыг энгийн ойлгомжтой, илүү уян хатан болгох зэрэг саналууд голчлон ирсэн.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхийн газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Сангийн яам дээрх уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг судлан үзэхээс гадна олон улсын байгууллагуудын өгч буй санал, зөвлөмжийг харгалзан үзсэний үндсэнд Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг боловсрууллаа.

Энэ удаагийн татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтөөр иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 2,2 орчим их наяд төгрөгөөр үе шаттай бууруулахаар тооцож байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хэлэлцүүлгийн явцад аж ахуйн нэгжүүдээс нийтлэг байдлаар ирүүлсэн саналууд буюу татвар ноогдуулах орлогын босгыг нэмэгдүүлэх, шатлалыг өөрчлөх, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн хөнгөлөлт чөлөөлөлтийг нэмэгдүүлэх, тайлан гаргах хугацааг уян хатан болгох, бизнес эрхлэхэд татварын орчныг илүү хялбар, энгийн, ойлгомжтой болгоход чиглэгдэнэ. Тухайлбал,

1.Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын хөнгөлөлтийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор 90 хувийн татварын буцаалт эдлэх буюу татварын 1 хувийн ачааллын босгын дүнг 1,5 тэрбум төгрөгөөс 2,5 тэрбум төгрөг болгож өсгөх.

2.ААНОАТ-ыг 25 хувиар тооцон ноогдуулж эхлэх. Татвар ноогдуулалтын орлогын босгын хэмжээ 6 тэрбум байсныг 10 тэрбум болгон, 6-10 тэрбум төгрөгийн татвар ноогдуулах орлогод 15 хувиар татвар ноогдуулах хөнгөлөлт үзүүлэх.

3.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.1-д заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн үйл ажиллагааны орлогод ноогдох албан татварыг хөнгөлж, их хэмжээний өгөгдөл, сервер, супер компьютер зэрэг компьютерын элэгдэх хугацааг 3 жил болгох.

4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан тушаах, төсөвт төлөх хугацааг хойшлуулах зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны өрсөлдөх чадвар сайжирч, бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурна. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгмийн тогтвортой байдал бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайдад баярлалаа. Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Жаргалсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

П.Жаргалсайхан: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих, бизнесийн идэвхжилийг нэмэгдүүлэх, өргөжих нөхцөлийг бүрдүүлэх, бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын илүү хялбар, таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын бизнесийн орчны олон улсын тавцанд өрсөлдөх чадвар сайжирч, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн татварын ачаалал буурах, улмаар эдийн засгийн өсөлт нэмэгдэж, нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл бүрдэх, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа тогтвортой өргөжүүлэн хөгжүүлэх, санхүүгийн чадавхаа бэхжүүлэх, бизнесийн идэвхээ нэмэгдүүлж, дотоод, гадаадад зах зээлд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзсэн байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин хуулийн төсөлд татвар ногдуулах орлогын босгыг нэмэгдүүлж, 6-10 тэрбумын орлоготой аж ахуйн нэгжүүдэд 25 хувиар татвар төлөхөөр тусгагдсан нь хэдэн аж ахуйн нэгжийн татварын ачаалал хэдий хэмжээгээр буурч байгаа талаар, виртуал бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААНОАТ-ыг 100 хувь хөнгөлөхөд хамрагдах аж ахуйн нэгжүүдийн тоо болон үзүүлэх хөнгөлөлтийн дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68,8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Жаргалсайхан гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүчийн хуультайгаа адилхан байгаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Засгийн газраас Татварын багц хуулийг намрын чуулганд өргөн бариад бараг сүүлийн өдөр өргөн барьсан билүү. Тэгээд Соронзонболд гишүүнээр бас ахлуулсан ажлын хэсэг гараад, хэлэлцэх эсэхийг нь шийдээгүй байхад бид эхний төслөөр нь маш их ажлыг, маш их хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад, нэлээд ажлыг хийсэн. Тэгээд ер нь Төсвийн байнгын хороондоо бас энэ ажлын хэсгийнхээ дүгнэлтийг өгөөд, Засгийн газарт бас дүгнэлтийг өгсөн. Яг энэ хэлэлцүүлгүүдийнхээ явцад ямар ямар саналууд иргэдээс болон аж ахуйн

нэгжүүдээс гарсан юм бэ гэдгийг. Тэгээд яах вэ Засгийн газар маань хуулиа өөрөө эргүүлээд татчихсан. Эргээд орж ирж байгаа хууль маань бол тэр хэдхэн сарын өмнө өргөн барьсан хуулиасаа тэс ондоо өөр л хууль орж ирж байгаа л даа.

Гэхдээ яах вэ, энэ аливаа өөрчлөлтийг гэдэг юм уу энэ томоохон бодлогуудыг бас хамгийн төгс хийх гээд л хуулиудыг их удаан барьдаг, их удаан хэлэлцдэг энэ явдлыг бас халж, тодорхой хэмжээнд боломжийн жижиг жижиг өөрчлөлтүүдээ цаг тухай бүрдээ хийгээд явах ёстой гэсэн энэ хандлагыг нь дэмжиж, хүлээж авч байна. Хүлээлтэд бүрэн нийцээгүй ч гэсэн тодорхой хэмжээнд бас дэмжихүйц сайн саналууд орж ирсэн байна. Шаталсан татварыг дэмжиж байна. Орон сууц борлуулсны татварыг иргэдийн 100 мянган хүний гарын үсэг цуглуулсантай ч холбоотой энэ асуудал яригдаад байгаа. Тэгээд хууль санаачлагчид Засгийн газар Монгол улсын иргэний үргэлжилсэн 5-аас доошгүй жилийн хугацаанд өмчилсөн бөгөөд өөрийн үндсэн оршин суух хаягт бүртгэлтэй амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулж байгаа энэ татвараас чөлөөлөх гэсэн ийм саналыг оруулж ирж байгааг бас дэмжиж байна. Энэ бол бас яг ченжүүд биш, харин яг тухайн иргэн өөрөө тэгээд анхны борлуулалтын орлого гэж бас ойлгож байгаа. Импортын суудлын автомашины гаалийн татварыг тансаг хэрэглээ буюу 100 мянган ам.доллараас давсан хэсэгт тансаг хэрэглээний татварыг онцгой албан татвар ногдуулна гэдгийг бас дэмжиж байгаа. Гагцхүү надад бол энэ 100 мянган ам.доллар буюу 350 орчим сая төгрөг гэж тооцож байгаа нь өөрөө жоохон арай хэт өндөр байгаад байна уу даа. Энийг жоохон бууруулж болохгүй юу. Яагаад гэвэл энэ 360 сая төгрөг чинь нийт импортоор орж ирж байгаа машины 0,3 хувийг л эзэлж байгаа. Тэгээд ер нь наана нь 100, 150 сая төгрөг ч гэсэн уг нь бол тансаг хэрэглээнд ороод л явчихмаар юм биш үү л гэж санагдаад байх юм. Тэгэхээр энэ дээр яг бодлого юу байсан бэ.

2 дахь нь болохоор ХХОАТ-ыг 792 мянган төгрөг гээд яг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй гэж ер нь авчхаад гэхдээ тоогоор нь тавьж байгаа л даа. Тэгэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр гээд дүйцүүлээд авчихаар цаашид ямар асуудал үүсэх вэ гэхээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хөдлөх болгонд энийгээ өөрчлөөч гэдэг нийгмийн шаардлага орж ирэх байхгүй юу. Тэгэхээр уг нь энийгээ 800 мянга гэдэг юм уу, 1 сая төгрөг гэдэг юм уу яг түүгээрээ л нэг тодорхой нөгөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тайлбарлаж 792 мянга гэж авахгүйгээр зүгээр тодорхой дүнгээр байвал уг нь илүү зөв байдаг юм. Тэгээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой та хэд маань энэ хэлэлцээрээ хийлээ гэж өчигдөр мэдээлэл яваад байна лээ. Гэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ зүгээр нэмэгдүүлнэ л гэсэн болохоос биш яг хэд болгох гэж байгаа юм, яах яах гэж байгаа юм гэдгийгээ тохироогүй байна шүү дээ. Энэ чинь тэгээд Сангийн сайд одоо бодолцохгүй бол 5 сардаа уг нь төсвийн төсөөлөл юмнудаа боож байгаа. Эргээд энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хэрхэн яаж тогтоогдохоос авхуулаад төрөөс ЭМД-ын шимтгэл, нийгмийн даатгалын сайн дурын шимтгэл гэхчлэн маш олон ийм хоорондоо .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Загджавын Мэндсайхан хариулна.

3.Мэндсайхан: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өсөх хэрээр цаашдаа бид нар ингээд шатлал үүсээд явна гэж та болгоомжилж байна. Тийм учраас бид нар 792 гэдэг тоогоор нь оруулж ирж байгаа юм. Хуульдаа тийм ээ. Цаашдаа бол яах вэ, өнөөдөр бид нар нөгөө жишиж

авсан нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ гэж яриад байгаа болохоос биш энэ хэмжээгээ аваад явчихсан болохоос биш цаашдаа бол энэ чинь бол нийт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 792 мянгад оногдох татварыг 10 хувийг нь чөлөөлнө л гэдэг энэ агуулгаар орж ирж байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмээд тэндээс тодруулж байгаа юм уу. Мэндсайхан сайд нэмээд. Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Автомашин дээр онцгой албан татвар тавьж байгаа. Ер нь бол онцгой албан татвар дээр бусад улс орнуудад авто бензин, тэгээд архи, тамхи, чихэрлэг ундаа, автомашин энэ дээр бол нийтлэг хэрэгжүүлдэг. Тэгээд манайд архи, тамхи дээр бас тодорхой үе шаттайгаар ингээд нэмэгдүүлээд байх хуулийн төслүүдийг саяхан хийсэн. Тамхи дээр бас ажлын хэсэг гараад ингээд явж байгаа. Чихэрлэг ундаан дээр 2027 оны 1 сарын 1-ээс бол мөрдөхөөр явж байгаа. Ингээд автомашины зохицуулалт байхгүй байсан. Тэгээд энийг бол шинээр оруулж байгаа. 100 мянган доллар гэдэг манай өмнө оруулж ирсэн импорт оруулж ирсэн автомашинуудад аваад үзэхээр нийтлэг хэрэглэгдээд байдаг. Ланд 200, Ланд 300 дээр энэ тансаг хэрэглээ рүүгээ орохгүй. Тэгэхээр энэ нийтлэг үнийг нь авсан байгаа. Бусад улс орнуудын хувьд аваад үзэхэд энэ үнэлгээнээс бага ч байна, энэ үнэлгээнээс өндөр ч байна. Тэгээд 33 хувь 1/3 нь үнэлгээнийх нь 1/3-тэй тэнцүү байгаа. Бусад оронд .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Ч.Чимидсүрэн: Мөн л ялгаагүй 100-аас дээш хувьтай өөрийнх нь үнэлгээнээс ч илүү давчихсан хувьтай ч байна. Бага 20 хувьтай, 22 хувьтай ийм орнууд ч бас байгаа юм. Тэгэхээр бид нар нийтлэг хэрэглээгээ бодоод эхний ээлжид энэ өндөр хэрэглээтэй хэсэгт бас ийм онцгой албан татвараа оруулж ирэх нийтлэг практикийг бодож ингэж оруулж ирсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Ариунзаяа гишүүн нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: Яах вэ, би хэлэлцүүлгийн шатад энэ 792-ыг зүгээр шууд 800 мянга болгох, 300 мянган долларыг 250 сая төгрөг болгох гэдэг ч юм уу ийм саналуудыг гаргах байх шүү гэсэн ийм урьдчилсан байдлаар саналаа хэлчихье.

Би дахиад нэг тодруулах асуудал болохоор НӨАТ төлөгчийн босготой холбоотой 400 сая төгрөг болгохоор НӨАТ төлөгчдийн хэдэн хувь нь энэ дотроо багтах вэ. Тэгээд энэ нь ямар сөрөг болон эерэг үр дагавартай вэ гэдгийг яг Сангийн яам өөрийнхөө бодлоороо тайлбарлаад өгөөч. Болохгүй бол би дараагийн асуудал дээр бас асуулт асуух учраас тэр 3 минутыг ашиглая. Ер нь Сангийн яам, Соронзонболд гишүүд нартай бид нар ажиллаж байхад уг нь хүн болгон л НӨАТ төлөгч болох хэрэгтэй гэдэг ийм асуудлыг ярьж байсан. Тэгэхээр энэ 400 сая болгосноор нийт НӨАТ төлөгчдийн хэдэн хувь нь орох вэ. Тэгээд эерэг болон сөрөг нөлөөллүүд нь юу байх вэ гэдгийг.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг. Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Ариунзаяа гишүүн та бас сайн мэдэж байгаа. Энэ НӨАТ-ын босгыг 400 сая төгрөг нэмэгдүүлэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байгаа.

Тэгэхдээ нөгөө сайн дураар НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх босго нь 10 саяараа үлдэж байгаа. НӨАТ-ын суутган төлөгчийн босгыг 400 саяыг хүргэснээр бол НӨАТ төлөгчөөр 23,4 мянган суутган төлөгч бүртгэлээс хасагдана. Төсвийн орлого дээр бол 160,6 тэрбум төгрөгөөр буурна гэсэн ийм тооцоолол байгаа. Тэгэхээр ер нь НӨАТ-ын босго нэмэгдүүлснээр жижиг, дунд бизнес эрхлэгчдийг татварын дарамтаас аль болох чөлөөлж өгч байна л гэж бид нар энэ агуулгыг оруулж ирсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

А.Ариунзаяа: 24 мянган аж ахуйн нэгж, байгууллага нь нийт НӨАТ төлөгчдийнхөө хэдэн хувийг эзэлж байгаа вэ гэдэг л ийм асуудал байгаад байгаа юм. 44 хувийг эзэлж байгаа юм уу. 34 хувийг эзэлж байгаа юм уу. НӨАТ-ын татварын орлого нь бол нийт татварын орлогын 20 хувийг бас эзэлж байгаа гэж байгаа. Тэгэхээр яах вэ, бид нар бас энийг ярилцах л ёстой юм байна лээ. Яах вэ нэг талдаа ашигтай. Мэдээж нөгөө аж ахуйн нэгж, байгууллагууддаа сайн. Гэхдээ нөгөө талдаа томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд юу гэдэг юм харилцаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь жижиг аж ахуйн нэгж, байгууллага нь бас НӨАТ төлөгч байх ёстой гэдэг ийм шалгуур тавьчихлаар маш олон аж ахуйн нэгж, байгууллагууд гэдэг юм уу, жижиг аж ахуйн нэгж, байгууллагууд нь томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудтай харилцагч байх тэр харилцаан дээр нь бас сөргөөр нөлөөлчих вий дээ гэдэг ийм болгоомжлол бол байна. Гэхдээ сайн дураараа бас НӨАТ төлөгч болох боломж байгаа юм байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайханы урилгаар Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцож буй Ховд аймгийн жүдо бөхийн өсвөрийн шигшээ багийн Ганхуяг дасгалжуулагчтай тамирчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд спортын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Аж ахуйн нэгж, байгууллагууд бас энэ татвар ноогдох орлогоос хасагдах зардлууд дээр нэлээн гомдолтой байдаг. Өөрөөр хэлбэл бодитой гарчихсан бизнесийн зардлуудаа татварт ноогдох орлогоос хасагдуулж чаддаггүй. Тэгэхээр үүний нэг хэсэг нь яг элэгдлийн зардал байдаг. Тэгэхээр элэгдлийн одоогийн хуулиар болохоор барилга 40 жил, машин, тоног төхөөрөмж 10 жил, тэгээд компьютерыг 2 жил, бусдыг нь бүгдийг нь 10 жилээр элэгдэлд тооцдог. Өөрөөр хэлбэл энэ бусад гэдэг ангилал дотор асар олон эд хөрөнгүүд 2, 3 жил, 10 жил хүрэхгүйгээр элэгдээд дуусдаг. Шинэчлэх шаардлагатай болдог. Тэгэхээр энэ нь өөрөөр хэлбэл зардлаа бодитойгоор бас тусгаж чадахгүй байгаа ийм асуудлууд байгаа. Тэгэхээр бас олзуурхууштай нь энэ хуулийн төсөл дээр энэ дата центртэй холбоотой сервер супер компьютертой холбоотой энэ хөрөнгүүдийг 10 жилээр элэгдэл тооцдог байсныг нь 3 жил болгож оруулж ирсэн байна. Тэгээд энийг бол бас дэмжиж байна. Үүнтэй холбогдуулаад асуулт байна.

Энэ 10 жилээр бусад хөрөнгийн элэгдлийг тооцож байгаа энэ зүйл ангиуд дотор ер нь аж ахуйн нэгжүүдээс ирж байгаа гомдол гэх юм уу. Бид нарын энэ хөрөнгийг 10 жилээр элэгдэл тооцоод байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна гэсэн дарааллаар нь авч үзвэл ямар ямар өөр жишээлбэл, элэгдэл тооцох хугацааг

нь богиносгох шаардлагатай ийм хөрөнгүүд байгаа гэж үзэж байгаа вэ. Татварын ерөнхий газар дээр тиймэрхүү мэдээлэл байгаа юу.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгээс хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон. Албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Татварын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой аж ахуйн нэгжүүдээс маш олон төрлийн саналууд ирсэн. Саналуудыг бол хуулийн төслүүдэд тусгаад явж байгаа. Яг элэгдэлтэй холбоотой аж ахуйн нэгжүүд болон холбогдох чиг үүргийн яамдаас ирүүлсэн саналыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах энэ хуулийн төсөлдөө оруулсан. Энэ дээр их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график, процессор, сервер, супер компьютерыг 3 жилээр элэгдүүлэх гэсэн ийм санал орж ирсэн. Энэ саналыг хуулийн төсөлд тусгасан байгаа.

Б.Пүрэвдорж: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Энэ бусад жишээлбэл оффисын тавилга ч юм уу 10 жил элэгдүүлнэ гэж бараг байхгүй болчхоод байгаа байхгүй юу. 2, 3 жил болоод л зарим минь өөрчлөгдчихнө. Тэгэхээр нөгөө зардлаа зөв тооцож чадахгүй болохоор ийм асуудлууд байгаа. Тэгэхээр энэ зүйл заалт дээр аж ахуйн нэгжүүдээс бас Улсын Их Хурлын гишүүдээс тодорхой саналууд ирсэн байгаа. Тэгээд энэ дээр бас зарчмын зөрүүтэй санал гаргаж, зарим нэг элэгдлийг бодит байдалд нь нийцүүлж, энэ хугацаа дээр нь элгэдгийг тооцох ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж оруулъя гэж бодож байгаа. Нөгөө талаас бас аж ахуйн нэгжүүдийн хувьд бас компаниудын хувьд яг энэ дээр бас тодорхой саналууд байвал бас явуулаарай гэж хэлмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Сүүлийн үед манай брэнд үйл ажиллагаа зогсоолоо. Манай компани 5 сарын 1-ээс эхлээд үйл ажиллагаа явуулахаа болилоо. Манай брэнд ахиж цаашид үйл ажиллагаа явуулж чадахгүй нь. Бид нар татварын дарамтыг дийлэхгүй нь. Манай аж ахуйн нэгж цаашдаа энэ үйл ажиллагаа эрхлэхээ болилоо. Манай 16 ажилтан өнөөдрөөс эхлээд ажилгүй болж байна гэдэг мэдэгдлийг бид нар өдөр болгон харж байгаа. Өдөр болгон харж байгаа шүү. 2 жил татвар багасгах, татварын тухай бодлого, НӨАТ, аж ахуй нэгжийн тухай ганц ч үг ган хийгээгүй Засгийн газар өнөөдөр татварын хуулиудыг бөөндөж оруулж ирж байна. Энэ бөөндөж оруулж ирэхдээ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Хөрөнгө оруулалтын тухай хууль нь дагаж орж ирсэнгүй. Эд нар чинь уг нь нэг ийм эко систем юм байгаа шүү дээ. Хаа ч очиж бид нар бас нэг аятайхан Сангийн сайдтай болчхов уу даа гэж би бас бодож байгаа юм. Өөрөө бизнес эрхэлж байсан. Аж ахуйн зовлон удирдаж байсан. Ажил, алба удирдаж байсан ийм хүн.

Гэхдээ манай Сангийн яам ер нь хэзээ энэ татвар төлөгчдөө, хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүстээ бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хайртай болох юм бэ. Хэзээ хайртай болох юм. 1 татвар төлөгчийг яаж 2 болгох тухай ямар бодлого байгаа юм. Одоо татвар төлж байгаа бүх хүмүүсээсээ бүх татварыг нь яаж ийж байгаад авах тухай бодлого бодоод, тэр олж байгаа

орлогоороо улсын төсвийн зарлагаа бичээд байгаа байхгүй юу. Жишээ нь, 1 татвар төлөгчийг яаж 2 болгох юм. 10 татвар төлөгчийг яаж 20 болгох юм. Ийм бодлого юу байгаа юм бэ гэдгийг би Сангийн яамнаас асууя.

2 дугаарт Татварын ерөнхий газраас асууя. 1-9 ажилтантай аж ахуйн нэгж чинь нийт аж ахуйн нэгжийн чинь 87 хувь, 10-19 ажилтантай нийт аж ахуйн нэгжийн чинь 6 хувь, ингээд бараг 95 хувь нь 20 хүртэл ажилтантай ийм компаниуд байна. Энэ аж ахуйн нэгжүүдийг яаж бойжуулах юм. Яаж дэмжих юм. Өнөөдөр нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн чинь 44 хувь нь л үйл ажиллагаа явуулж байгаа. Нарийвчилсан тоо яривал 44,6 хувь. 54 хувь нь үйл ажиллагаа явуулахгүй байгаа. Яагаад явуулахгүй байна вэ гэхээр татварын дарамтаа дийлэхгүй байгаа. Зүгээр 1 компани байгуулж үзье гэдэг ийм хоосон бодолтой бол яваагүй л байх. Ямар нэгэн байдлаар аж ахуй эрхэлж үзье, улс эх орныхоо эрх ашигт нь нэмэрлэе, эдийн засагт нь жоохон ч гэсэн эргэлт оруулъя, ажлын байр бий болгоё, бизнес хийгээд үзье гэсэн бодлоор л компани байгуулж байгаа шүү дээ. Тэр 54 хувь руу чиглэсэн үйл ажиллагаа явуулахгүй байгаа тэр 54 хувийг яаж үйл ажиллагаа явуулах вэ гэдэг ямар бодлого байгаа вэ. Татварын ерөнхий газарт.

Үйл ажиллагаа нь эхлээгүй байхдаа татвар төлөөд эхэлж байгаа. Жишээ нь үүн дээр та хэд маань ямар бодолтой байгаа юм бэ. Тэгээд аж ахуйн нэгж нь жоохон орлого олно. Бусдаар хүмүүс ажил хийлгэнэ. Тэндээс нь хүртэл татвар авна. Хоолны мөнгө өгнө татвар авна, унааны мөнгө өгнө татвар авна. Давхар НДШ авна. Өнөөдөр Монгол орон өөрсдийгөө залуучуудын улс гэдэг оюутнуудын улс гэдэг. Тэгтэл өнөөдөр оюутны хөдөлмөр эрхлэхийг дэмжиж байгаа хууль байхгүй шүү дээ. Би одоо санаачлаад явж байгаа Манай гишүүд нэгдэнэ гээд бараг 20-иод гишүүд илэрхийлж байгаа.

2 дугаарт цагийн хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн эрх зүйн зохицуулалт бас байхгүй. Бүтэн цагийн ажлын хуультай. Тэгтэл цагаар хөдөлмөр эрхлэх оюутнууд чөлөөт цагаар хичээлээсээ гадуур 7 хоногт 20 цагаас ихгүйгээр хөдөлмөр эрхлэх гэдэг ийм хуулийн боломж манайд байхгүй. Тэгтэл одоо аж ахуйн нэгжүүд нэг талаасаа цагийн хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг авах сонирхолтой болсон байна. Нөгөө талдаа оюутан, залуучууд хөдөлмөр эрхлэх сонирхолтой болсон байна. Эд нарыг зохицуулж байгаа хуулийн зохицуулалт байхгүй. Энэ дээр Татварын ерөнхий газар ямар бодлоготой байгаа юм. Зуныхаа амралтаар 1 сар ажил хийж байгаа оюутнаас НДШ авч яах гээд байгаа юм. Тэр компани нийгмийн даатгал шимтгэл тэр хүнд өгч яах гээд байгаа юм. Энэ мэтээр татварын бодлого .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр аж ахуйн нэгжийн татварын ачаалал дундаж хувь нь 10,5 хувь байгаа юм. Сегментээр нь аваад үзэх юм бол бичил аж ахуйн нэгж дээр 5,5, жижиг, дунд аж ахуйн нэгж дээр 5,6, дунд аж ахуйн нэгж дээр 7 хувь, том аж ахуйн нэгж дээр 13,4 хувь байгаа юм.

Энэ удаагийн бид нарын татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн оруулж байгаа энэ өөрчлөлтүүд дээр гарах үр дүн нь бас татварын ачааллыг 0,5 хувиар аж ахуйн нэгж, байгууллага дээр бууруулна гэсэн ийм тооцооллууд гарсан. Тэгээд энэ дээр тухайлбал аж ахуйн нэгж дээр төлж байгаа гол татвар болохоор ААНОАТ дээр 1 хувийн ачаалалтай дээд босгыг бол 1,5 байсныг 2,5 болгож байгаа. Том болон

дунд аж ахуйн нэгж дээр өөрөөр хэлбэл 6 тэрбумаас дээш ашигтай ажилласанд нь шууд 25 хувиар авч байсан тэр дундын шатлал буюу 6-10 тэрбумын ашигт нь бол 15 хувийн ачааллыг бууруулах зохицуулалт, мөн татварынхаа өрийг төлөх хугацаанд нь хугацааг хойшлуулах тэр боломжууд байгаа юм. Үүнээс гадна ер нь хувь хэмжээ бол харьцангуй бүс орон нутгийнхантай харьцуулахад бол манай татварын хувь бол өндөр биш. Гэхдээ хууль даган мөрдөлтийн түвшинтэй уялдуулаад бидний хувьд энэ татвар төлөгчдөө мэдээ мэдээллээр хангах зөвлөгөө өгөх энэ ажлуудаа бас нэлээдгүй илүү сайн хийх ёстой. Дээр нь гарсан хуулийг дагасан дүрэм журам, арга аргачлал, зөвлөмжийг бол тухай бүрд нь ойлгомжтой, энгийн маягаар хийх юм бол илүү их ойлголцоод яваад байх боломжтой.

Тэгээд татвар төлөгчдийн хувьд бас мэдээллээр хангагдаагүйгээс хамаараад бас зөрүүтэй ойлголтууд бас нэлээд гардаг асуудал дээр Татварын ерөнхий газар болон яамнаас анхаарч энэ зөвлөн туслах чиглэл рүү бас ажлууд төлөвлөөд ажиллаж байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Татварын байгууллага. Индрийн 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар, Цогтнаран. Бичил жижиг бизнес эрхлэгчдийнхээ татварын ачааллыг бууруулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 50 сая байсныг 400 сая болгож нэмэгдүүлж байгаа. Мөн ААНОАТ-ын тухай хууль дээр хялбаршуулсан журмаар буюу 1 хувиар татвар төлөх босго маань 1,5 байсныг 2,5 тэрбум болгож, өөрөөр хэлбэл нэмэгдүүлж байгаа. Мөн иргэдийн ХХОАТ-ыг 792 мянган төгрөгийн орлогыг нь чөлөөлж байгаа гэх мэтчилэн бизнес эрхлэгч, бичил жижиг бизнес эрхлэгч болон хувиараа бизнес эрхлэгч үйл ажиллагааны орлоготой иргэдийнхээ орлогыг хамгаалах, сууриа хамгаалах зорилгоор энэ удаагийн Татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьсан байгаа.

Б.Пүрэвдорж: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Би яагаад энийг асуугаад байгаа юм гэхээр нийт ажиллах хүчний чинь бараг 80 хувь жижиг дунд бизнес дээр байгаа байхгүй юу даа. Нийт ажиллах хүчний чинь 80 хувь. Тэгээд хэрвээ энэ жижиг дунд бизнес рүүгээ чиглэсэн 5 ажилтантай, 10 ажилтантай, 15 ажилтантай компани руугаа чиглэсэн бодлого байхгүй бол дампуурах юм бол нийт ажил ажиллах хүчин 80 хувь нь ажилгүй болно гэсэн үг.

2 дугаарт манай энэ Түвшин гишүүн бид хэд хамтраад Оюутны хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, Цагийн хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулиудыг санаачилж байгаа юм. Бид нар нэлээн их хэлэлцүүлэг хийсэн. Өргөн барина. Тэгээд Сангийн яамнаас битгий, боломжгүй, бүтэхгүй гэдэг ийм санал өгөөд байгаарай. Өнөөдөр дэлхий дээр оюутан, залуучууд нь цагаар хөдөлмөр эрхэлдэг хуулийн зохицуулалтгүй цорын ганц улс өнөөдөр Монгол Улс болсон шүү. Хүн хичээлийнхээ хажуугаар хөдөлмөр эрхэлье гэхээр хуулиараа чи болохгүй гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийн юунуудыг битгий яагаарай.

Тэгээд 2 дугаарт би дахиад тэр 1 татвар төлөгчийг яаж 2 болгох гээд байгаа юм бэ. Ямар бодлого байгаа юм бэ гээд энэ асуултад хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ. Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Бизнес эрхлэгчид татварын бодлогоор хувь хэмжээний зохицуулалтаас гадна ерөнхий процессын зохицуулалтуудаа бол энгийн ойлгомжтой болгох тал дээр явж байгаа. Тэгээд түрүүний хэлснээр бол бид нар энэ удаа яг одоогийн нөхцөл байдалдаа таарсан цөөн тооны буюу 5, 6 төсвийн нөлөөтэй ийм заалтаар эрх зүйн орчиндоо нэмэлт, өөрчлөлтийг бол оруулж байгаа. Яг бизнесийн үйл ажиллагаагаа ямар чиглэлээр салбарлах вэ 1-ийг 2 болгох вэ, групп, охин, толгой компаниас явуулах нь хөрөнгө оруулагчдын одоогийн байгаа хууль, эрх зүйн орчиндоо нийцүүлж гаргах шийдвэр байх гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууна. Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Улсын Их Хурлын гишүүн болсноосоо хойш 2 жил асуулт асуусан болоод, хариулсан болоод ийм 2 жилийг л өнгөрөөж байна л даа. Тоо асуухаар тоо хариулдаггүй. Жишээ асуухаар чи хариулдаггүй. Бодит юм асуухаар бодит юм хариулдаггүй. Би ерөөсөө энийг ойлгохгүй байгаа юм. Тэгээд энэ хурал даргалагч, Улсын Их Хурлын дарга нар энэ дээр жоохон хариуцлага тавимаар байгаа юм. Татвараас зугтсан гэдэг эрүүгийн ялтай шүү дээ. Мэднэ тийм ээ та хэд. Тэгсэн мөртөө татвар төлөгчийг дэмжих бодлого байхгүй. Шууд яллана. Чи бизнес эрхэлж байгаа бол чи ингээд татвар төлөөгүй бол чамайг яллана. Тэр хүнийг 3 хүн ажиллуулна уу, 5 хүн ажиллуулна уу, 1 хүн ажиллуулна уу, өөрөө өөртөө ажлын байр бий болгоно уу. Тэр дээр манайд дэмжсэн механизм алга. Дахиад хэлье. Нийт ажиллах хүчний чинь 80 хувь жижиг, дунд компанид ажиллаж байна. Нийт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн чинь 95 хувь нь жижиг дунд аж ахуйн нэгж байна. Эд нарыгаа яах гээд, яаж бойжуулах юм гээд би асуугаад байна шүү дээ.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Чимидсүрэн хариулаач.

Ч.Чимидсүрэн: Таны хэлж байгаа энэ сегментийн ангиллаар бол энэ тоонууд батлагдаж байдаг. Тэгэхээр одоо Татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн үндсэндээ 1000 орчим нь том сегменттэй. 3000 орчим нь бол дунд сегменттэй. Бусад нь дунд, бичил сегменттэй байгаа. Тэгэхээр эдгээр аж ахуйн нэгжүүдийн хувьд татварын ачаалал түрүүн би хэлсэн. Тийм өндөр биш, өөрөөр хэлбэл 1 хувийн ачаалалтай байгаа. Тэгэхээр энэ түвшинд бизнес эрхлэгчид хувиараа бизнес эрхлэх эсвэл .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууна.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр одоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн орж ирсэн төслийг хэлэлцэж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль анх энэ ардчилал зах зээлийн нийгэмд Монгол Улсад үүсэж бий болохдоо анх дээд хязгаар нь 42 хувийн орлогын албан татвартай байсан үе саяхан шүү дээ. 2007 онд 4/10-ын бодлого гээд байгаа энэ бодлогын үед Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль 10 хувьтай, дээд хязгаар, хувь хэмжээ нь 25 хувьтай байсан. 2019 оны хууль буюу 2020 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн хуулиар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын босгыг 1 хувь, 10 хувь, 15 хувь, 25 хувь гээд хуучин байсан 2 хувь дээр нь доошлуулаад 1 хувь гээд 1 ийм шатыг бас нэмж өгсөн байдаг юм. Тэгэхээр

энэ дээр гишүүдэд бас би мэдээллийн шугамаар үндсэн ерөнхий мэдээлэл өгөөд, асуултаа асууя гэж бодож байна.

Миний хувьд бол энэ татварын ачаалал нэмэгдлээ. Татвараас болоод бизнес эрхлэгчид хаагдаад байна. Татвараас болоод бизнес явахгүй, эдийн засаг удаашраад байна гэдэг дээр манай Их Хурлын гишүүд бид нар бас дүгнэлт хиймээр юм шиг санагддаг юм. Өнөөдөр яг аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид чинь яг хамгийн гол асуудал нь юу байна гээд аваад үзвэл 1 дүгээрт энэ зээлийн хүүгийн дарамт байна шүү дээ. Зээлгүй жижиг, дунд эрхлэгч гэж байхгүй. Зээлийн хүү бол хамгийн чухал асуудал байгаа.

2 дугаарт нь үйл ажиллагаа эрхлэх байр сав, түрээсийн асуудал байгаа. Дараа нь татварын асуудал байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд бид нар бол энэ дээр бизнес эрхлэгчдийг дэмжих үүднээс бодлогуудаа бид нар зөвхөн татвараас гадна өөр бусад бодлогуудыг бид нар бас хамт бодож явах ёстой гэсэн ийм зарчмын байр суурьтай байдаг гэдгийг бас илэрхийлж хэлье.

Ингээд 2019 оны татварын хуулийг оруулж ирэхдээ олон улсын татварын удирдлагын яг энэ шилдэг арга, аргачлалыг хуулийг татварын хуулийг хэрэгжүүлдэг энэ аргачлалыг оруулж ирсэн. 2019 оны энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль маань ч гэсэн тухайн үедээ жижиг дунд үйлдвэрлэлийн хуультай хамт өргөн баригдаж, хамт яг уялдаж, босго нь хүртэл хоорондоо уялдаж батлагдсан хууль байдаг. Үүнтэй холбоотойгоор яг энэ татварын хуулийг олон улсын стандарт зарчмынх нь дагуу хэрэгжүүлэх олон улсын сайн туршлага болсон энэ сегментийн зарчим буюу татвар төлөгчдийг энэ борлуулалтынх нь орлогоос нь хамаарч ялгаатай татварын хуулийг хэрэгжүүлдэг сегмент болгож авч үздэг. Өөрөөр хэлбэл аав, хүү 2 дээр адилхан размерын хувцас таардаггүй шиг, том, жижиг бичил аж ахуйн нэгжүүд дээрээ бид нар бас ийм ялгаатай бодлого авч явах ёстой юм байна гэдэг ийм үүднээс энэ татварын хууль орж ирсэн. Ингээд саяын Чимидсүрэн даргын хэлж байгаа тэр том, дунд, жижиг бичил гэсэн ийм аж ахуйн нэгжүүд сегмент болгож, татварын удирдлагадаа бид нар авч явдаг.

Үүний үр дүнд бол татварын албаны хийсэн, тэр тэр үеийн татварын хуулийн 1 ажил бол энэ Татварын хуулийн дагуу тайлагнал өгөх асуудал байгаа. Хуучин бол том, жижиггүй бүгдээрээ улирал болгон тайлан өгдөг байсан бол одоо жилдээ 2 удаа, хагас бүтэн жилээр тайлан өгдөг болсон байгаа. Үүнтэй холбоотой нягтлан бодогчид ямар гомдол гаргадаг вэ гэвэл хагас жилийн чинь тайлан наадамтай давхцаад байна. Бүтэн жилийнх чинь цагаан сартай давхцаад байна гэдэг ийм асуудал тавьдаг. Тэгэхээр үүнтэй холбоотой ямар өөрчлөлт орж ирсэн бэ гэсэн 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт нь энэ хялбаршуулсан горим гэж байгаа. Хуучин бол НӨАТ-ын босготой нь уяад, 50 сая төгрөгийн борлуулалтын орлого хүртэлх байвал 1 хувиар татвараа өгдөг ийм хялбаршуулсан горим байсан. Одоо та нарын өргөн барьсан хуулиар чинь НӨАТ-ын босгыг 400 сая гэхихсэн. Тэгвэл энэ хялбаршуулсан горимыгоо дагаад яагаад 1 хувиараа оруулж ирээгүй юм бэ гэдэг ийм асуудал байна.

3 дугаарт нь тэр 1,5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой байвал орлогоосоо зарлагаа хасаад, 1 хувиараа татвараа төлдөг ийм татварын систем бас

ийм босготой байсан. Тэр босго чинь бас ингээд саяын хуулиар орж ирээгүй байна. Ямар учраас .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ татварын шатлалыг бий болгосноороо өмнө нь бол та мэдэж байгаа. 6-аас дээш тэрбумын ашигтай байх юм бол шууд тэрнээс доошоо байх юм бол 10, тэрнээс дээш байх юм бол 25 хувийн босготой байсан. Энэ бол аж ахуйн нэгжүүдэд хэтэрхий огцом нэмэлт байна гэдэг ийм асуудлууд үүссэн. Энэ хүрээнд нь бол дунд нь шатлал үүсгээд 6 хүртэл бол 10, 6-10 тэрбумын хооронд 15 гэдэг ийм дундын шатлалыг оруулж ирж байгаа. Ингээд 10 тэрбумаас дээш бол 25 болгоод явахаар. Энэ босгыг нэмснээр том аж ахуйн нэгжүүдийн татварын ачаалал 0,3-0,5 хувиар буурч байгаа. 13 хувьд хүрэхээр байна. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн татварын хөнгөлөлтийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор 90 хувийн татварын буцаалт эдлэх буюу татварын 1 хувийн ачааллын босго бол 1,5 байсан. 1,5 тэрбум төгрөгийн борлуулалттай байгаад орлогоосоо зарлагаа хасаад, татвараа төлөх юу нь 1 хувь байсан бол. Энэ босгыг 2,5 тэрбум болгож өсгөж өгч байгаа. Энэ бол аж ахуйн нэгжүүдэд түрүүн та хэллээ. Хялбаршуулсан байдлаар явахад энэ татварын суурь баазыг нэмэгдүүлэх, татварын хөнгөлөлтийн хэмжээг аж ахуйн нэгжид нэмэгдүүлэх зорилгоор оруулж ирсэн татвар байгаа. Тэр нэмэлт тооцоололтой юмыг нь Чимидсүрэн дарга хариулчих.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон. Чимидсүрэн дарга.

Ч.Чимидсүрэн: Тайлагналтай холбоотой асуулт эхэлж хариулъя. Одоо бол хагас жилийн тайланг 7 сарын 20-нд, жилийн эцсийн тайлан 2 сарын 10-нд байгаа. Энэ дээр бид нар бас хугацааны боломж олгоод, түрүүний таны хэлдэг шалтгаанууд мөн олон нийтээс, тэр тусмаа аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн ажилтнуудын саналаас хамааруулаад, хагас жилийн тайланг 7 сарын сүүлийн өдөр, бүтэн жилийн тайланг 2 сарын бас сүүлийн өдөр болгоод, 10-20 хоног сунгаж байгаа. Тэгэхээр энэ нь бол тайлагнал болоод татвар төлөх хугацаанд бас татвар төлөгч талдаа боломж бүрдэж байна гэсэн санаа.

2 дахь нь хялбаршуулсан горимын 1 тэрбумыг асуулаа гэж ойлголоо. Тэгээд энийг бол аж ахуйн нэгж, байгууллагын 300 саятай уяхад арай боломжгүй юм байна гэж үзсэн. Одоо бид нарын хэрэглэж байгаа нь өөрөө хязгааргүй байгаа байхгүй юу. Дээд хязгаарлалт байхгүй. 5 тэрбум ч бай, хэд ч бай дээшийгээ хялбаршуулсан горимыг ашиглаж болох байгаа юм. Тэгэхдээ хязгааргүй байхад бас тийм сөрөг нөлөөллүүд гараад байна гээд эдийн засгийн цагдаа болон холбогдох .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут хариулъя.

Ч.Чимидсүрэн: Бас хязгааргүй байгаа дээр сул талууд байгаа, зөрчил үүсээд байна гэсэнтэй холбогдуулаад хязгаарлалт тавих шаардлага гарсан. Тэгээд бид нар нөгөө 1 хувийн ачаалалтай буюу нөгөө жижиг, дунд аж ахуйн нэгжийн хувьтай бол арай тэнцүүлж болохгүй. Гэхдээ ингээд хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүс дор хаяж 1-2 хүн, 2-3 хүн дунджаар байгаа бол гээд дундажлаад бид нар бас 1 тэрбумаар тогтоосон байгаа.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулаадахъя. Дархан-Уул аймгийн Хонгор сумын одонтой ээжүүд Төвийн бүсийн гишүүдийн урилгаар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд урт удаан нас, эрүүл энхийг хүсэн ерөөе. Танай суманд манай Гэрэлцэцэг гээд их сайн эмэгтэй байгаа шүү. Заяабал гишүүн нэмж тодруулъя.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхлээр Чимидсүрэн даргаас саяын асуулт дээр нэмээд 1, 2 асуулт бас үргэлжлүүлээд асуучихъя гэж бодож байна. Та сая хэллээ. Энэ хагас бүтэн жилийн тайланг сүүлийн өдрөөр гэж өөрчилж байгаа гээд. Тэгээд сүүлийн өдрөөр гэж өөрчилчихөөр чинь нөгөө Татварын хуулийн хувьд төлөх, тайлагнах хугацаа чинь энэ сарын сүүлийн өдөр болчихоор тухайн сарын орлого дээр бас сөрөг нөлөөлөл ирнэ л дээ. Тийм учраас би энэ хагас жилийн тайланг 8 сарын 5 болгоод, бүтэн жилийн тайланг цагаан сарын дараа буюу 3 сарын 5-ны өдрөөр гээд өөрчлөх ийм саналтай байгаа юм. Энэ дээр та ямар бодолтой байна вэ.

2 дугаарт нь энэ шатлалыг 0-6 тэрбум хүртэл борлуулалтын орлоготой байвал 10 хувь гээд хуучин 2,5 байсныг 6 болгож нэмж байгаа юм байна. Тэгэхээр энийг 6-10 гээд дахиад 15 хувийн шатлал нэмчихсэн байна л даа. Энийг энэ дундын шатлал дээр ер нь хэдэн аж ахуй нэгж байгаа учраас 6-10 гэж нэмсэн юм. Ер нь шууд 0-10 .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Чимидсүрэн дарга.

Ч.Чимидсүрэн: Тайлагналын хугацаа дээр бол яах вэ, бид нар 10-20 хоног өгч байгаа учраас тайлагнах хугацаа нь ч гэсэн хуучнаа бариад уламжлалт юугаараа хүнийхээ нөөцийг ашиглаад бас илүү боломж олгож байгаа юм. 10-20 хоногийн. Тэгэхээр тайлагналт төлөлт дээр давуу тал гарна. Системийн хувьд тийм хүндрэл гарахгүй гэдгийг манай татварын алба илэрхийлж байгаа.

6-10 тэрбумын ашигт нь 15 хувийн шатлал нэмж байгаа дээр бол цэвэр татвар төлөгчдийн, олон нийтийн санал гарсан. Тэгэхээр 6 тэрбум гэдэг бол бид нар 2019 онд л 3 тэрбум байсныг 2019 онд 6 тэрбум болгочоод явж байгаа. Тэгээд түүнээс хойш 5 жилийн дараа дахиад 10 тэрбумын босго болгох тухай асуудал буюу олон нийтийнхээ саналаар энэ босгыг нь өөрчлөөч гэж байгаа юм. Тэгээд 10 хувь байж байгаад 25 хувь болгох бол хэт огцом 250 хувиар нэмэгдүүлээд байна. Тийм учраас энэ дээр нь бас дундын шатлал гаргаач гэсэн л татвар төлөгчдийнхөө санал хүсэлтэд тулгуурлаад хийгдсэн .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд нэмж хариулъя.

З.Мэндсайхан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ дундын тооцооллоор бол 2027 онд 6-10 тэрбумын ашигтай, нийтдээ 338 аж ахуйн нэгж байсан байна. Ашигтай ажилласан энэ нь аж ахуйн нэгжийн 0,5 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр 10-аас дээш тэрбумын ашигтай гэж үзэж байгаа 280 гаруй аж ахуйн нэгж байгаа. Тэгэхээр тус өөрчлөлтийг оруулснаар бол 162 орчим тэрбум төгрөгийн л нөлөө үзүүлнэ гэсэн ийм тооцоолол гарч ирсэн.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Өнөөдөр Татварын хуулиудын нэмэлт, өөрчлөлтүүдийг Засгийн газрын орж ирснээр хэлэлцэж байна. Өчигдөр Их Хурлын даргын оруулж ирсэн Улсын Их Хурлын тухай, Дэгийн тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хэлэлцсэн. Тэгээд энэ оруулж ирж байгаа өөрчлөлтүүдийг ер нь бол буруутгахгүй байгаа гэдгийг Сангийн сайд эхлээд сонсоод авчхаарай. Хариулахдаа хуулийн хэлээр Их Хурлын гишүүд шийднэ, саналаа оруулж болно. Дэгийн горим зааж байгаа юм шиг битгий хариулаарай гэж бас хүсье.

Энэ хууль орж ирсэнтэй холбоотой 1 сөрөг шүүмжлэл явах байх. Тэр нь юу вэ гэхээр аж ахуйн нэгжүүд энэ олон шатлалд ороод, аж ахуйн нэгжүүд томрохгүй, хуваагдаад ингээд татвараа багасгах асуудлууд гарах уу, үгүй юу гэдэг тийм шүүмжлэл явах байх. Тэгэхдээ би бол түүнийг аж ахуйн нэгжүүдийн аль шатлалд татвараа төлж байх тухай нь тэдний өөрсдийнх нь зан төлөвийн асуудал учраас тэрэнд нь бол туйлаас ач холбогдол өгч, аж ахуйн нэгжүүд рүүгээ сэрдлэг, хардлага явуулмааргүй байгаа юм. Энэ аж ахуйн нэгж, компани байгуулаад явж байгаа хүмүүстээ эхний хэдэн жилд нь татвараас чөлөөлчихдөг тэр боломж олгож болохгүй юу. Огт татваргүй байх. Тэр хооронд инновац орж ирнэ. Соёл нь бүтээгдэнэ. Санхүүжилт, хуримтлал нь бий болно. Боловсон хүчин нь тогтвортой ажиллаж эхэлнэ. Нийгмийн даатгал эд нараасаа бусад энэ татварыг нь байхгүй болгох чиглэлээр оруулж ирж болохгүй юм уу.

2-т нь Засгийн газар ашгийн салбарт, ашиг бүтээдэг бизнесийн салбарт өрсөлдөөд байдгаа больж болохгүй юм уу. Энэ бол татварын тодорхой хувь хэмжээ тогтоох, шатлал тогтоохоос илүү их ач холбогдолтой зүйл шүү дээ. Засгийн газрын харьяа компаниуд, төрийн өмчит, орон нутгийн өмчит гэдэг. Хамгийн том алдагдлыг бий болгож байгаа компаниуд бол тэд. Нөгөө талдаа маш цөөхөн компани хамгийн том татвар засагт төвлөрүүлж байгаа компаниуд. Тэгэхээр энэ нь юу вэ гэхээр Засгийн газрын харьяа компани байна гэдэг бол нэг талаасаа засагт барьж байгаа намын төлөөний хүмүүс очиж намаа тэжээж байгаа, улс төрчдийг тэжээж байгаа. Нөгөө талдаа иргэд Монгол Улсдаа эзэн нь байж, бизнес эрхлэх тэр боломжийг хааж байгаа. Ашиггүй ч гэсэн татаасаар явдаг, газрыг нь өгдөг, банкны баталгааг нь өгдөг, санхүүжилтийг нь өгдөг, тусгай зөвшөөрлийг нь өгдөг. Ингээд бизнес буюу ашиг олох салбарт төр Засгийн газар буюу эрх барьж байгаа намууд байгаад байхаар энэ иргэд чинь гадагшийгаа яваад байгаа юм.

Нөгөө утгаараа тархины гоожилт ч гэж ярьдаг. Чадвартай, чадалтай, хөдөлмөрлөдөг, бүтээдэг хүмүүс чинь өөр улс орныг зориод байгаа юм. Өнөөдөр тэгээд Татварын хууль ярьж байсан. Дахиад 2 дахь хуулийнхаа төсөл дээр дахиад л ярих хэрэг гарч байна. Дахиад 1 машины тухай. Өмнөх хууль дээр дугуйных нь хий гарч байна. Хийлээд явж байн. Зөв өө, зөв гэсэн. Одоо нэг пяавар чимэглэлийн никель эд анги нь хугарчихсан байна. Тэрийгээ сольж наагаад гоё харагдаад л цаашаа явах гэж байна. Энэ бодлогын өөрчлөлтүүдээ хийх тэр өөрчлөлт рүүгээ хэзээ орох юм бэ.

2024 онд Их Хурал тангаргаа өргөөд, төсөв, төсвийн тодотгол, Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэлж байх үед Иргэний Зориг Ногоон намын байр суурийг тодорхой илэрхийлсэн. Засгийн газар бизнесийн салбарт иргэдийнхээ ашигтай өрсөлдөх ёсгүй гэж. Тэрнээс хойш хэр өөрчлөлт орсон юм.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Төр хэтэрхий оролцоод төрийн өмчит компаниудаар бизнес хийгээд байна гэж. Тэгэхээр төрийн өмчит компаниудыг ярихын өмнө бас бид нар яг энэ байгуулагдсан зорилгыг бас харах ёстой. Хувийн хэвшлүүд ашиггүй гээд ордоггүй салбарууд дээр зарим аж ахуйн нэгжүүдийг төрийн өмчит компани зайлшгүй байх ёстой учраас байгуулсан байгаа. Нөгөө талдаа тодорхой стратегийн бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг тогтвортой байлгахын тулд төрөөс энэ стратегийн бүтээгдэхүүний үнийн бодлогыг хамгаалах зорилгоор байгуулсан компаниуд байгаа. Мөн манай үндэсний баялагтай холбоотой стратегийн уул уурхайн компаниуд байгаа. Энэ компаниуд маань хувийн хэвшлийг булаагаад байгаа асуудал байна уу гэвэл зарим талаараа байгаа байх. Гэхдээ бид нар анх байгуулсан зорилгодоо хэрхэн хүрсэн бэ гэдгийг үнэлж байж энэ төрийн өмчийн компаниудын асуудлаар ярих ёстой.

Төрийн өмчийн компаниудыг хувьчлаад орж ирсэн орлогоор нь ийм юм хийх ёстой гэдэг ийм асуудлуудыг их ярьж байгаа. Гэхдээ энэ чинь бол төрийн өмч анх хөрөнгө оруулаад хийчихсэн, төрийн өмчид бүртгэлтэй, одоо хөдлөх болон хөдлөх бус үл хөдлөх хөрөнгүүд байгаа шүү дээ. Энийг борлуулснаар орлого нэмэгдэнэ гэсэн ойлголт биш байхгүй юу. Бид нар хөдлөх болон хөдлөх бус хөрөнгөө мөнгөн хөрөнгө болгож л хувиргаж байгаа. Түүнээс биш энэ төсвийн нэмэлт орлого болж орж ирнэ гэсэн ойлголт бол биш.

Бүртгэлийн хувьд бид нар орлогоо төр төрийн өмчит компанийн байшин барилга, сав байдаг юм уу, үйл ажиллагаа явуулж байгаа тэр хөдлөх хөрөнгүүд байдаг юм уу, энийг хувьчилж олсон орлого бол хөрөнгийн бүртгэл дээрээ л өөрчлөлт орж, мөнгөн хөрөнгө рүү л шилжинэ гэсэн үг. Түүнээс биш үүгээр төсвийн юу хаагаад явна гэсэн ойлголт байхгүй.

2 дугаарт энэ төр хэтэрхий их зөвшөөрөл өгч байна гэж байна. Энэ хүрээнд 200 гаруй хуулийг цэгцлээд, Эдийн засгийн эрх чөлөөний хуулийг Засгийн газар ирэх 7 хоногт хэлэлцээд, Их Хуралдаа өргөн барина. Энэ асуудлаар янз бүрийн бизнес эдийн засгийн орчинд нөлөөлж байгаа тэр саад бэрхшээлүүдийг бүгдийг нь чөлөөлье гэж байгаа юм. Ингээд Бизнесийн эрх чөлөөний хуулиа оруулж ирье. Эдийн засгаа тэлэхийн тулд бид нар аж ахуйн нэгжээ дэмжье. Бизнесийн орчноо дэмжье гэж байгаа юм. Тэдэнд саад болж байгаа бүх асуудлыг шийдье гэж байгаа юм. Нэмээд Чимидсүрэн дарга хариултыг нь өгчих.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрхэт эрдэм” сургуулийн Отгонхуяг багштай 9^а ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр аж ахуйн нэгжийн татварыг эхний хэдэн жил нь татваргүй байж болох уу гэж байна. Тэгээд түрүүн Заяабал гишүүн хэлсэн манай оронд чинь ер нь аж ахуйн нэгж, байгууллагын татварын хувь хэмжээ дээд тал нь 40 хувь байсан үе эд нар бол бий. Тэгээд энийг ингээд үе шаттай багасгасаар одоо нийт аж ахуйн нэгжийн 96, 97 хувь нь 1 хувийн л ачаалалтай байгаа. Гэхдээ бид нарт бас Инновацийн тухай хуулиар энэ IT-ийн компани бас эхний 5 жилдээ 90 хувиар чөлөөлөгдөж байгаа. Ийм хууль мөрдөгдөж

байна. Тэгэхээр нийт аж ахуйн нэгжид хязгааргүйгээр ингээд эхэнд нь чөлөөлөх боломж байхгүй. Борлуулалтын орлоготой нь уяад, тэгээд түрүүний хэлснээр бид нар 1,5-ын босготой байсан 1 хувийн ачааллыг 2,5 тэрбумын борлуулалт хүртэл нэмэгдүүлж энэ удаа оруулж ирсэн байгаа.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: Миний 3 асуултын алинд нь ч хариулсангүй. Аж ахуйн нэгжийг шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжид эхний хэдэн жилд нь татвараас 100 хувь чөлөөлөх боломжтой юу гэж асуусан. Хариулт нь байхгүй.

Засгийн газар бизнесийн ашиг олж байгаа салбараасаа ашиг олох тэр үйл ажиллагаанаасаа татгалзаж, ухарч болохгүй юу гэж асуусан. Төрийн өмчит компани ямар зорилгоор байгуулагдсан тухай хариулаад явчихлаа. Тийм болохоор хариулт ерөөсөө огт ирсэнгүй.

Дээрээс нь нэмээд тодруулаад асууя. Өнөөдөр 6 тэрбум төгрөг, 10 тэрбум гээд шатлалууд яригдаж байна. Энэ өмнөх Татварын тухай хуулиар байсан шатлал. Тухайн үед энэ шатлалыг тогтоож байхад Монгол төгрөг Америк долларын харьцдаг ханш хэд байсан юм. Одоо хэд болчихсон юм. Тэр утгаараа нөгөө инфляцаа буюу нөгөө татварын орлого, дээрээс нь тэр тухайн аж ахуйн нэгжийн бэхжилтэд хэр сайн сайн нөлөөлж чадаж байгаа юм. Зүгээр ханшийн зөрүүгээр явж байгаа, дагаж хөдөлж байгаа татвар шиг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд. Тэгээд тодорхой асуулт асууж байна. Хариулаарай.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2027 онд би бас хамгийн сүүлийн тооцооллоор хэлье. 6-10 тэрбум төгрөгийн ашигтай ажилладаг 338 аж ахуйн нэгж байсан. Эдгээр маань 25 хувийн татвар төлдөг байсан. Энэ чинь 6 тэрбум хүртэлх татвар төлөхөд 10 хувь хүртэл яваад тэрнээс дээш гарчхаад 25 гээд, 15 хувийн огцом өсөлт бий болоод байсан. Энэ татварын хуулийн өөрчлөлтийг би зохиогоод оруулаад ирээгүй. Аж ахуйн нэгжүүд маань энэ огцом шилжилт чинь дарамт болоод байна гэдэг асуудлыг хөндөж тавьсан. Энэ олон уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд гарч ирсэн. Тийм учраас бид нар энэ 2-ын дунд 6-10 гэдэг шатлалыг оруулж ирж байгаа. 15 хувийн татвартай байхаар. Энд нийтдээ 280 гаруй аж ахуйн нэгж хамрагдана. 10 тэрбум төгрөгийн ашигтай байгаа. Төсөвт ирэх ачаалал нь бол 162 орчим тэрбум төгрөг байгаа. Энэ хэмжээгээр өмнөх .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн, Иргэний Зоригийг ногоон намын дарга асуултаа нэмж тодруулна.

Б.Батбаатар: Зүгээр Монгол төгрөгийн ханшийн уналтаар төсвийн цоорхойгоо нөхөж байгаа бодлого Засгийн газар олон жил барилаа л гэж харж байгаа шүү дээ. Иргэдийнхээ, бизнес эрхлэгчдийнхээ өсөн торних боломжийг нь хааж байгаа л гэж ойлгож байгаа. Энд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Татварын хууль хэдэн жилийн өмнө ямар гадаад валютаар Монгол төгрөгийн ханшийн уналтаар, энэ ханшийн өөрчлөлтөөр явж байгаа зүйлээр энэ татварын хувь хэмжээ чинь өөрчлөгдөж, мөн чанартаа өөрчлөлт орсон юм уу гэдэг тухай л асууж байгаа юм.

Ханшийн өөрчлөлтөөр иргэдийнхээ халаасыг суйлах замаар төсвийн алдагдлаа нөхөөч. Өнөөдрийн тоо баримтыг гаргасаар л явна шүү дээ. Долларын ханш 1300 хүрлээ гээд л талбай дээр салаавч гаргаад зогсож байсан хүмүүс цагтаа байж л байсан. Одоо 3600 давчихсан. Монгол төгрөгийн ханш хэд болж байгаа юм. 1 төгрөгийн үнэ цэн гэдэг зүйлээ ойлгож, энэ төсөв төлөвлөгөө юм нь .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууна.

Б.Түвшин: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Татварын ерөнхий хууль дээр энэ TADAT аргачлалыг нэвтрүүлнэ гээд ингээд заачихсан байна. Энэ бол ер нь сайн зүйл. Татварын бүртгэл, тайлагнал төлөлт, зөрчил, гаалийн бүрдүүлэлт гэсэн энэ 5 хэсгийг томъёолоод, тооцооллын аргачлалыг нээлттэй нийтэлдэг ийм л аргачлал байгаа. Энийгээ харин бид нар яг одоо байгаа хандлага арга зүйгээрээ хэрэглүүлэх юм бол ямар ч үр дүнгүй болно. Энийг бол тийм хяналтын хэрэгсэл биш, татвар төлөгчид өөрсдөө нээлттэй үнэлгээгээ хардаг, санал гомдлоо гаргадаг, ил тод байдал болон татвар төлөгчийн эрх ашгийг хангадаг ийм байдлаар оруулж суулгах юм бол энэ бол татварын албанд дэвшил болно гэдгийг хэлье. Тийм учраас яг энэ эрсдэлийн үнэлгээг нь яг ямар аргачлалаар хийж байгаа юм. Тэгээд ялангуяа бичил, жижиг бизнес эрхлэгчид бол мэдээлэл дутмагаас болоод эрсдэлтэй ангилалд орчихдог. Түүнд яаж тусалъя гэж бодож байна вэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт энэ хуулийн тэр татвараа төлж чадахгүй байгаа аж ахуйн нэгжүүдийн орж ирж байгаа мөнгийг 80/20-оор нь хуваая гээд байгаа. Энийг уг нь 50/50 болгочихмоор л байгаад байгаа юм. 63.2 дахь заалтыг нэмээд байгаа. 63.1.4 дэх заалтыг хасахгүй бол энэ чинь угаасаа хэрэгжихгүй. Тэгээд 63.1 1.4 дэх нь бол бүгдийг нь ав л гэсэн ийм агуулга явж байгаа шүү дээ. Тэгээд энийг хасах уу, хасахгүй юу. Ер нь татвар ноогдох энэ татварын ачааллын гол асуудал чинь бодит татвар, нэрлэсэн татвар 2 л байгаа шүү дээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэдэг зүйл ангилал дээр маш олон хөнгөлөлт, чөлөөлөлтийг өгч байна. Одоо энэ татварын хуулиа тойруулаад хөнгөлөлт, чөлөөлөлт өгсөөр байгаад энэ нь бол бүр хэрээс хэтэрлээ. Төр бол авах юмаа авдаг. Зөв, шударга зарцуулдаг болно уу гэхээс биш тодорхой хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт өгсөөр байгаад энэ нь мөчрөө дийлэхээ байсан. Авах ч юмаа авч чадахгүй болсон. Одоо энэ хөнгөлөлт чөлөөлөлтүүд арай хэтэрч байна гэдгийг бас хэлэх хэрэгтэй. Тийм учраас бодит татварыг бууруулах хэрэгтэй.

Ер нь бол ААНОАТ 10 хувиар байхад бодит татвар 36 хувьтай байна гэж судалгаа гаргаж байсан. 5, 6 жилийн өмнө. Одоо энэ хэвээрээ л байх шиг байна. Улам л чанга болчихсон. Тийм учраас энэ татвар ногдох орлогыг бодитойгоор бууруулаад, бодит татварын ачааллыг үе шат руу нь хэлэх хэрэгтэй. Энэ шатлалуудыг ойртуулахлаар аж ахуйн нэгжүүд чинь жижгэрнэ шүү дээ. Яг тэндээс бодитойд татвар ногдох орлогын шатлал нь буурснаараа аж ахуйн нэгжүүд босоод ирэхгүй шүү дээ. Тийм учраас ер нь энэ шатлалуудыг буулгахаасаа илүүтэй бодит татварыг бууруулчихвал яадаг юм. Татвар ногдох орлогоос хасагдах зардлыг нь нэмэгдүүлэх ийм бодлого ер нь бодож байгаа юу. Ер нь энэ Татварын багц хууль болон Аж ахуй нэгжийн орлогын албан татварыг энэ хөнгөлөлт, чөлөөлөлтөөс нь салгаад, жоохон цэгцтэй болгох цаг болсон юм биш үү. Энэ тал дээр бол тодорхой хариулт авчхаад тэгээд үргэлжлүүлээд асууя.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ удаагийн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бизнес эрхлэхэд хүндрэлтэй зарим заалтыг л оруулж ирсэн. Тухайлбал, өртэй компанийн дансыг бүрэн хаах биш, зүгээр ирээдүйд орж ирэх орлогынх нь 20 хувийг нь үлдээгээд, бизнесээ үргэлжлүүлэх боломжийг нь олгох, нэмэгдсэн өртгийн албан татварын ноогдлыг төлөх хугацааг 2 сар хүртэл хойшлуулах, тэгээд татвар тайлагнах, төлөх хугацааг хойшлуулсан тайлангаа засах хугацааг нь 2 жилээр бол сунгасан, алдангийн хэмжээг 50 хувиар хязгаарлах гэх мэт энэ нэмэлт, өөрчлөлтийн заалтууд орж ирж байгаа юм. Татвар төлөгчийн эрсдэлийн үнэлгээг аж ахуйн нэгж маш олон хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлж байна гэж байна. Бодит татварыг бууруулах чиглэлээр гээд энэ чиглэлүүд дээр бол бид нар зарим тал дээр бол тантай санал нэг байна. Гэхдээ бид нар энэ богино хугацаанд аж ахуйн нэгж, иргэддээ аль болох, ялангуяа хөдөлмөр эрхэлж байгаа иргэддээ бодит дэмжлэг болох тэр заалтуудыг оруулж ирж байгаа юм. Бид Татварын багц хуулиараа энэ реформын шинжтэй асуудлуудаа дахин оруулж ирнэ. Эдийн засгийн ийм хүндрэлтэй үед богино хугацаанд аж ахуйн нэгж, иргэд, хөдөлмөр эрхэлж байгаа иргэддээ дэмжлэг болох тэр заалтуудыг татварын нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирье гэж цомхон хүрээнд оруулж ирж байгаа. Маш богино хугацаанд үр дүн нь гарахаар. Тэр татварын системийн талаар Чимидсүрэн дарга, Цогтнаран дарга хариулчих.

Б.Пүрэвдорж: Цогтнаран дарга хариулъя.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Түвшин гишүүний асуултад хариулъя. Түвшин гишүүн TADAT-ийн үнэлгээтэй холбоотой асуудлыг хөндлөө. TADAT-ийн үнэлгээ гэдэг бол улс орнуудын татварын байгууллагуудын үйл ажиллагааг үнэлдэг ийм систем. Өөрөөр хэлбэл Татварын албаны давуу болон сул талуудыг тодорхойлоод, олон улсын сайн туршлага нэвтрүүлэх дээр дэмжлэг үзүүлдэг ийм систем байгаа. Татварын албаны үйл ажиллагааг бол 2-3 жилийн хугацаанд давтамжтайгаар үнэлдэг. Монголын татварын алба 2021 онд бол TADAT-ийн үнэлгээнд хамрагдсан. Татварын ерөнхий хууль дээр орж ирж байгаа хууль даган мөрдөлтийн түвшин гэдэг бол өөр. Энэ бол тухайн татвар төлөгчөө татварын хууль даган мөрдөлтийг нь татвар төлөгч талаасаа үнэлж байгаа тийм үнэлгээ Харин TADAT нь бол татварын албаны үйл ажиллагааг үнэлж байгаа үнэлгээ юм.

Б.Пүрэвдорж: Түвшин гишүүн нэмж тодруулъя.

Б.Түвшин: Сангийн сайд хэлж байх шиг байна. Зүгээр энэ бол богино хугацааны шийдэл гэж байна. Яг үнэндээ бол шууд, маш богино хугацааны түр зуурын л эдийн засгийн хүндрэлийг давах гэж байгаа гэдэг аргачлал явж байх шиг байна. Тэр учраас амласан ёсоороо тэр Татварын багц хуулийг оруулж ирж, энэ бодит татварыг нэрлэсэн татвартай ойртуулах бодлого явуулах зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Ер нь нөгөө нүдээ онохгүй гэдэг шиг татварын ачааллыг бууруулъя гээд ярихаар яг эцсийн татвар төлөгчийг нь буруу тодорхойлоод, хөнгөлөлт чөлөөлөлт өгдөг. Эсвэл тэр жижиг дунд аж ахуйн нэгжүүд рүүгээ хандчихдаг. Энэ татварын ачаалал, бизнесийн орчин гэдэг чинь бол дундаж болон өсөж яваа, тэгээд ихээхэн татвар төлдөг байгууллагууддаа хүндрэл учирч байгаа. Тэр байгууллагуудыг л олон болгоё, тэтгэе гэдэг ийм бодлого шүү дээ. Тэгээд энэ олон тархай бутархай хөнгөлөлт, чөлөөлөлтөө болиод, ер нь энэ Пүрэвдорж даргын тэр 5 хувийг нь 3 хувь юм уу, 2 хувь болгоод буулгачхаач гэвэл

татвар ноогдох энэ орлого чинь нэмэгдэж, аж ахуйн нэгжүүд өсөх юм биш үү. Ер нь маш энгийн байх ёстой шүү дээ.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Нэмэгдсэн өртгийн албан татвар бол төсвийн орлогын 20-оос дээш хувийг бүрдүүлж байгаа манай гол тогтвортой татварын 1 байгаа. Тэгэхээр Пүрэвдорж гишүүний санаачилсан хуулийн хувьд 5 хувь болгож бууруулснаар бол төсвийн орлого 4,1 их наядаар тасарна гэсэн үг. Энэ хэмжээгээр орлого байхгүй болно л гэсэн үг. Дэлхийн нэмэгдсэн өртгийн албан татварын системтэй 175 орны хүрээнд ингээд аваад үзэх юм бол Монгол Улс 10 хувийн хувь хэмжээ гэдэг бол харьцангуй доогуур тооцогдож байгаа. Манайхаас доошоо татвартай 9 орон л байгаа. ОУВС-ийн зүгээс ч гэсэн ер нь энэ нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг бол буулгах нь буруу гэж зөвлөхөөс гадна та бол өчигдөр байхад нөгөө Шри-ланкын жишээ ярьж байсан нэмэгдсэн өртгийн албан татвараа 15-аас доошоо буулгаад 8 хувь болгосон. Төсвийн орлого нь 30 хувиар буурсан. Ингээд дефолт зарласан ийм гашуун түүх байгаа. Тэгэхээр бид нар энэ татварын.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд аа, миний өргөн барьсан тэр НӨАТ-ын татварыг 5 хувь болгох, буцаан олголт нь 2 буюу нийтдээ 3 хувь төлөх энэ хууль бол зарчмын зөрүүтэй санал гаргаад тэр уул уурхай архи, тамхи дээр 10 хувь хэвээрээ байна. Тэгэхээр энэ тохиолдолд бол ойролцоогоор 1,5 их наядаар татварын орлого буурна гэж байгаа юм. Тэгэхдээ буцаад яг энэ Түвшин гишүүний хэлсэнчлэн татварын бааз суурь нэмэгдсэний үр дүнд ерөөсөө орлого буурахгүй гэсэн ийм эдийн засгийн тооцооллын судалгаа гарсан шүү гэдгийг хэлье.

Нэмээд Түвшин гишүүн тодруулъя.

Б.Түвшин: Энэ Шри-ланкын жишээг дахиад 1 тодорхой хэлчихье. Мега төсөл гэж нэрлээд, мега төслүүд нь тооцоолсноосоо үр ашиггүй болонгуут мега төслийнхөө объект болох хамгийн том боомтоо Хятадын зээлээр бариад, тэгээд үр ашиггүй болонгуут нь алдчихсан шүү дээ. Энэ хамгийн гол Шри-ланкын кэйс юм байгаа юм гэдгийг хэлье.

2 дугаарт нэмэгдсэн өртгийн албан татварын энэ хөнгөлөлт, чөлөөлөлтүүд үүнийг тооцож бодож олгох үйл ажиллагааны зардал буюу Activity based costing чинь энэ хөнгөлөлтөөсөө илүү зардал гаргаж байгаа шүү. Төрийн албан хаагчдад маш их ачаалал нэмж байгаа. Тэрний оронд 2, 3 хувь функт бууруулчихад бол татварын бааз суурь нэмэгдэх юм байгаа шүү гэдгийг дахиж хэлье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Гомбын Ганбаатар нарын урилгаар Дорноговь аймгийн Мандах, Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд улс төрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Болдын Жавхлан гишүүн асуулт асууна.

Б.Жавхлан: Татварын багц хуулиа өргөн барьсан. Их сайн хэрэг. Гэхдээ энэ дээр бас ганц нэг тодруулж хэлэх зүйлүүд байна. Энэ дотор чинь үндсэндээ 4 том хууль орж байж яг багц хууль татварын реформ гэдэг энэ үзэл баримтлал маань өөрөө бий болж босож ирж байгаа. Татварын суурь хууль, Хувь хүний орлогын албан татварын хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, НӨАТ-ын хууль гээд. Өмнө нь өргөн баригдсан байсан багцаас ялгаатай нь гэвэл Засгийн газраас дахин өргөн барьсан нь НӨАТ-ын хуулиа бүхэлд нь татчихсан байна лээ. Тэгэхээр яах вэ, энэ дээр хэлэх зүйлүүд байна. Нөгөө яг татварын багц реформ гэдэг агуулга чинь ингээд алдагдчихаж байгаа юм биш үү. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд хийгдсэн олон нийтийн санал асуулга хэлэлцүүлгээр хамгийн их хүлээлттэй байгаа хуулиуд маань энэ НӨАТ-ын хууль байгаа. Дараа нь ААН, ХХОАТ. Гэтэл яг энэ хамгийн хүлээлттэй байгаа хуулиа эргүүлэн татчихаар яг энэ НӨАТ дагасан нөгөө яг том реформ маань ингээд цуг бүр алга болчихлоо.

Уг нь тэгэхийн оронд 2 жил хэлэлцүүлэг хийчихсэн. Олон нийт, баялаг бүтээгч, татвар төлөгчдийн дунд нэгэнт хүлээлт бий болчихсон байсан. Өмнө нь өргөн баригдсан байсан хууль дотор мөн эдгээрийг нь тусгачихсан ийм зүйлүүд байсан. Яах вэ, энэ жилийн хувьд НӨАТ-ыг татсан шалтгаан нь гадаад, дотоод нөхцөл байдал, татварын орлого, төсвийн нөхцөл байдлаас шалтгаалаад орлоготой уялдуулж татсаныг бол ойлгож байна. Гэхдээ энийг арай өөр байдлаар буюу үзэл баримтлал бодлогоо хадгалаад реформоо бүхэлд нь хадгалаад харин орлогод нөлөөлөхгүй байдлаар аажмаар хугацааг нь дарамт багатайгаар хойш нь шийддэг ч юм уу энэ чинь бүр 2030 оноос хэрэгжих байдлаар ч шийдэж болно шүү дээ. Реформоо хадгалаад.

Дээрээс нь мөн өргөн баригдсан байсан НӨАТ-ын хууль дотор орлогод нөлөөлөхгүйгээр олон нийтийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн хэд хэдэн чухал ийм заалтууд байсан. Тухайлбал, яг мөнгөн суурь луу шилжицгээе. Импортлогч компаниудын гааль дээр, хил дээр НӨАТ хураадгийг, татвар авдгийг больё. Болиоч ээ. Энд борлуулалтын хугацаа өгөөч, тодорхой хугацааны дараа ингээд НӨАТ-аа тайлагнаад төлөөд явдаг больё гэдэг энэ маш олон жил яригдсан байсан. Энэ заалтуудыг уг нь оруулсан байсан. Энэ маань бүхэлдээ татагдаад, тэр дотор нь байхгүй болчихсон.

Өөр энэ чинь бараг 30 гаруй мянган аж ахуйн нэгжүүдийг хамруулсан ийм хэлэлцүүлэг болсон. Энэ нь бол нөгөө Худалдаа аж үйлдвэрийн шат шатын танхимуудаар дамжиж мөн шууд аж ахуйн нэгжүүдтэй нь ч уулзалт хийсэн зүйлүүд байгаа. Тэр дотор бараг 90 хувь нь хэлж байсан 1 зүйл байгаа. Бүр онцгой анхаарал татсан. Тэр юу вэ гэвэл энэ татвар төлөгч яг ялангуяа энэ НӨАТ-ын татвар гэдэг маань өөрөө ийм гинжин шинж чанартай ийм татвар. Аж ахуйн нэгжүүд бол зөвхөн энийг чинь суутган дамжуулагч агентын үүрэг гүйцэтгэдэг. Тэрнээс эцсийн татвар төлөгч биш. Гэтэл тэр дундаас нь ингээд 40 гаруй хуулиар 40 гаруй салбарын төлөөллүүд, аж ахуйн нэгжүүд бизнесүүдийг татвар суутган төлөгчөөс нь үүргээс нь бүр чөлөөлөөд хаячихаар тэр нөгөө дамжуулагч цаана нь байгаа урд нь байгаа аж ахуйн нэгжүүд дээр энэ чинь бараг торгууль болж очоод байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ больчихъё. Тэгээд бүгдээрээ суутган төлөгч больё гэдэг маш хүчтэй ийм саналууд 90 гаруй хувь нь хамарсан ийм зүйлүүд орж ирсэн боловч энэ нөгөө НӨАТ-ын хуулийг татахад мөн л бас байхгүй болчихож байгаа юм. Тэгэхээр нөгөө реформ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тодруулъя.

Б.Жавхлан: Ийм зүйлүүд ингээд алга болчихсон. Харамсалтай байгаа юм. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн шатдаа оруулах гэхээр энэ чинь нөгөө нэмэлт, өөрчлөлт учраас, тэгээд хууль нь татагдчихсан, өргөн баригдаагүй учраас ямар ч боломжгүй болчихож байгаа юм. Тэгэхээр нөгөө яг олон нийтийн хүлээлттэй нийцсэн том реформ чинь ингээд байхгүй болох гээд байна шүү гэдгийг хараадхаач. Энэ дээр юу гэж харж байна. Мөн шинээр өргөн барьсан дотор өмнө нь байгаагүй үнэхээр дэмжиж болохгүй 1 заалт байна. Уучлаарай. Энэ НӨАТ-ын суутган төлөгчийн босгыг 50-аас 400 сая болгож байгаа бол энэ маш том суурь бодлогын ухралт болно. Ухралт болно. НӨАТ-ын хууль 2005 онд анх энэ систем өөрөө бий болсон юм. Тэгээд 2015 онд Ардчилсан нам засаг барьж байхад Сангийн дэд сайд Пүрэв гуай ахлаад, яг и-баримтад суурилсан энэ цоо шинэ НӨАТ-ын системийг бий болгосон юм..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж дахиад 1 минут.

Б.Жавхлан: Надад итгэхгүй байгаа бол Пүрэв сайдыг дуудаад асуугаарай. Энэ систем чинь ер нь юу болчихов гээд. Тэгээд Пүрэв гуайд бол Гавьяат битгий хэл бараг баатар өгөхөд болохоор шүү. Тэгэхээр энэ 50 сая байж байгаад 40 сая болгочихоор энэ хооронд 23 мянган аж ахуйн нэгжүүд гулсаж доошоо орох гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл НӨАТ төлөгч биш болж байна гэсэн үг. 62 мянган аж ахуйн нэгжийн түрүүн Чимидсүрэн дутуу хэлж байна. 62 мянган аж ахуйн нэгжийн 61 мянга нь манай Монгол Улсад 1 хувийн татвар төлдөг юм. 1500 аж ахуйн нэгж л 10 хувийн татвар төлж байгаа. Тэр 61 мянгын 45 мянган буюу 74 хувь нь НӨАТ-ын бүртгэлд байдаг. 45 мянгын чинь 23 мянга нь ингээд алга болчихно. 50-аас илүү хувь нь алга болчихож байгаа байхгүй юу. Нэг талаар ингээд чөлөөлөх гээд байгаа юм шиг мөртөө энэ чинь өөрөө тэр аж ахуйн нэгжүүдийг бүр хорлочхож байгаа юм. Тэд нар голцуу бэлтгэн нийлүүлэгч ийм компаниуд байдаг. Тэгвэл тэд нараас худалдаж авдаг том компаниуд, том худалдааны төвүүд та НӨАТ-гүй танаас авахгүй гээд тэд нарыг чинь бүр байхгүй болгочихно..../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ер нь бол санал хэллээ. Жавхлан сайд урьд нь бас яг энэ бодлого хэрэгжүүлээд олон жил болсон болохоор асуудлаа нэлээн сайн мэдэж байгаа байх. Тийм учраас энэ хэлэлцүүлгийн явцад энэ асуудлуудыг оруулах талаар ажиллаарай гэж хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Туваан гишүүн алга байна.

Туваан гишүүний өнөөдөр төрсөн өдөр болж байгаа. Туваан гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэе.

Жавхлан гишүүн сая үг хэлсэн. Дахиад хэлэхгүй гэж байна. Үг хэлэх юм уу. Жавхлан гишүүн үг хэлнэ. Индрийн 1 дүгээр микрофон.

Б.Жавхлан: Засгийн газраас өргөн барьсан Татварын багц хуулийг бүрэн дэмжиж байгаа. Нэлээдгүй хугацаанд бас өргөн хэмжээний хэлэлцүүлэг хийгээд, баялаг бүтээгч, аж ахуйн нэгж, татвар төлөгч нарт бол маш том хүлээлт бий болсон байгаа. Тийм учраас энийг яаралтай, энэ хавартаа багтааж нэлээн явуулах ёстой. Уг нь амжвал баталж байх хэрэгтэй юм байгаа юм. Тэгж байж 2027, 2028 оны яг төсвийн бодлогод ингэж шингэж орж, яг аж ахуйн нэгжүүд дээр хөрсөн дээр бодит амьдрал дээр үйлчлэл нь очих ёстой юм. Тийм учраас энийг бүрэн дэмжиж байна.

НӨАТ-ын хуулиуд дээр бол бүхэлд нь татсан нь бол бас харамсалтай. Уг нь бодлогоо хадгалж үлдээд, яг Татварын багц реформ гэдгээ хадгалаад, мэдээж орлогод сөрөг нөлөөтэй бол энийг нь хугацааг нь жоохон хойш нь шийдээд ингээд явчхаж болох байсан юм. Гэхдээ ямар ч байсан өргөн барьсан хэмжээнд Татварынхаа багц хуулиудыг хэлэлцээд, үүнийг яаралтай батлаад, тэгээд ажилд нь оруулах шаардлагатай байгаа. Тэгээд бүрэн дэмжиж байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Цэндийн Баатар гишүүн алга байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг энэ татварын багц хуулийг хамтатган явуулна.

15.15 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна.

З.Мэндсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг өргөн танилцуулж байна.

Энэ хүрээнд Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, МҮХАҮТ, Улаанбаатар хотын худалдааны танхим болон Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээж авлаа.

Иргэд, аж ахуйн нэгжүүдээс татварын ачааллыг бууруулах, хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэхэд татварыг энгийн ойлгомжтой, илүү уян хатан болгох зэрэг саналуудыг голчлон ирүүлсэн.

Түүнчлэн Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас үүдэн дэлхийн газрын тосны үнэ тогтворгүй болж, инфляц нэмэгдэх, өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өсөх эрсдэл бий болоод байна.

Энэ нь иргэдийн бодит орлого, худалдан авах чадвар болон бизнесийн тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй тул гадаад орчны сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын өсөлтөөс урьдчилан сэргийлэх аж ахуйн нэгжүүдийн тогтвортой үйл ажиллагааг дэмжих шаардлага тулгараад байна.

Сангийн яам дээрх уулзалт, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг судлан үзэхээс гадна олон улсын байгууллагуудаас өгч буй санал, зөвлөмжийг харгалзсан үзсэний үндсэнд Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Энэ удаагийн татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 2,2 орчим их наяд төгрөгөөр үе шаттай бууруулахаар тооцож байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг боловсронгуй болгох, албан татвар тайлагнах үйл ажиллагааг уян хатан болгоход чиглэгдэнэ. Тухайлбал,

1.Иргэдийн татварын ачааллыг бууруулах зорилгоор хөдөлмөр эрхэлж буй иргэдийн сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод ноогдуулах албан татварыг 100 хувь хөнгөлж, буцаан олгох.

2.Бүх нийтээрээ шударга татвар төлдөг татварын орчныг бүрдүүлэх зорилгоор үйл ажиллагааны орлогыг хялбаршуулсан горимоор тайлагнах, босох, дүнг 1 тэрбум төгрөгөөр тогтоож, борлуулалтын орлогын 1 хувиар татвар төлөх боломж олгох.

3.Татвар төлөгчийн тодорхой хугацаанд өмчилсөн орон сууцаа худалдан борлуулсан тохиолдолд үл хөдлөх борлуулсны албан татвараас чөлөөлөх.

4.Татвар төлөгчдийн татвар тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах зорилгоор тайлан тушаах албан татварыг төсөвт төлөх хугацааг хойшлуулах зэрэг өөрчлөлтүүд тусгагдаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын иргэдийн татварын ачаалал буурч, бодит орлого нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг иргэн өрх бүрд хүргэх зэрэг чухал ач холбогдолтой байна.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих орлогын тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг тэлэх, иргэдийн бодит орлого болон худалдан авах чадварыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагын хүрээнд татварын хөнгөлөлтийг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдэд хамаарах татварын хялбаршуулсан горимд олон улсын жишигт нийцсэн босго тогтоох, хувь хүн тодорхой хугацаанд өмчилсөн өөрийн орон сууцаа худалдан борлуулсан тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын албан татвараас чөлөөлөх, түүнчлэн татварын тайланд тушаах болон төлөх хугацааг хойшлуулах зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн, урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжих зэрэг үр дагавартай гэж үзсэн байна.

Хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөвт үзүүлэх нөлөөллийг нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын дүнтэй харьцуулсан тооцоолол хийсэн эсэх, мөн иргэдийн сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод ноогдуулах албан татварыг 100 хувь хөнгөлөхөд улсын төсвийн орлогын бууралтыг тооцсон эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх буюу 68,8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүчийн хуулийн төслийн бүрэлдэхүүнтэй адил.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Хүн амын орлогын албан татвар бол энэ сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн бүрдүүлдэг гол татвар байгаа. Тэгээд энэ татвар нь бусад татвартай бас адилхан биш. Төсөв дээр ирэх нөлөөлөл нь 2 дахин үржигддэг. Өөрөөр хэлбэл тухайн орон нутгийн сум, дүүргийн энэ татварын орлого нь байхгүй болчихоор тэр хасагдсан дүнгээр төсвөөс бас тодорхой хэмжээний энэ дутагдсан дүнг нь нөхөж өгөх ийм зайлшгүй шаардлага үүсдэг учраас бас энийг нэлээн хариуцлагатай, сайн ярилцаж, дүн шийдлүүдийг нь ярих ёстой санагдаж байгаа. Өөрөөр хэлбэл бусад татваруудтай адилхан шууд нөлөөтэй биш, 2 дахин үржүүлдэг ийм нөлөөтэй байгаа юм.

Тэгэхээр Байнгын хороон дээр асуулт асуухад энэ хүн амын орлогын албан татвартай холбоотойгоор тэр 2 дахин нөлөөг нь тооцохоор 1,7 их наядын татварын ачаалал 9,5 сая хүртэлх татварын орлого дээр нь хүн амын орлогын албан татварыг 0 хувь хэрэглэснээрээ ийм ачаалал ирэх юм байна гэдэг тооцооллуудыг хэлж байсан.

Нөгөө талаас бас яг үүнтэй адилхан хуулийн төсөл Баярмаа нарын гишүүдээс бас хүн амын орлогын албан татварыг 9,5 гэж энэ босго тавихгүйгээр бүгдийг нь 1 хувь болгоё гэдэг ийм санал тавьсан. Тэгэхээр үүний нөлөө 5,4 их наядын төсөв дээр ирэх нөлөөтэй байна гэж ийм дүнгүүдийг танилцуулж байсан. Тэгэхээр энэ дүнгүүдийг бас чуулганы нэгдсэн хуралдаан дээр яг энэ 2 хуулийн төсөл дээрх төслийн нөлөөнүүдийг бас илүү яг тодотгоод зөв тайлбарлаад өгөөч 1 дүгээрт.

2 дугаарт НӨАТ-ын буцаан олголтын хуулийн заалтыг хүчингүй болгож байгаа. Тэгээд энийг нөгөө талд нь тэнцүүлээд хүн амын орлогын албан татварыг бас бууруулж байгаа. Тэгэхээр үүний бас харьцуулсан НӨАТ-ын иргэд дээр ирж байгаа татварын ачааллыг ямар хэмжээгээр бууруулж байсныгаа болиод Хүн амын орлогын албан татвар дээрээ ямар хэмжээний хөнгөлөлт, чөлөөлөлт авчирч байгаа гэдэг талаараа бас мэдээлэл өгөөч гэж хүсье.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Монгол Улсын хувьд хүн амын орлогын албан татвар гэдэг бол ерөөсөө 2025 оны байдлаар төсвийн орлогын 9 хувийг бүрдүүлж байгаа юм. ХХОАТ бол ерөнхийдөө онцлог нь орон нутгийн төсвийг бүрдүүлдэг. Манай орон нутгийн төсвийн бол орлогын 40 гаруй хувийг бүрдүүлж байгаа. Сум, дүүргийн төсвийн гол эх үүсвэр болдог. Тэгэхээр эдийн засгийн аль ч мөчлөгийн үед бол тогтвортой орлогыг бүрдүүлдэг ийм татвар байгаа. Татварын хэмжээг огцом бууруулснаар Баярмаа гишүүний санаачилсан хууль бол 1 хувь байгаа. Тэгээд энэ хууль дээр чинь аваад үзэхэд бол яах вэ 2,7 их наядын төсвийн орлого дээр нөлөө үзүүлэхээр

байгаа. Дам нөлөөгөөрөө орон нутгийн татварын орлогыг бүрдүүлдэг онцлогтой учраас бид нар энэ хэмжээгээр нь татаасыг нэмж өгөх болно. Ингээд харах юм бол 5,4 их наядын төсөв дээр ачаалал ирэх ийм онцлогтой байгаа.

Зүгээр энэ Засгийн газрын өргөн барьсан хуулиар бол 792 мянган төгрөг гэдэг бол нийтдээ жилдээ бол 840, дам нөлөөгөөр бол 1,7 орчим их наядын ийм нөлөөлөл үзүүлнэ гэсэн ийм. Гэхдээ гол нь иргэдийн маань гар дээр бодит буцаалт болж очно.

Баярмаа гишүүний тэр өргөн барьсан одоо хэлэлцэхээр бэлтгэж байгаа хуулийн төсөл дээр бол бизнесийн орлого, иргэний түрээсийн орлого, хүүгийн орлого, ноогдол ашгийн орлого, үл хөдлөх хөрөнгийн хувьцаа, үнэт цаас борлуулсны гээд бүх орлогуудыг 1 байхаар үзчихсэн байгаа. Тэгэхээр үүний чинь нөлөө бол бүр төсөв дээр ирэх ачаалал бол тэр хэмжээгээр бид нар авч явж даахгүй болно л гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Энэ хуулийн төсөл үнэхээр тийм бага, дунд орлоготой иргэдийгээ дэмжих төсөл бүрэн болж чадаж байгаа гэж бодож байгаа юу. Одоо бид нар чинь энэ тоон дээрээ хэд гэж байлаа. 2021 онд 43,200, 2024 онд 18300 гэсэн ийм төлбөрийн баримт олгоогүй гэх гомдол байна гээд оруулчихсан байсан. Тэгээд 9 сая 504 мянган төгрөг хүртэлх орлогыг, 9 сая 504 мянга хүртэлх энэ чинь орлого гэхээр чинь мэдээж аж ахуйн нэгж шиг ашиг биш шүү дээ. Тэгэхээр үүнийхээ 100 хувийн хөнгөлөлт гэхээр чинь хэдэн төгрөг болох юм.

Манай иргэдийн тайлангийн асуудал дээр нөгөө хялбаршуулсан горимд хамрагдах тэр 1 тэрбум хүртэлх гэхчихсэн байсан байх. Пос, и-баримт, банкны гүйлгээтэйгээ уялдуулж шалгах тодорхой механизм нь хуульд эсвэл нөгөө дагалдах журамдаа суух ёстой шүү дээ миний ойлгож байгаагаар. Тэгэхгүй бол энэ чинь нөгөө татвараа суутгуулдаг иргэн, тэгээд нөгөө бизнес эрхлэгчдэдээ борлуулалтын орлого, татварын шударга бус ялгаа нэмэгдэх асуудлууд дээрээ яаж хянаж байгаа юм. Тэгээд энэ татварын тайлангийн хугацааг сунгахтайгаа зэрэгцүүлээд тайлан өгөөгүй иргэнийг шийтгэх гэхээсээ илүүгээр урьдчилан сануулдаг, цахимаар тусалдаг, тэгээд тэр 1 товчны баталгаажуулах системийн хууль хэрэгжихээсээ өмнө бэлэн болгох шаардлагатай болов уу гэж бодож байна. Тийм боломж нөхцөл нь тооцогдсон юм болов уу, үгүй юм болов уу. Татварын шинэчлэл гэдэг бол бид нарын нөгөө ойлгоод байгаа зүйлээр зүгээр ингээд Улсын Их Хурлын гишүүд сүүлийн 2 жил байнга л ярьж байгаа. Татварын шинэчилсэн бодлогоо Татварын багц хуулиа оруулж ирээч ээ. Иргэн, аж ахуйн нэгжийгээ энэ татварын асуудал дээр тулдаг хана хэрмийг нь авч хаяя. Тэгээд энэ хүрээндээ Хүн амын орлогын албан татварыг бууруулах тухай асуудлууд Их Хурлын гишүүд санаачлаад, гарын үсэг зурчихсан, өргөн бариад ингээд явж байдаг.

Дээрээс нь нэмээд нөгөө үл хөдлөх хөрөнгө борлуулсны буюу орон сууц борлуулсны 2 хувийн татварыг авахгүй байх тухай 100 мянган иргэн D-Parliament дээр цахимаар гарын үсгээ зураад, тэрийг хэлэлцэхээр Улсын Их Хурал ажлын хэсэг байгуулчихсан. Ингээд татвартай холбоотой нэлээн олон санаачилгууд гараад ирэхээр сүүлдээ энэ татварын ийм түрүүн дахиад л би нөгөө машиныхаа дугуйг хий нь жаахан суларлаа, хийлчихлээ. 1 гоёл чимэглэлийн машиныхаа нэр усыг тодотгосон нэг эмблем нь уначихлаа, тэрийг нь засаад сайжруулчихлаа гэдэг

шигээ яваад байна. Суурь татварын бааз суурь, иргэдийгээ дэмжсэн бодлого, татвар төлдөг орчин гэдэг чинь ашиг олдог орчин гэсэн үг шүү дээ. Тэр ашиг олдог бизнесийн орчноос Засгийн газар гараа татах хэрэгтэй, оролцдоггүй байх хэрэгтэй. Иргэдэд боломжийг нь олгодог байх хэрэгтэй. Тэр тухай ярихаар зөрүүлээд нийгмийн хариуцлагын хүрээ яриад байгаа юм. Тодорхой нөгөө ашиггүй ажилладаг энэ зүйлүүдийг яриад байгаа юм. Угаасаа цагдаа, эрүүл мэнд, тодорхой салбарууд дээр энэ нийгмийн хариуцлага үүрэх нь Засгийн газрын үүрэг байдаг шүү дээ. Ашиг олж байгаа эсэхээсээ татвараа олоод, ашиг олж чадахгүй салбараа санхүүжүүлж, тэр нийгэм, улс орныхоо асуудлыг, иргэдийнхээ эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг хангаж явах нь Засгийн газрын үүрэг шүү дээ. Төрийн үүрэг. Тэгэхээр ийм байдлаар хариулаад ингээд.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Та 3 асуулт асуухдаа гурвууланд нь эвдэрсэн машин ярилаа л даа. Би тэгээд машинаар чинь л буцаагаад хариулъя. Эвдэрдэггүй машин гэж байхгүй л дээ. Та өөрөө машинаа эвдрэхээр хаячихдаг юм шиг байна. Эвдэрсэн машинаа бид нар засаад явах ёстой. Энэ бол бага орлоготой иргэдэд үзүүлж байгаа дэмжлэг биш. Энэ хүн амын орлогын албан татварын бодлого бол хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ дэмжиж байгаа дэмжлэг юм. Ажлын байрыг хадгалах. Өнөөдөр Монгол Улсад хөдөлмөрийн насны ажиллах хүч гээд үзэх юм бол 1,4 сая иргэн байна. Үүний чинь 71 хувь нь буюу 1 сая орчим нь хөдөлмөр эрхэлж байна. Цалин хөлс авч байна. Энэ иргэдийнхээ орлогыг эдийн засгийн хүндрэлтэй үед орлогыг нь хамгаалах зорилгоор 792 мянган төгрөг хүртэлх цалингийн орлогынх нь татварыг 100 хувь чөлөөлж өгье. Түүнээс дээш гарсан татвараа төл гэж байгаа юм. Энэ нь жилдээ хөдөлмөр эрхэлж байгаа 1 хүнд 950 мянган төгрөгийн орлого хэмнэгдэж, өөрийнх нь гар дээр үлдэх нь. Улсын төсөв дээр нийтдээ бид нар 840 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг энэ татварыг үзүүлснээрээ хөдөлмөр эрхэлж байгаа иргэдэд үзүүлэх гээд байгаа юм. Түүнээс биш бага орлоготой иргэдийг хүн амын орлогын албан татвараас чөлөөлөх гээд байгаа асуудал огт биш. Энэ эдийн засгийн хүндрэлтэй үед машин эвдэрч болзошгүй байна. Тэр эвдэрч болзошгүй хэсэг дээр нь бид нар засвар үйлчилгээ хийж байна гэж ойлгох хэрэгтэй. Түүнээс биш машинаа хаяад явъя. Шинэ машин явъя гэж бол болохгүй байх.

Б.Пүрэвдорж: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Арвис” сургуулийн Оюун-Эрдэнэ багштай 12^а ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Батын Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: Манай Засгийн газрын гишүүн, Сангийн сайд 3 ахиж давтуулж хэлж байж эвдэрхий машинтай байгаа гэдгээ хүлээн зөвшөөрлөө. Зөв. Дугуйгаа хийлээд явна. Ойр зуур юмаа засаад явна. Тэгээд зам туулна гэж байдаг болохоос төгс машин бүтээнэ гэж байдаггүй юм. Наад машиныхаа эвдрэлийн оношийг та нар буруу тодорхойлоод байна. Буруу юмыг нь засаад байна. Паалан засвар, косметик хагалгаа хийгээд байна. Гол тэр суурь болсон татварын бааз сууриа нэмэгдүүлэх, иргэд ашиг олоод татварын бааз сууриа нэмэгдүүлж улс оронд татвар төлдөг тэр орчныг нь булааж авчхаад тэгэнгүүтээ одоо өөр зүйл яриад байдаг.

Би тэгээд түрүүн хэлсэн шүү дээ. 2 дахь хууль дээр оруулж ирж байгаа өөрчлөлтүүдийг би огтоос эсэргүүцээгүй шүү. Дэмжиж байгаа. Гэхдээ .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариульъя.

3.Мэндсайхан: Батбаатар та бол бас Засгийн газрын гишүүн хүн байсан. Тэр машин тэрэг оношлоход оролцож байсан. Зармыг унаж ч явсан байх. Тэгэхээр юу яана. Энэ хэлэлцэж байгаа асуудлаа ойлго оо. Энэ ХХОАТ яриад байгаа юм. ХХОАТ-аар хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ хэрхэн дэмжих вэ гэдэг асуудлыг ярьж байна. Та татварыг нь авах гээд байна гэж яриад байх юм. Энэ чинь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж бүгд татвар төлөх үүрэгтэй. Харин тэр татварын авах хувь хэмжээгээ бид нар зөв зохистой байлгах, энэ төсвийн баялгийн хуваарилалтыг нь зөв хийх тал дээр л бид нар энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Эдийн засаг чинь өөрөө хүндрэлтэй байна гэдэгтэй та санал нэг байгаа. Гадаад орчин чинь хүнд байна. Энэ үед аж ахуйн нэгж, иргэдийнхээ үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлд нь, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийнхээ орлогыг тогтвортой байх, хамгаалах чиглэлд нь энэ бодлого орж ирж байгаа гэж би танд 3 дахаа хариульъя.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн нэмж тодруульъя.

Б.Батбаатар: Яах вэ, тэгээд татварын шинэчлэл гэдэг чинь ганцхан хувь бууруулах биш л дээ. Нэг тийм улс төрийн гоё үг хэрэглэгдээд, тэр нь иргэд дээр очоод ачаалал болоод асуудал үүсгээд байдаг. Тэр механизмаараа яваад байж болдоггүй. Шударгаар татвараа төлж байгаа иргэнээ хамгаалж, орлогоо нууж нуугдаж чаддаг, орлогоо нууж чаддаг тэр хэсгийг нь өөгшүүлэхгүй байдаг ийм бодлого л байх ёстой шүү дээ. Шийдлийнхээ хувьд. Тиймээс энэ төсөлдөө хөнгөлөлт гэдэг сайхан үгнийхээ цаана хяналт, автоматжуулалт, иргэнийгээ хамгаалах тэр баталгаа дутаж байна гэж энэ төсөл дээрээс чинь харагдаад байгаа юм. Энэ хувилбар чинь ер нь бусад гишүүдийн өргөн барьж байгаа татварын өөрчлөлтийг Засгийн газар санаачилгыг гар дээрээсээ алдчихаасаа өмнө өөр тийш нь залаад явчихъя л гэдэг ийм л улс төрийн тоглоом яваад байна гэж энд харагдаад байгаа юм. Орж ирж байгаа зүйлийг огт буруутгаагүй гэж би хэлсэн .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл дарга байхгүй байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна.

Ө.Шижир: Жишээ нь манай одоо байгаа хэрэглэж байгаа татварын хууль татвартай холбоотой хуулиуд бол хүнийг 1 цаг ч хөдөлмөр эрхэлсэн, 1 удаагийн ажил хийсэн ч тэр, 1 хоног ажил хийсэн ч тэр, хоолны мөнгө өгсөн ч тэр, авсан ч тэр, унааны мөнгө өгсөн ч тэр түлшний мөнгө өгсөн ч, тэр нүүрсний мөнгө өгсөн ч тэр бүгдээс нь татвар авдаг, давхар НДШ авдаг ийм л тогтолцоо байгаад байгаа шүү дээ. Тэгээд бид нар ингээд бүгдээс нь яаж хувь авах вэ гэдэг л ийм бодлоготой гэсэн үг. Жишээ нь НДШ хувь хүнээс 11,5, аж ахуйн нэгжээс 10,5. Хүн амын орлогын татвар 10 хувь, НӨАТ 10, ААНОАТ 10 хувь, нийслэлийн худалдан авалтын татвар 2 хувь. 1 хувь байсныг нь ингээд нэмчихсэн. Тэгээд нэмэх нь инфляц гээд ингээд иргэдийн бодитой авч байгаа бодит орлого чинь өөрөө орлого болж очих нь багасаад байгаа учраас энэ юмнуудыг бид нар зайлшгүй хэлэлцэх хэрэгтэй юм байгаа юм.

1 дүгээрт машины татвар, торгууль, хураамж гээд. Ингээд төлж болох бүх юм хурааж болох бүх юм ингээд татвар болчихоод байгаа юм. Тэгээд жишээ нь энэ Татварын багц хуулиуд дээр энэ олон хуулиудыг харахаар 1 удаагийн шинжтэй ажил, 1 удаагийн шинжтэй хийж буй гүйцэтгэл, 1 өдөр ажил хийсэн оюутан гэдгээс ямар нэгэн байдлаар ингээд татвараас хөнгөлсөн, чөлөөлсөн юм байхгүй байгаад байгаа юм. Одоо энд сууж байгаа Сангийн яамныхан бодвол бүгдээрээ л гадаад, дотоод их, дээд сургууль төгссөн байлгүй дээ. Та нар оюутан байхдаа гадаадад хөдөлмөр эрхэлж байсан байлгүй дээ. Хичээлийн бус цагаар. Тэгж л амьдарч ахуйгаа авч явж байсан байх. Гэтэл өнөөдөр 1 оюутан Монгол Улсад хичээлийн бус цагаар ажил хийсний төлөө бүтэн татвар төлж байгаа. Жишээ нь бодвол Сангийн яамнаас Америкт сурч байсан оюутнууд байж л байгаа байлгүй. Монгол Улсад өнөөдөр цагийн хөдөлмөр эрхлэх тухай ойлголт байхгүй. Ийм эрх зүйн зохицуулалт байхгүй. Шууд зөвхөн хүн амын орлогын татварыг нь авахгүйгээр бүх татвар шимтгэлийг нь бүгдийг нь авчихдаг. Жишээ нь ийм юмнууд дээр манай Сангийн яам ямар бодлоготой байгаа юм бэ. 2028 онд Монгол Улсад 1,5 сая ажиллах хүч бий болно гээд биччихсэн байгаа юм энэ ном дээрээ. 1,5 сая ажиллах хүчийг бид нар одоогоос бэлдэх ёстой юм. Тэгэхийн тулд оюутан залуучуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нээж өгөх ёстой. Оюутны хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчныг бий болгож өгөх ёстой. Хичээлийн бус цагаараа ажил хийж байгаа оюутнуудаас зөвхөн хүн амын орлогын албан татварыг нь л авна. Тэр нийгмийн даатгал, шимтгэл, компаниас төлж байгаа энэ бол бүгдийг нь болих хэрэгтэй. Ариунзаяа гишүүн ээ, байхгүй. 2 юм байгаа. Хөдөлмөрийн тухай хууль дээр чинь 1 заалт байгаа. Тэр Засгийн газрын хөтөлбөр дээр 1 заалт байгаа. Өнөөдөр та нар гараад асуугаарай. Жи Эс юм уу, Си Юд ажил хийж байгаа оюутан НДШ давхар төлж байгаа. Давхар төлж байгаа. Компани хүртэл төлж байгаа. Тэгээд ганцхан өдөр ажил хийсэн оюутан өнөөдөр НДШ давхар төлж байгаа. Энэ нь аж ахуйн нэгждээ дахиад дарамт учруулж байгаа. Аж ахуйн нэгжүүд дээ дахиад дарамт учруулж байгаа. Тэгэхээр би хэлье. Би оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийг санаачилсан байгаа. Манай олон гишүүд дэмжиж байгаа. Үүн дээр Мэндсайхан сайд аа, та болохгүй, бүтэхгүй гэдэг санал битгий хэлээрэй. Яагаад гэвэл бид нар 1,5 сая ажиллах хүчийг одоогоос бэлдэх ёстой байхгүй юу даа. Оюутан байхдаа хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс ажлын байрандаа хамгийн үнэнч ажилтан болдог. Хамгийн сайн ажилтан болдог. Энэ орон зайг өнөөдөр бид нар хийж өгөөгүй. Тэгэхээр 1 удаагийн шинжтэй үйл ажиллагаанаас, зуны амралтаар ажил хийсэн оюутнуудаас НДШ компанид нь ч тэр, хувь хүнд ч битгий тавь. Энэ чинь татварын дарамт ажил.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Нөгөө 1 удаагийн шинжтэй гүйцэтгэх ажлууд дээр татвар төлөөд байна гэж. Энэ дээр бол нөгөө татварын хэлэлцүүлгийн явцад ийм саналууд бол их ирсэн байна лээ. Аж ахуйн нэгж, иргэдээс. Гэхдээ бид нар энэ Татварын багц хуулийн өөрчлөлтөөрөө оруулж ирье. Сууриар нь. Түүнээс биш одоо юу гэдэг юм оюутны хөдөлмөр эрхлэлт ч гэдэг юм уу энэ нас, хүйс, мэргэжлээс хамаарсан тийм ялгаатай татвар бол байж болохгүй л дээ. Зүгээр Хөдөлмөрийн тухай хуулийн 66 тэр бүхэлдээ цагийн ажлын, бүтэн биш ажлын эрх зүйн орчныг тодорхойлчихсон байдаг юм байна. Тэгэхээр та тэрийг бас хараарай. Би ч бас харъя. Хоёулаа энэ дээр тэгээд цаашдаа яг ямар өөрчлөлт хийх тал дээр бол хамтраад явахад бол асуудал байхгүй. Гол нь энэ удаагийн өргөн барьсан хууль бол би түрүүн асуултад хариулахад хэлж байсан. Богино хугацаанд бизнес, эдийн засаг болон хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ

дэмжихэд ямар бодитой дэмжлэг нь байж болох вэ гэдгийг Татварын нэмэлт хуулиар өргөн барьж байгаа юм.

Хэлэлцүүлгийн явцад гарсан маш олон саналууд байгаа. Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой маш олон хэрэгтэй заалтууд байгаа. Эдгээр бүгдийг бид нар нэгтгээд Татварын багц хуулиараа Засгийн газар өргөн барина.

Б.Пүрэвдорж: Шижир гишүүн нэмж тодруулъя.

Ө.Шижир: Яагаад ингээд байна вэ гэхээр манайх чинь өөрөө угаасаа хэрэглээний эдийн засагтай, улирлын чанартай бизнестэй. Аялал жуулчлал гээд ярих юм бол зуны 3 сар. Тэгээд зуны гуравхан сар хөдөлмөр эрхэлж байгаа оюутнуудаас үүний 2 сард нь ажилласан оюутнуудаас НДШ авна гэхээр ажиллах хүчиндээ ч хэцүү, ажиллуулж байгаа компанидаа ч хэцүү. Тэгээд энэ чинь нийтдээ бол жилд 58 орчим тэрбум төгрөгийн л асуудал яригдах юм байна лээ шүү дээ. Тэгтэл бид нар чинь 58 тэрбум төгрөгөөр 1 жил хотынхоо бордюрыг сольж байгаа шүү дээ. Ирээдүйд ажиллах хүчнээ бэлдэх бодлогоо бид нар хотын 1 жилийн бордюрын мөнгөөр хийчхэж болохоор байна шүү дээ. Өнөөдөр жишээ нь байнгын ажлын байр бус хүнийг ажиллуулахад хүртэл бид нар НДШ төлж байгаа. Тэр хүнд хоолны мөнгө өгвөл тэндээсээ төлж байгаа. Унааны мөнгийг өгвөл бас төлж байгаа. Тэгэхээр ийм татварын дээрэнгүй бодлогыг бид нар болих хэрэгтэй. 1 татвар төлөгчийг яаж олон болгох вэ гэдэг бодлого баримаар байна Сангийн сайд аа. Би танд итгэж байна. Үнэхээр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Энэ татвар бол өөрөө орлогыг дахин хуваарилах л гол зорилготой байдаг. Төр бол өөрөө эдийн засагт оролцох бас гол хэлбэр нь бол татвар. Тэгэхээр би ХХОАТ дээр ярихад зарим прогрессив татварыг нь бол би дэмжиж байгаа. Ам бүлээсээ хамаарсан, орлогоос нь хамааруулсан татварын хөнгөлөлт бол дэлхий нийтийн нийтлэг жишиг. Тийм учраас энэ тал дээр бол Сангийн сайдаас асуухад энэ ам бүлийнх нь орлого, тоотой хамааруулаад амьжиргааны баталгаажих доод түвшин нь 538 мянган төгрөг байгаа. 5 ам бүлтэй айл бол 2 сая 690 мянган төгрөгийн цэвэр орлоготой байж байж ядаж тэр айл хоол, хүнс тэжээлийн наад захын хэрэгцээгээ хангана гэдэг шинжлэх ухаанаар эдийн засгийн дүнгээр илэрхийлбэл. Үүнтэй нь уялдуулаад хүн амынхаа орлогын албан татварын хөнгөлөлтийг үзүүлэх талаар бодож үзэв үү. Бас ийм санал олон хүмүүсээс ирдэг юм. Тухайлбал 5 ам бүлтэй айлын 700000-ын хөнгөлөлт 1 өөр, ганц бие амьдарч байгаа хүмүүсийн 700000-ын хөнгөлөлт бол 1 өөр гэж. Тэгээд яах вэ, би таны тэр хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг дэмжье гээд байгаа нь их зөв юм байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд яг хөдөлмөр хийж байгаа, яг татварт баригдчихсан, тогтмол байж байгаа хүмүүсээ л бид нар чинь 1 ч төгрөгийн зөрөөгүйгээр дарамтлаад, шахаад ингээд авдаг. Гэтэл үүний хажуугаар төлдөггүй, татвараас зугтаж чаддаг, том жижиггүй энэ хүмүүс рүүгээ ерөөсөө 1 далайцтай орж бол чадахгүй байгаад байна уу даа гэж би харж байгаа юм. Тийм утгаар бол энэ хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт гэдэг бол нийгмийнхээ эмзэг нөгөө талаар хөдөлмөр эрхлэлтээ дэмжих гээд янз янзын зорилготой байдаг учраас энийгээ нэг концепцтой оруулж ирээд шийдвэл бас зөв.

792 мянган төгрөг цаашдаа ер нь яг энэ мөнгөн дүнгээрээ байх уу. Эсвэл цаашдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дагаад өсөөд ингээд хөнгөлөгдөөд явах юм уу гэдэг дээр тодруулж асуумаар байна.

2019 оны татварын хууль дээр бас санал өгч байхад мөнгөн дүнгээр нь орхиод ингээд үндсэндээ 7 жилийн дараа л өөрчлөх гэж байна л даа. Тэгэхээр энийг хөвөгч буюу бүр ярих юм бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй гэхээсээ илүүтэйгээр амьжиргааны баталгаажих доод түвшний 1,5 хувьтай тэнцэх хэмжээний ч гэдэг юм уу ингэж жоохон индексжүүлэх байдлаар хөнгөлөлтөө тавихгүй бол 1 удаа хөнгөлөлтөөр царцчихдаг асуудал байдаг юм.

2 дугаарт бол шууд 1 хувь болгоё. Ер нь татвар төлөхгүй байя гээд энэ одоохондоо бол арай биш л гэж би хэлмээр байна. Яг бодит байдлыг дүгнэхэд. Дэлхий дээр хүн амын орлогын албан татвар 0 байдаг, 1 байдаг орон гэхээр Арабын хэдэн орон л байна лээ. Бид нар магадгүй уул уурхайнхаа тэр лицензийнхээ авдаг татварыг аваад, ноогдол ашгаа аваад ингээд чадах юм бол заавал хүн амын орлогын албан татвараас нэг их олигтой орлого орж ирэхгүй бол тэрийг тэглэчхэж болох цаг үе ирэх байх. Гэхдээ өнөөдөр бол би биш болов уу гэж би бодож байгаа. Цалингаа юугаар тавих вэ, тэтгэврээ юугаар тавих вэ гээд олон асуудал нөгөө талд нь гарч ирнэ. Саяхан бид нар чинь 2,5 их наядын хөрөнгө оруулалтыг Их Хурлын гишүүд уралдаад л тавилаа. 1 гараараа тэгээд нөгөө талаараа огт татвар төлөхгүй бай гээд байхаар логикийн хувьд бол таарахгүй болчихоод байгаа. Ер нь татварын дарамтыг буулгах гэдгийг бол бид нар концепцтой, ирэх 5, 6, 10 жилийн дотор яаж хөнгөлөх вэ гэдэг юмаа бодлогоо гаргах нь чухал юм болов уу гэж бодож байна.

Сургалтын гээд 1 зүйл байна. Би сургалтын зээлийн хөнгөлөлтийг ингээд аваад үзсэн чинь зээл гэнэ, төлбөрийн хөнгөлөлтийг 1 жилийн сургалтын төлбөрийг л хөнгөлчхөж байгаа юм байна лээ. Дийлэнх хүмүүс хөөрхий хүүхдээ англи хэлний сургалтын төлбөрт өгөх гээд IELTS сургалт өгөх гээд 2 сая төгрөг төлж байна. Тэрний хөнгөлөлтийг авч байгаа. Гэтэл зарим нь 100 сая төгрөгийн татварын хөнгөлөлтийг авчихдаг. Асар өөр ялгаатай байгаа байхгүй юу. Татварын хөнгөлөлт эдлэх дээрээ. Өөрөөр хэлбэл нөгөө өндөр орлоготой, чадамжтай, боломжтой гэдгээсээ хамаараад татварын эрс тэрс ялгаатай хөнгөлөлтийг эдэлж байгаа учраас энийг дундаж хэмжээгээр, магадгүй 20 сая, 50 саяар жишээлбэл татварын .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг амьжиргааны баталгаажих доод түвшинтэй харьцуулж үзсэн үү гээд. Бид нар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг бол 3 талт хэлэлцээр буюу мэргэжлийн холбоотой хамтарч тогтоож байгаа. Энэ талаар бол та бас сайн мэдэж байгаа. Тэгэхээр амьжиргааны баталгаажих доод түвшнийг бол Үндэсний статистикийн хорооноос буюу төрийн байгууллагаас 100 хувь тодорхойлж байгаа юм. Тэгэхээр бид нар бол энэ 3 талт хэлэлцээрийн хүрээнд тогтсон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ барих нь зөв гэж үзсэн.

792 мянга бол цаашдаа ингээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ хөдлөх хэмжээгээр хөдлөөд явна гэсэн ойлголт биш. Яг энүүгээрээ суугаад явна. Энэ хэмжээгээрээ л хөнгөлөлтөө аваад явна гэсэн үг.

Зүгээр ам бүлийн тоотоо хамруулаад хөнгөлөлт үзүүлэх талаар тооцсон уу гэж байна. Ер нь бусад оронд байдаг шиг орлогыг 1 дор цуглуулаад, жишээ нь орлогын газартаа гааль, татвар, нийгмийн даатгалыг 1 дор цуглуулдаг гарах халамж, тэтгэмж, эрүүл мэнд, хүүхдийн мөнгө гэх бодлого нь 1 дор ингээд удирдах бол хүүхдийн тооноос хамаарсан дэмжлэг байж болно гэж үзэж байна. Нэмээд Чимидсүрэн дарга хариулчих.

Б.Пүрэвдорж: Чимидсүрэн дарга нэмж хариулъя. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Бид нар ХХОАТ дээр 792 байх уу 500 байх уу гээд. Засагт бол анх орж байхдаа 500 мянга байсан. 500 мянгыг бас үндэслэлээ бид нар Статистикийн ерөнхий газраас гаргадаг хүн амын амьжиргааны доод түвшин гээд. Тэр бол бид нарыг тооцоолол хийж байх үед 490 хэдэн мянга буюу 500 орчим мянга байсан. Тэгээд үүгээр тооцож оруулж болох юм гээд. Тэгээд засаг дээр нэмэгдээд, дор хаяж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүнг ингээд 100 хувь хөнгөлчих нь зүйтэй. ХХОАТ-аас гэдэг ийм шийдвэр гараад явсан. Гэхдээ энэ 792 мянгыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уяагүй. Энэ тогтсон тогтмол тоо байгаа.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр яах вэ, энийг ер нь цаашдаа хөнгөлөлт байдаг юм уу, индексжүүлээд ер нь бол явбал уг нь зүгээр байгаа юм. Тэгэхээр яах вэ, хэлэлцүүлгийн шатанд энэ тал дээр бол ярилцаж болох болов уу гэж бодож байна.

Орон сууцын хөнгөлөлтийн асуудал дээр ингээд ярихаар бид нар бас зарим нэгэн юмыг шийдэхдээ жоохон савлаж шийдээд байдаг. 2 хувийн татварын хөнгөлөлт бол яах вэ ер нь бол зөв. Тэрийг хөнгөлөх нь. Гэхдээ иргэдийн ихэнх нь юу хүсэж байна вэ гэхээр анх удаагаа татварын хөнгөлөлт эдэлж байгаа хашаа байшин авч байхдаа 1 сая 500 байхад нь хөнгөлөлт эдэлчихсэн, дараа нь эсвэл ганц өрөө байр авч байгаа хүмүүс хүүхэд гаргаад 5, 6 ам бүл болоод 2 өрөө байр болгоё гэж байхад нь дахиад жоохон хөнгөлөлтийн дэмжлэг болгох ийм боломж нь уг нь бол иргэдэд илүү хүртээмжтэй байгаад байгаа юм. Түүнээс биш нийт иргэдийн дийлэнх нь байсхийгээд л байраа зараад л байдаг тийм хүмүүс бараг байхгүй л дээ. Яг статистикийн юугаар авч үзвэл. Тэгэхээр бид нар яавал илүү иргэдийг орон сууцжуулахад нь дэм болж чадах вэ. Яавал эргүүлээд энэ татварын хөнгөлөлтийн бодлогоор тэр байр орон сууц сургалтын төлбөр гэх мэтчилэн дэмжлэг болох вэ гэдэг дээр л анхаарвал зүгээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн Норжмаа багштай 12^р ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Багшид сурган хүмүүжүүлэх ажилд нь өндөр амжилтыг хүсье.

Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Ер нь бол сая Эрдэнэбат гишүүний асуулттай ерөнхийдөө нэлээн төсөөтэй асуулт асуух гээд байна. Юу гэхээр Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн 23.1 дээр бол индексжүүлсэн ерөнхийдөө шатлалтай

хөнгөлөлт байсан. Тэгээд энийг шатлалгүй болгоод, ерөнхийдөө бүгд сарын 79200 төгрөгийн хөнгөлөлттэй байхаар хуулийн өөрчлөлт оруулж ирж байна. Тэгэхээр энэ дээр би юу асуух гээд байна вэ гэхээр энэ дээр зардал нь жишээлбэл 840 тэрбум төгрөгийн төсөвт нөлөөлөх нөлөөлөл үүсэж байгаа гэж байгаа юм. Жилд. Тэгэхээр заавал мэдээж бүх хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийгээ дэмжиж байна гэж байгаа зорилгыг нь бол ойлгож байна. Гэхдээ тэр тохиолдолд бид нар түрүүн Шижир гишүүний хөндөж ярьсанчлан бид нар илүүтэй НДШ-ийнхээ тогтолцоогоор уг нь дэмжвэл илүү дэмтэй байгаад байгаа юм. Нөгөө талаасаа Хувь хүний орлогын албан татварын тухай хөнгөлөлтийг ярихад бол хавтгайдаа гэхээсээ илүүтэйгээр яг одоо хэцүү байгаа буюу бага орлоготой мөн түүнчлэн яг энэ бага орлоготой, цалин багатай байгаа нөхцөлд бас залуучууд ихэнх нь байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл дөнгөж ажил эрхэлж эхэлж байгаа залуучуудын хувьд хамгийн их өндөр ачаалалтай байдаг буюу нөгөө ипотекийн зээлтэй байдаг, нөгөө бага насны хүүхэдтэй байдаг. Тэгээд нөгөө бүх цалин нь бол юу гэдэг юм 2 сая 500 хүртэл ч юм уу, 1 сая 500 хүртэл эхэлж байдаг. Тэгэхээр энэ хэсгээ илүү дэмжээд явбал нөгөө нөлөөлөл буюу эффект нь илүү сайн байх юм болов уу гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр 1 тооцооллыг бас та бүхэн маань хийгээд өгөөч. Тэгээд хэлэлцүүлгийн явцад бас энэ дээр зарчмын зөрүүтэй санал гаргаад явъя гэдэг бодолтой байгаа. Жишээлбэл, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар 0-6 сая төгрөгийн орлого дээр 240 мянга, жилийн 240000-ын хөнгөлөлт өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг би ямар эффектийг хүсээд байна вэ гэвэл бид нар мэдээж юу гэдэг юм 2 сая 500 төгрөг хүртэлх цалинтай хүмүүсийн орлого дээр орлогын татвар нь 5 хувь байхаар тэр нөлөөллийг энэ хөнгөлөлтөөрөө бий болгочих юм бол уг нь яг хэрэгтэй байгаа хүмүүст нь нэлээн дэмтэй юм болох гээд байгаа л гэж харагдаад байгаа юм. Тэгэхээр Татварын ерөнхий газраас хүсэх гээд байгаа хүсэлт маань яг энэ хөнгөлөлтийг бүх хүмүүсийн хувьд биш. 2 сая 500 төгрөг хүртэлх цалинтай хүмүүсийн хувьд татварын төлөлт нь 5 хувьтай тэнцүү байхаар хөнгөлөлтийг үзүүлье гэвэл төсөвт ямар нөлөөлөл үзүүлэх вэ буюу энэ 840 тэрбум төгрөгөөр чинь тэр хөнгөлөлтийг зөвхөн бага орлоготой буюу 2 сая, 1 сая 500, эсвэл 2 сая 500, чадвал 2 сая 500 хүртэлх цалинтай хүмүүс дээр тэр нийт төлж байгаа татварын хэмжээ чинь 10 биш 5 байх боломжтойгоор тооцооллыг хийгээд үзээч гэдэг ийм хүсэлт байгаа юм. Тэгэхээр энэ тооцоолол дээр үндэслэж байгаад бид нар хэлэлцүүлгийн явцад энийг өөрчлөх боломж гарах нь уу гэж харж байгаа. Тэгэхээр яг бол би асуумаар байгаа боловч энэ дүн бас бэлэн биш байгаа байх гэж бодож байна л даа. Тэгэхээр цаашдаа яг энэ харьцуулалтуудыг бид нар хийж үзэж байгаад нэгэнт бид нар татвар бол өөрөө шатлалтай явдаг. Тэгэхээр хөнгөлөлтийг шатлалтай явуулах буюу яг энэ бага, дунд орлоготой иргэдээ дэмжихэд бодлогоо чиглүүлэхэд бол бас татварын бодлогын хувьд бол их зөрүүтэй юм болохгүй болов уу гэж харж байгаа юм. Тэгээд энэ дээр бас хөндөж яримаар байгаа нь 23.4 дүгээр зүйл буюу орон сууцын нөгөө анхны орон сууц худалдан авсан дүн байдаг. Энэ дээр нэмэлт 1 минут авчихъя.

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тодруулъя.

Г.Уянгахишиг: Одоогийн 23 дугаар зүйлийн 4 дээр болохоор орон сууцын хөнгөлөлт байдаг. Анх удаа орон сууц худалдаж авч байгаа тохиолдолд 6 сая төгрөг хүртэлх хөнгөлөлт өгдөг. Энэ нь бол одоогийнхоор бол 60 сая төгрөгийн орон сууц худалдаж авсан ч юм уу эсвэл өөртөө орон сууц барьсан ч юм уу ийм хөнгөлөлт байгаад байгаа байхгүй юу. Тэр бол нэлээн олон жилийн өмнөх зүйл байгаа юм. Тэгэхээр би бол одоо 2 хувь буюу өөрийнхөө эзэмшиж байгаа, өмчилж байгаа,

анхны байр нь байгаа гэсэн үг шүү дээ. Тэр байраа худалдан борлуулсны 2 хувийн татварыг хөнгөлөх гэхээсээ илүүтэйгээр бид нар анх удаа орон сууц авч байгаа залуучуудаа илүү дэмжих талын бодлогоо нөгөө яндангийн тоогоо цөөлж гэж бодож байгаа бол энэ буцаан олголтыг жаахан нэмэх тал руугаа байсан нь тэр 2 хувийг хөнгөлөх гэхээсээ илүү эффект нөлөөлөл нь сайн юм болов уу гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ 2 дээр бас Сангийн сайд маань .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Тэр 5 хувь гэдэг тооцооллыг би танд дараа хийлгээд хүргүүлжэ. Ер нь зүгээр хүн амын орлогын албан татварын нөгөө цалин хөлс, түүнтэй адилтгах жилийн орлогод шаталсан тогтмол дүнгээр жилийн 0-240 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлүүлэх зохицуулалттай. Гэхдээ сард 12 сая, жилдээ 36 сая төгрөгийн орлоготой хувь хүн бол татварын хөнгөлөлт эдэлдэггүй. Тооцооллыг нь хийж хөнгөлөлтийг үзүүлдэг байгаа. Одоо бид нар хүн амын орлогын албан татвар дээр 10, 15, 20 гэсэн хувийн шаталсан татвартай байгаа. Өмнө нь 45 хүртэл татвартай байсан. Одоо 792 мянгаас дээш илүү гарснаа бол шаталсан татвараараа аваад явна. 10 хувь дээр бол иргэдийн тоо бол 1 сая 20 мянга орчим иргэн 10 хувийн татварт хамрагдаад явж байгаа. 15 хувьд 6 мянга орчим иргэн буюу 0,6 хувь байгаа. Хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн маань. 20 хувь дээр бол 5,2 мянган иргэн буюу 0,5 хувь нь энэ шаталсан татвартаа хамрагдаад явж байгаа. 2025 онд цалингийн орлогоороо нийслэл дээр гэхэд 687,6 мянган иргэн, орон нутагт 344 мянган иргэн одоогийн хуулиар 92,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг эдэлсэн байна. Хууль дээр нөгөө иргэдийн өмчилсөн хаяг дээрээ 5 жил амьдарсан бол үл хөдлөх хөрөнгөө борлуулахад нь 2 хувийн татвараас чөлөөлж өгөх заалт орж ирж байгаа юм. Нэмэлт зүйлийг нь Цогтнараран дарга хариулах уу.

Б.Пүрэвдорж: Цогтбаатар дарга. Индрийн 4 дүгээр микрофон. Цогтбаатар дарга аа, нөгөө НӨАТ-ын тухай хуулиар мэдээлэл ирүүлэхээр ярьсан. Тэрийгээ өгөөрэй. Уучлаарай Цогтнараран. Уучлаарай.

Б.Цогтнараран: Иргэдийн анх удаа худалдаж авсан орон сууцын үнийн 60 сая төгрөг буюу 6 сая төгрөгийн хөнгөлөлт эдлүүлээд явж байгаа. Өнгөрсөн 2025 онд орон сууцын хөнгөлөлтийг бол 35 мянган иргэнд 80,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг ХХОАТ-аас нь хөнгөлсөн гэдэг ийм дүн мэдээтэй байна. Цалингийн орлогоос хөнгөлөлт эдлүүлсэн дүнг бол сая Сангийн сайд танилцуулчихлаа. Цалингийн орлогоос 240 мянга хүртэлх төгрөгийн шатлалаар нь нийт 92,8 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг цалин болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос бол хөнгөлсөн гэдэг ийм дүн мэдээ байна.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Нэмж Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Саяын тоон дээр жишээлэх юм бол яг тэр анхны орон сууцаа худалдан авсны хөнгөлөлт 80 тэрбум гэж байна шүү дээ. Тэгэхээр тэрийг бид нар ядаж 6-г нь 2 дахин нэмэгдүүлчихдэг ч юм уу, 12 сая хүртэлх ч юм уу болгодоо гэхэд л тэр чинь 2 дахин нэмэгдэх ч гэдэг юм уу бүр ингээд хар тооцооллоор бодох юм бол. Тэгэхээр яг төсөвт нөлөөлөх нөлөөлөл нь өөрөө 2 хувийг нь хөнгөлөхөөсөө нөлөөлөл яаж бууж байгаа вэ гэдэг харьцуулсан судалгааг бас авъя. Тэгээд тэрийгээ харж байгаад ер нь бол дараагийн юу гэдэг юм, мэдээж орон сууцаа

сайжруулах гэдэг хэрэгтэй, бүгдэд нь л хэрэгтэй зүйл. Гэхдээ яг анхны орон сууцаа авах буюу бид нар орон сууцжуулалтыг дэмжье гэж байгаа бол нөгөө яндангийн тоогоо цөөлье гэж байгаа бол энэ анхны орон сууц авч байгаа тохиолдолд тэр хөнгөлөлт чинь арай өндөр байсан нь арай илүү дээр юм болов уу гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр түрүүний хэлснээрээ 2 харьцуулсан судалгаа авъя гэж байгаа. Нөгөө хөнгөлөлттэй холбоотой болон энэ орон .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ Татварын багц хуулийг Улсын Их Хурлын бас нэлээн олон тооны гишүүд бараг 10-аад гишүүд ажлын хэсэг байгуулаад, судалгаа хийгээд, боловсруулаад энэ чинь бараг 170, 180 мянган татвар төлөгч нартай санал аваад, тэгээд хэлэлцүүлсэн байдаг. 2 жил шахуу хэлэлцүүлсэн. Тэгээд эндээс бол яг 56 хувь нь бол хувь хэмжээг бууруулах тал дээр бол санал өгсөн байдаг. Энэ дотор бол НӨАТ-ын хууль, НӨАТ-ыг бууруулах, ХХОАТ-ыг бууруулах чиглэлээр өгсөн байдаг. Ер нь яах вэ, бүх татварын хууль дээр би үг авч чадаагүй болохоор яг энэ дээрээ багцлаад хэлэх гээд. Сая яах вэ Уянгахишиг гишүүний ярьдаг бол үнэн л дээ. Бид нар угаасаа ХХОАТ дээр анх удаагаа орон сууц авч байгаа хүнээ хөнгөлчихсөн байхгүй юу. Тэгэнгүүтээ дахиад 2 хувь гэхээр чинь нөгөө орон сууцын наймаа хийдэг хүмүүсээ дэмжсэн байдалтай тэр 2 хувь чинь явчих гээд байгаа юм. Тэгэхээрээ бид нар багц хуулиа харвал нөгөө том зургаараа юмаа харж байгаад явахгүй бол тэнд хэдэн хүн санал өглөө гэнгүүт тэрийгээ ингэж оруулаад яваад байж болохгүй байгаа юм. Тэгээд энэ дээрээ бас юмаа хармаар байгаа юм.

Тэгээд Татварын ерөнхий хууль дээр бол маргаан таслах зөвлөлийг хараат бус байлгах тал дээр бол энэ юунд бол ороогүй байна лээ. Энэ дээр бас анхаармаар байгаа юм. Энэ чинь бол бид нар шүүхээр том том байгууллагууд бол татвар бага төлдөг. Маргаанаар янз янзын байдлаар асуудлуудаа шийдүүлдэг асуудал бол гарсан шүү. 1 биш удаа.

НӨАТ дээр уг нь бол өмнө нь баталчихсан юмаа тэр чигээр нь явуулчихмаар байгаа юм. Тэгээд бид нарын нөгөө гаргасан саналуудаа, энэ татварын багц хууль руу орсон саналуудтайгаа хамтатгаад баталчихвал уг нь яг нөгөө сая Эрдэнэбат гишүүний яриад байгаа өрхийн орлогыг хамгаалах тал дээрээ бол маш зөв хувилбартай болчих гээд. Дээрээс нь НӨАТ гэдэг маань тэр 50 саяыг 400 сая болгочихоор чинь НӨАТ төлдөг аж ахуйн нэгжийн тоо л багасахаас биш эсвэл аж ахуйн нэгжүүдээ задлаад л байхаас биш өөрөөр бол тэнд ямар нэгэн үр дагавар гарахгүй байхгүй юу. Уг нь бол тэр чинь яг 50 саяар нь үлдээгээд, эцсийн хэрэглэгчид нь хөнгөлөлт өгчихөөр яг тэр дундын гар дээрээсээ наймаа хийдэг яадаг ийдэг бүх хүмүүсийн чинь зарж байгаа юманд нь НӨАТ тооцдог болъё гээд угаасаа тэр хуульд орчихсон байсан юмыг тэр чигээрээ л явчих байсан юм. Тэгсэн бол одоо тэр хүнсний үйлдвэрлэл, энэ гар дээрээс наймаа хийж байгаа хүмүүсээ бүгдийг нь НӨАТ-ын яг тэр бүртгэл гэдгээ агуулгаар нь бүртгэчих боломжтой байлаа. Тэгээд эргээд эцсийн хэрэглэгч дээр нь харин тэр шаталсан хувилбараараа бид нар хөнгөлөлтөө өгсөн бол яг л уг нь байгаа оночихоор байсан юм л даа. Тэгээд ингээд 1 баталсан юмаа эргэж буцаад цөмөөрөө яваад байна л даа. Тэгэхгүй бол яг бид нар НӨАТ-ын хуулийг судлаад явж байхад бол төрийн байгууллагууд өөрсдөө НӨАТ-ын баримтгүй худалдан авалт эд нар хийгээд яваад байсан байхгүй юу. Сургууль байдаг юм уу, цэцэрлэг байдаг юм уу, юу байдаг юм, нөгөө жижиг төсөвт үйлдвэрийн газрууд ч гэдэг юм уу. Тэгээд энэ чинь эргээд нөгөө татвар

төлөгчийнхөө бааз суурийг улам бэхжүүлэх биш, нөгөө саарал эдийн засаг гэдэг юмаа улам томсгоод байгаа харагдсан. Энэ дотор жишээлбэл малчдын яг гар дээрээс зардаг сүү, энэ ногоочдын гар дээрээс зардаг ногоо эд нар бүгдийг нь уг нь тэр худалдан авалтаас НӨАТ тооцож, өртгөө бууруулах ийм хасалт хийх ийм боломж уг нь яг энэ үйлдвэрүүддээ эсвэл дундын яг арилжаа хийдэг улсууддаа олгосон бол энэ яг жинхэнэ утгаараа НӨАТ-ын хууль чинь бүртгэлийн гэдэг шинж чанар агуулах байлаа л даа. Тэгээд энэ асуудлаа орхигдуулсан байна.

Хувь хүний орлогын албан татвар дээрээс тэр 792 мянган төгрөг байх. Тэр 792 мянган төгрөг хүртэлх цалингийн орлогыг чөлөөлөх агуулгыг бол дэмжиж байгаа. Энэ бол яалт ч үгүй хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд бол зайлшгүй зүйл байдаг. Тэгэхгүй бол бид нар энэ чинь яг бизнесийг дэмжиж байгаа гээд тухайлбал 2,5 тэрбумын орлоготой аж ахуйн нэгжийг 1 хувийн татвар, яг ингээд өдөр шөнөгүй ажиллаж байгаа иргэдээсээ бол ингээд .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минутаар тодруулъя.

Х.Ганхуяг: Тэгээд энэ чинь нөгөө аж ахуйн нэгжүүдээс хамаагүй бага татвар авдаг болчихдог. Эргээд иргэдээсээ харьцангуй өндөр татвар, дээрээс нь НДШ яг ирж байгаа ачаалал нь бол аягүй өндөр болчихоод байгаа юм л даа. Тэгэхээр уг нь агуулгаараа бид нар яг тэр НӨАТ-ын буцаалтаа тэр чигээр нь явуулаад, энэ 50-ыг 400 сая болгосноо болиод, тэгээд энэ бусад зохицуулалтуудаа энэ чигээр нь явуулчихсан бол уг нь татварын систем чинь уг нь бол зөв болчихмоор юм шиг харагдаад байх юм. Тэгээд энэ дээр манай Сангийн яамны Татварын бодлогын газрын даргаас тодруулга авчихмаар байна. Энэ чинь уг нь бол хамтдаа 2 жил хэлэлцүүлсэн хууль байхгүй юу. Тэгээд одоо өөр л юм оруулж ирээд байна л даа.

Б.Пүрэвдорж: Хэн хариулах вэ. Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Ганхуяг гишүүн өмнөх онд бас энэ хэлэлцүүлгүүдийг удирдаж байсан учраас энэ саналуудыг нэлээн сайн дэлгэрэнгүй мэдэж байгаа. Тэгээд өмнөх саналууд дээр гарсан төсөл дээр бол нийт саналуудын 52 хувийг нь хуулийн төсөлд тусгаж байсан. Тэгээд энэ өөрчлөлтүүд дээр хийсэн судалгааны асуудлуудыг бол бид нар ингээд орхихгүй. Дараагийнхаа хуулийн шинэчлэлдээ суурь болгоод энэ судалгааны ажлуудаа явуулах юм. Тэгэхээр яг одоогийн энэ эдийн засгийн нөхцөл байдалд цөөхөн тооны заалтаар энэ нэмэлт өөрчлөлтүүдийгээ оруулаад явж байгаа. Тэгэхээр цаашид багц хууль шинэчилсэн хуулийн хүрээнд түрүүний таны хэлсэн НӨАТ-ыг иж бүрэн системээр нь харах тухай асуудал, тэр татварын маргааны асуудал, хувь хүний орлого энэ тэртэй холбоотой яригдчихсан дутуу зүйлүүд бас ороод явах бололцоотой гэж үзэж байна.

Б.Пүрэвдорж: Ганхуяг гишүүн нэмж тодруулъя.

Х.Ганхуяг: Энэ асуудал дээр би бол Жавхлан сайдтай бас адилхан байр сууриа илэрхийлээд байгаа шүү дээ. Ер нь цөмөөрөө яг энэ зөв байгаа юмаа явуулъя. Тэгэхдээ жоохон хугацааг нь л хойшлуулчихъя л даа. Тэгэхгүй бол яг наад 2 хувийн татвар гэдэг маань яг анх орон сууц авч байгаа хүндээ 6 сая биш, 15 сая төгрөгийн хөнгөлөлт өгчих. Тэр чинь яг нөгөө байгаа оносон хөнгөлөлт байхгүй юу. НӨАТ-ын тэр 2, 5, 10 хувиа буцаалтаа өгье. Гэхдээ ирэх жил чаддаггүй юм гэхэд 2028, 2029 оноос хэрэгжүүлэхээр оруулчих л даа. Наад 50 саяыг 400 сая болгодгоо

харин больчих л доо. Энэ чинь ингээд л улам л тэр гар дээрээс наймаа хийдэг юм, нөгөө и-баримтгүй болдог, тэгээд нөгөө малчдаасаа бараа бүтээгдэхүүн үйлдвэрүүд нь авч чаддаггүй, нөгөө манай хүнсний бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн чинь өрсөлдөх чадвар нь улам буурна шүү дээ. Яг ингээд явахаар. Тэгээд энэ дээр би уг нь аягүй л тодорхой хэлээд байх юм. Чимидсүрэн дарга энэ дээр миний яриад байгаа зөв юм уу, буруу юм уу хэлээдэх л дээ. Яг ингээд тойруулаад, дараагийн удаа татварын багц хууль орж ирнэ гэдэг бол ойрын хугацаанд орж ирэхгүй шүү.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Асуусан юм уу. Тойруулаад байна гэж байна шүү. Чимидсүрэн дарга тойруулахгүй хариулъя.

Ч.Чимидсүрэн: 4 хууль дээр ингээд тодорхой тооны төсвийн нөлөөтэй, богино хугацаанд үр дүн нь гарах ийм өөрчлөлтүүдийг бол оруулж ирж байгаа. Тантай тэр НӨАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг системээр нь шийдэх ёстой гэдэгтэй санал 1 байна. Тэр дээр маш олон чухал зүйлүүд байсан. Бүх нийтээрээ НӨАТ-аа төлдөг больё. Хөнгөлөлт чөлөөлөлтийг байхгүй болгоё. Бэлэн бусаар тооцоо хийх юм бол тэрийг нь хасагдуулгыг нь хийдэг больё гэх мэтчилэн олон дэвшилтэт зүйлүүд бол өмнөх төслүүд дээр бас явагдаж байсан. Энийг бол цаашид дараа нь иж бүрнээр нь авах үед тооцоод авч явах нь бол зүйтэй гэж бодож байна.

Б.Пүрэвдорж: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Засгийн газраас энэ Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирсэн. Үүнтэй холбоотой асуултуудаа бас асууя.

Ер нь Хувь хүний орлогын албан татварын тухай хууль дээр орж ирж байгаа энэ татварын орлогууд бол яг сум, дүүргийн төсвийг бүрдүүлж байгаа. Сумын төсөв, дүүргийн төсвийн үндсэндээ 60-70 хувь нь энэ ХХОАТ-аар бүрдэж бий болдог ийм гол зүйл. Тэгэхээр энэ ХХОАТ-ыг өшөө илүү хөнгөлж, чөлөөлөх тусмаа сум, дүүргийн төсөв тэр хэмжээгээр багасна л гэсэн үг. Үүнтэй холбоотой ингээд орж ирсэн 3 заалттай холбоотой асуулт асууя.

1 дүгээрт нь иргэдийн 5-аас доошгүй жил үргэлжлэн амьдарсан, өөрийн үндсэн оршин суух хаягтай бүртгэлтэй амьдран суугаа орон сууцаа борлуулсан орлогоос чөлөөлнө гэдэг юм орж ирсэн байгаа юм л даа. 1 дүгээр заалт. Үүнтэй холбоотой энэ хууль тогтоомж анхнаасаа татвар төлөгч болон татварын алба бүх талдаа ингээд ойлгомжтой байвал их амар байдаг. Хууль хэрэгжихэд ямар нэгэн алдаа завхрал гардаггүй. Тэр агуулгаар нь асуумаар байгаа юм.

1 дүгээрт нь энэ 5 жил гэдэг юмыг яаж сонгосон юм бэ. 3 жил байж болоогүй юм уу. 7 жил байж болоогүй юм уу. Ямар тооцооллын үндсэн дээрээс сонгосон юм бэ гэж.

2 дугаарт нь оршин суух хаягт бүртгэлтэй гэдэг нь яг юу гэж байгаа юм бэ. Яаж нотлох юм бэ. Тэрийгээ маш тодорхой бас хэлээд өгчихвөл үзэж байгаа энэ хүмүүс, иргэдэд бас ойлгомжтой. Анхнаас нь хууль маань их ойлгомжтой явах байх гэж ингэж бодож байна.

3 дугаарт нь олон улсад бол энэ хөрөнгийн татварууд ерөнхийдөө Capital Gains Tax буюу анх 300 саяар авсан байр маань зах зээлийн үнэ өсөөд 500 сая болчихдог. Тэгээд 500 саяасаа анх авсан үнэ нь зардлаа хасаад, үлдэж байгаа тэр 200 саяасаа л татвараа төлөөд явдаг ийм л татварын төрөл олон улсад байдаг л даа. Тэгээд энийг яг энэ чигээр нь яг энэ Capital Gains Tax гэдэг рүү нь ер нь оруулчхаж болоогүй юм уу гэсэн ийм 1 дүгээр заалттай холбоотой асуулт байна.

2 дугаарт нь. 15.6 дээр орж ирсэн 1 тэрбум төгрөгийн Хувь хүний орлогын албан татварын тааз тавьж өгсөн байгаа. Өмнө нь таазгүй байсан. Тэгээд энэ яагаад 1 тэрбум гэж дахиад тааз тогтоох болов. Яагаад 1 тэрбумаар тогтоох болов. Ямар тооцоо судалгаа байна. Би зүгээр энийг ингэж харж байгаа юм. Өндөр цалинтай иргэд, аж ахуйн нэгжтэйгээ цалин авах биш, гэрээ байгуулаад Хувь хүний орлогын албан татварын цалингаас суутгадаг 10 хувиа биш, эндээс шууд гэрээ байгуулаад, гэрээний үндсэн дээр шууд орлого гэж үзээд, 1 хувиараа татвараа төлөөд явах бас ийм бултах орон зай бас байсан юм болов уу гэж ингэж хараад байна. Энэ дээрээ та нар ямар бодолтой байна. Иргэдэд хамгийн гол нь энэ татвар маань ялангуяа маш их хялбар ойлгомжтой баймаар байгаа юм. Энэ агуулгаараа энэ 1 тэрбум төгрөгийн татварын тааз босгож байгаа чинь яг энэ хялбаршуулсан татварын горимд хамаарагдахаар байна уу, үгүй байна уу гэж.

Дараагийн асуудал нь энэ нөгөө сарын 792 мянган төгрөгийн орлогод ноогдох татварыг хөнгөлөхтэй холбоотой асуудал байгаа. Монгол Улсад энэ цалингийн сан 36 их наяд байдаг. 1,1 сая иргэн ажил хөдөлмөр эрхэлж, цалин авч байна. Үүнтэй холбоотойгоор яг ингээд энд ноогдох орлогыг хөнгөлөөд, буцааж олгох юм бол дахиад 1 орчим их наяд төгрөгийн асуудал яригдана гээд сая Сангийн сайд маань хэлж байна. Тэгээд энийг би яг цалин дээрээсээ суутгаж авах юм уу эсвэл төлчхөөд, жилийн дараа тайлангаа өгөөд буцаагаад буцаан олголт хэлбэрээр авах юм уу гэдгийг бас нягтлангууд нэлээн асуугаад байгаа юм. Энэ дээр бас тодорхой хариулт өгөөч ээ.

Тэгээд Ханбогд сум дээр жишээлбэл уул уурхайн компанид ажилладаг Ховд аймгийн Ховд сумын иргэн буцаан олголт харьяалалтай сум, оршин суугаа дүүрэг гэдгээрээ Ховд аймгийн Ховд сумаас авах асуудал үүсдэг. Тэгэхээр тэр чинь тэнд чинь буцаан олголт өгөх санхүүгийн эх үүсвэргүй болчихно шүү дээ. Тэн дээр ямар тооцоо байна вэ гэсэн асуултыг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Чимидсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Эхний асуудал нь өөрийн орон сууц нь яагаад 5 жил заавал амьдарсан байгаад борлуулбал чөлөөлнө гэж байгаа юм бэ гээд 5 жил дээр явж байна. Тэгэхээр энэ дээр бас нэлээн хувилбарууд бас яригдсан. Тэгээд бусад улс орнуудын туршлагыг бол авч үзсэн. Тэгээд ер нь өөрийнхөө оршин суугаа үндсэн орон сууц дээрээ ихэвчлэн энэ хөнгөлөлтийг эдлүүлдэг. Хугацааны хувьд бас 2-5 жил тэр амьдарсан байх ийм нийтлэг практикууд бол бидний судалсан улс орнууд дээр байгаад байгаа юм. Мөн энэ санал бол өөрөө бас 100 мянга давсан иргэдийн санал байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад Улсын Их Хурлаас бас ажлын хэсэг байгуулагдсан. Тэгээд ажлын хэсэг дээр гарсан саналууд маань бол ер нь 5 жил байвал гэдэг саналуудыг бас бидэнтэй ярилцсан. Тэгээд энэ аль аль талынх нь саналыг аваад 5 жил өмчилсөн, тэгээд хаяг дээрээ байгаа гэдгийг явж байгаа юм.

Тэгэхээр үндсэн оршин суух хаяг гэдгийг бас тодруулаад энэ Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухаар Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд оруулсан тэр хаягийг нь бид нар авч үзнэ гэж үзэж байна.

1 тэрбумын босгыг асуусан. Тэгээд энэ дээр бол түрүүн бас ярьсан. Нөгөө иргэн, хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүс бол одоогоор ийм хязгаарлалтгүй яваад байгаа. Тэгээд бизнес эрхэлж байгаа хүмүүсийг аж ахуйн нэгж, байгууллагын, жижиг дундын түвшинтэй босготой бол ингээд шууд аваад үзэж болохгүй. Энэ бол орлогоос нь тооцож байгаа тоо. Тэр аж ахуйн нэгжийнх бол нөгөө ашгаас нь татвар ноогдуулдаг. Тэгэхдээ тэр босгыг эсвэл нөгөө хялбаршуулсан горимын аж ахуйн нэгжийн 300 саятай дүйцүүлэх энэ 2-ын дунд бол авч үзэж байгаа. Гэхдээ 1 тэрбум гэдэг нь бол хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүс ядаж өрхийн бизнес хийхэд 3 гишүүнтэй байх, тэгээд 1 тэрбумаар бодох юм 2,5 орчим дунджаар байж болох юм байна. 2-3 гишүүн бизнес эрхэлж байгаа бол гэдэг утгаар нь 1 тэрбум гэдгийг авсан байгаа.

ХХОАТ-ын хөнгөлөлтийг жилийн эцэст буцаан олгохоор хуулийн төсөлд орсон байгаа.

Б.Пүрэвдорж: Загджавын Мэндсайхан сайд нэмж хариулъя.

З.Мэндсайхан: Заяабал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2025 онд 144,6 мянган иргэн тайлан ирүүлснээс 143,9 мянган иргэн нь 1 тэрбум хүртэлх төгрөгийн орлого тайлагнаад, 50,1 тэрбум төгрөгийн татвар ноогдуулсан байгаа юм. 2025 онд 1 тэрбумаас дээш орлоготой 662 иргэн, 2,5 тэрбумаас дээш орлоготой 210 иргэн тайлагнасан байна. Хамгийн өндөр орлого 14,8 тэрбум, 7,9 тэрбум гэж тайлагнасан иргэн 14 компанитай. Тэр сая бас Чимидсүрэн хэллээ. Хуулийн өөрчлөлт дээр хүн амын орлогын албан татварын хөнгөлөлтийг татвар төлөгч татварын тайлан гарган дараа онд нь буцааж авахаар хуульд тусгасан байгаа.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууна.

П.Батчимэг: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль гээд энэ татварын багц хууль төсөл өнөөдөр ингээд хэлэлцэж байна. Ерөнхий сайд маань орж ирээд ер нь энэ танхимд байгаа хэдхэн гишүүддээ асуултад хариулсан бол их сайн байх байлаа. Энэ Засгийн газар, тэгээд энэ сайд нарыг сүүлийн үед хараад байхаар ер нь бол ажилд хандаж байгаа хандлага, асуултад хариулж байгаа байдал энэ тэр нь бол өмнөх өмнөх Засгийн газрынхаа гишүүдээс, кабинетын гишүүдээсээ нэлээн тийм доогуур, тийм саармаг болчихсон ийм байдал ажиглагдаж байх юм. Тэгээд энэ Учрал сайдын Засгийн газар манай улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа цалинтай, орлоготой юм шиг мөртөө өнөөдөр зээлээс зээлд, татварын өрөнд баригдчихсан, бүсээ чангалаад өлөн зэлмүүн амьдраад байгаа энэ 1,3 сая иргэдээ ядуу гэж ер нь тооцож үзэж мэдрэх ийм чадвар, ойлгох чадвар байгаа юм болов уу. Дундаж давхрын яг энэ 1,3 сая иргэн чинь Монгол Улсын эдийн засгийг бүрдүүлээд, татварын энэ олон олон дарамтуудыг даваад, ачааг нуруундаа үүрээд ингээд гадаа сууж байгаа шүү дээ. Өнөөдрийн оруулж ирж байгаа энэ Татварын багц хууль яг үнэндээ дундаж давхаргыг тэлнэ, энэ орлогын тэгш бус байдлыг бууруулна, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ гэж

яриад байгаа юм. Тэгээд хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ дэмжинэ гэж ийм аргацаасан, хуурсан ийм юу л хэлээд байна л даа.

Яг үнэндээ төрийн олон төрлийн энэ өндөр татвар хураамж, НДШ-ийн муу үр дагаврын л өнөөдөр жишээ нь энэ байгаа юм. Тэгээд НДШ-д 11,5 хувь, ХХОАТ-т 10-20 хувь, нийслэл хотын албан татварт 2 хувь, үл хөдлөх эд хөрөнгөд цалин хөлсны орлогынхоо үндсэн 50 хувийг ингээд талыг нь төрд өгчхөөд байна шүү дээ. Тэгээд юугаар нь амьдруулж, яаж амьдруулах гээд байгаа юм бэ. Бараг энэ ажилтай байна гэдэг ер нь ялтай байгаа энэ 1,3 сая. Энэ 2022 оны статистик тоо шүү. Өнөөдөр 2026 онд яг хэд болсныг сайд нар хариулаад өгөөрэй.

Тэгээд энэ Засгийн газраас оруулж ирж байгаа Хувь хүний орлогын албан татварын хууль бол өнөөдөр энэ төсөлд 792 мянган төгрөгийн орлогоос 0 хувь гэж тооцоод, 2 сая төгрөгийн орлогоос 1 хувь гэж тооцож байгаа чинь бүр үнэхээрийн том зөрүү. Энийг хүлээн зөвшөөрөх үү. 800 мянган төгрөгийн орлоготой өнөөдөр яг хэдэн иргэн манай улсад байна вэ. Энийг хэлээд өгөөч. Өнөөдөр 800 мянган төгрөгийн цалин аваад ажиллах тийм ажиллах хүчин, сонирхолтой иргэд ер нь хэд байгаа юм бэ. Одоо дундаж цалин 2,2-2,5 сая гэж тооцох юм бол энэ яг сегмент, энэ дундаж давхаргын иргэдийнх нь энэ орлогыг нэмэгдүүлэх, энэ татварыг бодитоор хөнгөлөх энэ бодлого татварын багц хуульд өнөөдөр орж ирсэнгүй. Яг дэмжиж ажиллах, энэ татварыг бодитоор хөнгөлөх, орлогыг нь нэмэгдүүлэх энэ дундаж давхарга чинь өнөөдөр хүлээлттэй, нийгэм бүр захиалгатай энэ хууль орж ирчхээд байна шүү дээ. Энийгээ бүгдээрээ сууж байгаад хэлэлцчихдэггүй юм уу. Ерөнхий сайд нь орж ирээд энэ асуудалд нухацтай хандаад, дараагийн чуулган дээр хэлэлцэх эсэх дээр дахиж санал аваад, энийг нэг өнөөдөр Засгийн газар .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ иргэд, аж ахуйн нэгжээ дэмжихгүй байна гэж байна. Дэмжиж байгаа. Дэмжих гээд энэ хуулийг Засгийн газар өргөн барьж оруулж ирсэн. Би танд нэг тоо хэлээд өгье. Энэ ер нь яагаад оруулж ирсэн юм бэ гэхээр өнөөдөр бид нар Засгийн газрын татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал бол иргэн, өрхийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээс гадна олон улсын нөхцөл байдлаас уялдуулаад богино хугацаанд эдийн засагт үзүүлэх тэр сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор л энэ хуулийг оруулж ирсэн байгаа. Энэ хуулийг баталснаараа бол иргэн, аж ахуйн нэгжид нийтдээ 2,2 их наяд төгрөгийн татварын ачааллаар бууруулахаар тооцсон байгаа. Бүх татварынх нь ангиллаар нь тооцож оруулж ирсэн байгаа. 4 татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байна шүү дээ. Цалин хөдөлмөрийн хөлсний орлоготой иргэдийн хувьд 792 мянга хүртэлх орлогод ноогдох татварыг 100 хувь хөнгөлснөөр иргэдийн татварын ачааллыг 4 хувиар бууруулж байгаа. Аж ахуйн нэгжүүдийн хувьд 90 хувийн хөнгөлөлтийн босгыг 2,5 тэрбум болгон нэмэгдүүлснээр нийт аж ахуйн нэгжийн 94 хувь нь хувийн татварын ачаалалтай байх боломжийг бүрдүүлж өгч байгаа. 6-0 тэрбумын ашигтай ажиллах юм бол 15 хувийн татвар төлдөг ноогдуулах босгыг дунд нь 10, 25 гэсэн хуучин 2 босгын дундуур шатлалтай болгож оруулж ирж байгаа.

Хуулийн төслүүд батлагдах юм бол богино хугацаанд буюу 2027-2028 оны эдийн засагт өсөлт нь 0,7-оор нэмэгдэх юм байна. Өрхийн орлого 3,2 хувиар өснө гэсэн тооцооллыг бид нар хийж үзсэн. Энэ бол энэ татварын хөнгөлөлтийг үзүүлснээр ачааллыг бууруулснаар иргэд, аж ахуйн нэгж дээр гарч ирэх ачаалал нь ийм хэлбэрээр бууж, эдийн засагт өсөлт ийм болох нь гэдэг тооцооллыг нь бид нар гаргаж ирсэн байгаа юм. Тийм учраас энийг богино хугацаанд Засгийн газар. Энэ бол татварын Батчимэг гишүүн ээ, багц хуулийн өөрчлөлт, шинэчлэлт биш шүү. Татварын нэмэлт, өөрчлөлтүүд. Бид нар Засгийн газар багц хуулийн өөрчлөлтийг ч гэсэн татаж аваад, богино хугацаанд эдийн засаг иргэдэд, аж ахуйн нэгжид өөрчлөлт үзүүлэх тэр заалтуудаар нэмэлт, өөрчлөлт болгож оруулж ирж байгаа юм. Татварын багц хуулиа бид нар хэлэлцүүлгийн түвшинд гарсан бүх асуудлаар нь сууриар нь реформ болгож оруулж ирнэ.

Б.Пүрэвдорж: Пүрэвийн Батчимэг гишүүн нэмж тодруулъя.

П.Батчимэг: Мэндсайхан сайд аа ойлгож байгаа. Тэгэхдээ энэ оруулж ирж байгаа хуулийн төсөл чинь үнэхээр татварын шинэчлэл реформ яг болж чадаж байгаа юм уу. Би тэгж харахгүй байна л даа. Лоозонгийн чанартай тэрийг нэмэгдүүлнэ, энийг бууруулна, дундаж давхаргыг нэмэгдүүлнэ энэ тэр гээд ингээд яриад байгаа мөртөө яг амьдрал дээр бодит байдал дээр энэ чинь ерөөсөө үг хэл, үйлдэл чинь нэгдэхгүй байгаа юм. Яагаад би Засгийн газрыг өнөөдөр яг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт энэ хуулиудад оруулахдаа зоригтой, дорвитой алхам хийж чадахгүй байгаа юм бэ гэж би асуугаад байна шүү дээ.

Өнөөдрийн оруулж ирж байгаа энэ хуулийн төслүүдийн нэмэлт, өөрчлөлтийг харахаар ерөөсөө огтоосоо иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, татварын хөнгөлөлт болж харагдахгүй байна шүү дээ. 79200 төг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хариулт авах юм уу. Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Би түрүүн бас хэлсэн. Энэ татварын нэмэлт, өөрчлөлтүүдийг баталснаар 2,2 их наядын татварын ачааллыг бууруулна. Иргэдийн орлого дээр гэхэд хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ дэмжье гэж байна. Нийтдээ өнгөрсөн оны юугаар 1 сая 22 мянган иргэн тайлагнасан байна. Хөдөлмөр эрхэлж байна. Энэ иргэдийн гар дээр жилдээ 950 мянга буюу нийтдээ 840 тэрбум төгрөгийг үлдээе. Орлого болгож. Татварынх нь ачааллаас бууруулж.

Та түрүүн асуусан 792 мянгаас доошоо орлоготой хэдэн иргэн байна гэж. 330 мянган иргэн байна. Тэгэхээр бид нар бодитой гарч ирж байгаа тоо тооцооллоо ярихгүйгээр бид нар сайхан харагдахгүй байна, муухай харагдаад байна гэдэг өнцгөөр ярьж болохгүй байх л даа. Энэ татварын хуулийг батлагдсантай залгуулаад бид нар Бизнесийн эрх чөлөөний хуулийг Засгийн газар яаралтай оруулж ирнэ. Ирэх 7 хоногт хэлэлцээд. Үүгээр бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд болон үйл ажиллагаа явуулахад иргэд аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж байгаа тэр хүндрэл бол .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж хариулъя.

3.Мэндсайхан: Иргэд Аж ахуйн нэгжүүдэд саад болоод байгаа тэр бүх зүйлийг чөлөөлье гэж байгаа юм. 200 орчим хуулийг бид нар энэ тусгай зөвшөөрөл олгодог

байдал, газартай холбоотой асуудал гээд бүх асуудлыг бид нар энэ хуулиараа дагалдуулаад энэ нь дараагийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, яаралтай өргөн барина. Ингээд бид нар бизнес эдийн засаг руугаа чиглэсэн аж ахуйн нэгжүүд, иргэдийнхээ хөдөлмөр эрхлэх боломжийг нь дэмжсэн энэ бодлогуудыг шат дараатай оруулж ирнэ. Энэ татварын хуулийн араас залгаад Бизнесийн эрх чөлөөний хууль орж ирнэ.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриас үг хэлнэ.

Зочин танилцуулъя. “Сихихутаг” Хууль зүйн их сургуулийн Эрх зүйн эчнээ ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сургуулиа төгсөөд ажил хөдөлмөрийн гараа дээр гарч байгаа та бүхэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Үг хэлэхээр Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн үг хэлнэ. Индрийн 2 дугаар микрофон.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе. Татвар бол хамгийн гол нь шударга, тэгээд иргэдийн энэ орлогыг хамгаалах гэсэн энэ зорилгуудаа бол биелүүлэх шаардлага байна. Та бүхний ярьж байгаа ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийг илүү хамгаалах тэр зорилтууд бол биелээгүй байна гэж харж байгаа. Зөвхөн татвар төлөгчдийг орлогоор нь ангилж байна. Иргэдийг бол орлогоор нь ангилж байна. Хөдөлмөр хийж байгаа, ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийг хамгаалах тусгай бодлого бол энэ татвар дээр ороогүй байна гэж үзэж байна. Жишээлэхэд, зарим улс оронд илүү цагаар хөдөлмөр хийж байгаа бол илүү цагийн орлогын татвар дээр хөнгөлөлт үзүүлж байна. Хүн дуртайдаа бол ажил хийдэггүй. Амьдралаа сайжруулъя, амьдралынхаа чанарыг дээшлүүлье, орлогоо нэмье гэж илүү цагаар ажилладаг. Тэгэхээр дэлхий нийтэд ярьж байгаа энэ татварын реформын асуудал бол эдгээр хуулиуд дээр тусаагүй байна гэж үзэж байна.

2 дугаарт татвар бол аж ахуйн нэгжүүдэд шударга байх хэрэгтэй. Дэлхий даяар энэ татварын реформ шинэчлэлийн хүрээнд дижитал үйлчилгээний татвар гэдэг ойлголт гарсан. Монголын контент үйлдвэрлэгч жишээлэх юм бол кино үйлдвэрлэж байгаа, киног түгээж байгаа энэ контент үйлдвэрлэгч яг орлогынхоо татварыг төлөөд явж байгаа бол үндэстэн дамнасан цахим үйлчилгээ үзүүлж байгаа энэ аж ахуйн нэгжүүд Монголд татвараа ингээд бүртгүүлдэггүй. Тэгээд би татварын албаныханд хэлж байсан. Та бүхэн бол энэ татварын дарамтыг бууруулъя гэвэл энэ татварынхаа баазыг нэмэгдүүлэх тал дээр шинэчлэл хийгээч. Энэ дижитал үйлчилгээний татвар гэдгийг Франц, Энэтхэг, дэлхийн маш олон улс бол зөвшилцөөд хийж байна. Нэтфлексстэй ойлголцож байна,. Ютүбтэй ойлголцож байна. Фэйсбүүк компанитай ойлголцож байна. Энэ татварын баазыг өргөтгөх чиглэлээр санаачилга ерөөсөө гаргахгүй байна. Монгол хүний орлого, Монгол аж ахуйн нэгжийн орлогыг яаж хэрхэн авах тухай, татварын орлого цуглуулах тухай боддог ийм газар болсон байна гэдэг дээр би шүүмжлэлтэй хандаж байна гэдгийг дахин хэлье.

3 дугаарт нь бол энэ татвар төлөгчийн эрхийн асуудлыг ерөөсөө оруулж ирээгүй байна. Татвар төлөгчийг ангилах юм байна. Сайн, муу, дунд гэж ангилах юм байна. Тухайн татвар төлөгч нь би энэ муу ангилалд орохгүй гэвэл яах юм бэ гэдэг зохицуулалт нь маш тодорхойгүй байна. Энэ хууль дээр бол татварын ерөнхий газар журмаар зохицуулах юм байна. Тэгэхээр Татварын ерөнхий газар бол дур зоргоороо ингээд татвар төлөгчдөө ангилдаг улаан, ногоон, цэнхрээр нь будах ийм хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна гэж бол бид харж байгаа. Энийг хэлэлцүүлгийн явцад бол сайжруулах нь зөв гэж үзэж байгаа.

Хамгийн сүүлд нь бол энэ бүс нутгийн татварын ачааллын ялгааг тэнцвэржүүлэх, хамгийн их төсөвт орлого бүрдүүлж байгаа энэ бүс нутгийн татварыг яах юм бэ, тухайн бүс нутагт нь үлдээх эсэх энэ зохицуулалт бас орж ирээгүй байна. Ийм учраас татварын энэ 4 хууль бол ямар нэгэн реформын шинжтэй хууль биш. Зүгээр ийм аргацаасан хууль байна. Энэ хууль бол томоохон шинэчлэл авчрахгүй юм байна гэдгийг Засгийн газрын гишүүд нь мэдэж байгаа юм байна. Татвар гэдэг бол төсөв. Төсөв гэдэг бол тоогоор илэрхийлж байгаа хөгжлийн бодлого. Ганцхан сайд сууж байна. Энэ татвар бол бүх асуудалтай холбоотой. Тийм учраас Засгийн газар бол энэ өргөн барьсан 4 хууль дээрээ бол үнэхээр өөрсдөө ч гэсэн сэтгэл гаргаж ажиллахгүй байна гэсэн ийм дүгнэлттэй байна. Тэгээд хэлэлцүүлгийн явцад бусад саналуудаа хэлээд явъя. Баярлалаа.

С.Бямбацогт: Баатархүү гишүүн санал хэллээ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа.

Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт хойшлуулаад, хамтад нь санал хураалт явуулна.

16.28 цаг.

17 цагаас санал хураалттай. Гишүүдийг 17 цагт санал хураалтдаа бас бэлэн байхыг хүсье.

Дараагийн асуудалдаа оръё.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

3.Мэндсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт татварын шинэчлэл хийхээр тусгагдсаны дагуу Засгийн газраас боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслүүдийг танилцуулж байна.

Энэ удаагийн татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачааллыг 2,2 орчим их наяд төгрөгөөр үе шаттай бууруулахаар тооцож байна.

Монгол Улс анх 1998 онд нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлж, улмаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг 2006, 2015 онд шинэчлэн найруулснаас хойш 10 жил өнгөрсөн байна.

2024 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 58 орчим хувь нь мөнгөн хөрөнгийн дутагдалтай, 29 хувь нь буюу 30 мянга гаруй аж ахуйн нэгж алдагдалтай ажилласан нь бичил, жижиг бизнес эрхлэгчдийн төлбөрийн чадвар буурах, санхүүгийн дарамтад орох, улмаар бизнесийн тогтвортой байдлаа хадгалахад хүндрэлтэй байгааг харуулж байна.

Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, МҮХАҮТ, Улаанбаатар хотын худалдааны танхим болон Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран 2025 онд улс орон даяар давхардсан тоогоор 13 мянга гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт хийж, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 176 мянга гаруй саналыг хүлээн авлаа.

Иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой саналуудыг авч үзэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлэх босго дүнг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн татварын уян хатан зохицуулалтыг бий болгох, татварын бодлогоор орлогын тэгш бус байдлыг бууруулах зэрэг саналуудыг түлхүү ирүүлсэн байсан.

Засгийн газар гадаад орчинд үүсээд буй нөхцөл байдал, татвар төлөгчтэй хийсэн уулзалт, олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналыг харгалзан үзсэний үндсэнд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах чиглэлээр боловсрууллаа. Үүнд:

1.Бичил жижиг бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа өргөжүүлэх боломж олгох зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэх;

2.Татвар төлөгчийн хууль, даган мөрдөлтийн түвшин, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан дотоодын болон импортын нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 2 хүртэлх сараар хойшлуулах боломжийг бүрдүүлж, аж ахуйн нэгжийн мөнгөн урсгал уян хатан байдлыг дэмжих. Түүнчлэн хуулийн төсөлтэй хамт шаталсан татварын тогтолцооны зарчимтай уялдуулан импортын суудлын автомашины гаалийн тодорхой үнийн дүнгээс нэмэгдэл хувиар тооцож татвар ноогдуулах зохицуулалт бүхий Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслүүд батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулах, бизнес идэвхжих, тэлэх бололцоог хангах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, орлогын тэгш бус байдлыг бууруулах зэрэг ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт боловсруулсан Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Л.Мөнхбаясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан төгрөгийн ханш суларч инфляц зээлийн хүүгийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор нэгжүүдийн мөнгөн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг дэмжих, мөн бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа өргөжүүлэх боломжийг бүрдүүлэхтэй холбоотойгоор нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэх, татвар төлөгчийн хууль, даган мөрдөлтийн түвшнийг харгалзан дотоодын болон импортын нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийг 2 хүртэлх сарын хугацаагаар хойшлуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар бизнес эрхлэгчдийн мөнгөн хөрөнгө эргэлтийн хөрөнгийн ачааллыг бууруулж, бизнесээ идэвхжүүлэх, өргөжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн байна.

Хуулийн төслийг D-Parliament.mn сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Татварын ерөнхий хуульд татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулахаар тусгасан нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн татварын хуулиудтай хэрхэн уялдаж байгаа талаар, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг нэмэгдүүлсэнтэй холбоотой МХАҮТ болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн саналуудын талаар, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэхдээ хувь хүн, хуулийн этгээдэд ялгаатай бодлого баримтлах эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 68,8 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 68,8 хувийн саналаар үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Мөнхбаясгалан гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг түрүүний ажлын хэсэг хэвээрээ. Ажлын хэсэг Их Хуралд хүндэтгэлтэй хандахыг хүсье. Одоо Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Татварын энэ хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж ирсэн зүйл, заалтуудыг нь дэмжиж байна. Яршиг төвөг, бүр реформ хийнэ гэж хүлээхээ больё. Зүгээр сөөм сөөмөөр ч гэсэн хамаагүй ингээд өөрчлөлтүүдийг хийгээд, шуурхай бага багаар ч гэсэн эерэг өөрчлөлт гараад явж байгаа бол сайн байна. Бүр системийнх нь хэмжээнд бүр орвонгоор нь өөрчилчихгүй, тэгээд л ямар ч байсан унагаачихгүй явсан нь зүйтэй байх гэж бодож байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой асуудлууд яригдаад байна. Энэ дээр Хувь хүний орлогын албан татварын тухай хууль дээр зүгээр шууд 792 гээд хувь хүний чөлөөлөгдөх хэмжээг 800 гээд 792 мянган төгрөгөөс холдуулахгүй бол цааш цаашдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх тутамд энийгээ нэмэгдүүл гэдэг ийм шаардлага орж ирнэ. Ирэх оноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ямар дүнгээр тогтоох вэ гэдгийг одоогоос ярилцаарай. Сангийн сайд аа, наадах чинь асуудал үүсгэнэ шүү. Өчигдөр гэрээ дээрээ хэлэлцээрээ байгууллаа гэсэн. Гэхдээ дүнгээ огт тогтоогүй байна лээ. 9 сарын 10-нд намрын чуулган нээгдэхээр болчихсон байгаа шүү дээ. Тэгэхэд та нар төсвөө өргөн барьчихсан байх үүргийг хүлээж байгаа. Тэр дотор чинь яг энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ тохирчихсоноос болж дараа жилийн НДШ-ийг сайн дурын шимтгэл хэдэн хувиар төлөх юм. ЭМД-ын шимтгэлийг сайн дурын шимтгэлийг нь хэдээр төлөх юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй хэдийг төлөх юм. Гадаадаас ажиллах хүч авахад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр хэдийг төлөх юм. Мөн түүнчлэн бид нар чинь сая амьгүй донорын ар гэрт нь бас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээр тэтгэмж өгнө гээд шийдчихсэн. Тэр болгон чинь явах учраас эртнээс яриарай. Тэгэхгүй бол 10 сар гээд л тохироогүй байгаад нөгөө өргөн барьсан төсөв чинь дахиж эвдэгдээд, зөндөө асуудал үүсдэг шүү. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ маань өөрөө уг нь анхны хууль нь бол цагийн хөлсний доод хэмжээ байгаа байхгүй юу. 1 цагийн доод хэмжээ. Энэ бол бүр 90 хэдэн онд батлагдаж байсан ийм хууль байдаг.

Тэгээд цагийн хөдөлмөр эрхлэлт зохицуулагдаагүй юм шиг ийм асуудлыг түрүүн Шижир гишүүн ярилаа. Үгүй ээ, Хөдөлмөрийн тухай хуулиар гэрээсээ ажиллах, цагаар ажиллах, зайнаас ажиллах, түр ажиллах бүхий л энэ асуудлууд зохицуулагдсан байдаг. Бид нар мөн түүнчлэн энэ хөдөлмөрийн тухай хуулиар оюутан, залуучуудын дагалдангаар ажиллах эрхийг нь бас нээгээд, тэгээд дагалдангаар зундаа 3 сарын хугацаанд ажиллалаа гэхэд ажил олгогч болон ажилтны НДШ төлөх тэр хэсгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоно гээд хуулиуд нь бол байгаад байгаа юм. Хууль байгаа. Зохицуулалт байгаа. Харин хууль хэрэгжихгүй байна гэдэг нь өөрөө зохицуулалтгүй байна гэсэн үг огт биш. Яагаад ер нь энэ НДШ-ийг нь зайлшгүй хаа нэгтэйгээс төлөөд байгаа юм бэ гэхээр тухайн хүн ажлын байран дээрээ гэмтвэл яах вэ, бэртвэл яах вэ. Энэ чинь нийгмийн хамгаалал талаасаа байхгүй юу. Энэ чинь нийгмийн даатгалыг татвар гэж ойлгогдоо бид нар болих ёстой. Энэ бол нийгмийн хамгаалал. Тэгэхээр энэ агуулгаар нь бас харж, дараа дараагийн асуудлуудаа ярих хэрэгтэй байна.

Гэхдээ ер нь энэ нийгмийн даатгалтай холбоотой энэ их дарамттай байна гэдэг асуудлыг их яриад байгаа учраас хувийн нэмэлт тэтгэврийн тухай, мөн түүнчлэн Түвшин нарын өргөн барьсан энэ тэтгэврийн нийгмийн даатгалын энэ өөрчлөлтийн тухай хуулиудыг хэлэлцэх шаардлагатай. Ингэснээр хэдүүлээ ямар ч байсан 1 удаагийн гэрээгээр тэгвэл яах юм бэ гэдэг асуудлаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахинаар нэмэгдүүлснээр ажил олгогчийн төлж байгаа дээд хэмжээ хязгаарыг ... би 1 минутаа нэмээд авчихъя. 2 минутаа нэмээд авчихъя тэгэх үү, дарга. Минут дуусах гээд байна. Тэгэхээр энэ хэмжээ хязгаарыг ч гэсэн тогтоохгүй бол .../минут дуусав/

С.Бямбацогт: 1 минут сунгая.

А.Ариунзаяа: Тогтоохгүй бол ердөөсөө ажил олгогч талдаа хувийн нэмэлт тэтгэврийг үүсгэх ямар ч инсентив буюу сэдэл төрөхгүй. Тэгэхээр энэ агуулгаар нь бид нар бас Нийгмийн даатгалын хуулиудаа бас эргэж харах хэрэгтэй байна. Бид нар энэ ажил, хөдөлмөр эрхлэлтийг бас нэмэгдүүлье гээд л бүлгүүд дээрээ суурилад л маш олон хуулиудыг гаргадаг. Нэн ялангуяа ахмадын хөдөлмөр эрхлэлтийг бас нэмэгдүүлнэ, сайжруулна. Ахмадыг 50-аас дээш ажилтантай бол та нар ажиллагсдынхаа 2 хувьд нь ахмадыг ажиллуул. Тэгвэл тэтгэврийн шимтгэлийг төлөхгүй байж болно. Хүсэлтийг гаргаж болно гээд хуулийг би санаачлаад, анх өргөн бариад явсан. Гэтэл явцынхаа дунд тухайн тэтгэвэр тогтоолгосон хүнийг ахмад гэдгийг зөвхөн 5.1.1 буюу 20-оос доошгүй жил төлсөн 65 насанд хүрсэн даатгуулагч гэгчихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг тэтгэврээ тогтоолгосон л бол хөнгөлөлттэй нөхцөлөөр наана нь тогтоолгож байгаа хүмүүс маш олон байгаа шүү дээ. Түүгээр нь бас өргөжүүлэх шаардлагатай.

С.Бямбацогт: 1 дор болохгүй. Хариулчхаад, дараад нь тодруулж болно. Сангийн сайд Мэндсайхан хариулъя.

3.Мэндсайхан: Ариунзаяа гишүүний хэлж байгаатай санал 1 байгаа. Тэр бид нар энэ хуулиа боловсруулахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зүгээр жишиг болгоод авчихсан болохоос биш энэ бол цаашаагаа хөдөлмөрийн доод хөлсний хэмжээтэй уялдаад, өсөөд явна гэсэн ойлголт биш. Хэлэлцүүлгийн явцад таны саналыг би бол бас зүйтэй юм байна гэж харж байна. 800 болгоод тэгшитгээд бид нар энэнээс гаргахгүй бол хүмүүс 792 гэдэг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ

байна гээд ингээд цаашаагаа уялдаад өсөх ёстой ч гэдэг юм уу ийм ойлголт авч магадгүй. Тэгэхээр хууль дээр бол 792 мянган л хүн амын орлогын албан татвараас чөлөөлөгдөнө гэж үзэж байгаа юм.

НДШ-ийн хувьд түрүүн бас гишүүд яриад байсан. Ингээд энэ татвар чинь хүн амын орлогын албан татвар, энэ нийтлэг татварууд чинь бид нарыг ажил хийх боломж олгохгүй байна гээд. НДШ гэдэг бол татварын асуудал биш ээ гэдгийг та ч хэллээ, би бас энийг давтаад хэлчихье. Баярлалаа.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Тэгээд ер нь ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлье л гэж байгаа бол өмнө нь гаргасан энэ хуулийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд 65 нас, 20 жил төлсөн гэдгийгээ өргөжүүлээд, одоо тэтгэвэр тогтоолгож байгаа наана нь малчны тэтгэвэр байна, олон хүүхэдтэй эхчүүд байна, хүнд нөхцөл байна, цэргийн тэтгэвэр байна гэх мэтчилэн маш олон насны бүлгүүдийг ч гэсэн хамруулах хэрэгтэй. Тэгэхээр энийг Сангийн яам, Засгийн газар бас дургүйцэж битгий хүлээж аваарай. Энэ бол ахмадыг 1 талдаа дэмжих, нөгөө талдаа туршлагатай ажилтнуудыг ажил олгогчид бас авах дур хүсэлтэй байх энэ нөхцөлийг зохицуулах учраас би бас хуулийн төсөл санаачлаад, манай ажлын хэсгээс бас өргөн барихаар бэлэн болж байгаа. Эрдэнэбат гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Тэгээд энэ хуулийг бас оруулах юм. Тэгэхээр нийгмийн даатгалын ойлголтыг бид нар бас сайн өгөхгүй бол буруу тийшээ яваад байна шүү гэдгийг бас анхааруулж хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой аж ахуйн нэгжүүдээс санал ирсэн. Өөрөөр хэлбэл энэ татварын ачааллыг үүрэлцэж яваа яг шударгаар хуулиар, Үндсэн хуулиар хүлээсэн татвар төлөх үүргээ хэрэгжүүлж байгаа бизнес эрхлэгчдийн хувьд бол Улаанбаатар хотын танхим, үндэсний ХАҮТ гэх мэт байгууллагуудаас НӨАТ-тай холбоотой тодорхой саналууд өгсөн. Тэгээд энэ дээр энэ НӨАТ-ыг суутган тооцогч, босгогүй болгоё, бүгдээрээ татвараа төлдөг болъё. Дээр нь энэ НӨАТ-ын буцаан олголтыг болиод, тэр буцаан олголтын хувь хэмжээгээрээ НӨАТ-ын хувь хэмжээгээ багасгаад, тэгээд бүгдээрээ тэр ноогдох боломжит хэмжээ НӨАТ-ынхаа татвараа багасгаад, тэр босго гэж юм байхгүй, бүгдээрээ НӨАТ-аа төлдөг болъё гэсэн ийм саналууд гаргасан байгаа.

Тэгэхээр яах вэ, одоо энэ орж ирсэн хуулийн төслөөр болохоор энэ босгыг 400 сая болгоод нэмэгдүүлэхээр энэ бол бас МАН-ын мөрийн хөтөлбөрт орчихсон байгаа заалт л даа. Тэгээд энэ нь ингээд ирэхээр босго нэмэхээр НӨАТ төлөгчдийн энэ суурийн чинь тал нь байхгүй болчхож байгаа юм. Тэгэхээр энэ буцаад далд эдийн засаг руугаа орох, тэр татвар төлдөг хэсэг маань улам л тэнцвэргүй өрсөлдөөнд ордог болох, хажуугаар нь ийм өрсөлдөөний нөхцөл байдлаас үүдээд тэр нөгөө НӨАТ төлөгч биш аж ахуйн нэгжүүд ч бас ийм сөрөг үр дагавартай иймэрхүү үр дүн рүү хөтөлж магадгүй шийдвэр болох гээд байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас энэ татварын суурийг нь бууруулж байгаа. Тэгэхээр Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл дээр татвар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох гэдэг 4 дүгээр зүйл байгаа. Тэгээд энэ 4 дүгээр зүйлийн 2 дээр татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг

бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гээд заачихсан. Тэгээд энэ асуултыг уг нь Байнгын хороо дээр асуусан боловч тодорхой хариу өгөөгүй. Тэгэхээр Татварын ерөнхий хуулийн 4.2-оор харахаар өргөн барьж байгаа энэ хуулийн төслүүдийг төсөвтэй хамт өргөн барихаар иймэрхүү зүйл заалт харагдаад байгаа юм. Тэгээд энэ 4 хуулийг харахаар тэр нөгөө татварын өр барагдуулахтай холбоотой тэр 20 хувийн орлогыг нь үлдээхтэй холбоотой заалтаас бусад нь бүгд 2027 оны 1 сарын 1-ээс эхэлж мөрдөгдөх тийм хуулиуд байгаа юм. Тэгэхээр энэ дээр 4.2-ыг дахиад яг тодорхой тайлбар өгөөч. Түрүүчийн Байнгын хороо дээр бол ерөнхийдөө нэлээн бөөрөнхийлөх маягтай өнгөрсөн. Ийм асуулт байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Сангийн сайд хариулъя. Мэндсайхан сайд.

3.Мэндсайхан: Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд бол Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан жижиг дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих бодлого, зорилт, арга хэмжээний хүрээнд НӨАТ-ын босгыг бид нар нэмэгдүүлэхээр нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд бол өөрчлөлт боловсруулж орж ирсэн. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа НӨАТ-ын суутган төлөгчөөр бүртгүүлэх босго бол 50 сая төгрөг. Үүнийг 15 оны НӨАТ-ын шинэчилсэн найруулгын хүрээнд тогтоосон байгаа. Тухайн үед бол Монгол Улсын ДНБ 22,9 их наяд төгрөг байсан бол одоо 89,9 их наяд төгрөгт хүрч эдийн засгийн хэмжээ ойролцоогоор 4-5 дахин тэлсэн байна. Тэгэхээр тэр үеийн босготой уялдуулах нь бас босгыг шинэчлэн найруулах шаардлага бол бий болсон. Нөгөө талдаа бол ОУВС-аас хөгжиж буй орнуудад ашиглахыг зөвлөдөг НӨАТ-ын оновчтой босго тогтоох аргачлалын дагуу тооцож үзэхэд НӨАТ-ын суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг бол 398,5 сая төгрөг байхаар ингэж тооцож гаргасан юм байна лээ. Уг тооцоолол татварын албаны захиргааны зардал, татвар төлөгчийн хууль, даган мөрдөлтийн зардал, НӨАТ-ын хувь хэмжээ, борлуулалтад эзлэх нэмүү өртгийн хувь зэрэг үзүүлэлтүүдийг бол ашигласан. Тэгээд тооцооллын үр дүнг хэрэгжүүлэхэд ойлгомжтой, хялбар байлгах үүднээс 398,5 саяыг 400 сая болгож ингэж тэгшитгэж хуульд оруулж ирсэн байгаа.

Ер нь зүгээр яах вэ 400 сая төгрөг болгож нэмэгдүүлснээр 2025 онд НӨАТ тушаасан, тайлан гаргасан 69 мянга гаруй суутган төлөгчөөс 23 мянга орчим НӨАТ төлөгч бол энэ бүртгэлээс хасагдаж, НӨАТ-ын орлого 160,8 тэрбумаар буурах ийм тооцоо гарсан байгаа. Нэмээд Татварын дарга хариулаарай.

С.Бямбацогт: Татварын Ерөнхий газрын дарга Цогтнарэн. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Б.Цогтнарэн: Татварын ерөнхий газар Цогтнарэн. НӨАТ-ын босгогүй байх нь бол бичил жижиг бизнес эрхлэгчдэд дарамт нэмж, татварын албаны үйл ажиллагаанд зардлыг нэмэгдүүлдэг ийм эрсдэлтэй. Мөн хэт өндөр байх нь бас зохимжгүй. НӨАТ-ын бүртгэлийн системийг доголдуулдаг гэж үздэг. НӨАТ нь нийлүүлэлтийн гинжин хэлхээ бүрд үүсэж байдаг, нэмүү өртөг бүр дээр ноогдуулдаг ийм татвар. Тэгээд суутган төлөгч нь хуулийг үр ашигтай байх ийм асуудал байгаа. Тэгээд 72 мянган татвар төлөгч бол НӨАТ төлөгчөөр бүртгэлтэй байгаа. НӨАТ-ын босгогүй тохиолдолд 2 сар гаруй татвар төлөгч НӨАТ төлөх ийм асуудал үүснэ. Тэгэхээр НӨАТ-ын босго гэдэг олон улсын зарчмаараа заавал байдаг.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Би нөгөө Байнгын хороон дээр асуугаад хариултаа авч чадаагүй. Татварын ерөнхий хуулийн 4.2 дугаар заалтаа л асуумаар байгаа юм. Татварын суурийг бууруулахдаа энэ хөнгөлөлт, чөлөөлөлттэй хувь хэмжээтэй холбоотой энэ хуулийн төслүүдийг тухайн жилийн төсвийн хуультай хамт боловсруулна гээд ийм заалт байгаа. Тэгээд энэ зөрчил үүсэхгүй юу. Одоо энэ өргөн барьж байгаа хуулиуд чинь гэдэг асуулт байгаад байгаа юм.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Сангийн Яамнаас ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэр Татварын ерөнхий хуулийн 4.2 дахь заалт бол ингээд амьдрал дээр тодотгол хийх юм уу, бусад үеүдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, эсвэл татварын хувь хэмжээтэй холбоотой ийм санаачилгууд бол бас нэлээн гардаг. Тэгэхээр үүнийг илүү ихэвчлэн хаах зорилготой. Хэрэв төсвийн жилийн дундуур татварын хувь хэмжээ хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэхээр бол заавал дараагийн төсвийн жилийг эхлэхээр ийм зохицуулалтууд явж байгаа.

Тэгэхээр энэ татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт, магадгүй шинэчилсэн найруулга, багц хууль энэ тэрийг бол төсөвтэй уяхгүйгээр тусдаа хэлэлцэх нь илүү оновчтой. Төсөв хэлэлцэхээс өмнө татварын хуулиуд нь тодорхой батлагдчихсан. Түүндээ таарч төсөвлөлт хийх нь илүү оновчтой гэж үзэж байгаа. 2019 оны багц хууль ч гэсэн ингээд тусдаа хэлэлцэгдээд явсан. Зөрчил үүсэлгүйгээр явсан.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулж асууя. Дахиад.

Д.Энхтүвшин: Тэгээд яах вэ, бид хэд зөв ч бай, буруу ч бай, сайн ч бай, муу ч бай хууль дээдлэх зарчим гэж байгаа болохоор хуулиа л дагахгүй бол яг энэ дээр хэрвээ болохгүй бол хуулиа өөрчлөөд явах ёстой байх. Яг энэ хууль дээр бичсэнийг уншихаар төсөвтэй л хамт л энэ татварын хуулиудыг л өргөн барина, боловсруулна гээд л заачихсан байна л даа. Тэгээд саяын тайлбараас бас л яг хангалттай тайлбар авч чадсангүй. Хариулт хэрэггүй.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Ингээд өнөөдөр Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 4 дэх багц хууль биш л дээ. Татварын хуулиуд дээр нэмэлт, өөрчлөлтүүд хийж байгаа. Бүгд л татвартай холбогдож байгаа. Тэгээд манай энэ татварын бодлого, манай энэ эдийн засгийн суурь Монгол Улсын эдийн засгийн төрөлжилт, эрсдэл даах гадаад, дотоод шок, хөрш зэргэлдээ улсын нөлөөллийг дааж чадахгүй ийм суурь нөхцөлтэй байгаад байгаа юм. Хувийн хэвшлийн оролцоо, хувийн хэвшлийн чадавх, өсөх боломж энэ боломжууд бол бүх татварын хуулиудаар дэмжигдэж өгч чадахгүй байх. Тэр нь татварын хууль бүтнээрээ буруу буюу эсрэг муу гэсэн утга гэхээсээ илүү Монгол Улсын эдийн засгийн буюу санхүүгийн эдийн засгийн энэ суурь нөхцөл маань өөрөө болохоо байчихсан. Нөгөө зах зээлийн эдийн засаг биш, социалист эдийн засаг биш, хувийн эдийн засаг биш, төрийн өмчийн эдийн засаг биш, гадаадын хөрөнгө оруулалтын биш. Ингээд эдийн засгийн суурь ойлголт, суурь онол практикийнхаа хувьд түвшин нь болохоо байчхаад байгаа юм. Тэгэхээр ашиг олоод

татвар төлдөг тэр орон зайг эдийн засгийнхаа суурь нөхцөл дээр Монгол Улсын иргэнд нь олгож өгөөч ээ. Энэ улс орны эзэн нь болсон хүмүүс бизнес хийгээд, ашгаа олоод, татвар оршихуй дор төр буй гэдэгтэй адилхан татвараа төлөөд, хураагдсан татварыг нь, шударгаар төлсөн татварыг нь зөв хуваарилдаг энэ механизм руу оруулах боломж байхгүй юм уу гэж түрүүнээс хойш хуулиуд дээр асуугаад байгаа юм. Тэгээд багц хууль өргөн барихаараа нэлээн зүйлүүдийг өөрчлөх юм байна гэж ингэж харагдаж байгаа юм.

Түүнээс ингээд машин яриад, дугуйгаа хийл, бас бус юмнуудаа ядахдаа хажуугаа хардаг толио зас эд нар бүгдээрээ зөв шүү дээ. Засгийн газраас оруулж ирж байгаа татваруудыг зөв л гэж байгаа юм. Татварын өөрчлөлтүүдийг. Гэхдээ та нар энэ суурь Засгийн газар бүтцийнхээ хувьд, кабинетынхаа хувьд, гүйцэтгэх засаглалынхаа хувьд бүтнээр нь оруулж ирэхгүй байна гэдэг зүйлийг л яриад байгаа юм. Косметик зүйл битгий хийгээд бай л гэж байгаа юм. Тэрэнд эгдүүцээд уурлаад байвал бас Улсын Их Хурлын өмнө Засгийн газар бас болохгүй байх. Мэдээж 1 гишүүн Улсын Их Хурал биш хэдий боловч энэ дээр бол чуулганы үйл ажиллагаа явж байгаа тохиолдолд бол Улсын Их Хурлын үйл ажиллагаа явж байна гэж ингэж ойлгох хэрэгтэй.

2-т нь дөнгөж сая даргын дэргэдэх зөвлөл цахимаар хуралдлаа. Ирэх 7 хоногт нэлээн олон 32, 10 хэд, 20 хэд, 40 гишүүний өргөн барьсан татварын хуулиудтай холбоотой хуулиуд хэлэлцэх эсэхээр төлөвлөгөөнд орж ирж байна. Яг өнөөдрийн Засгийн газраас өргөн барьсан 4 хууль тэр чигээрээ. Тэгэхдээ түрүүн ингээд нэлээн асуугаад байдаг нь тэр байхгүй юу. Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулийг гараасаа алдахаас өмнө Засгийн газар оруулж ирж байгаа нь ийм косметик хэлбэрээр оруулж ирж байгаа юм уу гэдэг ийм улс төрийн шалтгаан ард нь байна уу, үгүй юу гэж асуусан. Тэгээд энэ 2 нь нийлж хэлэлцэгдээд хэлэлцэгдэх юм уу, нэг бол ирэх 7 хоногт Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулиудыг Засгийн газар өргөн барьсан учраас гээд чуулганы санал хураалтаар бүгдийг нь унагаах гэж байна гэдэг ийм л хардлага төрж байгаа. Тэгэхдээ магадгүй тэгэхгүй байвал илүү сайн. Энэ бол ирэх 7 хоногийн гишүүдийн санал өгөлтийн л процесс учраас энэ дээр учир зүггүй тэгнэ, ингэнэ гээд тааж хэлэх юм алга.

Тийм болохоор Их Хурлын гишүүд татвар дээр олон удаа ийм.../минут дуусав/

С.Бямбацогт: Засгийн газраас Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Засгийн газраас өргөн барьсан хууль бол косметик хууль гэж ямар ангилал байдгийг мэдэхгүй юм. Бизнесийн орчноо дэмжье, эдийн засгаа тэлье, аж ахуйн нэгжүүдээ дэмжье, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ дэмжье гэдэг хүрээнд оруулж ирсэн татварын нэмэлт, өөрчлөлтүүд. Энэ хүрээнд нийтдээ энэ татварын нэмэлт, өөрчлөлтүүд хэрэгжсэнээрээ 2,2 их наяд төгрөгийн хөнгөлөлт буюу татварын ачаалал аж ахуйн нэгж, иргэдээр буурах нь гэдгийг хэлж байгаа. Тэгээд энэ косметик гэдэг ойлголтод ордог бол би тэр ангиллыг нь ойлгохгүй юм байна. Засгийн газар ямар нэгэн хувь гишүүдээс, улс төрийн манлайллаа алдах гээд түрүүлж оруулж ирж байгаа ийм ядмаг бодлоор асуудалд хандаагүй. Бид эдийн засаг, нийгмийн гадаад эдийн засгийн шок нөлөөтэй үед иргэд, аж ахуйн нэгжээ явал дэмжиж болох вэ, богино хугацаанд явал арга хэмжээ авах вэ гэдэг Засгийн газрын бодлогоо боловсруулж, Их Хуралдаа өргөн барьж хэлэлцүүлж байгаа асуудал. Түүнээс биш энэ хэн нэг нь

улс төрийн орноо авах гэж оролддог ийм асуудлаар улс орныхоо эдийн засгийн ард түмнийхээ эдийн засгийн баталгаанд ханддаг ийм бодлого байхгүй байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, хууль оруулж ирж байгаа субъект маань Улсын Их Хурлын чуулганд саяны үг протоколд үлдэж байгаа. Сайн байна. Үнэхээр тийм байж чадаж байвал энэ сайн зүйл шүү дээ. Дэмжих ёстой шүү дээ. Хэрэгтэй бол энэ микрофон дээр алга ташиж өгсөн ч болно. Тэр үгэндээ бай. Монгол Улсын зүйр үг ч байгаа. Ер нь төр байгаа бол татвар байгаа, татвар байгаа бол төр байгаа л гэж байгаа шүү дээ. Сангийн сайдын хэлж байгаа үгийг бол энэ тэмдэглэлд үлдэж байгаа утгаараа би бол зөв л гэж бодож байна. Энэ оруулж ирж байгаа зүйлийг чинь 1 ч эсэргүүцээгүй гээд асуулт болгондоо би хэлсэн шүү дээ. Гэхдээ дутаад байна. Арай гүйцээгээд, арай илүү талаас нь харж болдоггүй юм уу л гэж саналуудыг, орж ирж байгаа зүйлийг эсрэг юм ярина гэж би хэлээгүй. Сайжруулах, дараа нь энэ зүйл дээр Засгийн газар ямар байр .../минут дуусав/

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулах уу. Үг хэллээ гэнэ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя. Алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Нэмэгдсэн өртгийн албан татвараар энэ 2026 оны шинэчлэлийн хүрээнд ингээд татвар ноогдох НӨАТ-ын хамрагдах босгыг 50 саяас 400 сая төгрөг болгоод нэмэгдүүлж байгаа нь ер нь бол жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд бол дэмжлэг болж байгаа. Гэхдээ ингээд харъя л даа хэдүүлээ. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хялбаршуулсан горимын 50 сая, 300 сая, 1,5 тэрбумын босго, мөн хувь хүний орлогын албан татварын 1 тэрбум төгрөгийн хялбаршуулсан горимын зохицуулалт гээд ингээд маш олон хөнгөлөлт чөлөөлөлтүүд бүгдээрээ уялдаагүй, тайлагнах хугацаа, татвар төлөх хугацаа, ер нь энэ татварын горимууд нь бүгдээрээ зөрүүтэй. Ингээд нэг ёсондоо нэгдсэн тогтолцоогүй болоод бид нар энэ их олон янзын хөнгөлөлт чөлөөлөлт рүү явж байна. Энэ бол татварын нэгдсэн бодлогын уялдаа тогтолцоог алга болгож байна гэж ингэж хувьдаа үзэж байна.

2 дугаарт татварын ийм хөнгөлөлт чөлөөлөлт, тэгээд энэ босгыг нь өндөрсгөх, багасгах, хялбаршуулсан дэглэм зэрэг нь яг үнэндээ бол төсвийн шууд бус зардал. Тэгээд одоогоор бид нарт энийг байтугай шууд зардлаа хэмжих тийм институт байхгүй. Тэгээд 1 мэдэхэд энэ зардлаа хэмжиж чадахаа байчихсан ийм л байдалд хүрэх гээд байна л даа. Тэгээд өнөөдөр жижиг дунд бизнесийн татварын хөнгөлөлт, орон сууцын татварын дэмжлэг, өндөр технологийн хөрөнгө оруулалтын урамшуулал гээд ийм маш олон төрлийн хөнгөлөлт урамшуулал байж. Үүний улмаас татварын бодлого өөрөө төсвийн далд зардал болж хувирч байна. Энэ далд зардлыг хэмжиж тайлагнахаа болихоо байсан. Тийм учраас энэ ОУВС-аас татварын зардлын тайлангийн аргачлалыг хийгээд, тэгээд энэ бүх төрлийн хөнгөлөлт чөлөөлөлтийг нийт ДНБ-ий тэдэн хувь эзэлж байгаа юм. Орлогын ямар бүлэг, ямар салбар, ямар өмчлөлийг дэмжиж байгаа юм гэдгээр нь ингээд гаргаад, анализ хийдэг энэ байдал руу шилжихгүй бол татварынхаа тогтолцоог бид нар энэ олон төрлийн хөнгөлөлт чөлөөлөлтөөр эвдэж байна гэдгийг бас хэлье.

Энэ нэмэгдсэн өртгийн албан татварыг хэн төлдөг вэ гэж. Өнөөдөр нэмэгдсэн өртгийн албан татварыг иргэд төлж байгаа гэж ойлгож байгаа. Үнэхээр тусгай, үнэтэй үйлчилгээ үзүүлж байгаа, бараа үйлчилгээ зардаг хүмүүс бол өртөг, ашиг дээрээ нэмэх нь нэмэгдсэн өртгийн татвараа нэмээд төлөөд явж байгаа. Манай Монгол Улсад үнэ яаж тогтож байгаа вэ гэхээрээ зах зээлийн үнээрээ тогтож байгаа. Зах зээлийн үнэ тогтож байгаад ихэвчлэн нэмэгдсэн өртгийн албан татварыг бизнес эрхлэгч 30 хувийг нь, дундын үйлдвэрлэн дамжуулан борлуулагч 30 хувийг нь, иргэд эцсийн худалдан авагч 30 хувийг нь төлж байгаа шүү дээ. Гэтэл энийг бид нар бүгдийг нь иргэд худалдан авагч төлж байгаа гэж ингэж ангилж байгаа нь бол одоо бид нар эдийн засгийн тооцооллоо нэмэгдсэн өртгийн албан татварынхаа ачааллыг бүрэн ойлгохгүй байна.

Тийм учраас ямар зарчмын санал байгаад байна вэ гэхээрээ энэ олон хөнгөлөлт чөлөөлөлтийн зардал, хийх ажил чинь өөрөө activity based costing буюу өртөг зардал нь энэ хөнгөлөлтөөсөө ч илүү гарчих магадлалтай байна шүү. Тийм учраас нэмэгдсэн өртгийн албан татварыг энэ олон хөнгөлөлт чөлөөлөлтийг болиод бүгдээрээ төлдөг болоод, зүгээр одоо байгаа 2 хувийн хөнгөлөлтөөрөө нэмэх нь 3 хувиар нь татварынхаа хувь хэмжээг буулгаад, одоо Пүрэвдорж гишүүний оруулж ирээд байгаа нийтдээ 5 хувиар татвараа бууруулчихад л манай Монголын эдийн засагт ялангуяа бизнес эрхлэгчдэд маш үнэтэй хувь нэмэр болно. Татварын бааз суурь нэмэгдэнэ. Иргэдийн сэтгэлгээ, сэтгэл санаа сэргэнэ, худалдан авалтын өртөг буурна. Энэ далд зардал чинь өртөг буурахад огт нөлөөлөхгүй байгаа. Энэ далд зардал чинь өртгөө тооцож чадахаа байгаад, бараа материалын үнийн өсөлтөд хийж байгаа. Буцааж хурааж аваад, буцааж олгож байгаа зардал чинь шударга, шударга бус байх нь эргэлзээтэй. Итгэлцэл төрүүлэхгүй, тэрийг авсан хүн болгон чинээлэг болохгүй, тогтвортой ажлын байртай болохгүй, төрөөс хамааралтай болно. Эргээд төрийн энийг хийх зардал нь .../минут дуусав/

С.Бямбацогт: Үг хэллээ. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Одоо дахиад л нөгөө тооцоололтой холбоотой асуулт асуух гээд байна. Одоогоор бид нар нөгөө 20 хувийн буцаалт олгож байгаа гэдэг маань үндсэндээ НӨАТ-ын хувь бол 8 хувь болсон гэдэгтэй адилхан гэж ойлгож байгаа. Тэгээд нөгөө талдаа 2026 оны 10 сарын 1-ээс болон 2027 оны 1 сарын 1-ээс үйлчилж эхлэх байсан нөгөө НӨАТ-ын буцаан олголтыг 50 хувь, 100 хувь хөнгөлөх энэ хуулиа хүчингүй болгох хуулийг бол нөгөө төсвийн хүрээний мэдэгдлээ дагуулаад оруулж ирчихсэн бас яригдаад явж байгаа. Тэгэхээр эдгээр дээрээс юуг ойлгож хармаар байна вэ гэхээр бид нарт тооцооллуудаа маш сайн гаргаж өгөөч. Өөрөөр хэлэх юм одоогийн яригдаж байгаа тэр буцаан олголтыг дахиад бүгдийг нь адилхан 20 хувь болгох, нөгөө 50 хувь, 100 хувийн хөнгөлөлттэйгөөр явах энэ 2-ын ялгаа.

Дараагийнх нь Пүрэвдорж гишүүн болон би бас хамт өргөн бариад явж байгаа энэ НӨАТ-ыг 5 хувь болгох хуулийн эффект буюу нөлөөлөл. Өөрөөр хэлбэл одоо 8 хувь байгаа нь 5 хувь болохоор хэр хэмжээний ялгаа үүсэх гээд байгаа юм бэ гэдэг асуудал байна. Түүнчлэн энэ дээр бид нар нэг юмыг анхаарах хэрэгтэй байна. Уг нь бол энэ чинь хэрэглээний татвар гэж хэлж байгаа шүү дээ. Эцсийн хэрэглэгч дээр очиж ноогдох ёстой татвар. Гэтэл нөгөө дундын босгыг нь нэмэгдүүлээд байдаг, дээрээс нь яг НӨАТ төлөлтийн системчлэл болон хяналт чинь бага байгаагаас хамаараад, буцаад яг дундын буюу дамжуулан борлуулж байгаа жижиг дунд бизнес

эрхлэгчид дээр яг НӨАТ-ын татварын ачаалал чинь өөрөө ирээд байгаа. Тэгэхээр уг нь бол энэ чинь НӨАТ үйлдвэрлэгчээс гараад, тэр 10 хувийг чинь суутган тооцоод, буцаж суутган тооцоод ингэж явсаар байгаад яг хэрэглэгч дээрээс татвар нь татагдаад буюу энэ дээр НӨАТ-ын татварын дарамт гэхээсээ илүүтэйгээр уг нь нөгөө нэмэлт хасалт чинь явчих ёстой шүү дээ. Тэгэхээр яг энэ дээр яагаад тогтолцоо нь буруу болчихоод байгаа юм бэ гэдэг дээр бас асуулт асуумаар байгаад байгаа юм. Одоо өөрөөр хэлэх юм бол яг дунд нь НӨАТ-ын өрөнд орчихсон хүмүүс маш олон байгаад байна шүү дээ. Аж ахуйн нэгжүүд, жижиг дунд бизнес эрхлэгчид. Тэгэхээр яг үүний шалтгаан нь юу байгаад байгаа вэ. Өөрөөр хэлбэл НӨАТ-ын хасалтаа хийгээд буцаан олголтоо авахаар энэ дээр яг юун дээр нь, аль хэсэг дээр нь алдаа гарчхаад байгаа вэ гэдгийг тодруулж асуумаар байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хариулаа аваад, тэгээд ер нь бид нар НӨАТ-ынхаа татварын яг гол учир холбогдлыг сайн ойлгож аваад ингээд явах юм бол уг нь бүгдээрээ НӨАТ байгаад, нөгөө НӨАТ-ууд суутгадаг байгаад, харин тэр НӨАТ-ын хувь хэмжээ чинь өөрөө багасах ёстой. Тэгж байж юмны үнэ буурах, бүгдээрээ НӨАТ төлөгчөөр байх боломж эд нар чинь гарч ирэх ёстой. Одоо жишээлбэл бид нар мэднэ шүү дээ. Ингээд худалдан авалт хийгээд очингуут НӨАТ-ынхаа баримтыг авах уу эсвэл зүгээр НӨАТ-гүй үнээ авах уу гэж асуудаг байхгүй юу. Тэгэхээр тэнд НӨАТ-гүй үнээр авах боломж нь байгаад байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ яг юуны доголдол юм. Яг ямар, гинж чинь аль хэсэгтээ тасарчхаад тэр худалдагч дээр худалдан борлуулагч дээр тэр НӨАТ-гүй зарах боломж нь үүсээд, хэрвээ НӨАТ-тай падаанаа өгөх юм бол 2 хувиа өгнө гэдэг энэ ялгаа юун дээрээс үүсээд байгаа юм. Тэгэхээр энийг Татварын ерөнхий газраас асуумаар байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ бол өөрөө энэ дунд ийм гайп буюу ийм цоорхой гараад байна гэдэг чинь тогтолцоо буруу яваад байна л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр асуултын гол хариулт авмаар байгаа юм маань. Дараа нь бол хэлэлцүүлгийн явцад тэр тооцооллуудыг надад гаргаад өгчихөд болж байна.

2 дугаарт тэр дунд яагаад НӨАТ-тай авах боломж, НӨАТ-гүй авах боломж нь байгаад байгаа вэ. Энэ яг юуны алдаа байгаад байгаа юм.

С.Бямбацогт: Мэндсайхан сайд хариулъя.

3.Мэндсайхан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. НӨАТ-ын урамшууллын буцаан олголтын 20 байсныг 50 болгон нэмэгдүүлснээр нийт хэрэглэгчдийн цөөнх өндөр хэрэглээтэй хэсэгт буюу 25 орчим хувьд нь бол буцаан олголтын 75-80 орчим хувь нь очихоор байгаа юм. Тэгэхээр энэ чинь нөгөө орлогын тэгш бус байдлыг улам нэмэгдүүлэх татварын бодлого болж хувираад байгаа байхгүй юу. Бага орлоготой дунд орлоготой иргэдийн хэсгээ бид нар бол одоогийн нөхцөл байдалд татварын бодлогоор дэмжих нь зүйтэй. Би танд жишээ хэлэхэд, ойролцоогоор 700 мянган төгрөгөөс бага орлоготой 83.500 өрхийн хүнсний зардлын 90 орчим хувь нь мах, сүү, гурил зэрэг НӨАТ-гүй бүтээгдэхүүнээс бүрдчихэж байгаа юм. Тэгэхээр 700 мянгаас доош орлоготой иргэд маань 37 мянган төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт авч байгаа юм. Гэтэл 2,1 сая төгрөгөөс дээшээ гэхэд 137 мянган төгрөгийн НӨАТ-ын буцаан олголт авчаж байгаа юм. Тэгэхээр энэ 2-ын хоорондын зөрөө чинь 3,7 дахин зөрүүтэй байгаа юм. Нэг ёсондоо бид нар худалдааны татварын бодлогоор нөгөө орлогын ялгаатай байдлыг чинь улам тийм дэвэргэсэн татварын бодлого болж хувирчих гээд байгаа юм.

Тэгэхээр Засгийн газар яаж байна вэ гэхээр ийм бодлого явуулж байхаар хөдөлмөр эрхэлж байгаа тэр сая иргэдийнхээ 1 сая 23 мянган орчим иргэн байгаа. Энэ иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжээд, хүн амын орлогын албан татвараас нь 10 хувийг нь 792 мянган төгрөгөөс чөлөөлөөд өгье. Үүний чинь нийт төсөвт ирж байгаа ачаалал бол 1,6, 1,7 их наяд байгаа. Хэрэв НӨАТ-ыг бид нар түрүүний таны хэлж байгаа 50 хувь болгоод буюу суурь нэгжээс нь 50 хувиар буулгаад 5 хувь гэж ойлгох юм бол төсөвт ирэх ачаалал нь 1,6-1,8 их наяд байгаа юм. Ойролцоо байгаа юм. Тэгэхээр бид нар хөдөлмөр эрхэлж байгаа 1 сая иргэддээ бид нар бодит дэмжлэг үзүүлэх үү. Энэ худалдааны татвараар, НӨАТ-ын буцаан олголтоор энэ орлогын ялгамжтай байдлыг улам дэвэргэсэн татварын бодлого явуулах уу гэдэг дээр Засгийн газар тооцож үзээд, хүн амын орлогын албан татвар буюу хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээ дэмжье гэдэг бодлогоор энэ хуулийг оруулж ирсэн байгаа юм. Тэр тооцоололтой асуудлыг нь Чимидсүрэн дарга хариулчих.

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон. Хэн хариулах вэ. Цогтнаран дарга уу, Чимидсүрэн дарга уу. Цогтнаран Татварын ерөнхий газрын дарга.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Цогтнаран. Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. 2026 оны 4 сарын 30-ны өдрийн байдлаар НӨАТ-ын өртэй нийт 41 мянган татвар төлөгч байна. Эдгээрийн 50 хувь нь буюу 24,7 мянган иргэн нь жижиг бизнес эрхлэгч. Эдгээр жижиг бизнес эрхлэгч нь нийт татвар төлөгчдийнхөө 60 орчим хувь. Өрийн дүнгийнхээ 50 орчим хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл энэ бичил жижиг бизнес эрхлэгч дээр НӨАТ-ын өр хуримтлагдах ийм дүр зураг ажиглагдаж байна. Энэ НӨАТ-ын босгыг 400 сая төгрөг болгосноороо бол энэ бичил жижиг бизнес эрхлэгч дээр ирж байгаа НӨАТ-ын ачааллыг бууруулна гэдэг ийм бодлого бол барьж байгаа. Энэ хуримтлагдсан татварын өртэй жижиг сегментийн 24 мянган татвар төлөгчийн 12,8 мянга нь бол .../минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Хуримтлагдсан татварын өртэй 24 мянган аж ахуйн нэгжийн бичил сегментийн аж ахуйн нэгжийн 12 мянга нь бол 400 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд байгаа. Өөрөөр хэлбэл 50 хувь нь 400 сая төгрөгийн орлогоос доошоо байгаа учраас НӨАТ-ын босгыг 400 сая төгрөг болгож нэмэгдүүлснээр энэ жижиг бичил мөн дээр нь хувь хүмүүс нэмэгдэнэ. Энэ иргэд дээр ирэх НӨАТ-ын ачаалал нь бол буурна гэж тооцож байгаа юм

С.Бямбацогт: Баярлалаа. Уянгахишиг гишүүн тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Тэгэхээр сая би хэлсэн шүү дээ. Энэ чинь өөрөө нэг ийм гинжин хэлхээ яваад байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ гинжин хэлхээнийх нь яг хаана ингээд тасарчхаад гэдэг юм уу, эсвэл саатал гарчхаад яг энэ нөгөө жижиг бизнес эрхлэгчид дээр НӨАТ-ын гол ачаалал нь очоод байгаа юм бол гэдэг дээр би хариулт авъя гэсэн шүү дээ. Тэр дээр нэг тайлбар өгөөч. Тэгж байж бид нар нөгөө оношилгоогоо зөв хийж байж эмчилгээгээ зөв гаргаж ирэхгүй бол яг одоо энэ тоон дээр ингээд гарангуут буцаад жишээлбэл хэрэглэгчдээсээ НӨАТ-аа авч чадахгүй байгаа юм уу. Нөгөө НӨАТ-гүй худалдан авалт байх боломжтой гарч ирээд байгаа шалтгаан нь юу юм бэ гэдэг энэ нөгөө татвар хураалттай холбоотой гэдэг юм уу. Яг татварын байгууллагын хяналт шалгалттай холбоотой юм уу. Энэ асуудал дээр нэг хариулт өгөөдхөөч.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ. Цогтнаран дарга хариулъя. Чимэдсүрэн дарга хариулъя.

Ч.Чимидсүрэн: Тэгэхээр НӨАТ-тай, НӨАТ-гүй, баримт олгоно, олгохгүй ялгаатай байгаа асуудлууд дээр нэлээдгүй олон шалтгаан бий. 1 шалтгааныг дурдах юм бол НӨАТ-ын хууль дээр бас нэлээдгүй олон чөлөөлөлтүүд байгаа. 49 чөлөөлөлт, нөгөө өөр 2 хуулиар гэхээр үндсэндээ 50 гаруй чөлөөлөлт байгаа. Энэ бол өөрөө тэр үйлдвэрлэлийн үе шатын дамжлагыг ингээд хуулиараа өөрөө ингээд орон зай өгөөд таслаад хаячхаж байгаа. Нөгөө талаар бас гаалиар импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүнүүд дээр түүвэр ачаа гээд орж ирдэг. Тэгээд тэр маань ингээд эх үүсвэр нь тодорхойгүй, дээр нь ингээд бүртгэлжээгүй учраас энэ маань нөгөө хаанаас орж ирсэн, НӨАТ-ын баримт төлөөгүй учраас энд ирэхээрээ нөгөө НӨАТ-тай бараануудтай өрсөлдөхөөр зэрэг ялгаатай байдлыг бас ингээд үүсгээд байдаг гэх мэтчилэн нэлээдгүй төвтэй байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр НӨАТ-ын асуудлыг бол иж бүрэн систем тогтолцоогоор нь .../минут дуусав/

С.Бямбацогт: Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. Батжаргалын Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр нэмэгдсэн өртгийн албан татвар бол улсын төсвийн орлогын хамгийн чухал байр суурь эзэлдэг ийм томоохон орлогын эх үүсвэр болсон ийм татварын төрөл. НӨАТ-ыг хэрэгждэг, НӨАТ-ын албан татвар буюу хэрэглээний албан татвар, тэр дундаа яг нэмэгдсэн өртгийн албан татвар буюу энэ нэмүү өртөг шингэсэн бараанд ноогддог албан татварыг хэрэгжүүлдэг 176 орноос өнөөдөр 150 орон НӨАТ-ын босготой байгаа. Босготой байгаа. Тэгээд энэ босгыг нь тооцдог хамгийн боломжит хувилбар, хамгийн оновчтой босго тооцоолдог ийм аргачлалыг өнөөдөр дэлхийн улс орнууд ОУВС-ийн зөвлөхүүдийн гаргасан Майкл Кин, Жак Минтс гээд ийм 2 ОУВС-ийн зөвлөхүүдийн гаргасан оновчтой нэмэгдсэн өртгийн албан татварын босгыг тооцдог аргачлалаар дэлхий нийт өнөөдөр босгоод тооцож явж байна.

Яг энэ босгоор нь тооцоод үзэхээр өнөөдөр Монгол Улсын НӨАТ-ын босго 2024 оны дүн мэдээн дээр тооцож үзэхэд энэ бол 400 сая байхаар ийм тоо мэдээ гарсан байдаг. Энэ ч агуулгаар бас Ардын намын мөрийн хөтөлбөр дээр тухайн үед ороод явж байсан гэдгийг би бас энд хэлэхийг хүсэж байна.

Тэгээд НӨАТ-ын босго байх ёстой түвшнээсээ хэтэрхий бага байхаар зэрэг жижиг дунд аж ахуйн нэгжүүд дээрээ илүү их тухайн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой асар их дарамт ордог. Эргээд татварын асар их хэмжээний өрөнд ордог гэсэн ийм судалгааны дүн нь байдаг. Эндээс нь аваад үзэхээр зэрэг энэ нь бас Монголд бас яг биеллээ олоод байгаа юм. Одоо сая өнөөдөр энэ манай ажлын албаныхны хариулж байгаагаар бол үндсэндээ 290 мянган аж ахуйн нэгж байна. Жилийн борлуулалтын орлого нь 50 сая төгрөгөөс доош орлоготой 230-аад мянган аж ахуйн нэгж байна гээд хэлж байна. НӨАТ төлөгч, суутган төлөгчийн үүрэгтэй 75 мянга орчим аж ахуйн нэгж байна гээд хэлж байна. Эндээс энэ босгыг нь 400 сая болгочих юм бол 23 мянган аж ахуйн нэгж яваад цаана нь 52 мянган аж ахуйн нэгж үлдэх юм байна гэсэн ийм тооцооллыг хийж байна л даа. Тэгээд энэ дээрээ бас яг энэ тоон мэдээ нь үнэн байна уу, үгүй юу. Та бүхэн энийг бас хараарай. Тэгээд би бол 400 саяын босгыг бол нэмэгдүүлэхийг дэмжиж байгаа. Харин энэ орлогыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор одоо 50 сая төгрөг хүртэлх орлого олоод байгаа аж

ахуй нэгж, бизнес эрхлэгчид маань НӨАТ-ын босго 400 сая болсонтой холбоотойгоор энэ 400 саяд ноогдох 1 хувийн орлогын албан татвараараа буцаагаад энэ чинь 400 саяасаа 1 хувь гэхээр 4 сая төгрөгийн нэмэлт орлогууд бас ороод ирэх боломжтой. Эндээс босго нэмэгдсэнтэй холбоотойгоор орлого дээр бол нэг тийм том нөлөө бол үзүүлэхгүй гэж ингэж бодож байна. Тэгэхлээр энэ дээрээ бас хэр зэргийн нөлөөллийг та нар тооцож байгаа юм бэ гэдгийгээ 1 дүгээрт хэлж өгөөч гэдгийг хүсэж байна.

2 дугаарт нь нэмэгдсэн өртгийн албан татварын нийт татварын хурааж авч чадаагүй байгаа өрийн 40, 50 хувийг нь нэмэгдсэн өртгийн албан татвар эзэлж байгаа. Тэр дундаа жижиг дунд бизнесүүд өнөөдөр НӨАТ-ын өрөнд орчхоод байгаа. Орлогын татварын гэхээсээ илүү нэмэгдсэн өртгийн албан татварын өрөнд ороод байгаа. Тэгээд жижиг дундууд дээр хамгийн их ачаалал орж байгаа татварын төрөл гэж ярих юм бол яг энэ төрөл байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр яг энэ дээрээ бас та бүхэн ажлын хэсгээс энэ дээр тодруулж өгөөч. Яг нийт өрийн чинь хэдэн хувь нь нэмэгдсэн өртгийн албан татвар вэ. Тэр дундаа жижиг дунд, жижиг бизнесүүд дээр хэдэн хувь нь яг энэ өрөнд чинь ороод байгаа юм бэ гэдэг дээр тодорхой тоо мэдээллийг бас хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Яах вэ, энэ бүх нийтээрээ НӨАТ төлөгч больё. 400 сая хүртэлх орлогод нь хялбаршуулсан горимоор явъя гээд сонсоход аягүй гоё сонсогдож байж магадгүй. Тэгэхдээ яг энэ системийг оруулах юм бол НӨАТ-ын нөгөө үндсэн зарчим борлуулалтад ноогдсон татвараас өмнөх шатанд ноогдуулсан суутгуулсан, суутгуулан төлснөө бол хасдаг энэ НӨАТ-ын үндсэн зарчим бол алдагдана. НӨАТ-ын системээ байхгүй болгоно гэж би харж байгаа. Энэ зөв үү. Та нар энэ дээр бас мэдээлэл өгөөч. Би нэмэлт 1 минутаа авчихъя.

С.Бямбацогт: Заяабал гишүүнд 1 минут сунгая. Асуултаа асууя.

Б.Заяабал: Дээрээс нь та бүхний оруулж ирж байгаа энэ хуулийн төслийн 16¹, 16² дээр байгаа юм. Хууль тогтоомж хууль даган мөрдөлтийн түвшин сайн байвал НӨАТ-ын энэ төлөх өрийг 1 сараар, дахиад болохгүй бол 2 сараар гээд 16² дээр ингээд 3 сараар хойшлуулж болно гээд заачихсан байгаад байгаа юм. Тэгээд хууль тогтоомжийг татварын алба байхгүйгээр, татварын байцаагч байхгүйгээр хуулийн дагуу татвараа төлөөд байгаа бизнес эрхлэгчдийг яагаад зөвхөн НӨАТ-ын татвар дээр нь төлөх хугацааг нь хойшлуулаад байгаа юм бэ. Яагаад бусад татварууд дээрээ бас төлөх боломжийг олгож болохгүй байгаа юм бэ гэдэг асуулт.

Дээрээс нь НӨАТ-ын буцаан олголт байгаа. Илүү төлөлт үүсдэг аж ахуйн нэгжүүд дээр. Тэгээд үнэхээрийн хууль тогтоомжийн даган мөрдөлт нь сайн байгаа юм бол НӨАТ-ын илүү төлөлт буюу буцаан олголтыг нь ямар нэгэн хуульд байгаагаар хяналт шалгалт явуулахгүйгээр тайланг нь үнэн зөв гэж үзээд буцааж олгож болохгүй байгаа юм бэ гэсэн ийм асуулт .../минут дуусав/

С.Бямбацогт: Сангийн яам 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулъя. Тодорхой хариулчхаарай. Манай Заяабал гишүүн Татварын ерөнхий газрын даргаар олон жил ажилласан. Татварын талаар нэлээн мэргэшсэн туршлагатай парламентч байгаа. Тэгэхээр бас эргэлзээтэй асуудлууд байна гэж яриад байна. Чимидсүрэн дарга 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Тэр НӨАТ-ыг 400 сая болгоод, тэгээд хялбаршуулсан горим гэсэн ойлголт байхгүй байгаа. Өмнөх төсөл дээр байсан. Одоо бол тэр асуудал орж ирээгүй байгаа шүү гэдгийг хэлье. Тэр 1 хувиар төлөх энэ удаа бол дурдагдаагүй.

Тэр яагаад 2 сараар НӨАТ-ын өрийг төлөх хугацааг хойшлуулаад байгаа юм бэ гээд. Энэ бол хэлэлцүүлгийн явцад маш их өндөр гарсан санал байгаа. Өөрөөр хэлбэл бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ борлуулаагүй, үйлдвэрлээгүй байхад эхлээд татвараа хил, гааль дээр төлчөөд тэгээд бараа бүтээгдэхүүнээ ав. Эсвэл гэдэг энэ шаардлага бол хэт харгис байна. Тэгэхээр энэ асуудлыг та бүхэн шийдэхийн тулд энэ аккруэл сууриасаа эсвэл мөнгөн суурь руу ор гэдэг иймэрхүү саналуудыг бол маш их олноор бол гаргаж тавьсан юм. Тэгээд бид нар судалгаа хийж үзэхэд ч гэсэндээ ер нь жижиг дунд бизнес эрхлэгч дээр эргэлтийн хөрөнгө, мөнгөний хомсдол өндөр гараад байсан юм. Тийм учраас тодорхой түвшинд энэ бараа бүтээгдэхүүнийг нь эргэлтэд оруулах тэр боломжийг үүсгэх, тэр хугацаанд нь хугацааны хөнгөлөлт эдлэх эрхийг бол оруулж өгч байгаа юм.

Татварын ерөнхий хууль дээр бусад татвар хугацааны хөнгөлөлт эдлэх заалт хэвээрээ байгаа юм. Тэр бол хуучнаараа үйлчлээд ингээд явна. Нэмэгдсэн өртгийн албан татвар дээр тухайлан 1 сар, тэгээд цааш нь 2 сараар сунгаад явах тийм нэмэлт боломжийг олгож өгч байгаа гэж ойлгоорой.

С.Бямбацогт: Заяабал гишүүн тодруулъя.

Б.Заяабал: Татварын ерөнхий хуулийн ажлын хэсгээс тэр Татварын ерөнхий хуулийн 53 дээр байгаа татварын хугацааг хойшлуулахтай холбоотой заалт дээр чинь яг энэ хууль тогтоомжийн даган мөрдөлт сайн бол гэдэг заалт байхгүй байгаа шүү дээ. Хууль тогтоомжийн даган мөрдөлт нь сайн байвал зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн хувьд ингээд үйлчлэхээр ийм л юм оруулж ирээд байна шүү дээ. НӨАТ дээр чинь л оруулж ирээд байна. Тэгэхээр би бол юу яриад байна гэхээр ерөнхий хуулийн 53 руугаа энэ заалтуудыг оруулчих. Тэгээд бусад бүх татвар төлөгчид, сайн гэсэн үнэлгээтэй байгаа бүх татвар төлөгчид энэ эрхийг нь эдлүүлье гэдэг ийм л зүйл хэлээд байгаа юм. Энэ дээр та бүхэн бас ажлын хэсэг гарахаар энэ дээрээ бас та бүхэн саналаа гаргаарай. Би энэ дээр бас санал гаргана гэдгийг хэлье.

Дээрээс нь энэ НӨАТ-ын хууль дээрээ яагаад импортын бараа гээд гаалийн татвартай холбоотой зохицуулалтуудыг ингээд холиод ороод ирсэн юм бэ гэдэг асуулт бас байгаад байгаа юм. Тэгээд би бол тэр импортын бараа оруулж ирж байгаа асуудал бол гаалийн татвар, гаалийн тарифынхаа татвар дээрээ энэ хөнгөлөлт чөлөөлөлтүүд нь .../минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Чимидсүрэн дарга Сангийн яам.

Ч.Чимидсүрэн: Зөвхөн импортын НӨАТ биш дотоодын НӨАТ дээр ч гэсэн хугацааны хөнгөлөлт хойшлуулалтыг хийх боломжийг бас байгаа. Би зүгээр жишээ хэлэхдээ зөвхөн импортоор орж ирж байгаа бараа бүтээгдэхүүн дээр ноогдох НӨАТ-ыг нь бол тайлбарлаад байгаа юм. Тэгэхээр ерөнхий хууль дээр бол аль аль нь дотоодын НӨАТ, импортын НӨАТ хоёулаа байгаа шүү.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн төслийн хэлэлцэх эсэхтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. Энэ 3 гишүүн, 4 гишүүн байна. Ганбаатар гишүүн нэрээ татлаа. Заяабал гишүүн нэрээ татлаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн үгээ хэлье. 3 гишүүн байна даа. Соронзонболд гишүүн үгээ хэлье. Соронзонболд гишүүн индэр дээрээс үг хэлнэ. \

Л.Соронзонболд: Миний хувьд бол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан татварын эрх зүйн орчныг сайжруулах энэ ажлын хэсгийг ахалж ажилласан юм. Тэгээд үүнээс өмнө болохоор бол бас 2024 онд бүрдсэн шинэ Улсын Их Хурлын даргын захирамжаар бас Ганхуяг гишүүний ахалсан татварын ажлын хэсэг ажилласан. Ингээд 2 жилийн хугацаанд маш их хэлэлцүүлгийг орон нутагт, Улаанбаатар хотод, бизнес эрхлэгчдийн дунд, иргэдийн дунд зохион байгуулсан. Ингээд тодорхой хэмжээнд бол татварын нэлээн их өөрчлөлт орох юм байна гэдэг ийм хүлээлт үүсгэсэн байсан. Тэгээд өнөөдрийн нэмэгдсэн өртгийн албан татварын энэ босгыг 400 сая төгрөг болгож байгаа дээр бол ер нь бол бизнес эрхлэгчид, ялангуяа орон нутагт жижиг дунд бизнес эрхэлж байгаа хүмүүс бол нэлээн дургүй хандаж байсан шүү гэдгийг бол зориуд цохон тэмдэглэж хэлмээр байгаа юм. Яагаад гэхээр ихэнх орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчид болохоор нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөг бизнес эрхлэгчтэй л арилжаа наймаа хийх ийм сонирхолтой байдаг. Яагаад гэхээр хэдийгээр нэмэгдсэн өртгийн албан татвар нь суутгалын татвар мөн боловч нөгөө талдаа нөгөө тал нь нэмэгдсэн өртгийн татвар дээрээ ямар нэгэн тухайн бизнес эрхлэгчийн хувьд давуу тал бий болгодоггүй учраас тийм НӨАТ төлдөггүй хүнтэй наймаа арилжаа хийх сонирхол их бага байдаг юм байна лээ. Гэтэл манай Засгийн газар энийг 400 сая төгрөг болгоод оруулж ирж байгаа нь өөрөө бол нэг талдаа бол учир дутагдалтай байна гэж миний хувьд харж байгаа.

Дээрээс нь болохоор энэ татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хэсгээс бол маш олон саналыг бүх татварын төрлүүдээр хийгээд, энийгээ болохоор Засгийн газарт бас өргөн барьсан байгаа гэдгийг бас зориуд энд бол цохон тэмдэглэж хэлмээр байгаа юм.

С.Бямбацогт: Баярлалаа. Пунсалмаа гишүүн үгээ хэлье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Нэмэгдсэн өртгийн албан татвар бол 2 зорилгоор бий болж байгаа.

1 дүгээрт нь бол хэрэглээнээс авч байгаа татвар,

2 дугаарт нь нийт мөнгөн урсгалыг ил тод болгох ийм зорилготой татвар байдаг юм.

Тэгэхээр хэрэглээнээс татвар бүрдүүлэх энэ зорилгын хүрээнд импортын НӨАТ-ыг 2 сар хүртэлх хугацаагаар хойшлуулж байгаа. Энэ бол маш үр дүнтэй шийдэл боллоо гэж би харж байгаа. Эхлээд бол энэ орж ирж байгаа бараан дээрээ импортын бараа оруулж ирж байгаа хүмүүс маань 5 хувийнхаа гаалийг төлчихнө, дараа нь 2 сарынхаа дараа НӨАТ-аа төлнө гэдэг бол энэ импортлогч компаниудын хувьд маш дэмтэй, зөв шийдэл боллоо гэж харж байгаа. Энэ дээрээс нэмэгдүүлээд бид нар ер нь бол тайлан гаргах энэ аргачлалыг одоо бол аккруэл суурьтай байгаа.

Энийг мөнгөн суурь луу шилжүүлэх тал дээр бас анхаарвал зүгээр санагдаж байгаа. Эсвэл 2 сар хүртэлх хойшлуулах энэ хугацааг 3 сар болгох ийм боломж байна уу гэдэг дээр.

Цаашлаад энэ 2 дахь зорилго нь бол ер нь иргэдээрээ дамжуулж бүх нийт эдийн засгийнхаа хэмжээг гаргаж ирэх зорилготой ийм татвар байгаа. Тэр ч утгаараа бид нар одоо энэ НӨАТ төлөгчийн босгыг 400 сая болгож байна. Яг одоо хэрэгжиж байгаа хуулиар бол НӨАТ төлөгчийн босго 50 сая байгаа. 50 сая төгрөгийн босгон дээр 20 мянган аж ахуйн нэгж НӨАТ төлөгч биш байдаг юм. Одоо энэ 400 сая болгоод өсгөхтэй нь зэрэг хэчнээн мянган аж ахуйн нэгж НӨАТ төлөгч биш болох вэ. Энийг тооцоход тун төвөгтэй байгаа. Ер нь бол энэ НӨАТ гэдгийг алаг цоог, зарим компаниуд нь төлдөг, зарим компаниуд нь төлдөггүйгээс болоод эцсийн хэрэглэгч дээр очдог барааны үнэ ханш маш ч өсдөг. Тэр ч утгаараа зах дээр 5 мянган төгрөгөөр борлогдож байгаа бараа дэлгүүр, маркет дээр ирэхээр 15 мянга болдог чинь энэ НӨАТ-ын алаг цоог тооцооноос болдог юм.

Тийм учраас миний санал бол энэ 400 сая хүртэлх энэ босгоо дахиж хараач. Эс бөгөөс энийг хувь хэмжээг нь магадгүй 2 хувийн буцаалтыг иргэд авч байгаа энэ 2 хувьтай нь дүйцүүлсэн НӨАТ-ыг тооцооч гэдэг ийм саналыг хүргүүлж байгаа. Тэгэх юм бол бид нарын улсын татварт бүрдүүлж байгаа НӨАТ хураалтын дүн багасахгүй. Мөн эцсийн хэрэглэгчдийн энэ өгч байгаа

С.Бямбацогт: Тэмүүлэн гишүүний цүнх явахгүй шүү. Байж бай.

Б.Пунсалмаа: Барааны үнэ бол өсөхгүй ийм өндөр ач холбогдолтой байх юм гэдэг энэ саналыг хүргүүлж байгаа юм. Тэгээд ер нь гол санаа нь бол энэ татварыг бол дэмжиж байгаа. Гэхдээ 400 саяынхаа босгыг бид нар дахин харах шаардлагатай гэж үзэж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Тэмүүлэн гишүүнийг санал хураалтдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Цүнх явахгүй ээ, цүнх хөл ургахгүй ээ. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн үгээ хэлье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ товчхон ярья. Бас энэ ирц бүрэн бүрдтэл бас жоохон ч гэсэн хугацаа хэрэгтэй байх Хурлын дарга аа.

Тэгэхээр энэ удаагийн яг энэ НӨАТ-ыг тодорхой хэмжээнд бууруулж байгаа энэ Засгийн газраас өргөн барьж байгаа энэ хуулийн төсөл бол үнэхээрийн бизнес эрхлэгчдийг гар газар, хөл хөсөр, амар тайван болгох тал дээр бол зарим нэгэн ахиц дэвшлийг хийж байгааг бол хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй гэж харж байна. Гэхдээ бидэнд та минь анхаарах ёстой зүйл байна. Энэ юу вэ гэхээр түрүүн Энхтүвшин гишүүн бас яриад байна. Татварын ерөнхий хуулийн 4.2 дугаар заалтад татварын аливаа хөнгөлөлт чөлөөлөлт, аливаа суурийг багасгах ихэсгэх ийм тохиолдолд ингэж чөлөөлөх тохиолдолд, хөнгөлөх тохиолдолд төсвийн хуультайгаа хамтарч оруулж ирэх ёстой гэсэн энэ хуулийн заалтыг Улсын Их Хурал бас зөрчиж болохгүй шүү. Тийм учраас хэлэлцүүлгийн явцад үүнийгээ засаад явах нь зүйтэй байна гэдгийг анхааруулж хэлэх нь зүйтэй.

Түүний зэрэгцээ яах вэ, 400 сая болж байна. Энэ ингээд тайлбар юмнуудаас нь харахад бол 12 мянган аж ахуйн нэгж яг бодит ачаалал нь буурна гэж үзэж байгаа

юм байна. Тэгэхээр зэрэг бид бас энэ аж ахуйн нэгжүүдийг дэмжихээс гадна хэрэглэгчдийг бас харах ёстой. Ялангуяа түрүүнд Уянгахишиг гишүүн ч гэсэн асуугаад байсан. НӨАТ-ын хуулийн 13.1, 13.10 гэсэн заалтууд байгаа. 13.1 заалт дээрээ бид өнөөдөр Монгол орны хөрсөнд ургуулсан хүнс ногоо, жимс жимсгэнэ, гурил улаан буудай гэсэн энэ бүтээгдэхүүнүүд, мөн үйлдвэрийн аргаар бэлдсэн монгол малын мах энэ бүтээгдэхүүн, тэгээд сүү гэсэн ийм бүтээгдэхүүнүүдийг зах зээл дээр гаргаж хэрэглэгчдэд хүргэхдээ бол НӨАТ-ын 10 хувиас нь чөлөөлнө гээд заачихсан. Гэтэл харамсалтай нь юу болж байна вэ гэхээр 13.10 заалт дээрээ юу гээд хэлчихсэн бэ гэхээрээ энийг бас Сангийн яамныхан их сайн сонсоорой. Эдийн засаг, хөгжлийн яам ч гэсэн сайн сонсоорой. Энэ дээрээ бид юу гээд хэлчихсэн бэ гэхээрээ дамжуулан борлуулагч бол энэхүү чөлөөлөх эрхийг эдлэхгүй гээд заачихсан. Энэ ямар байдал үүсгэж байна вэ гэхээр хотын гадна очоод та бүхэн зүгээр дэлгүүрүүдээр яваад үз. Зүгээр жижиг дэлгүүрүүдээр яваад үз. Тэнд 10 хувийг нь шингээгээд, НӨАТ-тай зарж байна. Би өөрөө дэлгүүрүүдээр явлаа. Өнөөдөр сүлжээний 5 том дэлгүүр байна. Carrefour байна, Номин байна, И-Март байна. Ингээд бусад сүлжээний ийм 5 том дэлгүүрт бол өнөөдөр НӨАТ-гүй зарж байна. Гэвч хотын захад зарж байгаа энэ үнэтэйгээ адилхан үнээр зараад яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ шударга бус өрсөлдөөнийг бий болгож байна гэж харж байна.

2 дугаарт бол бид энэ чөлөөлөх заалтыг ингэж алаг цоог хэрэглэснээс болоод үнэхээрийн ойлгомжгүй ийм нөхцөл байдал үүсгэсэн учраас цаашдаа бид яг энэ нэмэлт, өөрчлөлтийг оруулах үедээ 13.10 гэсэн энэ заалтыг авч хаях нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгааг хэлье.

Тэгээд энэ хууль 2027 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлснээр олон .../минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа ирж байх хооронд дараагийн асуудал орж байя. 2 жижигхэн асуудал байгаа. Санал хураалтыг түр хойшлууллаа.

17.33 цаг.

Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урья.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх хэсгийг явуулна.

Хууль санаачлагч илтгэлийг Тэмүүжин гишүүн танилцуулна. Энэ дээр асуулт, үг байхгүй. Шууд явчих юм байна лээ. Санал, дүгнэлтүүд яваад, дараа нь Цэнгүүн гишүүний хууль байгаа. Тэгээд санал хураалтууд явъя. Асуулт, үг бас байхгүй.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол улсын Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн тухай ойлголтод нийгэмд аюултай байдал гэх ухагдахууныг хэрэглэх замаар Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд заасан хууль ёсны зарчим буюу гэмт хэргийг зөвхөн хуулиар тодорхойлох зарчим, үзэл санааг гажуудуулан, гэмт хэрэг нь эрүүгийн хуульд заасан байхаас гадна нийгэмд аюултай гэх шинжийг агуулах ёстой гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараар нь хэмжинэ. Эрүүгийн хариуцлагыг гэмт хэргийн нийгмийн аюулын

шинж чанарт тохируулан хүлээлгэнэ гэх үзэл сурталчилсан субъектив агуулга хэмжихэд төвөгтэй хэмжүүрийг хуульчлагджээ.

Эрүүгийн хууль нь хууль ёсны гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял албадлагыг зөвхөн хуулиар тодорхойлох ёстой гэсэн агуулгыг илэрхийлдэг. Ингэснээр хэн нэгэн эрх мэдэлтэн өөрийн үзэмжээр бусдыг буруутгаж, эрүүгийн ял албадлага хэрэглэх дур зоргыг хязгаарладаг. Гэтэл Эрүүгийн хуульд хэн нэгний үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох ял албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ нийгэмд аюултай гэх субъектив ойлголтыг нэмж хуульчилснаар шүүх үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох ял албадлагын арга хэмжээг оногдуулж, хүлээлгэхдээ нийгмийн аюул гэх хийсвэр ойлголт хэрэглэж, гэмт хэрэгт тооцох ял оногдуулах эсэхийг зөвхөн хуулиар тодорхойлно гэсэн эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмыг гажуудуулж, шүүгч, прокурор, өмгөөлөгч өөрийн санаагаар томьёолох, нийгэмд аюултай, нийгэмд аюулгүй гэсэн субъектив шалгуураар гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял, албадлагын арга хэмжээг тодорхойлж үнэлэх боломжтой болсон байна.

Түүнчлэн Монгол Улсын эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх ял, албадлагын арга хэмжээг хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхой зааж, энэ зүйлд заагаагүй нөхцөл байдлыг харгалзан ял албадлагын арга хэмжээг хүндрүүлэхийг хэрэглэсэн. Гэтэл шүүх шийдвэртэй хэргийн нийгэмд аюултай учраас нийгмийн хор аюул бага учраас хэмээн ял албадлагын арга хэмжээг тогтоож байгаа нь Эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмыг үгүйсгэж буй бас нэг хэлбэр болсон байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар үндсэн 5 асуудал хөндөж байгаа бөгөөд үүнд сая дурдагдсан нийгэмд аюултай гэх субъектив нэр томьёо, хэмжигдэх төвөгтэй үйл ажиллагааг Эрүүгийн хуулиас хасах. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэгт хуулийн этгээд гэж бичигдсэн нь хуулийн этгээд гэдэг нэрийн ард төрийн байгууллага, иргэнд гомдож Эрүүгийн хуулиар иргэдийг айлган сүрдүүлдэг үйл ажиллагааг таслан зогсоох. Мөрдөн шалгах ажиллагааны нууц гэдэг Эрүүгийн хуулийн гэмт хэргийг хэт ерөнхий хавтгайруулан ерөнхий хуульчилснаас болж нууц хадгалах үүрэггүй иргэд Эрүүгийн хуульд хариуцлагад татагдаж байгаа үйл ажлыг хязгаарлах. Эрүүгийн хариуцлага гэдэг нэр томьёог Эрүүгийн хуульд буцаан хэрэглэсэнтэй холбогдуулаад Эрүүгийн хууль эрүүгийн албадлагын арга хэмжээ болон ял гэдэг үйл ажиллагааг эрүүгийн хариуцлага гэдэг нэр томьёонд багтааснаас мөн энэ эрүүгийн хариуцлага гэдэг ерөнхий нэр томьёогоо бусад 42 хуульд шууд авч хэрэглэсэнтэй холбоотойгоор хүний эрхэнд дордуулсан нөхцөлөө дүйцсэнийг зогсоох, эрүүгийн хуульд хэрэглэсэн хянан шалган шийдвэрлэх гэдэг нэр томьёог засаж, хянан шийдвэрлэх гэдэг нэр томьёог нэг мөр нэгдсэн байдлаар хэрэглэх томьёолол руу шилжүүлэх 5 асуудлыг шийдэхээр энэ хуулийн төсөл өргөн барьсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Бямбацогт: Тэмүүжин гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нараас 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 18 болон 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Эрүүгийн хуульд хэн нэгний үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ял албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ нийгэмд аюултай гэх субъектив ойлголтыг нэмж хуульчилснаар шүүх үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ял албадлагын арга хэмжээ оногдуулах хүлээлгэхдээ нийгмийн аюул гэх хийсвэр ойлголт хэрэглэж, гэмт хэрэгт тооцох ял оногдуулах эсэхийг зөвхөн хуулиар тодорхойлно гэсэн эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмыг гажуудуулж, шүүгч, прокурор, өмгөөлөгч өөрийн санаагаар томъёолох, нийгэмд аюултай, нийгэмд аюулгүй гэсэн субъектив шалгуураар гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял албадлагын арга хэмжээг тодорхойлж үнэлэх боломжтой болсон. Мөн Эрүүгийн хуулийн эрүүгийн хариуцлага хэмээх нэр томъёог хэрэглэж улмаар бусад хуулиар энэхүү эрүүгийн хариуцлага хэмээх ухагдахууныг үндэслэл болгож нийгмийн харилцааг зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчим, түүнийг Эрүүгийн хууль 1 гэмт хэрэгт 1 удаа ял оногдуулна гэснийг зөрчихөд хүргэсэн.

Эрүүгийн хууль дахь эрүүгийн хариуцлага гэсэн ухагдахуунд ял албадлагын арга хэмжээ гэсэн 2 өөр агуулга эрх зүйн үр дагавар бүхий ойлголт хамаардаг бөгөөд уг 2 ойлголтыг нэгтгэж, эрүүгийн хариуцлага хэмээн томъёолсныг эрүүгийн эрх зүйн бус нийгмийн харилцааг зохицуулсан хуульд эш татан хэрэглэж, ял шийтгүүлээгүй болон шүүх ял шийтгэх шаардлагагүй гэмт хэргийн шинжтэй үйлдэл эс үйлдэхүй боловч үүнд түүний улмаас үүссэн үр дагавар нь ялимгүй улмаас шүүх ял оногдуулахгүй Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэснийг хамааруулсан нь хүний эрхийг дордуулж байгаа зэрэг асуудлыг үүссэн байх тул Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийгэмд аюултай байдал, нийгмийн аюулгүй шинж чанар гэсэн ойлголтыг хасаж, эрүүгийн хариуцлага гэх ойлголтыг нарийвчлан ял албадлагын арга хэмжээ хэмээн ялгаж, бусад хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үзүүлэх эрх зүйн үр дагаврыг зөвхөн эрүүгийн ял хэмээн ойлголтод хамааруулж хэрэглэх зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг D-Parliament.mn цахим системд байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг хууль санаачлагчийн зүгээс Эрүүгийн хуулийн нийгэмд аюултай байдал, нийгмийн аюулгүйн шинж чанар гэсэн ойлголтыг шүүх практикт хэрхэн буруу хэрэглэж байгаа талаар, Эрүүгийн хуулийн хохирол, хор уршиг гэсэн ойлголтоос гадна хуулийн төсөлд шинээр хор аюул гэх ойлголт оруулж ирснээр хэрэг хянан шийдвэрлэхэд үзэмжээрээ шийдвэрлэх нөхцөл байдал үүсэх эсэх, албадлагын арга хэмжээг эрүүгийн хуулийн бүрэлдэхүүн хэсгээс гаргаж байгаа нь зохимжтой эсэх, Засгийн газрын хуулийн төсөлд өгсөн саналыг хэрхэн тусгасан

талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн ерөнхий анги, суурь зарчмууд хөндөгдөж, гэмт хэргийн шинж, хариуцлага, ял гэсэн онолын суурь зарчмууд хөндөгдөж байгаа учраас хуулийн төслийг нэмэлт, өөрчлөлт бус шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд боловсруулах байсан эсэх талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг

явуулсан талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Нарантуяа-Нара гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн, Амгаланбаатар гишүүн алга байна. 1 гишүүнээр тасаллаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Тэмүүжин гишүүний энэ өргөн барьж байгаа хуулийг бол дэмжиж байгаа. Энэ дээр тодруулах гээд байгаа 1 зүйл нь энэ албаны үүргийн дагуу олж авсан мэдээллийн дагуу гэрчийг илчилсэн, эсвэл энэ мэдээллээр задруулж, холбоотой асуудал дээр хүндрэл бэрхшээл үзүүлсэн энэ статистик мэдээлэл ер нь хэр их байдаг юм бэ. Энэ талын судалгаа нь тан дээр байна уу гэдэг асуулт байгаад байгаа юм.

Тэгээд дээрээс нь та энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр энэ эрүүгийн хариуцлага гэдгийг ингээд ял, албадлагын арга хэмжээ гэж 2 задлаад байгаа шүү дээ. Үүний гол давуу тал нь юунд байгаа вэ.

С.Бямбацогт: Хууль санаачлагч хариулъя. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Эрүүгийн хууль дээр 2015 оны Эрүүгийн хууль дээр эрүүгийн хариуцлага гэдэг энэ уламжлалт ойлголтыг нь халаад, ял, албадлагын арга хэмжээ гээд 2 тусдаа ойлголт бичсэн юм. Тэгээд бусад хуулиуд дээр хэрвээ яг энэ төрлийн үг хэрэглэх бол ял хүлээсэн бол, гэмт хэргийн шинжтэй бол гэх мэтчилэн ийм ойлголтоор илэрхийлсэн байсныг Эрүүгийн хууль дээр эрүүгийн хариуцлага гэдэг ойлголт ерөнхий ойлголт бий болгоод, ял, албадлагын арга хэмжээ бол эрүүгийн хариуцлага гэдэг нэр томъёонд илэрхийлэгдэнэ гэдэг нэг гарчиг байдлаар ашиглаад, үүгээрээ бусад бүх хуулиуд руу аваачаад эрүүгийн хариуцлага хүлээхээр бол, эрүүгийн хариуцлага хүлээсэн бол гэдэг энэ үгээр 42 хууль дээр байна уу даа ашигласан байдлаар хэрэглээд, энэ нь хүний эрхийн нөхцөл байдлыг дордуулж байна гэдэг ийм үнэлгээ, ийм нөхцөл байдлыг үүсгэсэн юм. Жишээ нь, 1 ийм юм болж байгаа юм. Зүгээр ердийн хууль эрүүгийн хууль биш шүү. 1 ердийн хууль дээр эрүүгийн хариуцлага хүлээхээр бол энэ хүнийг албан тушаалд томилохгүй. Эсвэл тендер өгөхгүй гэдэг ямар нэгэн хязгаарлалт тавьчихаж байгаа байхгүй юу. Тэгсэн чинь тэр хүн нь ял аваагүй, гэмт хэрэг үйлдсэн гэж ял аваагүй. Албадлагын арга хэмжээ авагдчихсан. Тэр албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хууль дээр байгаа албадлагын арга хэмжээ, Зөрчлийн хууль дээр байгаа албадлагын арга хэмжээ 2 яг адилхан. Дахиад. Тэгэхээр гэмт хэрэг хийгээгүй, ял аваагүй хүн албадлагын арга хэмжээ авагдсаныхаа төлөө эрхээ хязгаарлуулах болчхож байгаа юм. Хамгийн аюултай нь. Тэгээд бүр 42 хуулиар. Одоо зөвхөн эрүүгийн хариуцлага гэдэг үгийг сольсонтой холбоотойгоор энд дагалдуулан өргөн барьсан .../минут дуусав*/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 1 минут.

Х.Тэмүүжин: Зөвхөн энэ нэр томъёотой холбоотой энэ 40 хэдэн хууль байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 40 хэдэн хуулиар хүний эрхийг дордуулсан энгийн нөхцөл байдлаас нь гадуурхсан, ялгаварласан, нөхцөл байдлыг нь хүндрүүлсэн ийм байдал үүсгэчихсэн байгаа нь буруу нэр томъёо хэрэглэсэн энэ хуультай л холбоотой байгаад байгаа юм. Тэгээд энийг бол засах хэрэгцээ байгаа.

Түрүүчийн таны асуусан энэ мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой асуудал дээр одоогоор бол ийм ноцтой үйлдэл статистик бол гараагүй байна. Гэхдээ хуучин байгаа хуулиараа бол мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах мэдээллийг эрх бүхий албан тушаалтнууд албан үүргийнхээ дагуу олж авчхаад ХМХ рүү дамжуулах байдлаар, хэвлэлээр албан тушаалтнуудыг тодорхой мэргэжлийн хүмүүсийг урьдчилж ялладаг, гүтгэдэг, харлуулдаг. Тэгээд тэр үйл явдалдаа болохоор сэтгүүлчийг буруутгаад .../минут дуусав/

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Санал хураалтыг нэгтгээд явуулна.

17.48 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ренчинбямбын Сэддорж танилцуулна. Индэрт урьж байна.

Энэ дээр 1 л гишүүн үг хэлэхээр байсан байх аа. Тэгээд үүний дараа ер нь санал хураалтууд руу орно. Байнгын хорооны дарга сонгохоос эхлээд.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүнээс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөлтэй холбоотой асуулт,

хариулт гараагүй бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн төслийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр болгож өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Сэддорж гишүүнд баярлалаа.

Ажлын хэсэг танилцуулья. Энхжаргалын Сундуй “Төв тусгал” сургалт, судалгааны төвийн судлаач, Жанчивсэнгээгийн Дамбаасүрэн Өмгөөллийн “Грандлекс партнерс” компанийн өмгөөлөгч.

Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн, Тэмүүжин гишүүн нэрээ татлаа. Эрдэнэбүрэн гишүүн нэрээ татлаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Эндээс эхлээд санал хураалтаа эхэлчихье. Араас нь явна. Бүгдийг нь эндээс эхлээд хураагаад явчихъя. Тэгвэл Байнгын хороогоо нэгмөсөн явуулья.

Санал хураалтыг хойшлууллаа.

17.51 цаг.

Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэл танилцуулна. Үүний дараа санал хураалтууд эхэлнэ шүү гишүүд ээ. Танхимдаа хүрэлцэн ирээрэй ирээгүй гишүүд. Батсүмбэрэл гишүүнийг урьж байна.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал дүгнэлтийг танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Батсүмбэрэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт заасны дагуу Эдийн засгийн

байнгын хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг дэвшүүлсэн болно.

Батжаргалын Заяабал нь 1976 онд Увс аймгийн Өмнөговь сумд төрсөн. 1994 онд Увс аймгийн Улаангом сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 1999 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүү, эдийн засагч мэргэжлээр, 2008 онд АНУ-ын Жорж Майсоны Их сургуулийг Төрийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2017 онд МУИС-ийг Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн байна.

1999-2000 онд Улсын Их Хурлын гишүүний туслах, 2002-2005 онд Дэлхийн банкны Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн газарт мэргэжилтэн, 2008-2009 онд Түлш, эрчим хүчний яамны Төрийн захиргаа, удирдлагын газарт хэлтсийн дарга, 2009-2010 онд Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 2010-2012 онд Төрийн өмчийн хорооны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлэлцээрийн газрын дарга, 2012-2013 онд Төрийн өмчийн хорооны дарга, 2013-2017 онд Монгол Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, 2015-2016 онд Татварын ерөнхий газрын дэд дарга, 2015-2016 онд Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, 2016 оноос Улсын Их Хурлын зөвлөх, 2016-2019 онд Татварын ерөнхий газрын дэд дарга, 2019-2024 онд Татварын ерөнхий газрын дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалын төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргад дэвшүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хороон даргад Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ташрамд Эдийн засгийн байнгын хороог амжилттай удирдаж ажилласан Сэддорж гишүүнд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн өмнөөс талархал илэрхийлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Батсүмбэрэл гишүүнд баярлалаа. Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Байгаа юм уу. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Эрдэнэболд гишүүний микрофон өгье.

С.Эрдэнэболд: 1 ийм асуудал байгаад байгаа юм. Одоо бид нар сая Хөгжлийн хөтөлбөрийн тухай ярилцлаа. Тэгээд ерөнхийдөө юу болж байна гэхээр яг нөгөө зэрлэг баруун гэдэг шиг зүйл болсон. Баахан ажлын хэсэг рүү орсон зарчмын зөрүүтэй санал зарим нь боссон, зарим нь унасан. Нарийн ярих юм бол энэ дээр нам улс төрийн харьяаллын юм ч яригдсан. Тэгэхээр өмнө нь бол Их Хурлын дарга аа, та мэдэж байгаа шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 хүний доор байгаа Аюулгүйн зөвлөлөөс нөгөө төсөв маань үндэсний аюулгүй байдлын үзэл

баримтлалд нийцэж байгаа эсэх талаар, хөгжлийн хөтөлбөр маань нийцэж байгаа эсэх талаар бид нар ингээд шалгуур тогтоох ёстой болчихоод байгаа. Тэгэхээр ийм шалгуур тогтоохгүй байх юм бол бид нар тойрог тойрог руугаа төсвөө илүү хуваарилах гэж хичээдэг. Эсвэл салбар салбар луугаа төсвөө илүү хуваарилах гэж хичээдэг. Тэгээд шулуухан хэлэхэд хэн овсгоотой салбарын сайд, хэн овсгоотой Улсын Их Хурлын гишүүд нь төсвийн энэ том нүүгэлтсэн өрсөлдөөн дундаас өөрсдөдөө хуваарилуулах, өөрсдийнхөө тойрогт хуваарилуулах гэсэн ийм марафон болоод байгаа байхгүй юу. Тэгээд 1 л нэгдсэн улс юм бол энэ төсвийн бодлого, хөгжлийн бодлого, түүнд нийцэж гарч байгаа энэ төсөл, хөтөлбөрүүд маань 1 долгион дээр хэмжээсээр хэмжигддэг байх зайлшгүй шаардлагатай болчихоод байгаа юм. Тэгэхээр яг энэ ажил тэг дундаа дундаж байгаа учраас шинээр Эдийн засгийн байнгын хорооны дарга болох гэж байгаагийн хувьд Заяабал гишүүн маань энэ дээр бас зарчим барьж, тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эсвэл эднийх 10 жил, Аюулгүйн зөвлөл жишээлбэл 16 жил энэ ажлаа хийгээгүй байхгүй юу. Тийм учраас Их Хурлаасаа энийг санаачлаад, энэ хэмжүүрийг нь гаргадаг ч гэдэг юм уу энэ ажлыг явуулахгүй бол жилийн жилд бид нар энэ маргаанаас салахгүй байна. Энэтэй холбоотой нарийвчилсан албан бичиг шалгуурыг танд явуулъя. Энэ дээр та бас зарчим барьж ажиллах байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны даргын анхны том даалгавар болох нь. Сая бол 203 санал, тэрнээс ажлын хэсэг дэмжсэн нь 57, дэмжээгүй нь 150. Тэгээд энэ дээр яг зарчим барьж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нийцүүлж санал хураалгаж Их Хуралд оруулж ирэх 3 дахь хэлэлцүүлгийг явуулах ийм чиглэлийг өгсөн байгаа. Ажлын хэсэгтэйгээ маш нягт хамтарч ажиллаад, Улсын Их Хурлын Тамгын газраас бас дэмжлэг туслалцаагаа авч байгаад маш том хариуцлагатай асуудал таны анхны даалгавар болж байна даа.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Танхимд хэдэн гишүүн байна. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд ээ, ирц бүртгэлийн санал хураалт. Цогтбаатар гишүүн ирцэд байна. Доржханд гишүүн байна. Батсүмбэрэл гишүүн байна. Өөр ороогүй гишүүд байна уу. Эрдэнэболд гишүүн байна. Саранчулуун гишүүн байна. Санал хураалт явуулъя. Тэгээд хуруугаа уншуулаарай та бүхэн. Хуруугаа уншуулаагүй болохоор эсрэг гараад байна шүү дээ. Санал хураалт.

Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг сонгохыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 71,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Заяабалыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргаар сонгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддоржийг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны даргыг үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эдийн засгийн байнгын хорооны даргаар бас өмнө нь ажиллаж байсан манай Сэддорж гишүүн бас 2 жил гаруй хугацаанд маш сайн үр дүнтэй ажилласан. Тэгээд Улсын Их Хурлын бас бодлого үйл ажиллагаа, Засгийн газар, хууль санаачлагчдын оруулсан асуудлуудыг Эдийн засгийн байнгын хороон дээр амжилттай, тасалдуулахгүй, төрийн ажлыг тасалдуулахгүй явуулахад бас онцгой анхаарч ажиллаж байсан. Сэддорж даргадаа бас баяр хүргэе нийт гишүүдийнхээ өмнөөс.

Мөн бас шинээр Эдийн засгийн байнгын хорооны даргаар бас томилогдож байгаа Батжаргалын Заяабал гишүүндээ бас хамгийн том, хамгийн хариуцлагатай байнгын хороог амжилттай удирдаж ажиллах амжилтыг бас нийт гишүүдийнхээ өмнөөс хүсэн ерөөе.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо./18:00/

Одоо санал хураалтаа явуулна даа. Санал хураалтууд байгаа.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгэе гишүүд ээ. 67 гишүүн бэлэн болсон байна. Зарим 1 гишүүд бэлэн болж амжаагүй байх шиг байна. Бэлэн болохыг хүсье. Санал хураалт.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 67,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.03 цаг.

Одоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүн санал хураалтад оролцсоноос 68 гишүүн 70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.04 цаг.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад 62 гишүүн бэлэн болсон байна. 68 гишүүн танхимд байх шиг байна. 70-аад гишүүн. Бэлэн болсон уу. Санал хураалт явуулъя.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 53 гишүүн буюу 55,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.05 цаг.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтад бэлтгэе гишүүд ээ. 63 гишүүн болж байна. Санал хураалт. Хурууны хээгээ уншуулаагүй гишүүд хурууны хээгээ уншуулна уу. Санал хураалт явуулъя.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 56,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 54 гишүүн буюу 56,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

18.07 цаг.

Дараагийн санал хураалт.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. 67 гишүүн санал хураалтад бэлэн болсон байна. Санал хураалт. Жаргалсайхан гишүүн, Гомбын Ганбаатар гишүүд хурууны хээгээ уншуулъя. 71 гишүүн боллоо. Санал хураалт явуулъя.

1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 41 хууль байгаа шүү. Гишүүд ээ суугаарай. Баатархүү гишүүн ээ. Цэндийн Баатархүү гишүүн.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Одоо ингээд үндсэн нэмэлт, өөрчлөлт оруулах хууль нь явчихсан. Дагаж 41 хуулийн санал хураалт явна. Үүнийг бас Дэгийн хууль дээр хэдүүлээ нэгэнтээ гол бодлогын хууль нь явчихсан юм чинь багцлаад хураадаг тийм зарчимд шилжүүлбэ.

Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 74 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 71,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 64 гишүүн буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 63 гишүүн буюу 65,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 гишүүний 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 70 гишүүн буюу 72,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 96 гишүүнээс 71 гишүүн буюу 74 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15. Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16. Зээлийн мэдээллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүнээс 70 гишүүн буюу 72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 71,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тайван унш гэж байна. Тайван уншъя.

19. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 70 гишүүн буюу 72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 65 гишүүн буюу 67,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье

гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүнээс 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 буюу 68,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 64 буюу 66,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын

томьёоллоор санал хураалт явуулъя. Дөхөж байна шүү. 96 гишүүнээс 66 гишүүн буюу 68,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 буюу 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

36.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн орсноос 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

37.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн орсноос 70 гишүүн буюу 72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 70 гишүүн буюу 72,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүнээс 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

40.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн оролцоноос 62 гишүүн буюу 64,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

41.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 96 гишүүн орсноос 67 гишүүн буюу 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

42.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 96 гишүүн санал хураалтад оролцоноос 69 гишүүн буюу 71,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

18.23 цаг.

Одоо 1 санал хураалт байгаа. Гишүүд асуулт асууж, хариулт авсан. Үг хэлсэн. Зарчмын зөрүүтэй 1 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе Хурууны хээг уншуулаагүй гишүүд уншуулж бэлтгэнэ үү. Түрүүн 71 гишүүн байсан.

Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд уншиж танилцуулъя.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг.Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал

Нэг.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтын дүнг танилцуулъя. 96 гишүүн санал хураалтад оролцсоноос 68 гишүүн буюу 70,8 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

18.25 цаг.

Өнөөдрийн чуулганы хуралдаанаар нэлээн олон асуудлаар санал хураалт явуулж, олон санал хураалт явуулсан. Өндөр ачаалалтай ажилласан нийт гишүүддээ баярлалаа. 96 гишүүнээс 71 гишүүн өнөөдөр бас эцсийн мөчид, чуулганы төгсгөлд оролцлоо. Тэгээд 17 асуудал хэлэлцэж, 3 хуулийг эцэслэн баталлаа.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийг өнөөдөр баталсан.

Энэ хуулийг баталснаар дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах газрын тос боловсруулах үйлдвэр, Монголчууд газрын тосоо дотооддоо боловсруулдаг болох, мөн Баруун бүсийн эрчим хүчний хэрэглээг бүрэн хангах Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн ажил саадгүй үргэлжлэх боломж бүрдэж байгаа. Цахилгаан эрчим хүч, шатахууны хараат байдлыг бууруулах томоохон төслүүдийг цаг хугацаанд нь дуусгах санхүүжилтийн асуудлыг шийдэж байгаа учраас энэ хууль чухал ач холбогдолтой гэж хэлж болно. Өмнө нь энэ хуулийн төслийг бас боловсруулж өргөн барьсан Алтаншагай нарын гишүүд, сүүлд яаралтай

горимоор өргөн мэдүүлсэн Засгийн газар, Сангийн сайд Мэндсайханы хувь нэмэр, үүрэг оролцоо чухал байсныг бас энд онцлон тэмдэглэж бас хэлье.

Дараагийн бас эцэслэн баталсан хууль бол Монгол Улсад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай төслүүдээс эхлээд уул уурхай, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын том жижиг бүх төслүүд, хөтөлбөрүүдэд үнэлгээ хийдэг энэ нь аж ахуйн нэгж, иргэдэд багагүй хүндрэл чирэгдэл учруулдаг байсан. Тэгвэл Улсын Их Хурал Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг баталснаар үсчин гоо сайхан, автомашин угаалгын үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүд үнэлгээ хийлгэх шаардлагагүй болж байгаа гэх мэтчилэн иргэдэд учирдаг хүнд суртлыг багасгасан, үнэлгээ хийлгэх ялгаа заагийг тодорхой болгосон ач холбогдолтой хуулийг Их Хурал өнөөдөр баталлаа. Хуулийг боловсруулах ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга, Наранцэцэгийн Алтаншагай, Бат-Эрдэнэ, Гомбын Ганбаатар, Замира, Мөнхбат, Мөнхсоёл Одонтуяа, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Сандаг-Очир нартаа бас талархлаа илэрхийлье.

Мөн бас түрүүчийн 7 хоногт эцсийн хэлэлцүүлгийг хийсэн Цусны донорын тухай хуулийг өнөөдөр эцсийн найруулга сонсож баталсан.

Монгол Улсын хэмжээнд цусаа тогтмол хандивладаг 210 мянган донор бүртгэлтэй байгаа. 1 иргэний хандивласан цус 3 хүний амийг авардаг гэж ярьдаг. Ямар нэгэн хариу нэхэлгүй сайн санаа, сайхан сэтгэлийн үндсэн дээр иргэдийнхээ алтан амийг аврах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, цусаа хандивладаг иргэдээ алдаршуулах, сайн дураар бас цусаа хандивлах донорын эгнээг өргөжүүлэх үйлийг бодитоор дэмжихэд бидний баталсан хууль маш чухал ач холбогдолтой хууль гэдгийг онцолж хэлье. Манай Улсын Их Хуралд цусаа хандивладаг донор гишүүд бас цөөнгүй байгаа. Энэ хуулийн төслийг манай Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Ариунзаяа, Алдаржавхлан, Батсүмбэрэл нар бас санаачилж батлууллаа. Манай Улсын Их Хурлын гишүүн Баясгалан гишүүн маань бас ажлын хэсгийг ахалж ажилласан. Хууль санаачилсан гишүүд болон ажлын хэсэгт ажилласан гишүүддээ бас баярлалаа гэдгийг бас хэлье.

Өнөөдөр бас Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын багц хуулиудыг бид нар хэлэлцэх эсэхийг шийдсэн. Ирэх 7 хоногт бас гишүүдийн санаачилсан татварын хуулиуд хэлэлцэнэ. Тийм болохоор энэ татварын хуулиуд бас нийгмийн анхаарал татсан маш чухал асуудал. Татварын бодлого гэдэг бол эдийн засгийн өсөлтийг дэмжих, орлогын тэгш бус байдлыг бууруулах, төсвийг бүрдүүлэх, нийгэм, эдийн засгийн тэнцвэрийг хангах гол үндсэн үүрэгтэй арга хэрэгсэл. Энэ агуулгаар татварын аливаа өөрчлөлт нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдсан, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, нийгэмд шударга ёсыг тогтоох бас оновчтой бас зохистой байх ёстой. Татварын бодлогын орчин, хувь хэмжээ зэрэг нь нийгмийн бүхий л сегментэд хамаардгийн хувьд иргэд, хувийн хэвшлийн хамгийн их анхаарал татсан, хамгийн их шүүмжлэл дагуулдаг сэдэв байсаар ирсэн. Энд бид бас цаашдаа хэлэлцүүлгүүд дээр онцгой анхаарах ёстой.

Гэхдээ татварын бодлого бол улс төрчдийн хууль санаачлагчийн юу гэдэг юм улс төрийн попордог сэдэв бас байж болохгүй. Улс орныхоо эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, нийгэмд маш сөрөг нөлөөтэй ийм асуудлуудыг илүү анхаарах ёстой. Татварын хувь хэмжээг огцом бууруулсан популист шийдвэр гаргасны хор

уршгаар дампуурч, дефолтод орсон Шри-Ланк улсын жишээг та бүхэн бас бид бүхэн бас сайн мэдэж байгаа. Тийм болохоор татварын хувь хэмжээг хэт их бууруулах юм бол төрийн албан хаагчдын цалингаа тавьж чадахгүйд хүрэх, боловсрол, эрүүл мэнд гээд хөрөнгө оруулалтаа санхүүжүүлж чадахгүйд хүрэх, ахмадуудынхаа тэтгэврийг нэмж чадахгүйд хүрэх, хүүхдийн мөнгөө өгч чадахгүйд хүрэх ийм эрсдэлүүд гарч болзошгүй. Тийм болохоор маш хариуцлагатай хандах ёстой.

Мөн бас ОХУ, Украин дайнаас үүдэлтэй үнийн өсөлт бүрэн арилж амжаагүй байхад Ойрх Дорнодын хямралаас шалтгаалсан үнийн өсөлт бас өнөөдөр бидэнд бас нэлээн давлагаа нөмөрч ирсэн байгаа. Энэ үед бас иргэдийн бодит орлогод сөргөөр нөлөөлөх, худалдан авах чадварыг бууруулах, бизнесийн өртөг нэмэгдүүлэх, ашигт ажиллагаа муудах, эдийн засгийн идэвхжил бүхэлдээ саарах ийм бас нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд бид бас ажиллаж байна. Иргэд маань бас ажиллаж амьдарч байгаа.

Тийм болохоор бас эдийн засгийг хүний бие гэж үзэх юм бол манай эдийн засгийн цусны эргэлт нь муудсан, зогсонги байдалд орсон ийм үед энэ цусны урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгаа сэргээх үүднээс татварын хуулиудыг хэлэлцэх гэж байгаа нь цаг үеэ олсон гэж үзэж байгаа.

Нэг талаас бас үнийн өсөлт гээд хүндрэлтэй дарамттай асуудлууд байна. Нөгөө талдаа бас иргэдийн орлогыг хамгаалах, эдийн засгийг эрчимжүүлэх ийм 2 эсрэг зорилго нэгэн зэрэг тэнцвэртэйгээр шийдвэрлэх эгзэгтэй цаг үед татварын хуулиудыг бид бас маш анхааралтай хэлэлцэж батлах нь зүйтэй. Тийм болохоор ажлын хэсэг байгуулагдах байх. Энэ дээр бас ажиллах ажлын хэсэг, Төсвийн байнгын хороо онцгой анхаарч бас хэлэлцүүлгүүдийг явуулж, энэ хуулиудыг иргэдийнхээ орлогыг хамгаалах, эдийн засгаа эрчимжүүлэх, 1 зоосны 2 тал болсон эсрэг, тэсрэг зүйлүүдийг хэрхэн яаж зөв зохицуулах вэ гэдэг дээр бас анхаарч ажиллах ёстой шүү гэдгийг бас хэлье.

Мөн энэ 7 хоногт Улсын Их Хурал өөрсдийнхөө бас дэгийг Улсын Их Хурлын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлууд хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн. Ирэх 7 хоногт бас Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудыг хэлэлцэнэ. Төрийн эрх барих, хууль тогтоох, төлөөлөх дээд байгууллага маань өөрсдөө дээрээсээ эхлээд өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлэх ёстой. Өөрсдөө хариуцлагатай, ёс, зүйтэй, сахилга баттай, үлгэр жишээ байж байж бидний бас үлгэр дуурайлал, манлайлал ард түмэнд хүрнэ. Тийм болохоор бид өөрсдөө илүү манлайлалтай, илүү үлгэр жишээ байж байж төрийн албан хаагчдаа, Засгийн газартаа шаардлага тавина.

Тийм учраас Улсын Их Хурлын багц хуулиуд бас бидний бас иргэдэд илүү хүлээн зөвшөөрөгдөх, иргэдийн итгэлийг олох, төрд итгэх иргэдийн итгэлийг сэргээхэд илүү чухал хууль. Улсын Их Хурлын үйл ажиллагаа сайжирч, Улсын Их Хурлын нэр хүнд бэхэжсэнээр энэ парламентын засаглал маань ардчилсан парламент маань бэхэжнэ. Тийм болохоор энэ бүхэнд бид бас илүү онцгой анхаарч, энэ ажлын хэсэг байгуулахдаа анхаарч ажиллах ёстой гэдгийг бас энд сануулж хэлье.

Ийм бас олон чухал хуулиудыг хэлэлцсэн 7 хоног болж өнгөрлөө.

Улсын Их Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Өнөөдрийн чуулганы хэлэлцэх асуудлууд дууслаа.

2026 оны 05 дугаар сарын 22-ны чуулганы нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье.

18.33 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ